



ШУА, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗАР



ШУА, ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

**ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭ**

*Судалгааны тайлан,  
дүн шинжилгээ*

УЛААНБААТАР 2017

## АГУУЛГА

Оршил .....	6
-------------	---

## I ХЭСЭГ

**ШУ-НЫ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТАД  
ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

<b>1.1 Хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ.....</b>	<b>10</b>
1.1.1 Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг хуульчилсан байдал.....	11
1.1.2 Эрх зүйн байдал.....	18
1.1.3 Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалт.....	26
1.1.4 Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг зохицуулсан байдал.....	40
1.1.5 Шинжлэх ухаан технологийн оюуны өмчийн харилцаа ба бусад.....	46
<i>Хяналт шинжилгээ-үнэлгээтэй холбогдон үүсэх харилцаа</i>	
1.1.6 Давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах .....	48
<i>Шинжлэх ухааны салбарын хуулийн давхардал</i>	
<i>Шинжлэх ухааны салбарын хуулийн зөрчил</i>	
<i>Шинжлэх ухааны салбарын хуулийн хийдэл</i>	
<i>Шинжлэх ухааны салбарын хуулийн бичвэрийн харьцуулалт</i>	
<b>1.2. Эрх зүйн актуудад хийсэн дүн шинжилгээ.....</b>	<b>60</b>
1.2.1 Засгийн газрын тогтоолд хийсэн дүн шинжилгээ.....	60
1.2.2 БСШУСЯ-ны захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хийсэн шинжилгээ.....	63
1.2.3 ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаалд хийсэн дүн шинжилгээ.....	66

## II ХЭСЭГ

**ШУ-НЫ САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, СТАТУС, БҮТЭЦ,  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ  
ҮНЭЛГЭЭ, САНАЛ ДҮГНЭЛТ ЭКСПЕРТИЙН СУДАЛГАА**

<b>2.1. Судалгааны арга зүй, аргачлал.....</b>	<b>72</b>
<b>2.2 Шинжлэх ухааны салбар: статус ба эрх зүйн орчин, институциудын уялдаа холбоо.....</b>	<b>76</b>
2.2.1 Шинжлэх ухааны салбарын статус.....	
2.2.2 Шинжлэх ухааны салбарын эрх зүйн орчин.....	79
2.2.3 Шинжлэх ухааны академи ба бусад институциуд хоорондын харилцаа, уялдаа холбоо.....	82

<b>2.3. ШУ-ны салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, үйл ажиллагаа.....</b>	<b>86</b>
2.3.1 ШУ-ны салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг.....	86
2.3.2 ШУ-ны салбарын үйл ажиллагаа.....	90
<b>2.4. Шинжлэх ухааны салбарын санхүүжилт.....</b>	<b>95</b>
<b>2.5. ШУТ-ийн ажлын үр дүн, нийгэм-эдийн засгийн үр нөлөө.....</b>	<b>98</b>
<b>Дүгнэлт.....</b>	<b>101</b>

### **III ХЭСЭГ ХАВСРАЛТУУД**

<b>3.1 Экспертэд хамаарах хүмүүсийн ХМХ-д нийтлэгдсэн нийтлэл, ярилцлагад хийсэн контент анализ.....</b>	<b>105</b>
<b>3.2 Экспертийн санал асуулгын судалгааны нэгдсэн дүн /үр дүнгийн хүснэгтээр/.....</b>	<b>124</b>
<b>3.3 Дэлхийн улс орнуудын үндэсний ШУА-уудын статус, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилтийн харьцуулсан шинжилгээ.....</b>	<b>145</b>
<b>3.4 Шинжлэх ухааны докторын цол зэргийн талаарх олон улсын жишиг.....</b>	<b>202</b>

## Хүснэгт, зургийн жагсаалт

### I ХЭСЭГ

#### ШУ-НЫ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЭРХ ЗҮЙН АКТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Хүснэгт 1.1.1: Үйл ажиллагаа

Хүснэгт 1.1.2: Шинжлэх ухааны салбарын оролцогчид, гэдгээрийн эрх зүйн байдал

Хүснэгт 1.1.3: Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалт

Хүснэгт 1.1.4: Санхүүжилт

Хүснэгт 1.1.5: Хууль тогтоомжийн зөрчил

Хүснэгт 1.2.1: Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн байдал

Хүснэгт 1.2.2: БСШУС-ын Сайдын тушаалын хэрэгжилтийн байдал

Хүснэгт 1.3.1 ШУА-ийн эрх зүйн актуудын тогтоох хэсэгт хийсэн дүн шинжилгээ

Хүснэгт 1.3.2 ШУА-ийн эрх зүйн актуудад хийсэн дүн шинжилгээ

### II ХЭСЭГ

#### ШУ-НЫ САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, СТАТУС, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ, САНАЛ ДҮГНЭЛТ ЭКСПЕРТИЙН СУДАЛГАА

Хүснэгт 2.1.1 Эх олонлог, авахаар төлөвлөсөн түүврийн олонлог. ШУ-ны салбар, хүйс, зэрэг дэвээр

Хүснэгт 2.1.2 Түүврийн бүтэц, ШУ-ны салбар, ЭША-ны зэрэг дэвээр

Хүснэгт 2.2.1 ШУС-ын гол хуулиудын сул талын үнэлгээ, хуулиудаар

Хүснэгт 2.2.2 ШУС-ын гол хуулиудын хэрэгжилтийн үнэлгээ, хуулиудаар

Хүснэгт 3.1.1 ШУА-д өөрчлөлт хийх чиглэл, шаардлага (дундаж үзүүлэлтээр эрэмбэлсэн үр дүн)

Хүснэгт 3.1.2 Монгол улсад шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэхэд төрийн зүгээс авбал зохих арга хэмжээ (Эрдэмтэн, судлаачдын асуулгын үр дүн)

Хүснэгт 3.2.1 ШУА-ийн үүргээ хэрэгжүүлж буй байдал

Хүснэгт 3.2.2 Их чуулганы үүрэг, түүний хэрэгжилт

Хүснэгт 3.2.3 Бага чуулганы үүрэг, түүний хэрэгжилт

Хүснэгт 4.1 Ажиллаж буй ШУ-ны салбарын санхүүжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ, хувиар

Хүснэгт 4.2 ШУТ-ийн үйл ажиллагааны санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмыг өөрчлөх боловсронгуй болгох санал

Хүснэгт 4.3 ШУА-ийн үйл ажиллагааны санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хийх арга хэмжээний талаарх санал /давхардсан хариулттай асуулт/

Хүснэгт 5.1 МУ-ын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр анхаарал хандуулж, хөрөнгө оруулах салбарууд

### Зургийн жагсаалт

Зураг 1.1 Судалгааны түүврийн бүтэц, нас хүйс, зэрэг цолоор

Зураг 1.2 Судалгааны түүврийн бүтэц, ажилладаг газар, ажлын газрын харьяалаар

Зураг 1.3 Түүврийн бүтэц, ажиллаж буй ШУ-ны салбар, эрхлэж буй ажлаар

Зураг 1.4 Түүврийн бүтэц, ЭШ-ний ажил хийж буй хугацаа, зэрэг дэвээр

Зураг 2.1.1 Үндсэн хуулийн "...шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" гэсэн заалтын хэрэгжилтийн талаарх үнэлгээ

Зураг 2.1.2 ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн "...Академи нь төрийн ивээлд байна" хэмээх заалт нь хувийн статустай ШУБ, нэгжийг орхигдуулсан, ер нь ШУ бүхэлдээ төрийн ивээл, хамгаалалтад байж чадахгүй байгаа гэсэн бодомжтой санал нийлэх эсэх

Зураг 2.2.1 ШУ-ны салбарын эрх зүйн байдлын үнэлгээ

Зураг 2.2.2 ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудын сул тал

Зураг 2.3.1 ШУА ба бусад институт хоорондын харилцаа, уялдаа холбоо, өнөөгийн байдлын үнэлгээ ба зохимжит уялдаа холбоог хувиар илэрхийлсэн нь

Зураг 3.1 2015 онд хийгдсэн ШУА-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн үр дүнгийн үнэлгээ

Зураг 3.2.1 ШУА-ийн үйл ажиллагаа, үр дүнгийн үнэлгээ

Зураг 3.2.2 "Их чуулган", "Бага чуулган"-ы үйл ажиллагаа, үр дүнгийн үнэлгээ

Зураг 3.2.3 ШУА улс орны болон салбарын асуудлыг "Их чуулган", "Бага чуулган"-аар хэлэлцэж шийддэгийг хэрхэн дүгнэж байна вэ?

Зураг 4.1 Санхүүжилтийн механизмыг өөрчлөх хувилбарын талаарх байр суурь

## ОРШИЛ

Монгол Улсын шинжлэх ухааны салбарыг эрчимтэй хөгжүүлэхэд эрх зүйн таатай орчин чухал хөшүүрэг болох тул шинжлэх ухааны онол-арга зүйн үндэслэл, таамаглалыг дэвшүүлэн холбогдох эрх зүйн эх сурвалжид анализ хийх, түүнийг шинжлэх ухааны эргэлтэд оруулах нь чухал байна.

“Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ” бичил төслийн судалгааг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн судалгааны баг 2016 оны 12 дугаар сарын 14-наас 2017 оны нэгдүгээр сарын 28-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

Судалгааны үр дүнг илтгэсэн тайлан 1) Шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээ; 2) Шинжлэх ухааны салбарын хууль эрх зүйн орчин, үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн талаарх экспертүүдийн үнэлгээ, дүгнэлт гэсэн үндсэн хоёр хэсэг, хавсралтуудаас бүрдэж буй. Үүнд:

**Шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжид хийсэн дүн шинжилгээгээр** Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны ажиллаж буй эрх зүйн орчин болон шинжлэх ухааны байгууллагын бүтэц, зохион байгуулалт, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж нөхцөл зэрэгт эрх зүйн үнэлэлт өгөхийг зорилоо. Тэрчлэн холбогдох хууль тогтоомжуудын эдийн засгийн хөшүүрэг, улс төрийн дэмжлэг, нийгмийн баталгааг судалж, санал зөвлөмж боловсруулахад чиглэв.

Монголчууд ХХ зууны эхэн үеэс орчин үеийн соёл, шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлж, хүн төрөлхтөний хөгжлийн чиг хандлагад нийцсэн эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, түүнийгээ байнга боловсронгуй болгох талаар онцгой анхаарч ирсэн. Тиймээс Монгол дахь эрх зүйн орчинг дор дурдсан түвшинд авч үзэв. Үүнд:

**1. Үндсэн хуулийн хүрээнд:** БНМАУ-ын Үндсэн хуулийн (1940) 34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Шинжлэх ухааны хүрээлэн нь БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд шууд захирагдах газарт багтаж байжээ. Харин БНМАУ-ын Үндсэн хуулийн (1960) 10 дугаар зүйлд “...соёл, шинжлэх ухааны газрууд, мөн улсын бүх байгууллагын эд хөрөнгө, энэ бүхэн бол улсын өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм” гэж зааж байв.

Одоогийн буюу 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлд “**Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна**” гэж заасан байдаг бөгөөд дээрх гурван зүйлийг агуулгын хувьд авч үзвэл 1940 оны Үндсэн хуулиар ШУА буюу шинжлэх ухааны байгууллагын статусыг Үндсэн хуульдаа шууд тусгасан, харин 1960 оны болон 1992 оны Үндсэн хуулиудад байгууллагын статусыг тодорхой тусгаагүй байна.

Тэгсэн хэрнээ 1992 оны Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Иргэний туурвисан **оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн**” хэмээн зааж, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх явдлыг хүний эрх, эрх чөлөө болгон тунхаглажээ.

**2. Олон улсын гэрээ, конвенци.** Монгол Улс 2016 оны байдлаар 266 олон талт олон улсын гэрээнд нэгдэн орж, соёрхон баталж, 1118 гаруй хоёр талт олон улсын гэрээг байгуулжээ. Үүнээс шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаатай шууд холбогдох НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын дүрэм, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн пакт, Зохиогчийн эрхийн

тухай, Дэлхийн оюуны өмчийн байгууллага байгуулах тухай конвенци гэхчлэн 15 олон талт гэрээнд нэгдэн оржээ.

Монгол Улсын хуулиудад “олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө” гэж заасан байдаг тул эдгээр гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилдэг. Гэхдээ энэхүү заалт нь гол төлөв хувийн эрх зүйн маргаантай холбоотой асуудалд хэрэглэгддэг бөгөөд нийтлэг үйл ажиллагаа явуулахтай холбогдсон асуудалд хэрэглэгддэггүй. Тиймээс шинжлэх ухааны холбогдолтой хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, мөн шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын олон талт гэрээг төдийлөн хэрэглэдэггүй нь бас нэгэн зөрчил үүсгэж мэдэхээр байна. Ийм нөхцөлд шинжлэх ухааны үндэсний эрх зүйн тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлж чадаж буй эсэх нь эргэлзээ төрүүлэхээр байна. Гэхдээ судалгааны ажлын гүйцэтгэх хугацаа, санхүүжилт болон бусад нөхцөлөөс хамааран судлах асуудлын хамрах хүрээг хязгаарлан авч үзсэн тул эл судалгаанд дээр хөндсөн асуудлыг нарийвчлан судлаагүйг тэмдэглэе.

**3. Хууль тогтоомжийн хүрээнд.** Өнөөгийн байдлаар Монгол дахь шинжлэх ухааны хууль тогтоомжийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн тухай (2006), Технологи дамжуулах тухай (1998), Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай (2006), Патентын (2006), Инновацийн тухай (2012) хууль зэрэг шинжлэх ухааныг хөгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан 19 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Мөн салбарын хөгжлийг дэмжих, нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэхтэй холбоотой “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого” (1998), “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (2000), “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” (2007) зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан, хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлж байна.

**4. Эрх зүйн акт.** Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны болон Шинжлэх ухааны академийн тэргүүлэгчдээс захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг судалж, хоорондын уялдаа холбоог хангах хэрэгцээ шаардлага амьдралаас урган гарчээ.

Шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжийн агуулгад дүн шинжилгээ хийхдээ дурдсан хуулийн зохицуулалтын агуулга, зорилго давхардсан, эсвэл ижил нөхцөлд өөрөөр журамласан, зохицуулалтын зүйл заалт нь хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн, зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, орхигдуулсан, зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утга агуулсан эсэхийг үндэслэл болгож давхар шалгаж магадлахыг хичээв.

Улс орны хөгжлийн түвшин нь шинжлэх ухааны салбарын ололт, амжилтаас ихээхэн хамаардаг бол шинжлэх ухааны хөгжил нь чадварлаг чадамжтай боловсон хүчин, түүний нөөц, шаардлагатай санхүүжилт, техник технологиор хангагдах, оновчтой бүтэц, зохион байгуулалт, зөв зохистой удирдлага менежмент, хууль эрх зүйн орчин, бодлогын зохицуулалт г.м олон хүчин зүйлүүдээс хамаардаг.

**Салбарын боловсон хүчин, түүний нөөц.** 2014-2015 оны жилийн эцсийн статистик мэдээгээр шинжлэх ухааны байгууллагад 2724 хүн ажиллаж байжээ. Үүний 1725 нь эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байснаас 1521 нь эрдмийн зэрэг цолтой ажиллагсад байв (*доктор Sc.D-ын зэрэгтэй 135, доктор Ph.D-ын зэрэгтэй 496, магистр зэрэгтэй 890*)<sup>1</sup>. ШУ-ны байгууллагад ажиллагсдын тоог нийт хүн амтай харьцуулбал 1 сая хүнд ойролцоогоор 556 эрдэм шинжилгээний ажилтан ноогдох бөгөөд дэлхийн дундаж (1500 орчим<sup>2</sup>) үзүүлэлтээс даруй 3 дахин

<sup>1</sup> БСШУЯ. Боловсрол, соёл шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн эмхтгэл (II). УБ., 2015. 148 дахь тал.

<sup>2</sup> Н.Одонгарав. “Ямба, ял хоёрыг нь үүрүүлж” шинжлэх ухааны “эрх чөлөөг” хангах нь Монгол улс хөгжих гол гарц мөн. Нийтлэл. 2016.10.24. <http://www.mas.ac.mn>

бага байна. Хэрэгцээт боловсон хүчнээр хангах бодлого алдагдаж, боловсон хүчнийг дэмжих, ажиллах нөхцөл боломжоор хангах, нийгмийн асуудлыг анхаарах, боловсон хүчний чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сургах, бэлтгэх үйл явц удаашрах, хоцрогдох, тасалдах байдал тус салбарын нэг гол дутагдал болсоор удаж байна.

**Хөрөнгө оруулалт, санхүүжилт, техник технологийн шинэчлэл.** Дэлхийн хөгжингүй улс орнууд ШУ-ны салбараа хөгжүүлэхийн тулд дунджаар ДНБ-ийхээ 3.28 хувь (Израйль 4.456%, Финлянд 3.934%, Швед 3.597%, Өмнөд Солонгос 3.561, Япон 3.357%, Дани 3.063%, АНУ 2.897, Герман 2.822%, Австри 2.722%, Сингапур 2.428%)<sup>3</sup>-ийг зарцуулж байгаа бол манай улсад шинжлэх ухааны салбарт 2008 онд ДНБ-ий 0.2 хувийг, 2009 онд 0.3 хувийг, 2010-2014 онуудад 0.2 хувийг<sup>4</sup> зарцуулсан байна. Мөн санхүүжилт бага байгаагаас үүдэлтэй шинжлэх ухааны салбарын судалгаа, туршилтын ажилд шаардагдахуйц технологийн шинэчлэл тэр бүр хийдэггүй. Хөрөнгө оруулалт, боловсон хүчний нөөц бага байгаа нь шинжлэх ухааны салбарын нийгэм-эдийн засгийн үр өгөөж мэдрэгдэхгүй байх гол шалтгаан болдог. Манай улсын ШУ-ны салбарын хөгжилд эдгээр хүчин зүйл сөргөөр нөлөөлж байгаа нь гарцаагүй. Гэхдээ байгаа нөөцийг зөв ашигласан тохиолдолд нөхцөл байдлыг одоогийнхоос дээрдүүлэх боломжтой. Үүний тулд бүтэц, зохион байгуулалтын зөв, үр дүнтэй тогтолцоог бий болгох шаардлагатай юм.

**Бүтэц, үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт.** Сүүлийн 27 жилийн хугацаанд Монгол улсад шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг сайжруулахтай холбогдуулан хоёр удаа бүтэц, зохион байгуулалтын томоохон өөрчлөлт хийсэн байна. Анх Засгийн газрын 1997 оны 31 дүгээр тогтоолд<sup>5</sup> үндэслэн хүрээлэн төвүүдийг нэгтгэсэн бол хоёр дахь удаад нь 2015 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолд үндэслэн 49 эрдэм шинжилгээний хүрээлэнг 23 болгож нэгтгэсэн билээ.

“Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2025 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд “...эрдэм шинжилгээний байгууллагуудын бие даасан үйл ажиллагаа хангалтгүй, санхүүгийн эх үүсвэр олох сонирхол бага, судалгаа шинжилгээний ажлын үр өгөөж хангалтгүй”<sup>6</sup>, “...тэргүүлэх хүрээлэн, их сургууль, судалгаа-сургалтын газрыг дэмжих, тэдгээрийн материал-техникийн бааз болон боловсон хүчний чадамжийг тэргүүлэх ээлжинд хөгжүүлэхэд хөрөнгө нөөцийг төвлөрүүлэх боломж өгөхгүй байна”<sup>7</sup> гэжээ. Мөн ШУА-ийн Философи Социологи Эрхийн хүрээлэнгээс 2013 онд хийсэн “Төсвийн бус эх үүсвэрээр хэрэгжиж буй судалгаа, хөгжлийн ажлын судалгаа”-ны тайланд “эрдэм шинжилгээний байгууллагууд аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааны хурд зах зээлийн эрчмийг гүйцэхгүй, хэрэгцээг нь хангаж чаддаггүй, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд албан байгууллагуудын оролцоо, оролцооны хэлбэр тодорхой бус” байна хэмээн дүгнэжээ. Энд дурьдагдсан асуудлууд өнөөдөр ч шийдэгдээгүй хэвээр үргэлжилж байна гэж хэлж болно.

Салбарын бодлого тодорхойлогчид, ШУА-ийн тэргүүлэгчид, Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга нар болон салбарын гол бүрэлдэхүүн хэсгийн төлөөлөл болох эрдэмтэн судлаачдаас бүрдсэн 105 экспертний уг судалгаанд хамруулсан бөгөөд респондентуудыг олон шатат санамсаргүй түүвэр болон зорилтот түүврийн аргаар сонгон авч, үр дүнг гаргав. Экспертийн санал асуулгын судалгаанд ШУ-ны салбарын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үр

<sup>3</sup> “ШУ-ны салбарын санхүүжилт” илтгэл. Илтгэгч: Г.Батхүрэл. Эдийн засгийн хөгжлийн яам Хөгжлийн бодлого, стратеги төлөвлөлт, зохицуулалтын газрын орлогч дарга. 2013.09.05./2016.10.24. <http://www.meds.gov.mn/>

<sup>4</sup> <http://www.meds.gov.mn/> //БШУЯ. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2015 оны төсвийн төсөл. 10 дахь тал. 2016.10.24

<sup>5</sup> Засгийн газрын тогтоол. МУ-ын ШУ-ны байгууллагуудын бүтцийн өөрчлөлт хийх чиглэл. №31. 1997. <http://www.legalinfo.mn/annex/details/1474?lawid=5592>

<sup>6</sup> “Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2025 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” төслийн баримт бичиг. БСШУЯ. УБ., 2006. 25 дахь тал.

<sup>7</sup> “Монгол улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2025 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” төслийн баримт бичиг. БСШУЯ. УБ., 2006. 31 дэх тал.

дүнгийн талаар гарсан ярилцлага, нийтлэлийн материал, хууль эрх зүйн баримт бичгүүдэд контент анализ хийсний үндсэн дээр экспертний анкетыг боловсруулан, анкет сурвалжлагын аргаар үндсэн мэдээллийг цуглуулж, зарим экспертүүдтэй гүнзгийрүүлэн ярилцсан болно.

Судалгааны ажлыг гүйцэтгэсэн Философийн хүрээлэнг түшиглэсэн төслийн багт тус хүрээлэнгийн хууль эрх зүй, улс төр, социологийн мэргэжлийн судлаачид багтсаны дээр УИХ-ын судалгааны албаны судлаач, БСШУСЯ-ны ШУТГ-ын мэргэжилтэн, ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын хуулийн мэргэжилтэн гэх мэт шинжлэх ухааны салбарын удирдлага, бүтцийн янз бүрийн түвшинд ажиллаж буй судлаач, эрдэмтэн, бодлогын мэргэжилтэн нар мөн орж ажиллав.

Нийгмийн оюун санааны амьдрал, сэтгэлгээг өөрчлөх, нийгмийн дэвшил хөгжлийн гол түлхүүр болсон шинжлэх ухааны салбарын хөгжлийн өнөөгийн байдал, түүний эрх зүйн орчныг боловсронгуй болгох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэхэд энэхүү судалгааны тайлан багахан ч болов нэмэр хандив болно гэдэгт судлаачдын баг найдаж байна.

I

---

**ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ,  
ЭРХ ЗҮЙН АКТАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**ЭРХ ЗҮЙН ШИНЖИЛГЭЭ**

---

**1.1 ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

**1.2. ЭРХ ЗҮЙН АКТУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

## 1.1 ХУУЛЬ, ТОГТООМЖИД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хамрах хүрээ.** Энэхүү судалгааны хууль тогтоомжийн дүн шинжилгээ хэсэгт хамрах хүрээг тодорхойлохдоо Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”-ийн 5.1<sup>8</sup>, 5.2<sup>9</sup> болон 5.3<sup>10</sup> дугаар заалтуудыг үндэслэсэн болно.

Судалгаанд Монгол Улсын Үндсэн хууль, шинжлэх ухааны салбарын харилцааг зохицуулж буй дараах гол хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг хамруулав. Үүнд:

- 1) Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль (1996)
- 2) Технологи дамжуулах тухай хууль (1998)
- 3) Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (2006)
- 4) Инновацийн тухай хууль (2012)

**Дүн шинжилгээний аргачлал.** Дүн шинжилгээг хийхдээ мөн аргачлал<sup>11</sup>-ын гуравдугаар зүйлд заасан уялдаа холбоог сайжруулах үндсэн аргаас:

- Агуулгын харьцуулалтын арга (3.1.3.б)
- Хууль тогтоомжийн эрэмблэлийн арга (3.1.4)-ыг сонгон ашигласан болно.

Дээрх аргыг сонгосноор шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжид дүн шинжилгээ хийхдээ хуулийн зүйл, заалт тус бүрээр задлан шинжлэхээс илүүтэй салбарт тулгамдаж буй нэн тэргүүний асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж буй өнөөгийн хууль тогтоомж зохицуулж чадаж буй эсэхэд агуулгын дүн шинжилгээ хийхийг зорив. Хууль тогтоомжийн дүн шинжилгээг:

- 1) Шинжлэх ухааны салбарын оролцогчдын эрх зүйн байдал
- 2) Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалт
- 3) Үйл ажиллагаа (бүтээл, хэрэглээ г.м)
- 4) Санхүүжилт гэсэн дэд сэдвийн хүрээнд холбогдох матрицаар хууль тогтоомжийн зөрчил, давхардал, хийдлийг гаргахыг зорив.

Мөн судалгааны хүрээнд түүвэрлэсэн хуулиудын зохицуулж буй харилцааны онцлогоос үүдэн *зохиогчийн эрх түүний баталгаа* болон *бусад харилцааны* зохицуулалтад ерөнхий шинжилгээ хийж, дүн шинжилгээний хэсгийн тавдугаар дэд сэдэв болгон оруулав. Ингэхдээ Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай хуулийн зохицуулалтыг хамруулаагүй болно.

Хуулийн дүн шинжилгээг хийхдээ:

“*Давхардал*” гэж хуулиар нэгэнт зохицуулсан харилцааг хэл зүйн хувьд хуулбарласан, эсхүл тэдгээрийн зохицуулалтын агуулга, зорилго ижил байхыг,

“*Зөрчил*” гэж нэг этгээдийн зан үйлийг ижил нөхцөлд өөрөөр журамласан, хамгийн дээд хүчин чадалтай буюу суурь харилцааг зохицуулж байгаа хуульд заасан журмаас өөр зохицуулалтыг тусгасан, өөр нэр томъёо хэрэглэсэн, зохицуулалтын агуулга нь тухайн хуулийн үзэл баримтлалтай зөрчилдсөн байхыг,

“*Хийдэл*” гэж тухайн харилцаанд оролцогчдын зан үйлийг хуульчилсан боловч түүнийг хэрэгжүүлэх арга зам, процедурыг заагаагүй, шаардлагатай зохицуулалтыг

<sup>8</sup> Бэлтгэл үе шатанд хуультай холбоотой 10 эрх зүйн актыг цуглуулна.

<sup>9</sup> Цуглуулсан хууль, хуульчилсан актаас хүчинтэй үйлчилж байгааг ялгах.

<sup>10</sup> Цуглуулсан хууль, хуульчилсан актаа уншиж танилцаад эдгээрээс тухайн хуультай шууд холбогдох хууль, хуульчилсан актыг ялгаж авах.

<sup>11</sup> ХЗДХ-ийн Сайдын тушаал. Дугаар 84. 2010 он., “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал”

орхигдуулсан, эсхүл зохицуулалт нь хэл зүйн найруулгын хувьд зөрчилтэй буюу салаа утгатай байхыг ойлгоно<sup>12</sup> гэснийг үндэслэл болгон энэхүү дүн шинжилгээг хийв.

## Нэг. Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагааг хуульчилсан байдал

Шинжлэх ухааны салбарт үйлчилж буй хууль тогтоомжийн зохицуулалтаас үзэхэд салбарын үйл ажиллагаа тодорхойгүй байна. Хэдийгээр “хууль” танин мэдэхүйн баримт бичиг биш ч гэлээ хуулийн зорилго, хамрах хүрээ, тухайн хуулиар зохицуулагдах харилцаа буюу салбарын үйл ажиллагаа маш тодорхой, нарийн хуульчлагдсан тохиолдолд тухайн хууль хэрэгжих үндэс, суурь нь болдог.

Гэтэл Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Технологи дамжуулах тухай хуулиуд нь тухайн салбарын харилцааг хязгаарлагдмал хүрээнд зохицуулах бөгөөд ойлгомжгүй, тодорхойгүй, системгүй, зохицуулалтгүй орхигдсон зүйл<sup>13</sup>-үүд цөөнгүй байгаагийн нэг нь шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа байна. Шинжлэх ухааны аль салбарт ямар бодлого баримталж, хэрхэн зохицуулж байгааг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудаас олж харах боломж хомс байна.

Мөн 1998 онд УИХ-ын 55 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого”-ийн нийтлэг үндэслэл хэсэгт:

1.1. Монгол Улсын хөгжин дэвших нэг үндэс нь шинжлэх ухаан, технологийн давшингүй хөгжлийг хангах явдал мөн.

1.2. Шинжлэх ухаан, технологийн дэвшил нь эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэх, оюуны баялгийг арвижуулах эх сурвалж, эдийн засгийн аюулгүй байдлын үндэс суурь мөн. Иймээс шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэхэд төрөөс онцгой анхаарал тавина.

1.3. Ажиллах хүч, зах зээл хязгаарлагдмал Монгол Улсын хувьд эдийн засгийн өсөлтийг хангах, хүн амын амьдралын түвшин, чанарыг сайжруулахдаа шинжлэх ухаан, технологийг түлхүү хөгжүүлж, түүний ололтод тулгуурлан дэлхийн зах зээлийн эрэлт, шаардлагад нийцсэн, экспортын зориулалт бүхий, шинжлэх ухааны багтаамж ихтэй бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

1.4. Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын зорилго нь экспортод чиглэсэн зах зээлийн эдийн засагтай, хүмүүнлэг, ардчилсан нийгэм байгуулах, улмаар түүний тогтвортой хөгжлийг хангах зорилгыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болохуйц түвшинд хүртэл нь шинжлэх ухаан, технологийн чадавхийг хөгжүүлэхэд оршино.

гэсэн зорилт тавьсан байна.

Тус бодлогын баримт бичигт:

- шинжлэх ухаан, технологийн бодлогын зарчим,
- бодлогын чиглэл,
- эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх орчин бүрдүүлэх,
- салбарын бүтэц, удирдлагыг боловсронгуй болгох,
- эрдэмтэн, эрдэм шинжилгээний ажилтныг дэмжих,
- гадаад харилцааг хөгжүүлэх гэсэн 7 бүлэг заалт орсноос дээрх зорилтод

нийцүүлэн шинжлэх ухаан, технологийн салбарыг бодитоор хөгжүүлэх, бүтээгдэхүүн үр дүнг зохих салбаруудын хэрэглээнд оруулахад шаардагдах тодорхой зохицуулалт харагдахгүй байх бөгөөд төрөөс шинжлэх ухааны салбарыг хэрхэн дэмжиж, хөгжүүлэх нь мөн л тодорхой тусгагдаагүй байна.

Тухайлбал, бодлогын баримт бичгийн нийтлэг үндэслэлийн 1.2, 1.3 дахь заалтуудыг үндэслэн шинжлэх ухааны ямар салбарыг хэдий хугацаанд төрөөс хэрхэн

<sup>12</sup> “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог сайжруулах аргачлал” ХЗДХЯ, 2010 он 84 дүгээр тушаалын хавсралт

<sup>13</sup> Дүн шинжилгээний хүснэгт 1-ийг үзнэ үү.

дэмжих, төрийн дэмжлэг ямар хэлбэртэй, ямар хүрээтэй байх талаар тодорхой зохицуулалт байхгүй бөгөөд эдгээр баримт бичгийг цаг үе, нөхцөл байдалтайгаа уялдуулан эргэж харах шаардлагатай гэж үзэж байна.

Судалгааны нэгдүгээр хүснэгт 1.1.1-д үзүүлснээр **Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар** ШУА-ийн үйл ажиллагааны хүрээг хуулиар тогтоогоогүй байна. Өөрөөр хэлбэл, ШУА нь шинжлэх ухааны төв байгууллага болохынхоо хувьд шинжлэх ухааны аль салбарт ямар бодлого баримтлах, мөн салбарын эрдэм шинжилгээний ажил, түүний үр дүнг хэрэглэнд оруулах, төрийн бодлого шийдвэр, хууль тогтоомжийн төсөл дэх судалгаа, шинжилгээний ажлын хэрэглээг тогтмолжуулах чиглэлд ямар үйл ажиллагаа эрхлэх талаарх зохицуулалт байхгүй байна.

Тиймээс уг хуулийн 5 дугаар зүйлд заасан Академийн удирдах дээд байгууллага болох Их чуулган, Бага чуулган болон тэдгээрийн хэлэлцэх асуудлаас ШУА-ийн үйл ажиллагааг түүвэрлэн үзэв. Ийнхүү үзэхэд ШУА нь:

- Шинжлэх ухаан, технологийн тодорхой салбар чиглэлийг хөгжүүлэхэд ЗГ-т дэмжлэг үзүүлэх,
- Эдийн засаг, нийгмийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-т өргөн барих,
- Судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх,
- Дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргах,
- Хэвлэлд шилжүүлэх ном, эрдэм шинжилгээний материалыг шүүн хэлэлцэх
- Эрдэмтдийг шагналд тодорхойлох болон ШУА-ийн дотоод бүтэц, зохион байгуулалттай холбоотой бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр хязгаарлагдаж байна.

Мөн Академийн эрх, үүргийг заасан 7 дугаар зүйл (*хүснэгт 1.1.3-ийг үзнэ үү*)-д заасан байдлаас ШУА-ийн үйл ажиллагааг гаргаж харвал дээрхтэй давхцаж байна. Харин 7.1.3-т зааснаар ШУА нь “*улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашидын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах*” гэж заасан нь ШУА-ийн үйл ажиллагааны үндсийг хангасан зохицуулалт болсон бөгөөд энэхүү зохицуулалтыг “үүрэг” болгон оруулахаас илүүтэйгээр үйл ажиллагааны хүрээнд хамруулбал зохистой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл ШУА-ийн үйл ажиллагаа хязгаарлагдмал бөгөөд цаашид шинжлэх ухааны салбарын эрх зүйн байдлын тухай хуулийг хянан үзэх хэрэгцээ шаардлага байгаа бөгөөд хэрэв хянан үзэхээр бол үйл ажиллагааны хүрээг тодорхойлон, түүний хүрээнд субъектүүдийн эрх, үүрэг, бүрэн эрхийн асуудлыг дахин нягталж үзэх нь зүйтэй.

**Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар** шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг тодотгон томъёолсон бөгөөд ингэхдээ эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно гэж заажээ. Үүний хүрээнд:

- *Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа*
- *Эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, сорилт, туршилтын бааз бэхжүүлэх*
- *Эрдэм шинжилгээний ажилтны баталгааг хангах*
- *Хамтын ажиллагаа* гэж ангилж болохоор байна.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд суурь болон хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн төсөл, эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил нь шинжлэх ухааны салбарын үндсэн үйл ажиллагаа гэж үзэхээр байна.

Эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх үйл ажиллагааг тус хуулийн 11.2.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллагын эрдэм шинжилгээний үйл ажиллагааг хамруулан ойлгож болохоор байна.

Эрдэм шинжилгээний ажилтны баталгааг хангах үйл ажиллагааны хүрээнд тус хуулийн 19 болон 21 дүгээр зүйлд ерөнхий зохицуулалт оруулсан байна. Гэтэл эрдэм шинжилгээний ажилтны хамгийн гол баталгаа болох тогтвортой ажлын байрны асуудал тус хуулийн хүрээнд бодлогоор хангагдаагүй гэж үзэж болох юм. Хуулийн хувийн хэргээс

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхэд салбарын эрдэмтдийн өгч байсан саналыг багцалбал:

- ШУА-ийн харьяа байгууллага болох эрдэм шинжилгээний байгууллагын бүтцэд зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз гэх мэтээр шинэ хэлбэрийн байгууллага байгуулах шаардлагагүй, байгууллаа гэхэд тусдаа бие даасан байгууллага байх шаардлагагүй бөгөөд энэ нь сургуулиудын дэргэд байх нь зөв;

- Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын зарчим, бүтэц, бодлого боловсруулж хэрэгжүүлэх арга, хэлбэрийн тухай тодорхой хуульчлах. Монгол Улсын **шинжлэх ухаан, технологийн бодлого** нь үндэсний оюуны болон эдийн засгийн бүтээлч чадавхийг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөх чадвар, үр ашигт маркетингийг төлөвшүүлэх, улс төр, нийгэм, экологи, мэдээлэл, технологийн аюулгүй байдал, тогтвортой хөгжлийг хангах, хувь хүний хангалуун аж амьдрал, боловсролын хэмжээг тууштай сайжруулах, шинжилгээ, боловсруулалтын бүх асуудлаар улс, хувийн хэвшлийнхэн, мөн иргэний нийгмийн бусад субъектүүдийн хүчин чармайлтыг тухайлсан бодлого, ухаалаг менежмент, оновчтой зохицуулалт бүхий эрхэм зорилго, стратеги баримжаалал, онолын концепци байх ёстой. Шинжлэх ухаан, технологийн бодлогын зарчим, хэрэгжүүлэлт, механизм, мониторингийг макро түвшинд томъёолох хэрэгтэй;

- Засгийн газрын дэргэдэх Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөр зөвхөн бодлого, стратеги, прогноз, мастер төлөвлөгөө, шинжлэх ухаан-инновацийн тааламжтай орчин, хүрээ зэрэг макро түвшний асуудлын талаар үнэлгээ, дүгнэлт, санал гаргуулдаг байх нь зохимжтой бөгөөд төсөл, түүний үр дүн нэвтрүүлэлт, байгууллагын тайлан, санхүүжилт зэрэг цаг үеийн болон тактикийн асуудлыг зөвлөлөөр авч хэлэлцэхгүй байх ёстой бөгөөд энэ нь үнэлгээний шат дамжлага цөөрөх сайн талтай;

- Холбогдох хууль тогтоомжууд шинэчлэгдсэн ч эрдэм шинжилгээний ажилтны цалин, орлого, амьжиргааны түвшин доогуур байна.

- ШУТС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашиглах тогтолцоог хуулиар бүрдүүлээгүй;

- ШУТ-ийн төсөл, суурь судалгааны сэдвийн санхүүжилтийг хэлэлцэн шийдвэрлэдэг шат дамжлага ШУТҮЗ, БСШУЯ, яамны ШУТГ, ШУТС, ШУА, салбарын яам, их сургуулийн эрдмийн зөвлөл зэрэг 7 шат дамжлагыг журмын дагуу дамждаг ч эцсийн дүндээ төслийн жагсаалтыг ШУТҮЗ баталж, БСШУЯ-ны ШУТГ шийдвэрлэдэг;

- Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг сайжруулж, ажлын албаны үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тодорхой зохицуулалт шаардлагатай. Учир нь олон тооны ТББ, их дээд сургуулиудын судалгааны төв, институт, зохион бүтээх товчоог олноор байгуулж, шинжлэх ухаан технологийн санхүүжилтийг тарамдуулж, уялдаа холбоог сулруулж, хуулийн үзэл баримтлалын хүн хүч, материал, санхүүгийн нөөцийг тэргүүлэх чиглэлд төвлөрүүлэх гол зорилт хэрэгжихгүйд хүрнэ;

- Эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэгч байгууллагын эрх үүргийг “суурь судалгаа”, “төсөл” боловсруулах, хэрэгжүүлэх дүрэмд тодорхой заасантай хуулийн заалт давхцаж байна зэрэг саналууд гарсан байна. Эдгээр багцалсан саналууд нь Шинжлэх ухаан, технологийн хуульд төдийлөн тусгагдаагүй бөгөөд хуульд тусгагдсан саналуудыг энд дурьдах шаардлагагүй гэж үзэв.

1998 оны 5 дугаар сарын 7-ны өдөр УИХ-аас баталсан **Технологи дамжуулах тухай хуулиар** технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлэх, технологи дамжуулахад тавигдах шаардлага, технологи дамжуулахтай холбоотойгоор технологийн түвшний үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Тиймээс технологи дамжуулах хүрээний үйл ажиллагаа нь тодорхой байна гэж ойлгож болохоор байна.

Хуулийн хувийн хэргээс үзэхэд тус хуулийн танилцуулгад “Эх орны байгалийн баялаг, үндсэн түүхий эдийг гүнзгий боловсруулах, экспортын чиглэлтэй үйлдвэр бий болгож, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар Монгол

Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах шаардлага тулгарч байна. Энэ зорилтыг шийдвэрлэхэд дэвшилтэт технологийг ашиглах, шинээр аж үйлдвэржсэн орнуудын хуримтлуулсан туршлагыг өөрийн орны нөхцөлд тохируулан хэрэглэх нь ихээхэн ач холбогдолтой юм...<sup>14</sup>” гэж хуулийн зорилтыг тодорхойлсон бөгөөд энэхүү зорилтын хүрээнд технологи дамжуулах үйл ажиллагааны үндэс болсон дараахь асуудлыг тусгажээ. Үүнд:

- 1) Технологи дамжуулах үйл ажиллагааны талаар төрөөс баримтлах бодлогын зарчим.
- 2) Технологийн түвшний үнэлгээ хийх журам, үнэ төлбөрийг тодорхойлох.
- 3) Дамжуулах технологид хамаарах зүйл, тавих үндсэн шаардлага, технологи дамжуулах талаарх Засгийн газрын болон шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх, технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг.
- 4) Технологи дамжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гэрээ байгуулахтай холбогдсон зарчмын асуудлууд<sup>15</sup>-ыг тусгасан байна.

2012 онд Инновацийн тухай хууль батлагдсантай холбоотойгоор Технологи дамжуулах тухай хуулийг хянан үзэх шаардлагатай гэж үзлээ.

**Инновацийн тухай хуулиар** шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхтэй холбоотойгоор:

- Инновацийн үйл ажиллагааны төрийн дэмжлэг,
- Холбогдох байгууллагуудын эрх мэдэл,
- Шинжлэх ухааны парк байгуулах, паркийн үйл ажиллагаа,
- Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулж байна.

Инновацийн гол үйл ажиллагаа болох инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дэд бүтэц болох гарааны компани, менежментийн компани, шинжлэх ухааны паркийн эрх зүйн үндсийг тогтоон өгч, мөн инновацийн тэргүүлэх чиглэлийг хэрхэн тогтоох тогтолцоог хуульчилсан зэрэг нь тус үйл ажиллагааг нэгдсэн бодлого, системтэй болоход дөхөмтэй сайн зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна. Мөн инновацийн үйл ажиллагааны төрийн дэмжлэгийн хэлбэрийг нэг бүрчлэн тодорхойлсон нь сайн хэрэг ч зах зээл дэх инновацийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих татварын бодлого дутагдаж байгаа тал байна. Тухайлбал инновацийн бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлт үзүүлж, ижил төсөөтэй импортын бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг нэмэх зэрэг баталгааг хуулиар зохицуулах боломжийг судалж үзэх шаардлага байна.

<sup>14</sup> “Технологи дамжуулах тухай Монгол Улсын хуулийн хувийн хэрэг” архивын материал. УИХ-ын Тамгын газрын архив. №1883, ХН№108. УБ., 1998.

<sup>15</sup> Мөн тэнд.

## Хүснэгт 1.1.1: Үйл ажиллагаа

ХУУЛЬ ТОГТООМЖ			
№	Хуулийн нэр	Үйл ажиллагаа	Тайлбар
1	<i>Шинжлэх ухаан академийн эрх зүйн байдлын тухай</i>	<p>§2. Шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх...</p> <p><b>§5.3.Их чуулган нь:</b></p> <p>5.3.1 шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, эрдэм шинжилгээний төсөлт ажлын үр дүн, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга зам, тус улсад шинжлэх ухаан, технологийн тодорхой салбар чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх;</p> <p>5.3.2 Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих;</p> <p>5.3.3 академийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж Засгийн газраар батлуулах;</p> <p>5.3.4 академийн гишүүдийг сонгох;</p> <p>5.3.5 академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон эрдэмтэн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаагаар сонгох;</p> <p>5.3.6 академийн ерөнхийлөгчид эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа академийн гишүүнийг буюу докторын зэрэгтэй эрдэмтнийг нэр дэвшүүлж Их чуулганаас сонгоно.</p> <p><b>§5.5.Бага чуулган нь:</b></p> <p>5.5.1/ тухайн салбарын чиглэлээр хийж байгаа судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх;</p> <p>5.5.2/ эрдэм шинжилгээний дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад шилжүүлэх;</p> <p>5.5.3/ салбарын шинжлэх ухааны хэвлэл, бүтээл, хэвлэлд шилжүүлэх ном, эрдэм шинжилгээний материалыг шүүн хэлэлцэж дүгнэлт гаргах;</p> <p>5.5.4/ эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх талаар санал гаргах;</p> <p>5.5.5/ салбарын чиглэлийн эрдэмтдээс Академийн гишүүнд нэр дэвшүүлэх;</p> <p>5.5.6/ эрдэмтдийг шагнал, урамшилд тодорхойлох;</p> <p>5.5.7/ бусад асуудал</p>	<p>Тус хуулийн 5 дугаар зүйлд ШУА-ийн эрх барих дээд байгууллага, түүний хэлэлцэх асуудлыг хуульчилсан. Энэ хуулийн зохицуулалтаас үзэхэд ШУА-ийн үйл ажиллагаа нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>■ ЗГ-т дэмжлэг үзүүлэх,</li> <li>■ Эдийн засаг, нийгмийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах,</li> <li>■ Судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх,</li> <li>■ Дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргах,</li> <li>■ Хэвлэлд шилжүүлэх ном, эрдэм шинжилгээний материалыг шүүн хэлэлцэхээр хязгарлагдаж байна.</li> </ul>
2	<i>Технологи дамжуулах тухай</i>	<p>§3.1.2. “технологи дамжуулах” гэж технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад иргэн, хуулийн этгээдэд гэрээний үндсэн дээр шилжүүлэх үйл ажиллагааны цогцолборыг ойлгоно.</p> <p>§8.1. Дамжуулах технологид дараахь зүйл хамаарна:</p> <p>8.1.1. технологийн горим, үйл ажиллагааны нөхцөл;</p> <p>8.1.2. технологийн шат дамжлагын дэс дараалал, горим, бүрдэл хэсгийн талаархи зөвлөгөө, үйлчилгээ;</p> <p>8.1.3. технологи нэвтрүүлэхэд шаардагдах техник, тоног төхөөрөмж;</p> <p>8.1.4. шинжлэх ухаан, технологийн судалгаа шинжилгээний үр дүн;</p> <p>8.1.5. патент, лиценз, бүтээгдэхүүний загвар;</p> <p>8.1.6. ноу-хау.</p>	<p>Энэ хуулиар:</p> <ul style="list-style-type: none"> <li>■ технологи эзэмшигч өөрийн технологийг ашиглах эрхийг бусад шилжүүлэх</li> </ul>

		<p>§7.1. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ашиглаж байгаа технологийнх нь улмаас хүний эрүүл мэнд, мал амьтан, байгаль орчинд хохирол учруулбал, эсхүл тухайн чиглэлийн технологи дамжуулахыг хянаж байхаар Засгийн газар хоорондын болон Монгол Улсын нэгдсэн бусад олон улсын гэрээ хэлэлцээрт заасан бол уг технологид төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан эрдэм шинжилгээний байгууллагаар үнэлгээ хийлгүүлнэ.</p> <p><b>§7.3. Эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага технологийн түвшинг үнэлэхдээ дараахь үзүүлэлтийг харгалзана:</b></p> <p>7.3.1. технологийн техникийн үндсэн үзүүлэлтүүдийг ижил төрлийн технологийн харгалзах үзүүлэлтүүдтэй харьцуулан тогтоосон үнэлэлт;</p> <p>7.3.2. технологийг ашигласнаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал, амьтан, үйлдвэрлэлийн нөхцөлд үзүүлж болох эерэг, сөрөг болзошгүй нөлөөлөл, сөрөг үр дагаврыг бууруулах зөвлөмж;</p> <p>7.3.3. технологийг ашигласны эдийн засгийн үзүүлэлтүүд;</p> <p>7.3.6. бүтээгдэхүүний стандарт, чанар, аюулгүй байдлын үзүүлэлт;</p> <p>7.3.5. технологийг ашиглахад шаардагдах мэргэжилтний хүрэлцээ хангамж;</p> <p>7.3.6. тухайн технологийн онцлогтой холбогдох бусад үзүүлэлт.</p>	
3	<p><b>Шинжлэх ухаан технологийн тухай хууль</b></p>	<p><b>“Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа”</b> гэж эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэх цогцолбор арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор шинэ болон нэмэлт мэдлэг, шинэ арга бий болгох, хэрэглэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг ойлгоно <b>§3.1.2</b></p> <p><b>Суурь судалгаа §3.1.3</b></p> <p>“Суурь судалгаа” гэж хүн, нийгэм, хүрээлэн байгаа орчны хөгжлийн үндсэн зүй тогтлын талаар шинэ мэдлэг бий болгоход чиглэсэн туршилтын болон онолын үйл ажиллагааг</p> <p><b>Хавсарга судалгаа §3.1.4</b></p> <p>“Хавсарга судалгаа” гэж шинэ мэдлэгийг ашиглахад чиглэсэн судалгаа, туршилтын ажлыг;</p> <p><b>Шинжлэх ухаан технологийн төсөл §3.1.8</b></p> <p>“Шинжлэх ухаан, технологийн төсөл” гэж эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг онол, арга зүйн өндөр түвшинд явуулж, захиалагчийн хэрэгцээ, шаардлагыг хангасан үр дүн бий болгох, түүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглах үйл ажиллагааг төлөвлөсөн баримт бичгийг</p> <p><b>Эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх §23.2</b></p> <p><b>Эрдэм шинжилгээний ажлын сорилт, туршилтын бааз бэхжүүлэх §23.2</b></p> <p><b>Хамтын ажиллагаа §23.3</b></p>	<p>Шинжлэх ухаан технологийн хуулинд хуулийн зорилгыг явцуу хүрээнд тодорхойлсон бөгөөд тус зорилгын дагуу тухайн хуулиар зохицуулагдах үйл ажиллагааг хязгаарлагдмал хүрээнд хуульчилсан байна.</p>
4	<p><b>Инновацийн тухай хууль</b></p>	<p><b>“Инновацийн үйл ажиллагаа”</b> гэж шинэ санаа, шинэ мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн, технологи, ажил, үйлчилгээг бий болгож зах зээлд нийлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг ойлгоно. <b>§3.1.3.</b></p> <p><b>Паркийн үйл ажиллагаа §21</b></p> <p>21.1. Паркийн нутаг дэвсгэрт дараах чиглэлийн үйл ажиллагаа явуулна:</p> <p>21.1.1. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулах, дэвшилтэт техник, технологийг дамжуулах;</p> <p>21.1.2. инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл;</p> <p>21.1.3. сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн сүлжээ бий болгох;</p> <p>21.1.4. нийгмийн суурь үйлчилгээ, хот төлөвлөлт, газар зохион байгуулалтыг тухайн бүс, орон нутгийн чадавхид түшиглэн цогцолбороор байгуулах;</p> <p>21.1.5. агуулах, тээвэрлэлт, логистикийн үйлчилгээ үзүүлэх;</p>	<p>Хуулийн 3.1.3-т зааснаар инновацийн үйл ажиллагаатай холбогдон харилцааг энэ хуулиар зохицуулах бөгөөд үйл ажиллагаа нь бусад хуультай харьцуулахад харьцангуй ойлгомжтой, нарийвчлалтай тодорхойлогдсон байна.</p>

	<p>21.1.6. паркийн нутаг дэвсгэрт хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх.</p> <p>21.3. Паркад Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.</p> <p><b>Инновацийн үйл ажиллагаанд оролцогчийн олон улсын хамтын ажиллагаа §28</b></p> <p>28.1. Инновацийн үйл ажиллагаанд оролцогчийн олон улсын хамтын ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд хэрэгжинэ.</p> <p>28.2. Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улс, тэдгээрийн байгууллага, хуулийн этгээд, иргэн Монгол Улсын нутаг дэвсгэрт инновацийн төсөл хэрэгжүүлэхээр хамтарсан компани байгуулж болно.</p> <p>28.3. Инновацийн үйл ажиллагаанд оролцогч нь инновацийн олон улсын байгууллагуудад бие даан гишүүнээр элсэн орох, олон улсын инновацийн төслүүдэд оролцох, гэрээ хэлэлцээр байгуулах эрхтэй.</p>	
--	--	--

## Хоёр. Эрх зүйн байдал

Юуны өмнө “*эрх зүйн байдал*” гэдэг нь эрх зүйн хэм хэмжээгээр тогтоосон субъектын эрх ба үүргийн цогц<sup>16</sup> гэж эрх зүйн тайлбар тольд тодорхойлсон байдаг.

Энэхүү судалгааны хүснэгт 1.1.2-т тус салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулах субъектын эрх зүйн байдал болон байгууллагын бүтэц, зохион байгуулах хэлбэрийн харьцуулалтыг оруулав. Мөн эдгээр байгууллагын бүрэн эрх, эрх, үүргийг хүснэгт 1.1.3-аар үзүүлэв (*хүснэгтээр харуулсан дүн шинжилгээг хойноос үзнэ үү*).

Холбогдох хуулиудын зохицуулалтаас үзэхэд шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаанд оролцогчдыг эрх зүйн байдлаар нь дараахь ерөнхий төрөлд багцалж болохоор байна. Үүнд:



### Удирдлагын буюу Захиргааны байгууллага гэдэгт:

1. Засгийн газар
2. Төрийн захиргааны төв байгууллагууд (яамд)
3. Яамны шинжлэх ухаан, технологийн зөвлөл
4. Агентлаг
5. Нутгийн захиргааны байгууллага (засаг дарга)

### Мэргэжлийн оролцогчид гэдэгт:

1. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл
2. Шинжлэх ухааны академи, түүний бүтцийн байгууллагууд
  - ▶ Ерөнхийлөгч
  - ▶ Их чуулган
  - ▶ Бага чуулган
  - ▶ Тэргүүлэгчид (Дэд ерөнхийлөгч, ЕНБД, Тэргүүлэгч гишүүд)
  - ▶ Тэргүүлэгчдийн ажлын алба
3. Эрдэм шинжилгээний байгууллагууд:
  - ▶ Хүрээлэн
  - ▶ Төв
  - ▶ Лаборатори
  - ▶ Зохион бүтээх товчоо
  - ▶ Туришлт, үйлдвэрлэл, үйлчилгээний бааз
  - ▶ Төрөлжсөн академи
4. Эрдэм шинжилгээний зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага, их, дээд сургууль
5. Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл

<sup>16</sup> С.Нарангэрэл. “Монголын эрх зүйн эх толь бичиг” дөрөв дэх хэвлэл. 2015.,УБ., 660 дахь тал.

6. Улсын музей, орон нутгийн музей, үндэсний номын сан
7. Эрдмийн Зөвлөл
8. Шинжлэх ухааны парк

**Бусад оролцогчид:**

1. Төрийн бус өмчийн шинжлэх ухааны академи
2. Шинжлэх ухаан, технологийн сан
3. Иргэн
4. Аж ахуйн нэгж
5. Байгууллага гэсэн үндсэн оролцогчид шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд өөр өөрийн бүрэн эрх, эрх, үүргийн дагуу оролцож байна.

Эдгээр байгууллагуудаас **“шинжлэх ухаан, технологийн сан”** гэх субъект нь Засгийн газрын 1993 оны 192 дугаар тогтоолын хавсралтаар баталсан дүрмийн дагуу *“Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын дагуу тодорхойлсон төслийг санхүүжүүлэхэд зориулсан хөрөнгийн эх үүсвэрийг Шинжлэх ухаан, технологийн сан /цаашид "сан" гэнэ/ гэнэ”* гэснээс үзэхэд эрх зүйн байдлын хувьд төрийн бус байгууллага байх бөгөөд бүтэц, зохион байгуулалт нь тодорхойгүй байна.


Мэргэжлийн оролцогчдын хувьд гол байгууллага болох ШУА-ийн эрх зүйн байдлыг Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулсан бөгөөд тус хуулийг 1996 онд баталж, 2006 онд дөрөвдүгээр зүйлд заасан Академийн харьяа байгууллагын тухай заалтад нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Тус хуульд *“Шинжлэх ухааны академи /цаашид ШУА гэх/ нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн. Академи нь төрийн ивээлд байна”* гэж эрх зүйн статусыг нь тодорхойлжээ.

Эрх зүйн тайлбар толь бичгийг шүүн үзэхэд **“төв байгууллага”** гэх нэр томъёог тайлбарласан тохиолдол үгүй бөгөөд мөн **“төрийн ивээлд байна”** гэх зохицуулалтын агуулга нь тодорхойгүй, тунхагийн шинжтэй байна. Иймд төрийн аль субъект, ямар чиглэлд хэрхэн ивээхийг тодорхой хуульчлах шаардлага байгаа бөгөөд ингэснээр шинжлэх ухааны салбарын алсын хараа, эрхэм зорилго, түүнд хүрэх зорилтууд, түүний хүрээнд хийгдэх үйл ажиллагааны цар хүрээ илүү тодорхой, нарийн чигтэй болж улмаар салбарын хууль тогтоомжуудыг батлахад боловсруулж байсан үзэл баримтлал<sup>17</sup> дахь зорилго бодитоор хангагдах боломж бүрдэхээр байна.

<sup>17</sup> Шинжлэх ухаан, технологийн сангийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг хавсралт2-оор хавсаргав.

ШУА-ийн хуулиар тогтоосон бүтцийн бүдүүвчийг гаргавал удирдах дээд байгууллага болон харьяа байгууллагуудаас бүрдэх бөгөөд түүнд Засгийн газрын оролцоог доорх схемээр үзүүлэв.

Схем 1: ШУА-ийн бүтэц<sup>18</sup> түүнд Засгийн газрын оролцоо



ШУА-ийн статус болох “*шинжлэх ухааны төв байгууллага*” гэх нэр томъёог тодруулах үүднээс Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулиудын холбогдох заалтуудыг авч үзэв. Үүнд:

- ▶ Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д “*Яам нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мөн*” гэж;
- ▶ Засгийн газрын агентлагын эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1-д “*Агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн*”

гэж зааснаас үзэхэд “*шинжлэх ухааны төв байгууллага гэж шинжлэх ухааны үйл ажиллагааны зохих хүрээ, тодорхой чиг үүргийг дагнан эрхэлсэн байгууллага*” гэж ойлгохоор байх бөгөөд захиргааны байгууллагын бүрэн эрхийг эдлэхгүй байх тул эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулсан хуультай онцгой статус бүхий байгууллага гэж ойлгогдохоор байна.

Хэдий тийм боловч энд статусыг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай **харьяаллын асуудал, төсөв санхүүгийн удирдлага, менежментийн зарчмууд тодорхой бус байна. Хуулиар ШУА-ийг зөвхөн “зөвлөмж гаргах”, “зөвлөх эрхтэй оролцох” гэх мэтчилэн** идэвхгүй үйл ажиллагаатай байхаар хуульчилсан байгаа нь шинжлэх ухааны

<sup>18</sup> Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль, 1996 он


талаар төрөөс баримтлах бодлого, түүний хэрэгжилтэд зарим ойлгомжгүй байдлыг үүсгэж, шинжлэх ухааны хөгжилд ч сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Судалгааны мэдээлэлд тулгуурласан хүснэгтэд (*хүснэгт 1.1.3-ыг үзнэ үү*) байгаа шинжлэх ухааны салбарын эрх, үүрэг болон үйл ажиллагаанаас үзвэл ШУА-ийн эрх хэмжээ хумигдмал, үйл ажиллагааны төрөл, цар хүрээ явцуу байх бөгөөд энэ нь төрийн бодлого, шийдвэр гаргах үйл явц дахь шинжлэх ухааны бүтээгдэхүүний хэрэглээ сул, улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрүүдэд тус салбарын оролцоо бага байх зэрэг бусад сөрөг үр дагаварт хүргэж болох талтай юм.

Энэ бүхнээс үндэслэн ШУА нь “шинжлэх ухааны төв байгууллага мөн” гэсэн статусыг тодорхой болгож “**ШУА бол шинжлэх ухааны төрийн төв байгууллага мөн**” хэмээн зааж, түүний үндсэн чиг үүрэгт “**иргэдийг соён гэгээрүүлэх, төрийн төв байгууллагад шинжлэх ухааны мэдээллээр үйлчлэх**” гэж оруулж болох юм.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар эрдэм шинжилгээний байгууллагыг дараахь байдлаар тодорхойлсон байна.

Схем 2: ШУТ тухай хуулиар тогтоосон оролцогчид



## Хүснэгт 1.1.2: Шинжлэх ухааны салбарын оролцогчид, тэдгээрийн эрх зүйн байдал

ХУУЛЬ ТОГТООМЖ <sup>19</sup>					
№	Хуулийн нэр	Хуулиар тогтоосон субъект түүний эрх зүйн байдал (удирдлагын болон мэргэжлийн оролцогч)	Бүтэц	Зохион байгуулалт	Дүгнэлт, Тайлбар
1	Монгол Улсын Үндсэн хууль Батлагдсан: 1992.01.13				Эрх зүйн аливаа тайлбар тольд “Төрийн хамгаалалтад байна” гэх нэр томъёоны тайлбар байхгүй байх бөгөөд хэн, ямар түвшинд хэрхэн хамгаалах нь тодорхойгүй байна.
2	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль Батлагдсан: 1996.05.23	Шинжлэх ухааны академи §2 ШУА нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн.	ШУА-ийн бүтэц: -Академийн гишүүд §3.2 Харьяа байгууллага §4: -Эрдэм шинжилгээний хүрээлэн, -Төв, -Лаборатори, -Бусад нэгж ажиллуулж болно. §4.1 -ШУ-ны тодорхой салбараар төрөлжсөн академи өөрийн бүтцэд байгуулж болно. §4.2	-ШУА нь өөрийн орны нэрд гарсан эрдэмтдээс шинжлэх ухааны салбарыг төлөөлүүлэн сонгосон гишүүдээс бүрдэнэ. §3.1 -Академийн гишүүдийн тооны дээд хязгаарыг 3Г тогтооно. §3.4 -Академи, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийн журмыг Засгийн газар тогтооно. §10.2	ШУАЭБТ хуулиар шинжлэх ухааны салбарын гол оролцогч болох 11 субъектыг хуульчлан тогтоосон. ШУА-ийн эрх зүйн байдлыг шинжлэх ухааны салбарын төв байгууллага гэж тодорхойлсон бөгөөд

<sup>19</sup> Судалгааны ажлын хүрээнд:

- Дээд боловсролын тухай хууль,
- Дээд боловсролын санхүүжилт, суралцагчийн нийгмийн баталгааны тухай хууль,
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль,
- Патентын тухай хуулиудыг анхны түүвэрлэлтээр авч үзсэн боловч хуулийн зорилго, хуулийн хамрах хүрээтэй холбоотойгоор энэхүү судалгаанд нарийвчлан судлаагүй бөгөөд шинжлэх ухааны салбар дахь зохиогчийн эрхийг хамгаалах харилцааны хүрээнд холбогдох хуулиудыг товчхон авч үзэхийг анхаарна уу.

<p><i>Нэмэлт орсон:</i> 2006.12.28</p>	<p>Академи нь <b>төрийн ивээлд</b> байна.</p> <p><b>1.Харьяа байгууллага §4</b></p> <p><b>2. Удирдах дээд байгууллага §5.1</b></p>	<p><u>Удирдах дээд байгууллага §5.1:</u> а. Академийн бүх гишүүдийн чуулган /цаашид “<b>Их Чуулган</b>” гэх/ б. Академи нь шинжлэх ухааны салбараар Бага чуулган /цаашид “<b>Бага Чуулган</b>” гэх/-тай байж болно. в. <b>Академийн ерөнхийлөгч нь</b> МУ-ын Ерөнхий сайдын шинжлэх ухааны зөвлөх байна. <b>§5.4</b> г. <b>Академийн Тэргүүлэгчид</b> нь ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, ЭНБД, Тэргүүлэгч гишүүдээс бүрдэнэ. Дэд ерөнхийлөгч, тэргүүлэгч гишүүний тоог Их чуулган тогтооно. <b>§6.2</b> -Их чуулганы чөлөөт цагт түүний өдөр тутмын үйл ажиллагааг Академийн тэргүүлэгчид удирдана. -Тэргүүлэгчид <b>ажлын албатай</b> байх бөгөөд түүний бүтэц орон тооны хязгаарыг Засгийн газар тогтооно. <b>§6.3</b></p>	<p><b>Их чуулган нь:</b> -Академийн гишүүдийг сонгох <b>§5.3.4</b> -Академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон эрдэмтэн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаагаар сонгох <b>§5.3.5</b> - Академийн ерөнхийлөгчийг МУ-ын Ерөнхий сайд батламжилна. Хэрэв батламжлаагүй бол дахин сонгууль явуулна. <b>§5.4</b> -Их чуулганы чөлөөт цагт түүний өдөр тутмын үйл ажиллагааг Академийн тэргүүлэгчид удирдана. <b>§6.1</b> Дэд ерөнхийлөгч, тэргүүлэгч гишүүний тоог Их чуулган тогтооно.</p>	<p>Ерөнхийлөгч нь ЕС-ын зөвлөхийн статустай байхаар заасан ч УИХ-ын байнгын хороонд ажлаа хариуцан тайлагнадаг, хуулиар тогтоосон чиг үүрэг, эрх үүрэг зэргээс үзэхэд эрх зүйн байдал ойлгомжгүй байна.</p> <p><b>НИЙТ: Нэр дурдсан 11 субъектыг энэ хуулиар тогтоосон байна.</b></p>
<p><b>3</b></p>	<p><b>Технологи дамжуулах тухай хууль</b></p>	<p>1.Засгийн газар 2.Яам 3.Оролцогчид</p>	<p>Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч: -Иргэн -Аж ахуйн нэгж -Байгууллага -эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага</p>	<p>-</p> <p>Хуулиар оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой заагаагүй байгаа нь тус хуулийн хийдлийг харуулж байна.</p>
<p><b>4</b></p> <p><b>Шинжлэх ухаан технологийн тухай хууль</b></p> <p><i>Шинэчлэн найруулсан:</i> 2006.12.28</p>	<p>Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлага</p>	<p><b>Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо: §5.1</b> - Засгийн газар; - Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл; - Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; -Монгол Улсын Шинжлэх ухааны академи;</p>	<p>9.2.Яамны ШУТЭ<sup>20</sup> бүрэлдэхүүн, дүрмийг тухайн асуудлыг эрхэлсэн ЗГ-ын гишүүн батлах ба <b>Зөвлөлийг сайд толгойлно.</b> <u>Эрдэм шинжилгээний байгууллага:</u> -Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ЭШБ<sup>21</sup> нь зохион</p>	<p>Удирдах 6 байгууллага, Эрдэм шинжилгээний байгууллага 11, нийт 17 байгууллага байна. Хуулийн зохицуулалтаас үзэхэд ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль болон Технологи</p>

<sup>20</sup> Шинжлэх ухаан технологийн зөвлөл

<sup>21</sup> Эрдэм шинжилгээний байгууллага

	<p>Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг дагнан болон сургалт, үйлдвэрлэлтэй хослон гүйцэтгэдэг хуулийн этгээдийг <b>эрдэм шинжилгээний байгууллага</b> гэнэ. <b>§11.1.</b></p>	<p>-Эрдэм шинжилгээний байгууллагын өөрийн удирдлагын байгууллага. -Монгол Улсын <b>яам шинжлэх ухаан, технологийн зөвлөлтэй</b> байж болно. <b>§5.2</b></p> <p><b>Эрдэм шинжилгээний байгууллагыг дор дурдсан хэлбэрээр</b> байгуулж болно: <b>§11.2.</b></p> <p>-Хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз; <b>§11.2.1.</b></p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамаарах дээд боловсролын байгууллага; <b>§11.2.2.</b></p> <p>-Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл; <b>§11.2.3.</b></p> <p>-Улсын болон орон нутгийн музей, үндэсний номын сан. <b>§11.2.4.</b></p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн эрхэлсэн салбарын эрдэмтэн, мэргэжилтнийг оролцуулсан судалгаа, шинжилгээний ажлын чиглэл болон хэрэгжүүлж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий <b>Эрдмийн зөвлөл</b> байгуулан ажиллуулна. <b>§11.3</b></p> <p>-Монгол Улсын нутаг дэвсгэрт судалгаа, шинжилгээний ажил эрхэлдэг, <b>төрийн бус өмчийн шинжлэх ухааны академийн</b> үйл ажиллагааг <b>Төрийн бус байгууллагын тухай хуулиар</b> зохицуулна. <b>§10.2.</b></p>	<p>байгуулалтын бүтцээ өөрөө тогтооно. <b>§11.4.</b></p> <p>-Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ЭШБ-ыг ЗГ үүсгэн байгуулна. <b>§12.1.1.</b></p> <p>-Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг ЗГ батална. <b>§7.3.</b></p> <p>-Зөвлөлийн бүрэлдэхүүнд ЗГ, ШУА, их сургуулиуд, хувийн хэвшлийн ЭШБ, бизнесийн төлөөллийг оролцуулах бөгөөд орон тооны НБД<sup>22</sup>-тай байна. <b>§7.4.</b></p> <p>-Төрийн бус өмчийн ЭШБ-ыг холбогдох хуульд заасан журмын дагуу <b>үүсгэн байгуулагч</b> нь үүсгэн байгуулна. <b>§12.1.2.</b></p> <p>-ЭШБ-ыг ... <b>ХЭУБТ</b><sup>23</sup> хуульд заасан журмын дагуу ... бүртгэнэ. <b>§12.2.</b></p> <p>-ЭШБ-ыг өөрчлөн байгуулах /нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх/ асуудлыг үүсгэн байгуулагч нь шийдвэрлэнэ. <b>§12.3.</b></p> <p>12.4.ЭШБ-ыг Иргэний хуулийн 32.1-д заасан үндэслэлээр татан буулгана.</p> <p>12.5.ЭШБ-д төрийн өмчийн төлөөлөл ажиллуулах, төрийн өмчид хяналт тавихтай холбогдсон харилцааг ТБОНӨТ<sup>24</sup> хуулиар...</p>	<p>дамжуулах тухай хуулиудын зохицуулалттай харьцуулахад эрх зүйн байдал нь харьцангуй ойлгомжтой.</p> <p><b>Хийдэл:</b> Шинжлэх ухааны технологийн Үндэсний зөвлөлийн бүтэц зохион байгуулалтыг хуулиар тодорхой заагаагүй боловч Засгийн газар<sup>25</sup> болон холбогдох яамны дэргэд сайдын тушаалаар байгуулагдаж байна. Засгийн газрын тогтоол, сайдын тушаалаар батлагдсан дүрмүүдээс үзэхэд ШУТЗөвлөлийн үйл ажиллагаа идэвхгүй, саармаг түвшинд байна. ШУТСангийн эрх зүйн байдлыг мөн хуулиар огт зохицуулалгүй орхигдуулсан байна.</p>
--	---	--	--	---

<sup>22</sup> Нарийн бичгийн дарга

<sup>23</sup> Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль

<sup>24</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

<sup>25</sup> [http://www.ipt.ac.mn/old/index.php?option=com\\_content&view=article&id=25:2014-06-27-03-37-17&catid=26&lang=mn&Itemid=124](http://www.ipt.ac.mn/old/index.php?option=com_content&view=article&id=25:2014-06-27-03-37-17&catid=26&lang=mn&Itemid=124)

5	<b>Инновацийн тухай хууль</b>	<p>-Инновацийн үйл ажиллагааны удирдлага <b>§5.1.</b></p> <p>-Шинжлэх ухааны парк <b>§18.1.</b></p> <p>-<b>Үндэсний инновацийн тогтолцоо</b> гэж инновацийн үйл ажиллагаанд оролцогч <b>өмчийн бүх хэлбэрийн байгууллага,</b> тэдгээрийн харилцааны хэм хэмжээний цогц <b>§3.1.5</b></p>	<p><b>Инновацийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоо нь:</b></p> <p>-Засгийн газар, -Яам, -Агентлаг, -Шинжлэх ухаан, технологийн үндэсний Зөвлөл, -Нутгийн захиргааны байгууллагаас бүрдэнэ. <b>§5.1.</b></p> <p>“<b>Шинжлэх ухааны парк</b>” /цаашид “парк” гэж/ гэж өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилгоор энэ хуулиар тогтоосон чиг үүргийг хэрэгжүүлэх тусгайлсан газар нутагтай, үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгмийн дэд бүтэц бүхий цогцолбор <b>§3.1.14</b></p> <p>-“<b>Паркийн удирдлага</b>” гэж паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлөөр хангах чиг үүрэгтэй хуулийн этгээд <b>§3.1.15</b></p> <p>-“<b>Паркийн нэгж</b>” гэж паркийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага болон сургууль, эмнэлэг, харилцаа холбоо, эрчим хүчний зэрэг нийтлэг үйлчилгээ үзүүлдэг байгууллага байна. <b>§3.1.16</b></p>	<p>Паркийг дараах зорилгоор байгуулна: <b>§18.1.</b></p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгжүүд хамтран инновацийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах орчин, дэд бүтцийг бүрдүүлэх;</p> <p>-Импортыг орлох болон экспортод чиглэсэн өндөр технологи, инновацийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд шаардагдах санхүүгийн олон талт эх үүсвэр, өндөр ур чадвартай мэргэшсэн хүний нөөц, дэд бүтцээр хангах, үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх;</p> <p>-Инновацийн үйл ажиллагаанд тулгуурлан бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэх, эдийн засгийн төрөлжилтийг бий болгох.</p> <p>-Паркийн оноосон нэрэнд “шинжлэх ухааны парк” гэсэн үгийг заавал хэрэглэх бөгөөд бусад хуулийн этгээдийн нэрэнд энэхүү үгийг хэрэглэхийг хориглоно.</p>	<p>Инновацийн тухай хуулиар инновацийн үйл ажиллагаанд оролцогч ерөнхий 7 төрлийн субъектыг хуульчилж өгсөн бөгөөд үүнээс удирдлагын тогтолцооны оролцоо ойлгомжтой байна.</p> <p><b>Хийдэл:</b> Харин үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага гэдэгт ямар ямар хуулийн этгээд ямар статустай оролцохыг хуулинд тодорхой заагаагүй байна.</p>
---	-------------------------------	--	--	---	--

## Гурав. Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалт

**Бүрэн эрх** (*лат. auctoritas; англ. authority, power; ор. полномочие*) - ...2. эрх зүйн онол, удирдлагын шинжлэх ухаан, түүнчлэн бараг бүх салбар эрх зүйд бүрэн эрхийг байгууллага, албан тушаал, аж ахуйн нэгжид удирдлагын чиг үүрэг гүйцэтгэж буй этгээд түүнчлэн хууль тогтоомж буюу хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт заасан чиг үүргийг хэрэгжүүлж буй зарим этгээдийн эрх хэмжээ ба эрх зүйн байдлын бүрэлдэхүүн хэсэг гэж үздэг. Энэ утгаараа бүрэн эрх нь хууль буюу эрх зүйн актад заасан тодорхой нөхцөл байдалд холбогдох субъектын ажиллах эрх ба үүрэг болдог.

Шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжоор хуульчилсан байгууллагуудын эрх, үүргийг харьцуулан судлах нь нэг талаас тэдгээрийн эрх зүйн байдлыг тодруулах нөгөө талаас шинжлэх ухааны салбарууд дахь оролцогчийн эрх, үүрэг давхардаж байгаа эсэхийг судлан тогтооход ач холбогдолтой юм.

Юуны өмнө эдгээр хуулийн зохицуулалтаас үзэхэд шинжлэх ухааны салбар дахь захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг нарийвчлан хуульчилсан боловч мэргэжлийн байгууллагуудын бүрэн эрх, эрх, үүргийг хангалттай хуульчилж өгөөгүй байна. Эрх мэдлийн хуваарилалтаас үзэхэд шинжлэх ухааны салбар дахь захиргааны байгууллагуудын оролцоо хэтэрхий их, харин мэргэжлийн байгууллагын оролцоо, эрх үүрэг хумигдмал байгаа нь тус салбарын хөгжилд бэрхшээл учруулж байгаа байдал ажиглагдаж байна.

Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалтыг салбарын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан байдлаас үзэхэд юуны өмнө оролцогчдын эрх, үүргийг хуульчлахдаа захиргааны байгууллагууд болох Засгийн газар, яам, яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөл, ШУ-ны Паркийн удирдлагын “бүрэн эрх”, ШУА болон бусад ЭШБ-ын “эрх”, “үүрэг”, ШУ-ны Паркийн “чиг үүрэг” гэх нэр томъёог ашигласан нь эрх зүйн статусыг тодотгож байна. Нөгөө талаас ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д заасан ШУА-ийн үүрэг гэдэгт бүрэн эрхийн шинжтэй заалтуудыг оруулсан нь хууль хэрэглэх шатанд зөрчил үүсгэх үндэслэл болж болохоор байгааг анхаарах шаардлагатай.

Хүснэгт 1.13-аас үзэхэд эрх, үүргийг “нарийвчлан хуульчилсан”, “дутагдалтай хуульчилсан”, “хангалтгүй хуульчилсан”, “хуульчлаагүй” гэж ангилж болохоор байна. Үүнд:

### Нарийвчлан хуульчилсан:

- Шинжлэх ухаан, технологийн хуулиар удирдлагын тогтолцооны байгууллагуудын бүрэн эрх болон эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч, гүйцэтгэгчийн эрх, үүргийг нарийвчлан зохицуулсан.
- Инновацийн тухай хуулиар мөн удирдлагын тогтолцооны байгууллагын бүрэн эрхийг нарийвчлан хуульчилсан байна.

### Дутагдалтай хуульчилсан:

- Инновацийн хуулиар ШУ-ны Паркийн удирдлагын бүрэн эрх, чиг үүргийг хуульчилсан боловч тус хуулийн §21-д заасан инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар эрх, үүрэгтэй оролцох талаар дутагдалтай зохицуулсан байна.
- Шинжлэх ухаан, технологийн хуулиар ЭШБ-ын эрх, үүргийг хуульчлахдаа хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз, төрөлжсөн академи зэрэг байгууллагын төрлөөр ялгавартай хуульчлаагүй бөгөөд ерөнхийлөн зохицуулсан байна.

### Хангалтгүй хуульчилсан:

- Технологи дамжуулах хуулиар технологи дамжуулах үйл ажиллагааны оролцогчид болох иргэн, ААН, байгууллага, үнэлгээ хийх эрх бүхий ЭШБ-уудын тухайн харилцаанд оролцохтой холбогдон үүсэх эрх, үүргийг маш хангалтгүй хуульчилсан.

### Хуульчлаагүй:

- Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар ШУА-ийн харьяа байгууллагуудын эрх, үүргийг огт хуульчлаагүй.

**Дүгнэлт:** Энэ нь Шинжлэх ухаан, технологийн хуулийн холбогдох зохицуулалттай давхцах эрх зүйн үр дагавар үүсэх магадлалтай байсан байж болох талтай ч “шинжлэх ухааны төв байгууллага”-ын харьяа

байгууллага болохынх нь хувьд эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулсан хуульд нь ЭШБ-уудын эрх, үүргийг төрөл тус бүрээр нь нарийвчлан заах нь эдгээр байгууллагуудын цаашдын хөгжилд түлхэц болох бөгөөд хуулийг нэг мөр хэрэгжүүлэх үндэслэл болно гэж үзэж болохоор байна.

Салбарын гол хуулиудаар оролцогчдын эрх, үүрэг, бүрэн эрх, чиг үүргийг зохицуулсан байдлыг үзвэл Засгийн газар, хариуцсан яамны бүрэн эрхийг холбогдох харилцаа бүрээр зохицуулсан тохиолдол тус тус гурав байгаа нь агуулгын хувьд хуулийн давхардал биш юм.

Шинжлэх ухаан, технологийн хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалаас (2006) үзэхэд:

- Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны удирдлагын тогтолцоог шинээр томъёолж, Засгийн газар, ШУТ-ийн Үндэсний Зөвлөл, ШУТ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүргийг холбогдох бусад хуулийн зохицуулалттай давхцдаг зөрчлийг арилгасан байна.

- Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхээс Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан яамны нийтлэг эрхлэх асуудалд хамаарах зүйлүүдийг хасч, харин зайлшгүй байх шинжлэх ухааны менежер, эрдэм шинжилгээний ажилтныг тодорхой чиглэлээр бэлтгэх, ЭШБ-д магадлан итгэмжлэл явуулах, эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулан урамшуулах, гадаадын болон олон улсын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн нэгдсэн бүртгэл хөтлөх, зохицуулах, захиалгын дагуу боловсруулсан шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах зэрэг асуудлыг нэмж тусгасан байна.

- Мөн Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл нь ШУТ-ийн хөгжлийн түвшин, чиг хандлага болон шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, суурь, хавсарга судалгаа болон шинжлэх ухаан, технологийн төслийн санхүүжилт, шинжлэх ухаан, технологийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зэрэг асуудлаар зөвлөмж гаргах бүрэн эрхийг хуульчилсан байна.

**Хүснэгт 1.1.3: Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд  
оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалт**

ХУУЛЬ ТОГТООМЖ				
№	Хуулийн нэр	Байгууллагууд (удирдлага болон мэргэжлийн оролцогч)	Бүрэн эрх (Эрх, үүрэг)	Дүгнэлт
1	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль	Шинжлэх ухааны академи §7	<p align="center"><b>7 дугаар зүйл. Академийн үүрэг, эрх</b></p> <p><b>1. Академи нь дараахь үүргийг гүйцэтгэнэ:</b>            1/ хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах;            2/ харьяа нэгж, лабораторийн үйл ажиллагааг зохицуулах, улсын захиалгатай судалгааны ажлыг үр дүнтэй гүйцэтгэх ажлыг зохион байгуулах;            3/ улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах;            4/ шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах;            5/ шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадлагаа хийх;            6/ салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх;            7/ эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.</p> <p><b>2.</b> Академи нь үйл ажиллагааныхаа талаар Улсын Их Хурлын холбогдох байнгын хороонд жил тутам танилцуулна.</p> <p><b>3.</b> Академи нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг гүйцэтгэх талаар Засгийн газартай гэрээ байгуулж ажиллана.</p> <p><b>4. Академи нь дараахь эрхийг хэрэгжүүлнэ:</b>            1/ эзэмшилдээ байгаа өмч хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг зохих хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах;            2/ эрдэм шинжилгээний бүтээл, ном, сэтгүүл хэвлэж нийтлэх;            3/ гадаад орны шинжлэх ухааны байгууллагуудтай харилцаа тогтоох, хамтын ажиллагаа хөгжүүлэх;            4/ өөрийн нэрэмжит шагнал бий болгож, түүний санг байгуулах.</p> <p><b>5.</b> Академи нь зохих журмын дагуу хийсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.</p>	<p>Хуулийн 7.1-д заасан Академийн үүрэг гэдэгт “чиг үүрэг” болон “бүрэн эрх”-ийн шинжтэй заалтууд оруулсан. Ийнхүү эрх, үүрэг, чиг үүрэг, бүрэн эрхийг ялгаваргүйгээр хуульчилсан нь <b>зорчлийн</b> шинжийг агуулж байна.</p> <p><b>Хийдэл:</b> ШУА-ийн үйл ажиллагааг явцуу хуульчилсантай холбоотойгоор Ерөнхийлөгчийн эрх, үүрэг ч явцуу хүрээнд хуульчилгдсан байна. Энэ нь шинжлэх ухааны салбарын хөгжил болон төрийн бодлого, шийдвэр гаргах, эдийн засгийн үр ашигтай гэгдэх томоохон төсөл хөтөлбөрүүдэд шинжлэх ухааны холбогдох салбар, хүрээлэнгүүдийн</p>

		<p><i>Академийн ерөнхийлөгчийн бүрэн эрх</i> <b>§8</b></p>	<p><b>8 дугаар зүйл. Академийн ерөнхийлөгчийн бүрэн эрх</b> 1. Академийн ерөнхийлөгч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ Улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааг боловсронгуй болгох, шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх асуудлаар санал, зөвлөмж боловсруулж Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих; 2/ Шинжлэх ухааны болон шаардлагатай бусад асуудал хэлэлцсэн Засгийн газрын хуралдаанд зөвлөх эрхтэй оролцох; 3/ Академийг дотоод, гадаадад төлөөлөх; 4/ Академийн тэргүүлэгчдийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах.</p> <p><b>9 дүгээр зүйл. Академийн гишүүдийн эрх үүрэг</b> 1. Академийн гишүүд /академичид/ дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ: 1/ Академийн удирдах байгууллагад сонгох, сонгогдох; 2/ Улсын Их Хурлын Байнгын хороод, төрийн захиргааны төв байгууллагын удирдах зөвлөлийн хуралд шинжлэх ухаан, технологийн асуудлаар зөвлөх эрхтэй оролцох; 3/ Академийн Их, Бага чуулганд таслах эрхтэй оролцох; 4/ Эрдэм шинжилгээний ажлынхаа талаар Академийн тэргүүлэгчдээр уламжлан Бага чуулганд жил бүр тайлагнах; 5/ Академийн дүрэмд заасан бусад эрх, үүрэг.</p>	<p>оролцоо хангалтгүй байгаагийн үндэслэл болж байна.</p>
<p><b>2</b></p>	<p><b>Технологи дамжуулах тухай хууль</b></p>	<p><i>Засгийн газар</i> <b>§5.1.</b></p> <p><i>Технологи дамжуулах талаархи технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</i> <b>§6.1.</b></p>	<p><b>Технологи дамжуулах талаар Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</b> -Технологи дамжуулах талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; -Төрийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын технологийн шинэчлэлийг эдийн засгийн баталгаагаар хангах; -Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчид үзүүлэх урамшуулалт, хөнгөлөлт, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох; -Хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p><b>Дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</b> -Технологи дамжуулах хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, хяналт тавих, технологи дамжуулах үйл ажиллагааг шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлэх төрийн бодлоготой нийцүүлэн зохицуулах; -Технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран эрх олгох, холбогдох дүрэм, журмыг боловсруулж мөрдүүлэх; -Технологи дамжуулахтай холбогдох мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; -Тэргүүний технологи нэвтрүүлэх асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран төсөл зарлаж шалгаруулах, тэргүүний технологи ашиглах талаар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал, санаачилгыг дэмжих; -Технологи эзэмшигчийн эрхийг хамгаалах асуудлыг зохицуулах; -Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.</p>	<p><i>“Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч”</i> гэж хэнийг ойлгох талаар хуулийн тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь хууль хэрэглэх, хэрэгжүүлэх шатанд ойлгомжгүй, тодорхойгүй байдал үүсгэхээр байгаа нь “хуулийн хийдэл”-ийн шинжийг агуулж байна. <b>Хийдэл:</b> “Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч”-д иргэн, ААН, байгууллага, эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллагыг оруулж болохоор боловч технологи дамжуулах үйл ажиллагаанд эдгээр</p>

		<p><i>Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч</i> <b>§11.1.</b></p> <p>-Иргэн <b>§7.2</b> -Аж ахуйн нэгж <b>§7.2</b> -Байгууллага <b>§7.2</b> -Эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага <b>§7.3</b></p>	<p><b>...Оролцогч дараах бүрэн эрхтэй:</b> -Хууль тогтоомжоор хориглосноос бусад технологи дамжуулах үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх; -Технологи дамжуулахтай холбогдсон мэдээлэл авах; -Технологи дамжуулах үйл ажиллагааны хүрээнд зуучлах, бусдаар зуучлуулах; -Дотоод, гадаадын болон олон улсын байгууллага, иргэнтэй хамтран ажиллах, туршлага солилцох, уулзалт, семинар, хурал зохион байгуулах.</p> <p><b>Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага</b> нь шинээр хэрэглэх технологийнхээ түвшинд 7.1-д заасан байгууллагаар үнэлгээ хийлгүүлж болно <b>§7.2</b></p> <p>Технологийн түвшинг үнэлэх эрдэм шинжилгээний байгууллага нь үнэлгээ хийж байгаа технологийн нууцыг чандлан <b>хадгалах үүрэгтэй</b> бөгөөд хийсэн үнэлгээнийхээ талаар батламж гаргана. <b>§7.4</b></p>	<p>субъектүүд ямар эрх, үүрэгтэйгээр оролцохыг хуульчлалгүй орхигдуулсан.</p>
<p>3</p>	<p><b>Шинжлэх ухаан, технологийн тухай хууль</b></p> <p><i>Шинэчлэн найруулсан: 2006.</i></p>	<p><b>Удирдлагын тогтолцоо:</b></p>	<p><i>Засгийн газар</i> <b>§6.1.</b></p> <p>-Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, хэрэгжилтийг нь зохион байгуулах; -Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлон батлах; -Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах; -Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх; -Шинжлэх ухаан, технологийн салбарт мөрдөх нийтлэг дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах; -Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл, судалгааны ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцож, улсын төсөвт тусгуулах, хэрэгжилтийг зохион байгуулах; -Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах; -Хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p><i>Шинжлэх ухаан технологийн үндэсний зөвлөл</i> <b>§7.2.</b></p> <p>Дараахь асуудлаар зөвлөмж гаргах бүрэн эрхтэй: -Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн хөгжлийн өнөөгийн түвшин, цаашдын чиг хандлага; -Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөр, Засгийн газрын захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслүүдийн санал; -Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилт, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа; -Төрийн төв болон нутгийн захиргааны байгууллагын шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны тайлан, захиалсан төсөл, түүний үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж байгаа байдал; -Суурь болон хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн асуудал; -Шинэ технологи нэвтрүүлэх, тэргүүний технологи нутагшуулах чиглэлээр технологийн парк, инкубатор, тэргүүлэх зорилтын сүлжээ байгуулах асуудал; -Шинжлэх ухаан, технологийн сангийн тайлан;</p>	<p>Технологи дамжуулах тухай хуульд заасан Засгийн газрын эрхтэй зарим талаар давхцах бөгөөд эрхийг ерөнхийлөн хуульчилсан нь эргээд баталсан эрх зүйн актууд нь хэрэгцээтэй эсэх, хэрэгждэг эсэхэд хяналт тавихад хүндрэл учруулахаар байна.</p>

<p><b>Шинжлэх ухаан, технологийн тухай хууль</b></p> <p><i>Шинэчлэн найруулсан:</i></p>			<ul style="list-style-type: none"> <li>-Тухайн жилд улсын хэмжээгээр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны нэгдсэн хөтөлбөр;</li> <li>-Яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэлэлт, дүгнэлт өгөх асуудал;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлоготой уялдуулан шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх асуудал;</li> <li>-Төрийн бус байгууллага, хуулийн этгээдээс хэрэгжүүлж буй төслүүд, тэдгээрийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлэх үр нөлөө;</li> <li>-Хэрэгжүүлж дууссан шинжлэх ухаан, технологийн төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн байдал;</li> <li>-Шинжлэх ухааны хөгжлийн олон улсын чиг хандлагатай уялдуулан эрдэм шинжилгээ, судалгааны шинэ чиглэлийг хөгжүүлэх асуудал;</li> <li>-Эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;</li> <li>-Хуульд заасан бусад чиг үүрэг.</li> </ul>	
		<p><i>Төрийн захиргааны төв байгууллага буюу яам</i></p> <p><b>§8.1.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх;</li> <li>-Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төслийг сонгон шалгаруулах, хэрэгжилтийг зохион байгуулах, суурь, хавсарга судалгааны чиглэл, санхүүжилтийг батлах;</li> <li>-Төрийн захиргааны бусад төв болон орон нутгийн байгууллагаас шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийн мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;</li> <li>-Улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадлагаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэх;</li> <li>-Эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах, мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх;</li> <li>-Эрдэм шинжилгээний байгууллагад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх, түүний үр дүнг ашиглахад зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт хийх, олгосон хөрөнгийг эргэж төлүүлэх арга хэмжээ авах;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>-Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг батлах;</li> </ul>	

2006.12.28/12.28			<ul style="list-style-type: none"> <li>-Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын захирал (дарга)-ын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох;</li> <li>-Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх;</li> <li>-Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулж урамшуулах;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн нэгдсэн бүртгэл хөтлөх, зохицуулах;</li> <li>-Хуульд заасан бусад бүрэн эрх.</li> </ul>	
		<p style="text-align: center;"><i>Яамны шинжлэх ухаан, технологийн Зөвлөл §9</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Эрхэлсэн салбарын шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх нэгдсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх;</li> <li>-Салбарын шинжлэх ухаан, технологи, инновацийн чадавхийг хөгжүүлэх;</li> <li>-Салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлох;</li> <li>-Салбарын хэмжээнд хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөл боловсруулах, захиалах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</li> <li>-Хэрэгжүүлсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгөх;</li> <li>-Эрхэлсэн салбарын хэмжээнд шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн холбоог бэхжүүлэх арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх;</li> <li>-Эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>-Салбарын эрдэм шинжилгээний байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох санал боловсруулах;</li> <li>-Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>-хуульд заасан бусад бүрэн эрх.</li> </ul>	
Шинжлэх ухаан,	Эрдэм шинжилгээний байгууллага	<p style="text-align: center;"><i>Хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, ТҮҮБ<sup>26</sup></i></p>	<p>Үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээр мэргэжлийн зэрэг ахиулах түр сургалт явуулах, судалгаа, шинжилгээний ажлын үр дүнг нийтэд мэдээлэх, сурталчлах, эрдэм шинжилгээний сэтгүүл эрхлэн гаргах эрхтэй. § 11.5.</p>	Эрдэм шинжилгээний эдгээр байгууллагын төрөлжсөн эрх, үүргийг нарийвчлан зохицуулаагүй.
		<p style="text-align: center;"><i>ЭШБ-ын зэрэглэлд хамаарах ДББ<sup>27</sup></i></p>	<p>Бүтэцдээ эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори, зохион бүтээх товчоо, туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз байгуулан ажиллуулах эрхтэй. § 11.7.</p>	

<sup>26</sup> Туршилт-үйлдвэрлэл-үйлчилгээний бааз

<sup>27</sup> Дээд боловсролын байгууллага

<p><b>технологийн тухай хууль</b></p> <p><i>Шинэчлэн найруулсан: 2006.12.2812.28</i></p>	<p><i>ШУ, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл</i></p>	<p>-Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх болон аж ахуйн үйл ажиллагааг хослон явуулах эрхтэй. § 11.8.</p> <p>-Хуулийн этгээдийн нэгдлийн хэлбэрээр эрхлэн гүйцэтгэж болох бөгөөд удирдлага, зохион байгуулалт, <b>оролцогчдын эрх, үүргийг үүсгэн байгуулах баримт бичгээр тодорхойлно.</b> § 11.9.</p> <p>-Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажилтай холбогдсон харилцааг энэ хуулиар, үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна. § 11.10.</p>	
	<p><i>Улсын болон орон нутгийн музей, Үндэсний номын сан</i></p>	<p>-Өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дангаараа буюу эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрхтэй... § 11.12.</p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллага нь өөрийн нэр, албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг, харилцах данстай байх ба бэлгэ тэмдэг хэрэглэж болно. § 11.13.</p> <p>-Эрдэм шинжилгээний байгууллага нь зориулалтын барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон туршилт явуулах бусад нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд ийнхүү хангах үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ. §11.14.</p>	
	<p><i>Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтны нийтлэг эрх, үүрэг §13</i></p>	<p><b>13.1.Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:</b></p> <p>13.1.1.суурь, хавсарга судалгаа, шинжлэх ухаан, технологийн төслийг гүйцэтгэх шалгаруулалтад оролцох;</p> <p>13.1.2.хууль тогтоомжоор нууцад хамааруулснаас бусад мэдээллийг чөлөөтэй олж авах;</p> <p>13.1.3.хууль тогтоомжоор төрийн болон байгууллагын нууцад хамааруулснаас бусад эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлынхаа үр дүнг олон нийтэд мэдээлэх;</p> <p>13.1.4.шинжлэх ухаан, технологийн чиглэлээр гадаад улс, олон улсын байгууллагаас зохион байгуулж буй эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох, судалгааныхаа ажлын үр дүнг мэдээлэх, харилцан мэдээлэл солилцох;</p> <p>13.1.5.олон улсын болон дотоод, гадаадын шинжлэх ухааны байгууллага, нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх, тэдгээрийн удирдлагад сонгогдох;</p> <p>13.1.6.эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх нөхцөл бололцоогоор хангагдах;</p> <p>13.1.7.эрдэм шинжилгээний ажил болон бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хуульд заасан хөнгөлөлт эдлэх;</p> <p>13.1.8.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг харилцан солилцох, хэвлэн нийтлэх;</p> <p>13.1.9.эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах, зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл өгөх.</p> <p><b>13.2.Эрдэм шинжилгээний байгууллага, ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:</b></p> <p>13.2.1.шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим, эрдэм шинжилгээний ажилтны ёс зүй, нэр төрийг эрхэмлэн ажиллах;</p> <p>13.2.2.шинжлэх ухаан, технологийн төсөл, туршилт, грантыг бодитой хэрэгжүүлэх;</p>	<p>Эрдэм шинжилгээний байгууллагын эрх, үүргийг ерөнхийлөн зохицуулсан.</p>

		<p>13.2.3. үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх бол байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх;</p> <p>13.2.4. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг уг ажлыг дууссанаас хойш 60 хоногт багтаан шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд хүргүүлж хадгалуулах;</p> <p>13.2.5. эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх;</p> <p>13.2.6. эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэж дүгнэлт гаргуулах, уг байдал тогтоогдвол ажлаа зогсоох, учирч болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;</p> <p>13.2.7. шинжлэх ухаан, технологийн салбарт гадаад улс, олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төслийн тухай мэдээллийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх;</p> <p>13.2.8. эрдэм шинжилгээнийх нь ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх, ашиглахад хамтран ажиллаж дэмжлэг үзүүлэх.</p>	
	<p><i>Захиалагчийн эрх, Үүрэг §17</i></p>	<p><b>17.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан эрх эдэлнэ:</b></p> <p>17.1.1. санхүүжилтийн зориулалтаар олгогдох хөрөнгийн талаар саналаа шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уламжлах;</p> <p>17.1.2. гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон хөдлөх, үл хөдлөх хөрөнгийг өмчлөх;</p> <p>17.1.3. ажлын явц, гүйцэтгэл, санхүүжилтийн тайлан, мэдээг гүйцэтгэгчээс гаргуулж авах;</p> <p>17.1.4. төслийн санхүүжилтэд аудит хийлгэж дүгнэлт гаргуулах;</p> <p>17.1.5. төслийн гүйцэтгэл гэрээнд заасан шаардлага хангаагүй бол олгосон хөрөнгийг нөхөн төлүүлэх арга хэмжээ авах;</p> <p>17.1.6. захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах асуудлыг гүйцэтгэгчтэй хамтран шийдвэрлэх;</p> <p>17.1.7. төслийн гүйцэтгэлтэй холбогдсон маргааныг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>17.1.8. хууль, гэрээнд заасан бусад эрх.</p> <p><b>17.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан үүрэгтэй:</b></p>	

			<p>17.2.1.захиалсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжүүлэгчтэй гэрээ байгуулах;</p> <p>17.2.2.санхүүжүүлэгчээс олгосон хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах;</p> <p>17.2.3.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч хянан, баталгаажуулах арга хэмжээг уг ажлын үр дүнг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх;</p> <p>17.2.4.захиалсан ажлынхаа санхүүжилтийн сар, улирлын хуваарийг санхүүжүүлэгчтэй хамтран тодорхойлох;</p> <p>17.2.6.Шинжлэх ухаан, технологийн сантай хамтарсан төсөл хэрэгжүүлэх бол уг төсөлд оруулах өөрийн хөрөнгийг Санд байршуулж зарцуулах.</p> <p>17.5.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашигласан талаар Зөвлөлд хоёр жил тутамд тайлагнана.</p>	
		<p><i>Гүйцэтгэгчийн эрх, үүрэг §18</i></p>	<p><b>18.1. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч дор дурдсан эрх эдэлж үүрэг хүлээнэ:</b></p> <p>18.1.1.гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал төлөвлөсөн хэмжээнээс нэмэгдэхээр байвал энэ тухай саналаа захиалагчид тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>18.1.2.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын санхүүжилтийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхийг захиалагчаас шаардах;</p> <p>18.1.3.захиалагч үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах санал тавьж шийдвэрлүүлэх;</p> <p>18.1.5.гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэх, хөрөнгө зардлыг оновчтой хуваарилж, үр ашигтай зарцуулах, үр дүнг тоо, чанарын хувьд захиалсан түвшингээс нь бууруулахгүйгээр боловсруулж захиалагчид хүлээлгэн өгөх;</p> <p>18.1.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад гэрээнд заасан үр дүнд хүрэх бололцоогүй нь нотлогдсон, эсхүл давагдашгүй хүчин зүйл, хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас уг ажлыг цаашид хэрэгжүүлэх бололцоогүй болсон бол энэ тухайгаа захиалагчид даруй мэдэгдэх;</p> <p>18.1.7. захиалгат ажлыг гүйцэтгээгүй буюу дутуу гүйцэтгэсэн, эсхүл үр дүн нь гэрээнд заасан шаардлага хангаагүй бол доголдлыг арилгах, чанарын зохих түвшинд хүргэх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх, эсхүл олгосон хөрөнгийг нөхөн төлөх;</p> <p>18.1.8.гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээд, иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь уг ажлын сэдвийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.</p>	
			<p>Засгийн газар инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	

4	<p><b>Инновацийн тухай хууль</b></p> <p><i>Батлагдсан: 2012.05.22</i></p>	<p><i>Засгийн газрын бүрэн эрх §6.1.</i></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Төрөөс инновацийн талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;</li> <li>-Инновацийн үйл ажиллагааны стратегийн тэргүүлэх чиглэлийг тогтоож боловсруулан УИХ-д өргөн мэдүүлэх, дунд хугацааны тэргүүлэх чиглэлийг батлах;</li> <li>-Инновацийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-Үндэсний инновацийн тогтолцоо, инновацийг хөгжүүлэх хөтөлбөр батлах;</li> <li>-Инновацийг хөгжүүлэхтэй холбогдсон нийгээр дагаж мөрдөх дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн батлах;</li> <li>-инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай улсын төсвийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тогтоох, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-инновацийн төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам, нөхцөлийг тогтоох;</li> <li>-инновацийн үйл ажиллагааг дагнан явуулах төрийн өмчит байгууллага байгуулах, түүнийг өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;</li> <li>-инновацийн дэд бүтцийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах;</li> <li>-парк байгуулахдаа Шинжлэх ухаан технологийн үндэсний зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэх;</li> <li>-паркийн байршил, үйл ажиллагааны чиглэлийг тогтоож парк байгуулах тухай шийдвэр гаргах;</li> <li>-паркийн удирдлагыг томилох, бүтэц, дүрэм, журмыг батлах;</li> <li>-паркийн нутаг дэвсгэрт олгосон газар, төрийн өмчийн барилга байгууламжийн ашиглалт, нутаг дэвсгэрт үйлчлэх хөнгөлөлт, урамшуулал, тэдгээрийн хэлбэр, хэмжээг тогтоох, паркийн үйл ажиллагаатай холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх.</li> <li>-хуульд заасан бусад бүрэн эрх.</li> </ul>	
		<p><i>Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага</i></p> <p><b>§7.1.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;</li> <li>-Инновацийн тэргүүлэх чиглэл, үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, тэдгээрт шаардагдах төсвийн санхүүжилтийн талаар санал боловсруулж Засгийн газарт өргөн барих;</li> <li>-Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагаас инновацийг хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах;</li> <li>-Инновацийн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхэд оролцогч талуудын түншлэл, үйл ажиллагааны уялдааг хангах бодлогыг хэрэгжүүлэх;</li> <li>-Инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулах талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах;</li> <li>-Энэ хуулийн 6.1.10-6.1.13-т заасан Шинжлэх ухааны парктэй холбоотой дүрэм, журам, төсөл боловсруулж Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлөөр хэлэлцүүлж, Засгийн газарт оруулах;</li> <li>-Засгийн газрын захиалгаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үндэсний хэмжээний, стратегийн ач холбогдол бүхий инновацийн төслийн хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-Инновацийн төсөл хэрэгжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжилт олгох, олгосон хөрөнгийг эргэн төлүүлэх арга хэмжээ авах;</li> </ul>	

		<ul style="list-style-type: none"> <li>-Холбогдох байгууллагатай хамтран инновацийн төслийн нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдэд энэ талаар үйлчилгээ үзүүлэх;</li> <li>-Үндэсний инновацийн тогтолцооны хөгжлийн түвшинг үнэлэх аргачлал боловсруулах, инновацийн мэдээллийн сан бүрдүүлэх;</li> <li>-Инновацийн үйл ажиллагаа эрхлэх хүний нөөцийг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;</li> <li>-Инновацийг хөгжүүлэх талаар гадаад улс, олон улсын байгууллагатай хамтран ажиллах;</li> <li>-Инновацийн үйл ажиллагааг урамшуулах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх;</li> <li>-Инновацийн бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журмыг баталж, хэрэгжилтийг зохион байгуулах;</li> <li>-Төрөөс шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаар баримтлах бодлогыг инновацийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг хангах;7.1.16.шинжлэх ухаан, технологийн салбарт инновацийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах;</li> <li>-Шинжлэх ухаан, технологийн салбарт инновацийн дэд бүтцийг байгуулах төлөвлөлтийг хийх, түүнийг хэрэгжүүлэх талаар санал боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;</li> <li>-Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын инновацид чиглэсэн үр дүнгийн талаар мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;</li> <li>-Технологийн туршилт, зүгшрүүлэлтэд инновацийн грант олгох;</li> <li>-Инновацийн чиглэлээр хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах;</li> <li>-Инновацийн соёлыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;</li> <li>-Хуульд заасан бусад бүрэн эрх.</li> </ul>	
	<p style="text-align: center;"><i>Яам, агентлаг</i> <b>§10.1.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Дангаараа болон өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран инновацийн хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх;</li> <li>-Салбарын инновацийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хэрэгжилтийг хангах;</li> <li>-Төрийн захиргааны төв байгууллагууд инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг өөрийн эрхлэх үйл ажиллагааны төсөвт багтаан шийдвэрлэх;</li> <li>-Хуульд заасан бусад бүрэн эрх.</li> </ul>	
	<p style="text-align: center;"><i>Аймаг, нийслэлийн засаг дарга</i> <b>§11.1.</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>-Орон нутагтаа инновацийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог хангах, хамтарсан санхүүжилттэй инновацийн төсөл хэрэгжүүлэх; §11.1.1</li> <li>-Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгуулагдсан паркийн хэвийн үйл ажиллагаагаа явуулахад шаардагдах нийгмийн дэд бүтэц байгуулах, суурь үйлчилгээ үзүүлэх ажлыг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр шийдвэрлэх, паркийн захиргаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах; §11.1.2</li> <li>-Орон нутгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэгдсэн инновацийн дэд бүтцийг хөгжүүлэх, инновацийн хөтөлбөр, төсөл боловсруулах; §11.1.3</li> <li>-Энэ хуулийн §11.1.3-т заасныг орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх, шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах, гадаадын хөнгөлөлттэй зээлд хөрөнгийн баталгаа гаргах; §11.1.4</li> </ul>	

			-Инновацийн үйл ажиллагааг дагнан эрхлэх үүрэгтэй орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд байгуулж ажиллуулах; §11.1.5. -Хуульд заасан бусад бүрэн эрх. §11.1.6.	
		<i>Шинжлэх ухааны парк</i> <b>§20</b>	<b>Паркийн удирдлагын чиг үүрэг: §20</b> -Паркийн удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагаас бүрдэнэ. -Төлөөлөн удирдах зөвлөл нь Засгийн газар, орон нутаг, паркийн нэгжийн төлөөллөөс бүрдэх бөгөөд нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувийг паркийн нэгжээс сонгоно. -Төлөөлөн удирдах зөвлөл паркийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: -Паркийн хөгжлийн талаар өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх; -Паркийн хөгжлийн онцлогтой уялдсан гадаад хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын бодлогын асуудлаар шаардлагатай тохиолдолд өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал оруулж шийдвэрлүүлэх; -Хуульд заасан бусад бүрэн эрх. Паркийн гүйцэтгэх удирдлага паркийн талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ: <b>§20.4.</b> -Паркийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах; -Хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийг зохион байгуулах; -Техник, эдийн засгийн үндэслэл, технологийн түвшний үнэлгээ, холбогдох байгууллагаар гаргуулсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг үндэслэн паркийн нэгжтэй гэрээ байгуулах; -Паркийн нэгжийн хэвийн үйл ажиллагаа явуулах орчин, дэд бүтцийг бүрдүүлэх, холбогдох заавар, удирдамжаар хангах; -Энэ хуулийн 20.4.1-20.4.4-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээг гэрээний үндсэн дээр авах; -Хуульд заасан бусад бүрэн эрх.	
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>				
1	<b>Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм.</b>  <i>Засгийн газрын 1993 оны 193 дугаар тогтоолын хавсралт</i>	<i>Шинжлэх ухаан, технологийн сан</i> <b>§3</b>	<b>Гурав.Сангийн захиргааны үүрэг, эрх</b> <i>3.9.Сангийн захиргаа нь дор дурдсан үүрэгтэй байна:</i> а/шинжлэх ухаан, технологийн хөгжлийг хөхүүлэн дэмжих, сангийн хөрөнгийг энэ дүрмийн 5 дугаар зүйлд заасны дагуу бүрдүүлэх ажлыг эрхлэх, уг хөрөнгийг зохистой ашиглах, улс орны оюуны өмчийг хамгаалан арвижуулахад чиглүүлэх; б/үндэсний зөвлөлөөс гаргасан үнэлэлт, дүгнэлт, саналыг харгалзан сонгож Шинжлэх ухаан, боловсролын сайдын шийдвэрийн дагуу шалгаруулсан төслийг санхүүжүүлж, үр дүнг тогтоосон хугацаанд тооцож байх; в/шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлого, үзэл баримтлалд нийцүүлэн судалгааны ажлын материаллаг баазыг бэхжүүлэх, хэвлэл, мэдээллийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээний хурал, семинар зохион байгуулах, залуу эрдэмтэд бэлтгэх, мэдлэг чадварыг дээшлүүлж, тэднийг	

			<p>эрдэм шинжилгээний ажилд татан оролцуулахад сангийн улсын төсвийн бус эх үүсвэрээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх;  г/эрдэм шинжилгээний ажлын бэлэн үр дүн, боловсрогдсон технологийг нэвтрүүлэх, борлуулах ажлыг зохион байгуулах;  д/эрдэм шинжилгээний байгууллагын тайлан, тэнцэл, санхүүжүүлсэн төслийн үр дүнг нэгтгэн гаргаж Шинжлэх ухаан боловсролын яам, Сангийн яаманд зохих журмын дагуу тайлагнах.</p> <p><i>3.10. Сангийн захиргаа нь дор дурдсан эрхтэй байна:</i>  а/санхүүжүүлж байгаа төслийн явц, үр дүнг холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад төслийн захиалагчтай хамтран шалгах, үр дүнг тооцож гаргуулах зайлшгүй шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох талаар санал боловсруулж үндэсний зөвлөлөөр уламжлан Шинжлэх ухаан, боловсролын сайдын зөвлөлд оруулах;  б/санхүүжүүлж байгаа төслийн явц, үр дүнг шалгах, үнэлэлт, дүгнэлт гаргуулахаар ажлын хэсэг түр хугацаагаар байгуулан ажиллуулах, ажлын хэсэгт үндсэн байгууллага, аж ахуйн нэгжтэй нь тохиролцон эрдэмтэд, мэргэжлийн хүмүүсийг оролцуулах;  в/төсөлд үнэлэлт, дүгнэлт гаргах болон хяналт шалгалт хийхэд оролцсон эрдэмтэд, мэргэжилтнүүдэд зохих журмын дагуу урамшил олгох;  г/төсөл боловсруулах заавар, үр дүнг хүлээн авах акт, төлөвлөлт, санхүүжилтийн маягт, үзүүлэлтийг боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулан мөрдүүлэх;  д/сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан, сангаас олгосон зээл, зээлийн хүүг төлөхөөс зайлсхийсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх тухай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, нэхэмжлэл гаргах.</p>	
--	--	--	--	--

## Дөрөв. Шинжлэх ухааны салбарын санхүүжилтийг зохицуулсан байдал

Шинжлэх ухааны салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн ивээлд байх төрийн дэмжлэг бүхий байгууллагуудын санхүүжилтийн эх үүсвэрүүдийг хуулиар тодорхой заасан байна. Хуулиудын зохицуулалтыг нэгтгэн үзвэл шинжлэх ухааны салбарын санхүүгийн эх үүсвэр нь:

- улсын төсөв;
- орон нутгийн төсөв;
- төслийн хөрөнгө;
- өөрийн үйл ажиллагааны орлого;
- гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө;
- хандив, тусламж;
- бусад эх үүсвэрээс бүрдэхээр байна.

Хуулийн зохицуулалтаас харахад тус салбарын санхүүжилтийн эх үүсвэрт зөрчил, хийдэл, давхардлын шинжтэй зохицуулалт агуулгын хувьд харагдахгүй, санхүүжилтийн боломжит бүх эх үүсвэрийг хуулиар зөвшөөрсөн байдалтай байна. Гэвч эрдэм шинжилгээ, судалгаа, төслийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үйлдвэрлэгч, хувийн хэвшлийн санхүүгийн оролцоог хуулиар тусгайлан заагаагүйгээс улсын төсөв, гадаад улс, олон улсын байгууллагаас олгохоос бусад санхүүгийн эх үүсвэр идэвхгүй шинжтэй байдаг нь холбогдох судалгаа<sup>28</sup>, тайлан<sup>29</sup>-аас харагдаж байна.

Нөгөө талаас Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 20 дугаар зүйлд ШУТС-ийн тухай зохицуулалт орсон байдаг бөгөөд ШУТС-нд олгох төсвийн хөрөнгийн хэмжээ ДНБ-ний 1.5%-иас багагүй байна гэсэн заалтыг 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар хүчингүй болгосон нь төсвийн хөрөнгөөр санхүүжих санхүүжилтийн баталгааг эрсдэлд оруулах, цаашлаад холбогдох хууль, бодлогын баримт бичгээр дэвшүүлсэн том зорилтуудаас ухарсан алхам гэж үзэж болохоор байна. Учир нь 2016 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр шинжлэх ухааны санхүүжилт нь 30.5 тэрбум төгрөг байгаа нь ДНБ-ний 0.16 хувь байна. Үүнээс 9,1 тэрбум төгрөг нь эрдэм шинжилгээний ажилд зарцуулагдсан байна. Өмнөх жилүүдийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай харьцуулахад 2013 онд тус салбарын санхүүжилт хамгийн өндөр буюу 38,1 тэрбум төгрөгийн санхүүжилттэй байсны 9,7 тэрбум төгрөг нь эрдэм шинжилгээний ажилд зарцуулагдаж байжээ. Өөрөөр хэлбэл, хуулиар тогтоосон ДНБ-ний 1,5 хувиас багагүй байна гэсэн зорилгодоо хүрч шинжлэх ухааны салбарыг санхүүжүүлж байсан удаа байхгүй байна. Бусад орны хувьд АНУ ДНБ-ний 2.7 хувь, БНХАУ ДНБ-ийхээ 2.1 хувь, Израйл улс ДНБ-ний 4.1 хувьтай тэнцэх хэмжээний санхүүжилт олгож байна.

2009 онд хийсэн судалгааны үр дүнгээс үзэхэд “*тус оны байдлаар ШУ-ны салбарын санхүүжилт ДНБ-ний 0,25-0,28% хэлбэлзэж байжээ. Энэ нь олон улсын ангиллаар шинжлэх ухаан үзэгдэл төдий явагдаж байгаагийн нэг шалгуур үзүүлэлт болдог байна. Санхүүжилтийн олон янз эх үүсвэр үүсээгүй буюу үндсэндээ улсын төсвөөс санхүүжсээр ирсэн*” гэсэн үр дүн гарсан байна.

Мөн судалгаагаар “Монгол улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний дийлэнхи хувь нь (95%) технологийн багтаамж нь нам буюу оюуны багтаамж багатай байгаа нь шинжлэх ухааны үр дүн амьдралд нэвтэрдэггүй, шинжлэх ухаан үйлдвэрлэлийн бодит холбоо байхгүйтэй холбогдоно”<sup>30</sup> гэсэн нь эрдэм шинжилгээ, судалгаа, төслийн ажлын үр дүнг

<sup>28</sup> ННФ. “Шинжлэх ухаан, технологийн сангийн зарцуулалт, үр дүнгийн мониторинг” 2009. УБ

<sup>29</sup> Жил бүрийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

<sup>30</sup> “Шинжлэх ухаан, технологийн сангийн зарцуулалт, үр дүнгийн мониторинг”. ННФ. УБ., 2009. 14 дэх тал.

үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үйлдвэрлэгч, хувийн хэвшлийн санхүүгийн оролцоог хуулиар тусгайлан заах шаардлагыг харуулж байна.

Нөгөө талаас тус судалгаанд “...Захиалагч төрийн яамдын хувьд үйлдвэрлэгчдийн санаа бодлыг төдийлөн авдаггүй, төслийг захиалахад түүний үр дүнг хэрэглэгч буюу үйлдвэрлэгчдийн оролцоо байдаггүй, тухайн салбарын тэргүүлэх салбарыг тодорхойлж чадаагүй зэргээс шалтгаалан үр дүнгүй төслүүдийг захиалж байна. Мониторингийн судалгааны явцад захиалагч яамдын ШУТ хариуцсан ажилтнуудын мэдлэг чадамжийг дээшлүүлэх шаардлагатай байгаа ба тэдэнд хариуцлага үүсгэдэг тогтолцоо байдаггүй нь нотлогдлоо. Тухайлбал ***ШУТ-ийн төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх журамд төрийн захиргааны төв байгууллагаас бусад байгууллага үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаагүй эсвэл ашиглах боломжгүй төсөл захиалсан бол төсөлд зарцуулсан мөнгийг буцаан төлөх*** тухай заалт оржээ. Энэ нь төр хувийг хэвшлийг ялгаварласан, одоогоор ШУТ-ийн төслийн дийлэнхи хувийг захиалж буй захиалагч яамдын холбогдох ажилтнуудад хариуцлага хүлээлгэхгүй, үр дүнгүй төслүүд захиалагддаг дээрхи бэрхшээлтэй асуудлыг шийдэхгүй байх заалт гэж үзэж байна” гэжээ.

Үүнээс үзэхэд үр дүнгүй төсөл захиалсан захиалагч яамдад хүлээлгэх хариуцлага, хариуцлагын тогтолцоотой холбоотой зохицуулалт одоо үйлчилж буй хууль тогтоомжуудад тусгагдаагүй байна.

## Хүснэгт 1.1.4: Санхүүжилт

ХУУЛЬ ТОГТООМЖ			
№	Хуулийн нэр	Үйл ажиллагааны санхүүжилт	Тайлбар
1	Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль	<p><b>Академийн санхүүжилт</b></p> <p>10.1.Академийн үйл ажиллагааны зардлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:</p> <p>1/ төсвийн хөрөнгө; 2/ төслийн хөрөнгө; 3/ өөрийн үйл ажиллагааны орлого; 4/ бусад орлого.</p> <p>10.2.Академи, түүний харьяа байгууллагуудын үйл ажиллагааны санхүүжилтийн журмыг Засгийн газар тогтооно.</p>	
2	Технологи дамжуулах тухай хууль	<p>§12.1 Технологи дамжуулах үйл ажиллагааг лицензийн гэрээгээр хэрэгжүүлнэ.</p> <p>12.2.11. технологи худалдан авах үнэ, лицензийн төлбөр, төлөх нөхцөл, хэлбэр;</p> <p><b>§15.Лицензийн төлбөр</b></p> <p>15.1. Технологи ашиглахаар авч буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн технологи эзэмшигчид төлөх төлбөрийг лицензийн төлбөр гэнэ.</p> <p>15.2. Лицензийн төлбөр нь нэг удаагийн, эсхүл тухайн технологи ашигласнаас олох ашгийн тодорхой хувь хэмжээгээр тогтоосон байнгын шимтгэл, эсхүл эдгээрийг хосолсон хэлбэртэй байж болно.</p> <p>15.3. Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч талууд лицензийн төлбөрийн хэмжээ, хэлбэр, хугацааг гэрээгээр харилцан тохиролцоно.</p>	Энэхүү үйл ажиллагааны санхүүжилт нь гэрээний үндсэн дээр эх үүсвэр нь бүрдэх бөгөөд энэ хуулиар гэрээний төлбөрийн тусгайлсан зохицуулалт байхгүй тул Иргэний хуулийн тусгай ангид заасан гэрээний холбогдох төрлөөр зохицуулагдана.
3	Шинжлэх ухаан технологийн тухай хууль	<p><b>§14</b> Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр:</p> <p>-улсын төсвөөс олгосон хөрөнгө; <b>§14.1.1</b></p> <p>-орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө; <b>§14.1.2</b></p> <p>-гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө; <b>§14.1.3</b></p> <p>-гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж; <b>§14.1.4</b></p> <p>-хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр. <b>§14.1.5</b></p> <p><b>§15</b> Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг санхүүжүүлэх журам:</p> <p>-Засгийн газрын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр; <b>§15.1.1</b></p>	

	<p><i>Шинэчлэн найруулсан: 2006.12.28</i></p>	<p>-нутгийн захиргааны байгууллагын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг орон нутгийн төсвийн хөрөнгөөр; <b>§15.1.2.</b></p> <p>-аж ахуйн нэгж, байгууллага, иргэний захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагчийн хөрөнгөөр. <b>§15.1.3</b></p> <p>-15.1.1-д заасны дагуу санхүүжилт хийхдээ шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд хамаарах суурь судалгаа, төслийг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ. <b>§15.2.</b></p> <p>-15.1.2, 15.1.3-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил нь Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбаруудын хөгжлийг түргэтгэх, үр ашигтай шинэ салбарыг үүсгэн хөгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх, экспортын нөөцийг өсгөх болон импорт орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчим хүчээр хангах, байгаль орчныг хамгаалах зэрэг стратегийн асуудлыг судлан шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа бол уг ажлын тодорхой хэсгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж болно. <b>§15.3.</b></p> <p><b>§16 Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам:</b></p> <p>-14.1.1, 14.1.2-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг Засгийн газраас баталсан журмын дагуу хянан магадлагаа хийж шалгаруулна. <b>§16.1.</b></p> <p>-16.1-д зааснаар шалгарсан эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг санхүүжүүлэхэд олгох хөрөнгийн хэмжээг Зөвлөлийн зөвлөмжийг үндэслэн шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно. <b>§16.2.</b></p> <p>-16.1-д заасан ажлын захиалагч нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага байх бөгөөд ... Иргэний хуулийн 343-358 дугаар зүйлд заасны дагуу ... гэрээ байгуулна. <b>§16.3.</b></p> <p>-Төрийн өмчит ЭШБ үйл ажиллагааныхаа үндсэн чиглэлийн дагуу суурь, хавсарга судалгааг гүйцэтгэх бол тэдгээрт грант олгох, эсхүл уг байгууллагад санхүүжилт олгох замаар асуудлыг зохицуулж болно. <b>§16.4.</b></p> <p>-15.1.3-д заасны дагуу 14.1.3-14.1.5-д заасан эх үүсвэрээс гүйцэтгэх эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлыг захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлнэ. <b>§16.5.</b></p> <p>-Төрийн өмчит ЭШБ-ын барилга байгууламж, сорилт, туршилтын зориулалттай тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахтай холбогдсон зардлыг улсын төсөвт тусгах, санхүүжүүлэх асуудлыг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна. <b>§16.6.</b></p>	
4	<p><b>Инновацийн тухай хууль</b></p>	<p><b>Инновацийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэр, хэлбэр §12</b></p> <p>12.1.Инновацийн үйл ажиллагааны санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>12.1.1.Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө;</p> <p>12.1.2.Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгө;</p> <p>12.1.4.Засгийн газрын бусад тусгай сангийн хөрөнгө;</p> <p>12.1.5.хөрөнгө оруулалтын компанийн хөрөнгө;</p> <p>12.1.6.гарааны компанийн хөрөнгийн анхдагч зах зээлээс бүрдүүлсэн хөрөнгө;</p> <p>12.1.7.инновацийн үйл ажиллагаанд оролцогч байгууллагын өөрийн хөрөнгө;</p> <p>12.1.8.гадаад улс болон олон улсын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө;</p>	

		<p>12.1.9.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.</p> <p>12.2.Энэ хуулийн 12.1.1, 12.1.3, 12.1.4-т заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх инновацийн төслийг Засгийн газраас баталсан журмын дагуу сонгон шалгаруулна.</p> <p>12.3.Инновацийн үйл ажиллагааг дараах хэлбэрээр санхүүжүүлнэ:</p> <p>12.3.1.эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлэх;</p> <p>12.3.2.буцалтгүй санхүүжилт олгох;</p> <p>12.3.3.инновацийн грант олгох.</p> <p>21.2.Үйлдвэрлэл технологийн паркийн үйл ажиллагааг энэ хуулийн 12.1-д заасан эх үүсвэрээс гадна паркийн өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлнэ.</p>	
<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ</b>			
<b>1</b>	<p><b>Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрэм.</b></p> <p><i>Засгийн газрын 1993 оны 193 дугаар тогтоолын хавсралт</i></p>	<p style="text-align: center;"><b>Хоёр.Сангийн хөрөнгийг бүрдүүлэх</b></p> <p><b>Сангийн хөрөнгийг дор дурдсан эх үүсвэрээс бүрдүүлнэ:</b></p> <p>а/төслийг захиалагч аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;</p> <p>б/улсын захиалгаар гүйцэтгэх төсөлд зориулан шууд болон эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр олгосон төсвийн хөрөнгө;</p> <p>в/шинжлэх ухаан, технологийн хөгжилд зориулан банкнаас олгосон зээл;</p> <p>г/аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс шинжлэх ухаан технологийн хөгжилд зориулан өгсөн хандив, тусламж;</p> <p>д/шинжлэх ухаан, технологийн хөгжилд зориулан гадаад орон, олон улсын байгууллага, гадаадын иргэдээс өгсөн хандив, тусламж;</p> <p>е/орлогын бусад эх үүсвэр.</p> <p>6.Сангийн хөрөнгийг бүрдүүлсэн эх үүсвэр, үндэсний зөвлөлөөс гаргасан үнэлэлт,дүгнэлт, төслийн үр ашиг, ач холбогдлыг харгалзан Засгийн газраас зарласан төсөл, суурь судалгааны төсөл, салбарын болон аж ахуйн нэгж, байгууллагын захиалгат төслийг ялгавартайгаар санхүүжүүлэх зарчим баримтална.</p> <p>7.Сангийн өдөр тутмын үйл ажиллагаа, сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зохистой зарцуулах, ашиглалтад хяналт тавих ажлыг сангийн захиргаа эрхлэнэ.</p> <p>Сангийн захиргааны орон тоо, ажиллах журам, төсөл санхүүжүүлэх зарчмыг Шинжлэх ухаан, боловсролын сайд, Сангийн сайд нар хамтран тогтооно.</p> <p>8.Сангийн захиргаа нь тогтоосон журмаар хийсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэж, банкинд харилцах данстай байна.</p> <p style="text-align: center;"><b>Төслийг санхүүжүүлэх</b></p> <p>11.Сонгон шалгаруулсан төслийг захиалагч, гүйцэтгэгч, сангийн хооронд байгуулсан гэрээний дагуу санхүүжүүлнэ.</p>	

	<p>12.Гэрээнд төслийг хэрэгжүүлэхэд захиалагчаас тавих шаардлага, гүйцэтгэгчийн үүрэг, хариуцлага, санхүүжүүлэх зарчим, үе шат, хугацаа, үр дүнг тооцох болон санхүүжилтийн зардлыг нөхөх нөхцөл, ашгийн шимтгэл, хүү зэргийг тодорхой тусгасан байна.</p> <p>13.Засгийн газар, төрийн захиргааны төв байгууллагын захиалгаар хийгдсэн болон суурь технологи, онолын судалгааны төслийг улсын төсвийн хөрөнгөнөөс шууд санхүүжүүлж болно.</p> <p>14.Техник, технологийн чиглэлтэй төслийг эргэж төлөгдөх буюу үйлдвэрлэлийн ашиг орлогоос зохих хувийг санд оруулах нөхцөлөөр санхүүжүүлнэ.</p> <p>15.Сангаас сонгон шалгаруулсан төслийг санхүүжүүлэхдээ уг төслийг хэрэгжүүлэхэд тухайн жилд зарцуулахаар тооцож батлуулсан хөрөнгийн 80 хүртэл хувийг урьдчилгаа хэлбэрээр олгож, төслийн эцсийн үр дүнгийн талаар захиалагчийн тодорхойлолтыг үндэслэн хөрөнгийн үлдсэн хэсгийг санхүүжүүлнэ.</p> <p>16.Захиалагч, гүйцэтгэгч, сан нь байгуулсан гэрээгээ тогтоосон хугацаанд хамтран дүгнэж, төслийн санхүүжилтийн үр дүн, холбогдох тооцоог хийж хэрэглэгчид нь шилжүүлэн хүлээлгэж өгсөн буюу үйлдвэрлэлд нэвтрүүлснээр уг төслийн үйл ажиллагааг дуусгавар болгоно.</p>	
--	---	--

## Тав. Шинжлэх ухаан технологийн оюуны өмчийн харилцаа болон бусад

Шинжлэх ухаан, технологийн салбар дахь оюуны өмч, зохиогчийн эрхийн харилцааг:

- Технологи дамжуулах тухай хууль,
- Инновацийн тухай хууль,
- Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль
- Патентын тухай хуулиар зохицуулсан байна.

Үүнээс шинжлэх ухааны салбарын хуулиудад оюуны өмч, зохиогчийн эрхийн харилцааг хэрхэн тусгасныг авч үзье. Учир нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль болон Патентын тухай хуулиар оюуны өмч, зохиогчийн эрхтэй холбогдон үүсэх аливаа харилцааг бүхэлд нь зохицуулсан.

Технологи дамжуулах тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар:

### Технологи дамжуулах гэрээг бүртгүүлэх

- 14.1. Технологи дамжуулах гэрээг оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад бүртгүүлнэ.
- 14.2. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь олон улсын буюу Монгол Улсын стандартын шаардлагад нийцээгүй технологийг гадаад орноос оруулах, шинээр хэрэглэх тухай гэрээг бүртгэхдээ дараахь үнэлгээ, дүгнэлтийн аль нэгийг үндэс болгоно:
- 14.2.1. хүний эрүүл мэндэд нөлөөлөх байдлын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;
- 14.2.2. мал эмнэлэг, үржил, ургамал, газар тариалангийн үйлдвэрлэлийн технологи дамжуулж байгаа тохиолдолд хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;
- 14.2.3. энэ зүйлийн 14.2.1, 14.2.2-т зааснаас бусад тохиолдолд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ.
- 14.3. Оюуны өмчийн асуудал эрхэлсэн байгууллага нь 14.2-т заасан дүгнэлтийг үндэслэн гэрээг бүртгэхгүй байж болно.
- 14.4. Технологи дамжуулах гэрээг бүртгээгүй тохиолдолд технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн технологийг ашиглахыг хориглох талаар шийдвэр гаргана.

Инновацийн тухай хуулийн 27 дугаар зүйлд Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг эзэмших, ашиглах харилцааг дараахь байдлаар зохицуулжээ. Үүнд:

<b>Журам батлах субъект:</b>	27.1. Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон оюуны өмчийг шинжлэх ухаан, технологийн төсөл санхүүжүүлэх гэрээнд өөрөөр заагаагүй бол тухайн ажлыг гүйцэтгэсэн иргэн болон хуулийн этгээд эзэмшиж болох бөгөөд өмчлүүлэх, эзэмшүүлэх журмыг <b>Засгийн газар батална.</b>
<b>Ерөнхий зохицуулалт</b>	27.2. Эрдэм шинжилгээний байгууллага дэргэдээ технологи дамжуулалт хариуцсан нэгж болон гарааны компанийг үүсгэн байгуулж болно. 27.3. Эрдэм шинжилгээний байгууллага өөрийн эзэмшлийн оюуны өмчийг эрх бүхий байгууллагаар үнэлүүлэн гарааны компанийн дүрмийн санд хувь нийлүүлэн оруулж болно. 27.4. Эрдэм шинжилгээний байгууллагын харьяа гарааны компанийн үйл ажиллагааны орлого, зарлагыг тусгай дансанд бүртгэх бөгөөд эрдэм шинжилгээний байгууллагад ногдох ногдол ашгийн 75-аас доошгүй хувийг сургалт, эрдэм шинжилгээ, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн зориулалтаар ашиглана.
<b>Төлбөр</b>	27.5. Зохиогчийн анхдагч эрхийг уг оюуны өмчийг бий болгосон судлаач болон эрдэм шинжилгээний байгууллагаас бусад хуулийн этгээд лицензээр эзэмшсэн тохиолдолд тэдгээрт роялти төлнө.
<b>Хориглолт, баталгаа</b>	27.6. Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг ашиглан гадаад улсад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг хориглоно.

<b>Лицензийн төрөл</b>	<p>27.7. Энэ хуулийн 27.6-д заасан байгууллагын зөвшөөрөлтэйгөөр төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн оюуны өмчийг ашиглан гадаад улсад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тохиолдолд олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу тухайн улсад уг оюуны өмчийн эрхийг баталгаажуулах, хамгаалах арга хэмжээг авна.</p> <p>27.8. Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнг эзэмшигч энэ хуулийн 27.6-д заасныг зөрчсөн тохиолдолд түүний тухайн оюуны өмчийг эзэмших эрхийг түдгэлзүүлэх, дараагийн эзэмшигчид шилжүүлэх, ашиглуулах харилцааг энэ хуулийн 27.1-д заасан журмаар зохицуулна.</p> <p>27.9. Онцгой нөхцөл байдал үүсэх үед болон үндэсний эрх ашгийг хангах зорилгоор Засгийн газар төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг дараах лицензийн нөхцөлөөр ашиглах бүрэн эрхтэй:</p> <p>27.9.1. онцгой эрхгүй лиценз;</p> <p>27.9.2. дамжуулах эрхгүй лиценз;</p> <p>27.9.3. цуцлах эрхгүй лиценз;</p> <p>27.9.4. төлбөрийг барагдуулсан лиценз</p>
<b>Оюуны өмчийн эзэмшигч нь ЭШБ бол хүлээх үүрэг</b>	<p>27.10.1. оюуны өмчийг зохиогч, бүтээгчид роялти хуваарилах;</p> <p>27.10.2. оюуны өмчийн ашиглалтаас олох роялти орлогоос тухайн оюуны өмчийг зохиогч, бүтээгчдэд төлсөн роялтийг хуваарилсны дараа үлдэх орлогыг зөвхөн шинжлэх ухааны судалгаа, сургалтад зарцуулах;</p> <p>27.10.3. оюуны өмчийг төрийн өмчит үйлдвэрийн газарт нэвтрүүлснээс олсон роялти орлого нь оюуны өмчийн эрхийг эзэмшигчийн жилийн төсвийн таван хувиас хэтэрсэн тохиолдолд илүү гарсан орлогын 75 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх, 25 хувийг эзэмшигч нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, технологийн зүгшрүүлэлтийн үйл ажиллагаанд зарцуулах</p>

### Хяналт шинжилгээ-үнэлгээтэй холбогдон үүсэх харилцаа

Шинжлэх ухааны салбарын харилцааг голлон зохицуулж буй салбарын 4 хууль тогтоомжид шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Тодруулбал хүснэгт 1.1.3-т үзүүлснээр хуулиар шинжлэх ухааны салбарын захиргааны байгууллага буюу удирдлагын тогтолцоог бүрдүүлэгч субъектүүдийн эрх, үүргийг хангалттай хуульчилсан байна. Харин түүнийг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх хуулийн зохицуулт байхгүй байна. Тухайлбал, 2009 онд Нээлттэй нийгэм форумаас хийлгэсэн мониторинг судалгаа<sup>31</sup>-ны үр дүнд “Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл нь **ШУТ-ийн талаар баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэнд үнэлэлт өгөх** үндсэн чиг үүрэг бүхий орон тооны бус Засгийн газрын дэргэдэх зөвлөл бөгөөд ШУТҮЗ-ийн дүрмийн 4.2-т зааснаар тус зөвлөл улиралд 1 удаа хуралдахаар заасан боловч “**УАГ-ын дүгнэлтэнд орсон мэдээгээр 2004 онд 1 удаа, 2005 онд 2 удаа, 2006 онд 1 удаа тус тус хуралджээ. ШУТҮЗ нь 2006 онд 9 яамны захиалгаар хэрэгжиж буй 36 төслийн эхний хагас жилийн үр дүнг 1 удаа хэлэлцэснийг эс тооцвол өөрийн чиг үүргийн дагуу төслүүдийн үр дүнг хэлэлцээгүй**” гэсэн үр дүн гарсан байна. Ийнхүү хуулиар бүрэн эрх, эрх, үүргийг нь хуульчлан тогтоосон ч эргээд хэрэгжилтэд хяналт тавих механизм үгүйгээс шинжлэх ухааны салбарын оролцогч байгууллагууд идэвхгүй ажиллах байдалтай байгаа нь холбогдох хуулиудад хяналтын механизмыг суулгах шаардлагатайг харуулж байна.

Нөгөөтэйгүүр ШУА-ийн төрийн байгууллага ч биш, төрийн бус байгууллага ч биш тодорхойгүй статус, “зөвлөх байр суурь...” төдийхнөөр хязгаарлагдах эрх зүйн байдал нь эргээд энэ салбарын үйл ажиллагааны идэвхжилтэд тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа байдал ажиглагдаж байна.

<sup>31</sup> “Шинжлэх ухаан, технологийн сангийн зарцуулалт, үр дүнгийн мониторинг”. ННФ. УБ., 2009.

## Зургаа. Давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, уялдаа холбоог сайжруулах

### Шинжлэх ухааны салбарын хуулийн давхардал

Судалгаа, шинжилгээний үйл ажиллагаатай уялдуулан Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хийдэл, давхардал, зөрчлийг арилгах, бусад хуулиудыг уялдуулах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, уг хуулийг хэрэгжүүлэхээр Улсын Их Хурал, Засгийн газраас баталж гаргасан холбогдох нийт дараах 27 эрх зүйн актад мониторинг хийсэн:

<i>Эрх зүйн актын төрөл</i>	<i>Тоо</i>
▪ Хууль	10
▪ УИХ-ын тогтоол	1
▪ Засгийн газрын тогтоол	7
▪ Сайдын тушаал	8
▪ Засгийн газрын агентлагийн даргын тушаал	1

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 68-р тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2010 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, тэдгээрийн уялдаа холбоог сайжруулах аргачлал”-д заасан хууль тогтоомжийн давхардлыг тогтоох шалгуур үзүүлэлтийн дагуу дээрх эрх зүйн актуудыг авч үзэхэд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн зохицуулалтын 4.1.1-ийг тухайн хуульд нийцүүлэн гаргасан Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрэм журамд хуулбарлан оруулсан байв.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, 2006.	Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн ерөнхий дүрэм БСШУ-ны сайдын 2007 оны 454 дүгээр тушаалын хавсралт
<b>4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим</b> <i>4.1.1. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх;</i>	<b>4 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны зарчим</b> <i>4.1.1. Үндэсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил явуулахгүй байх;</i>

### Шинжлэх ухааны салбарын хуулийн зөрчил

Хууль, тогтоомжийн зөрчил тодруулах 13 үзүүлэлтийн дагуу авч үзэхэд дараах 4 шалгуур үзүүлэлтээр нийт 7 зөрчил илэрсэн бөгөөд тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэхгүй байх, хуулийн зүйлийн нэр тухайн зүйлд байгаа хэсэг, заалтын агуулгын нийлбэртэй нийцэхгүй байх, тухайн хуульд бусад хуулиас авсан ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэхгүй байх зөрчил тус бүр нэг удаа, хуульд заасан нэр томьёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томьёотой зөрчилдөж байгаа 4 тохиолдол илэрсэн. Эдгээр зөрчлийн тохиолдлыг хүснэгт 1.1.5-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

#### Хүснэгт 1.1.5. Хууль тогтоомжийн зөрчил

Хуулиуд	Зөрчилтэй зүйл заалтууд	Тайлбар
<b>Шалгуур үзүүлэлт: Тухайн зохицуулалт нь хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх</b>		
Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	1.1. Энэ хуулийн зорилт нь шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт,	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль нь ерөнхийдөө хуулийн үндсэн зорилтод нийцсэн зохицуулалтыг агуулж байна. Гэвч сүүлийн жилүүдэд эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудаас гаргаж буй бүтээгдэхүүний

	санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтооходой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	нэр төрлийг бүрэн тодорхойлоход хуулийн 3 дугаар зүйл дэх “Хуулийн нэр томъёо” хангалтгүй байна. Мөн энэ хууль болон үүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн актууд нь ихэвчлэн байгалийн шинжлэх ухаан болон технологийн дэвшил гаргасан буюу гаргахад чиглэсэн үйл ажиллагааг гол төлөв зохицуулж байна. Иймээс нийгмийн шинжлэх ухааны салбарын судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг хөгжүүлэх, хөхиүлэн дэмжих, нийтийн хүртээл болгох тал дээр зохицуулалт тусгахад анхаарах шаардлагатай байна.
<b>Шалгуур үзүүлэлт: Хуульд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн болон бусад хуулийн нэр томъёотой зөрчилдөж байгаа эсэх</b>		
Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	<p><b>7 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэн эрх</b></p> <p>7.1.Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-тэй байна.</p> <p>7.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ ШУТТХ-ийн 7 дугаар зүйлд зааснаар Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн (ШУТҮЗ) дүрмийг Засгийн газар батлахаар заасан байна.</li> <li>➤ Технологи дамжуулах тухай харилцааг зохицуулах тул технологийн зөвлөл, технологийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг ШУ технологийн тухай хуулийн 7 дугаар зүйл мөн 11.2.3 дахь заалтад зааснаар зохицуулах нь зүйтэй.</li> </ul>
Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	<p>7.1. Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-тэй байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Хуулийн заалт ШУТҮЗ-ийн дүрмийн дараах хэсэгтэй зөрчилдөж байна.</li> <li>➤ 1.1. Энэ дүрмээр Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл (цаашид "Үндэсний зөвлөл" гэнэ)-ийн үйл ажиллагааг зохицуулна.</li> <li>➤ ШУТҮЗ-ийн дүрэм дэх товчлол нь ШУТТХ-ийн 7.1 дэх хэсгээс зөрүүтэй байна.</li> <li>➤ ШУТҮЗ-ийн дүрэм дэх товчлолын ШУТТХ-ийн 7.1 дэх хэсэгтэй адил болгох шаардлагатай.</li> </ul>
Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн дүрэм	<p><b>7 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн бүрэн эрх</b></p> <p>7.1.Засгийн газар нь шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын хэрэгжилтэд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/-тэй байна.</p> <p>7.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ ШУТТХ-ийн 7 дугаар зүйлд зааснаар ШУТҮЗ-ийн дүрмийг Засгийн газар батлахаар заасан байна.</li> <li>➤ Технологи дамжуулах тухай харилцааг зохицуулах тул технологийн зөвлөл, технологийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийг ШУ технологийн тухай хуулийн 7 дугаар зүйл мөн 11.2.3 дахь заалтад зааснаар зохицуулах нь зүйтэй.</li> </ul>
Инновацийн тухай хууль	<p>6.1.Засгийн газар инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>7.1.Өндөр технологи, үндэсний инновацийг хөгжүүлэх асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага инновацийн үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Технологи дамжуулах тухай хуульд дараах байдлаар заасан нь Инновацийн тухай хуультай зөрчилдөж байна.</li> <li>5.1. Технологи дамжуулах талаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</li> <li>6.1. технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь технологи дамжуулахтай холбогдсон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>➤ Инновацийн тухай хуульд Засгийн газар инновацийн үйл ажиллагаа болон технологи дамжуулах үйл ажиллагааг өргөн хүрээнд зохицуулсан байна.</li> <li>➤ Технологи дамжуулах тухай хуулийн зохицуулалтыг Инновацийн тухай хуульд нийцүүлэх.</li> </ul>
<b>Шалгуур үзүүлэлт: Тухайн хуульд бусад хуулиас авсан ишлэлийн дугаар нь нөгөө хуульд байгаа зохицуулалттай нийцэж байгаа эсэх</b>		
Шинжлэх ухаан, технологийн тухай хууль	25.1.4. энэ хуулийн 17.4, 17.5-д заасан үүргээ биелүүлээгүй захиалагч байгууллага, хуулийн этгээдийг 150000-200000 төгрөгөөр, албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгох;	<ul style="list-style-type: none"> <li>➤ ШУТТХ-ийн 17.4 дэх хэсэг 2012.5.22-ны өдрийн хуулиар хүчингүй болсон ба уг хэсгийг хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага хэсэгт ишилсэн хэвээр байна.</li> <li>➤ Хуулийн 25.1.4 дэх заалтаас 17.4 дэх хэсгийг хасах.</li> </ul>

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан Академийн үүрэг гэдэгт “чиг үүрэг” болон “бүрэн эрх”-ийн шинжтэй заалтууд оруулсан. Ийнхүү эрх, үүрэг, чиг үүрэг, бүрэн эрхийг ялгаваргүйгээр хуульчилсан нь зөрчлийн шинжийг агуулж байна.

### Шинжлэх ухааны салбарын хуулийн хийдэл

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг шууд хамааралтай 10 хуультай, мөн УИХ, Засгийн газар, холбогдох яам, агентлагаас гаргасан 17 тогтоол, шийдвэрийг харьцуулсны үндсэн дээр дараах саналыг гаргаж байна.

Уг хууль нь шинжлэх ухаан, технологийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын үйл ажиллагаанд хэрэглэгдэх нэр томъёо, үндсэн зарчим, үйл ажиллагааны удирдлага, түүний эрх, үүрэг, эрдэм шинжилгээний байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгах, санхүүжүүлэх болон эрдэм шинжилгээний ажилтны эрх, үүрэг, нийгмийн баталгаа, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулсан бөгөөд хуулийн хэрэгжилттэй холбогдуулан ЗГ, УИХ, сайдын зүгээс гаргасан тогтоол, дүрэм, журам цөөнгүй байв. Сүүлийн жилүүдэд улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг төрийн болон төрийн бус судалгааны байгууллагуудын тоо эрс нэмэгдсэн. Үүнтэй холбогдуулан судалгаа, шинжилгээний байгууллагуудаас гаргаж буй бүтээгдэхүүний нэр төрөл, тоо мөн адил өсөж байна. Иймд шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн “Хуулийн нэр томъёо” хэсэгт суурь болон хавсарга судалгааны төрлөөс гадна бусад судалгааны төрлүүдийг нэмж оруулах хэрэгцээ шаардлага байна<sup>32</sup>.

Технологийн түвшний үнэлгээний талаар Гэгээрлийн сайдын 1998 оны 271 дүгээр тушаалаар зохицуулж байсан нь одоо хэрэгждэггүй байна. Эрдэм шинжилгээний байгууллага технологийн түвшний үнэлгээ хийх нарийвчилсан зохицуулалтгүй буюу тодруулбал, Шинжлэх ухаан, технологийн тухай (2006) хуулиар технологийн түвшний үнэлгээ хийх талаар зохицуулалт бараг тусгагдаж өгөөгүй. Технологи дамжуулах тухай хуулийн 7.3 дахь хэсэгт эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага технологийн түвшний үнэлгээ хийхээр заасан байгаа хэдий ч эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллага гэж ямар байгууллагыг хэлэх, мөн технологийн түвшний үнэлгээ хэрхэн хийхийг заасан зохицуулалт байхгүй байна.

“...Хуулийн хэрэгжилтийг нэг мөр хангах үүднээс холбогдох эрх зүйн актуудтай өөрөөр хэлбэл, Технологи дамжуулах тухай хуультай холбогдолтой 56 хууль, МУ-ын ШУТ-ийг 2007-

<sup>32</sup> “ХЗҮХ-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах нийцлийн мониторинг”. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2016. 59 дэх тал.

2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр зэрэг УИХ тогтоол, Засгийн газрын тогтоолууд, бусад эрх зүйн актуудтай уялдуулах хэрэгтэй юм. Шинжлэх ухаан, технологийн зөвлөл ажилладаг хэдий ч шинжлэх ухааны хөгжлийн нэг гол тулгуур болох техник, технологийн хөгжлийн асуудлыг орхигдуулаад байна. Шинжлэх ухааны ололт, оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгох, ашиглаж нэвтрүүлэх үйл явц ямагт хоцрогдож ирлээ. Технологи, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж хэрэглэгчийн эрх ашгийг хангах бүтээгдэхүүн бий болгох, удирдан чиглүүлэх Технологийн зөвлөл байгуулагдаж үйл ажиллагаа явуулах шаардлагатай байгаа хэдий ч энэ нь Засгийн газрын хэмжээнд шийдвэрлэх асуудал болох нь холбогдох хууль, УИХ, Засгийн газрын тогтоолоос харагдаж байна. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар технологийн нэгдлийг байгуулж ажиллуулж болох хэдий ч энэ нь эрдэм шинжилгээний байгууллагын хүрээнд байгуулагдан үйл ажиллагаа явуулахаар (уг хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт), мөн уг байгууллагын үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батлах ба удирдлагыг удирдах зөвлөл хэрэгжүүлэхээр заажээ. Технологийн түвшний үнэлгээ заавал хийх итгэмжлэгдсэн шинжээчийг ажиллуулах нь байгаль орчин, хүний эрүүл мэнд, мал амьтанд сөрөг нөлөө бий болохоос урьдчилан сэргийлэх технологийг ашигласны эдийн засгийн үзүүлэлт, бүтээгдэхүүний стандарт чанар аюулгүй байдлын үзүүлэлтийг гаргах, техник, оюуны болон бусад хүчин зүйлийн цогц нөлөөллийг тодорхойлох, түүнд тулгуурлан технологийн хөгжил дэвшлийн цаашдын чиг хандлагыг тогтооход чухал ач холбогдолтой. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8.1.6 улсын захиалгатай эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, үр дүнд нь хянан магадлагаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай тохиолдолд санхүүжилтийг зогсоох, хохирлыг барагдуулах асуудлыг шийдвэрлэж ШУТ-ийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэхээр байгаа нь технологийн үнэлгээ хийх гэсэн ойлголтыг агуулахгүй юм. Технологийн үндэсний зөвлөл байгуулахдаа ШУТ-ийн тухай хуулинд нийцүүлэн яамдуудад ажиллаж байгаа ШУ, технологийн зөвлөлийг тус тусад нь дүрмийг өөрчлөн Засгийн газраас баталж өгвөл энэ чиглэлийн технологийн түвшний үнэлгээ хийх итгэмжлэгдсэн шинжээч ажиллуулах, технологи дамжуулах төвийн үйл ажиллагааг төрөөс дэмжих, уг хуулийн хариуцлагын тогтолцоог өөрчлөх гэх мэт ажлууд эрчимтэй хийгдэнэ гэж үзэж байна”<sup>33</sup>.

***Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар*** Шинжлэх Ухааны Академийн Ерөнхийлөгчийн эрх, үүргийг явцуу хүрээнд хуульчилжээ.

Эрдэм шинжилгээ, судалгаа, төслийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үйлдвэрлэгч, хувийн хэвшлийн санхүүгийн оролцоог хуулиар тусгайлан зохицуулах шаардлагатай байна.

Шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын зарчим, бүтэц, бодлого боловсруулж хэрэгжүүлэх арга, хэлбэрийн тухай тодорхой хуульчилж, судалгааны ажлын өрсөлдөх чадвар, үр ашигт маркетингийг төлөвшүүлэх, хувь судлаачийн ахуй амьдрал, боловсролын хэмжээг тууштай сайжруулах, бүхий л хэвшлийн судалгааны байгууллагын ухаалаг менежмент, оновчтой зохицуулалт бүхий үзэл баримтлалыг боловсруулж мөрдөх, ШУТС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлж мөрдөх хэрэгтэй байна.

Шинжлэх ухааны салбар дахь мэргэжлийн байгууллагуудын бүрэн эрх, эрх, үүргийг хангалттай хуульчилж өгөөгүй, шинжлэх ухааны салбарын харилцааг зохицуулж буй

<sup>33</sup> “ХЗҮХ-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль тогтоомжуудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах нийцлийн мониторинг”. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2016. 59 дэх тал

салбарын хууль тогтоомжид хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна.

Эрдэм шинжилгээний ажилтны хамгийн гол баталгаа болох тогтвортой ажлын байрны асуудал хуулийн хүрээнд бодлогоор хангагдаагүй, ШУТС-гийн бүтэц, зохион байгуулалт нь тодорхойгүй байна.

Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогчдын эрх зүйн байдлыг тодорхой заагаагүй байна.

Тухайн хуульд тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрхийг төрийн бусад байгууллагад шилжүүлсэн бөгөөд уг нарийвчилсан зохицуулалт батлагдсан эсэхийг /шалгуур үзүүлэлтийн дагуу/ авч үзэхэд дараах үр дүн гарч байна.

№	Тодорхой харилцааны нарийвчилсан зохицуулалтыг батлах эрх бүхий төрийн байгууллага	Батлагдсан эсэх
1.	7.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.	Дүрэм батлагдсан. <b>ЗГ-ын 2007 оны 146 дугаар тогтоол</b>
2.	11.6.Дээд боловсролын байгууллагыг энэ хуулийн 11.2.2-т заасан эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	Үнэлгээний үзүүлэлт батлагдсан. <b>Үнэлгээний үзүүлэлт батлах тухай /Дээд боловсролын байгууллага, үндэсний хэмжээний музей, номын санг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт/ БСШУ-ны сайдын 2007 оны 463 дугаар тушаал</b>
3.	11.11.Энэ хуулийн 11.2.3-т заасан байгууллагын үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батлах бөгөөд удирдлагыг нь Удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.	Дүрэм батлагдсан <b>Дүрэм шинэчлэн батлах тухай /ШУ, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм/ ЗГ-ын 2006 оны 142 дугаар тогтоол</b>
4.	11.12.Энэ хуулийн 11.2.4-т заасан байгууллага нь өөрийн үйл ажиллагааны чиглэлд хамаарах судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг дангаараа буюу эрдэм шинжилгээний бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд тэдгээрийг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.	Үнэлгээний үзүүлэлт батлагдсан. <b>Үнэлгээний үзүүлэлт батлах тухай /Дээд боловсролын байгууллага, үндэсний хэмжээний музей, номын санг эрдэм шинжилгээний байгууллагын зэрэглэлд хамааруулах үнэлгээний үзүүлэлт/ БСШУ-ны сайдын 2007 оны 463 дугаар тушаал</b>
5.	19.3. Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлагдсан <b>БШУ-ны сайдын 2012 оны №А/88 тушаал</b>
6.	19.4.Судалгааны ажлын арга барил эзэмшсэн байдал, ур чадварынх нь түвшин, ажлын үр дүнг үнэлэх, зэрэг дэвийг ахиулах зорилгоор эрдэм шинжилгээний ажилтныг 4 жил тутамд аттестатчилалд хамруулах бөгөөд журмыг нь шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлагдсан <b>Журам батлах тухай /эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам/ БШУ-ны сайдын 2007 оны №211 тушаал</b>
7.	20.2.Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрмийг эрдэм шинжилгээний байгууллагуудын саналыг харгалзан шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Журам батлагдсан <b>Дүрэм батлах тухай /Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм/ БСШУ-ны сайдын 2007 оны №454 тушаал</b>
8.	21.2.Улсын төсвөөс санхүүждэг эрдэм шинжилгээний байгууллагын ажилтны цалингийн	Журам батлагдсан

	сүлжээ, тэдгээрт нэмэгдэл, нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.	Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийн шинэчлэн батлах тухай ЗГ-ын 2014 оны 75 дугаар тогтоол
9.	22.2. Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам, шагналын хэмжээг Монгол Улсын Засгийн газар батална.	Журам батлагдсан Журам батлах, шагналын хэмжээ тогтоох тухай /Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам/ ЗГ-ын 2007 оны 147 дугаар тогтоол

Хуульд заасан хориглосон зохицуулалт нь түүнийг зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх (7.3.6) шалгуур үзүүлэлтийн дагуу Шинжлэх ухаан технологийн тухай хуулийг авч үзэхэд дараах үр дүн гарч байна.

Дд	Хуульд заасан хориглосон зохицуулалт	Хариуцлагыг заасан зүйл заалт
1.	13.2.4.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын тайланг уг ажлыг дууссанаас хойш 60 хоногт багтаан шинжлэх ухаан, технологийн мэдээллийн санд хүргүүлж хадгалуулах;	25.1.1.
2.	13.2.5.эрдэм шинжилгээний ажлын явц, гүйцэтгэл, түүнчлэн санхүүжилтийн зориулалтаар олгосон хөрөнгийн зарцуулалтын мэдээ, тайланг захиалагч, санхүүжүүлэгч байгууллагын шаардсанаар тухай бүр үнэн зөв гаргаж өгөх;	25.1.1.
3.	13.2.6.эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явц буюу үр дүнд байгаль орчин, хүн, мал, амьтны эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэхээр байдал илэрвэл мэргэжлийн байгууллагад мэдэгдэж дүгнэлт гаргуулах, уг байдал тогтоогдвол ажлаа зогсоох, учирч болох сөрөг нөлөөлөл, хохирлын талаар захиалагч, санхүүжүүлэгч, холбогдох бусад байгууллагад мэдэгдэх;	25.1.2.
4.	17.2.3.гүйцэтгэсэн ажлын үр дүнг хүлээн авч хянан, баталгаажуулах арга хэмжээг уг ажлын үр дүнг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэх;	25.1.3.
5.	17.5.Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрхэн нэвтрүүлж ашигласан талаар Зөвлөлд хоёр жил тутамд тайлагнана.	25.1.4.
6.	17.2. Эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын захиалагч дор дурдсан үүрэгтэй:	25.1.5.
7.	18.1.8. гадаад, дотоодын байгууллага, хуулийн этгээд, иргэний хөрөнгөөр гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын гүйцэтгэгч нь уг ажлын сэдвийг шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэх.	25.1.6.

### Шинжлэх ухааны салбарын хуулийн бичвэрийн харьцуулалт

“Шинжлэх ухаан, технологийн тухай” хууль болон бусад хууль тогтоомжийн эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /[www.legalinfo.mn/](http://www.legalinfo.mn/)-д байгаа хувийг бусад хуулийн хувьтай тулгасан нь:

№	<a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a>	“Төрийн мэдээлэл” сэтгүүл
	Шинжлэх ухаан технологийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны №4/481/ дугаарт нийтлэгдсэн	
1.	7.3.15.эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;	7.3.15.эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт;
2.	7.3.16.хуульд заасан бусад чиг үүрэг.	7.3.16.хуульд заасан бусад чиг үүрэг.
<i>Санал: Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 17.2.1 дэх заалтын дагуу дэс дараалалд оруулах</i>		

№	<a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a>	“Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2006 оны №7 /436/ дугаар
	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль	

2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2.1.Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль', Иргэний хууль I, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 1. Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн. 2. Иргэний хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
<b>Санал: Ишлэл хэсгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувьтай нийцүүлэх.</b>	

№	<a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a>	“Төрийн мэдээлэл” эмхэтгэл 2006 оны №7 /436/ дугаар
<b>Патентын тухай хууль</b>		
1.	2.1.Патентын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.	2.1.Патентын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль', Иргэний хууль I, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. 1. Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн. 2. Иргэний хууль - “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.
<b>Санал: Ишлэл хэсгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувьтай нийцүүлэх.</b>		

### Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн хэрэгжилт

2006 онд батлагдсан энэхүү хуулийн хэрэгжилт хангалтгүй гэж хэлж болно. Хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаа салбарын санхүүжилтийн нөхцөл байдлаас шалтгаалж орхигдсон. Шинжлэх ухааны талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэх төслийн талаар мэдээлэл бидэнд олдоогүй учир зөвхөн тус хуулийн хүрээнд зарим дүгнэлтийг хийж байгаа болно. Үүнд:

1. Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 8.1.13 дах заалтад “Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх” хэмээн заасан нь огт хэрэгжихгүй байна. Энэ зүйл заалт нь Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхэд хамаарч байгаа хэдий ч санаачилгагүй байдалтай нь холбоотойгоор өнөөдөр эрдэм шинжилгээний ажилтнууд цалин  $\text{100} \times \text{1000}$  байгаа юм.

2. Мөн түүнчлэн Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 9.1.7 дах заалтад “Эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, тус хуулийн 11.14 дэх заалтад “Эрдэм шинжилгээний байгууллага нь зориулалтын барилга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон туршилт явуулах бусад нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд ийнхүү хангах үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ” гэсэн зүйл заалтууд нь санхүүжилт бага учир хэрэгжихгүй, шийдвэрлэх арга зам нь тодорхойгүй байна.

3. Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн “Эрдэм шинжилгээний ажил болон бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хуульд заасан хөнгөлөлт эдлэх” тухай 13.1.7 дахь заалт хэрэгжихгүй байна. Зарим нааштай алхам бий боловч шагналын хэмжээ нь үр дүнгийн бодит үнэлгээ болж чадахгүй байгаа юм.

4. ШУТ-ийн тухай хуулийн 18.1.1 дэх заалт “Гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын зардал төлөвлөсөн хэмжээнээсээ нэмэгдэхээр байвал энэ тухай саналаа захиалагчид тавьж шийдвэрлүүлэх” гэдэг нь гэрээ байгуулаад тохирсон зардлаас санхүүжилтийг нь танаж олгодог тул хэрэгжихгүй, тус хуулийн 18.1.3 дах заалт “Захиалагч үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах санал тавьж шийдвэрлүүлэх” гэж байна. Гэтэл эрдэм шинжилгээний байгууллага оршин тогтнохын тулд энэ эрхийг эдэлж чадахгүй, ийм эрхээр асуудал хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээлэл байдаггүй.

5. Эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн баталгаа гэсэн хэсэгт Шинжлэх ухаан технологийн тухай хуулийн 21.1.2 дахь заалт буюу “Орон сууц барих буюу худалдан авах зориулалтаар буцалтгүй тусламж, хөнгөлөлтэй зээл авах” гэсэн заалт хэрэгжихгүй байна. Эрдэм шинжилгээний ажилтан байр барих болон бусад хэрэгцээ шаардлага гарахад цалингаа барьцаалж зээл авахаас өөр ямар нэг хөнгөлөлт эдлэхгүй байна. Цалингаа барьцаалж зээл авахад цалин бага учир их хэмжээний зээл авах ямар ч боломжгүй.

Шинжлэх ухаан, технологийн салбарын холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах талаар судлаачдын дунд дэмжигддэг саналуудыг холбогдох хуулиудаар ялган дараахь хүснэгтээр товчоолон харуулав.

#### Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал

№	Нэмэлт өөрчлөлт оруулах зүйл, заалт	Шинжлэх ухаан, технологийн хуульд нэмэх санал	Хэрэгцээ шаардлага, үндэслэл
1	1 дүгээр зүйлийн 1.1-г	....шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. “ <b>шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, дамжуулах</b> ” гэж нэмж оруулах/	Цаг үеийн шаардлагад нийцүүлэх буюу эдүгээ технологийн эрин зуунд амьдарч байгаа тул нийгмийн харилцаа өөрчлөгдөж, хөгжиж байна. Инноваци, технологи дамжуулах, нэвтрүүлэх зохицуулалтыг ШУТ-ийн хуулинд тусгах. Инновацийн тухай болон Технологи дамжуулах тухай хуулийн цогц уялдаа холбоо хангагдаж, ШУТ-ийн үйл ажиллагаа төгөлдөржинө.
2	3 дугаар зүйлийн 3.1.10-г, 2 дугаар бүлэгт	“ <b>шинэ технологи, инноваци нэвтрүүлэх, дамжуулах</b> ” хуулийн нэр томъёог нэмж оруулж тодорхой болгох	Хуулийн нэр томъёо тодорхой болж нэгдсэн ойлголттой болно.
3	4 дүгээр зүйлийн 4.1.7-д	“ <b>Шинжлэх ухаан, технологийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх</b> ” гэж нэмж оруулах	Олон нийтэд шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа, үр дүнг талаар түгээн дэлгэрүүлж, тэдэнд сургалт сурталчилгаа зохион байгуулах нь иргэний боловсрол, оюуны соёлын түвшинг дээшлүүлнэ.
4	5 дугаар зүйлийн 5.2-г	МУ-ын шинжлэх ухаан, технологийн зөвлөл, <b>шинжлэх ухаан, технологийн сантай байна.</b> /“ <b>шинжлэх ухаан, технологийн сан</b> ” гэсэн үгийг нэмж оруулах/	Гадаадын зарим улс орны Шинжлэх ухааны академи нь өөрийн гэсэн сантай байгааг жишиг болгох.
5	6 дугаар зүйлийн 1.7-д	Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, харьяаллын талаар шийдвэр гаргах. / <b>харьяаллын талаар</b> гэсэн үг нэмсэн/	Эрдэм шинжилгээний байгууллагыг Их сургуулийн, Шинжлэх ухааны академийн зэргээр ангилж байгуулах, өөрчлөлт оруулах, татан буулгахад харьяалал тодорхой болно.
6	7 дугаар зүйлийн 7.1-д	ЗГ нь ШУТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, бодлогын	Шинжлэх ухаан технологийн сан, зөвлөл нь орон тооны болсноор бие даан ажиллах орчин нөхцөл бүрдэнэ.

		хэрэгжилтэнд үнэлэлт өгөх, шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх, ШУТС-ийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах талаар тогтоол гаргах үүрэг бүхий ШУТ-ийн зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/-тэй байна. <b>/ШУТ-ийн зөвлөл нь орон тооны байна/</b>	Яамдуудад орон тооны бус байж болно.
7	7 дугаар зүйлийн 7.2-т	Зөвлөл нь дор дурдсан асуудлыг хэлэлцэж <b>тогтоол</b> гаргана. /зөвлөмж гэдгийг <b>тогтоол</b> болгосон/	Хамтын байгууллагын шийдвэр тогтоол байна.
8	7 дугаар зүйлийн 7.2.5-т	... <b>“дамжуулах..”</b> гэсэн үгийг нэмж оруулах	ШУТ-ийн ололт үйлдвэрлэл үйлчилгээнд дамжуулах үйл ажиллагаанд зарцуулах санхүүжилтийн эх үүсвэр тодорхой болно.
9	7 дугаар зүйлийн 7.3.15 <sup>1</sup> -д	“Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл” гэж өөрчлөх.	
10	7 дугаар зүйлийн 7.2.7-д	ШУТ-ийн сангийн <b>төлөвлөлт</b> тайлан. / <b>төлөвлөлт</b> гэсэн үг нэмж оруулах/	
11	7 дугаар зүйлийн 7.4-т	Зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газар, ШУА, их сургуулиуд, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллага, бизнесийн төлөөллийг оролцуулан зөвлөл нь <b>ажлын албатай</b> байна. /зөвлөл нь <b>ажлын албатай</b> гэсэн үг нэмсэн/	Зөвлөл ажлын албатай болсноор бие даан ажиллах орчин нөхцөл бүрдэнэ.
12	8 дугаар зүйлийн 8.1.7-д	<b>“...дотоод, гадаадад...”</b> гэсэн үгийг нэмж оруулах	Дотоод, гадаадад мэргэжилтэн бэлтгэх арга хэмжээг санхүүжүүлэх нөхцөл бүрдэнэ.
13	8 дугаар зүйлийн 1.11-т	<del>Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журам батлах.</del> /Энэ зүйл заалтын хүчингүй болгох /	Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах зөвлөлийн гишүүдийг өөрчлөх, бусад шаардлагаар заавал сайд тушаал гаргах шаардлагагүй. ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэх.
14	9 дүгээр зүйлийн 1.4 <sup>1</sup>	Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилт, зарцуулалт, тайлангийн асуудлыг шийдвэрлэх /шинээр оруулах <b>шинжлэх ухаан, технологийн сантай</b> холбоотой/	БСШУ хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шинжлэх ухаан, технологийн зөвлөл нь ШУТС-ийн санхүүжилт, зарцуулалт, тайлангийн асуудлыг шийдвэрлэх эрхтэй болно.
15	11 дүгээр зүйлийн 11.5-д	... <del>“мэргэжлийн зэрэг олгох түр сургалт явуулах”</del> гэсэн үгийг хасах	Боловсролын тухай хуулинд түр сургалт гэдэг ойлголт байхгүй.
16	13 дугаар зүйлийн 13.1.4-т	<b>“...гадаадад суралцах..”</b> гэсэн үгийг нэмж оруулах	Мэдлэгийн менежментийн тогтолцоо механизм бүрдүүлэх, мэдлэг, оюун ухаан шаардсан, оюуны багтаамж өндөртэй салбарын мэргэжилтэнг түлхүү бэлтгэх, хөгжингүй орнуудад залуучуудыг сургах, гадаадад суралцаж, ажиллаж буй өндөр мэдлэг, ур чадвар бүхий боловсон хүчнийг эх орондоо ирж ажиллах таатай нөхцөл бүрдүүлэх замаар шинжлэх ухаан, технологийн хүний нөөцийг зохистой бүрдүүлнэ.
17	13 дугаар зүйлийн 13.2.7-д	<b>“...гадаад улс, олон улсын байгууллага, ААН байгууллага, иргэний захиалгатай”</b> гэж өөрчлөх	

18	13 дугаар зүйлийн 13.2.8-д	“...технологи, инновацийг нэвтрүүлэх, дамжуулах” гэсэн үгийг нэмж оруулах	Эрдэм шинжилгээний ажлын үр дүн болох технологи, инновацийг нэвтрүүлэх, дамжуулахад хамтран ажиллаж эрдэм шинжилгээний байгууллага 2 дэмжлэг үзүүлэх орчин бүрдэнэ.
19	Гуравдугаар бүлэгт 14 дүгээр зүйлийг шинээр нэмж оруулах	Шинжлэх, ухаан, технологийн үйл ажиллагаанд оролцогч байгууллага болох “Шинжлэх ухаан, технологийн инкубатор” шинээр нэмж оруулах	Инноваци, технологи дамжуулах нэвтрүүлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, үндэсний технологийн уламжлалт салбарт ШУТ-ийн дэвшлийг нэвтрүүлэх, үндэсний үйлдвэрлэл, бизнесийг хөгжүүлэх асуудлыг зохистой шийдвэрлэх хүрээнд инновацийн үр дүнтэй арга хэрэгсэл болох технологи бизнесийн инкубацийг үүсгэн хөгжүүлэх, холбогдох байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Инноваци, технологи дамжуулалт гэсэн харилцан уялдаа бүхий үзэгдлийг нэгтгэн ажиллуулдаг сүлжээ бий болгох, хувийн хэвшлийн оролцоог хангах, төр, хувийн хэвшлийн түншлэлийг зүй зохистойгоор хэрэгжүүлэх. Технологи дамжуулах салбарт Outsourcing-ийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх.
20	Гуравдугаар бүлэгт шинээр нэмж оруулж буй 14 дүгээр зүйл-д	“Шинжлэх ухаан, технологийн судалгааны мэдээллийн нэгдсэн сан” бий болгож ажиллах	Судалгааны ажлын тайлан мэдээллийг харилцан солилцох, олон улсын мэдээллийн датад байршуулах, ижил сэдвээр давхардсан судалгаа гүйцэтгэж хөрөнгө санхүү, цаг хугацаа хэмнэх, шинжлэх ухааны талаарх статистик тоо баримтын нэгдсэн сан бүрдэнэ.
21	14 дүгээр зүйлийн 1.1 <sup>1</sup>	ШУТ-ийн сангийн хөрөнгөөр /шинээр шинжлэх ухаан, технологийн сантай уялдуулж оруулсан/	Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг төрөөс санхүүжүүлэх эх үүсвэрийн нэг төрөл.
22	15 дугаар зүйлийн 15.4-т	“Судалгааны санхүүжилт нь нийгэмд үр ашигтай томоохон төсөл хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэхэд эрдэмтдийн хамтын оролцоог идэвхжүүлэхэд нөлөөлөхүйц хэмжээнд байх” гэж шинээр нэмж оруулах	Эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, судалгааны үр дүнг төрийн бодлого шийдвэрт тусгаж хэрэгжинэ.
23	19 дүгээр зүйлийн 19.4-т	...4 жил тутамд гэсэн хугацааг “2 жил” болгож өөрчлөх	Эрдэм шинжилгээний ажилтны ажлын үр дүн, бүтээмж дээшилж, албан тушаал, зэрэг дэв дэвшиж, чадавхижна.
24	21 дүгээр зүйлийн 21.1.3-т	...25 ба түүнээс дээш гэсэн хугацааг “10 ба түүнээс дээш жил” гэж өөрчлөх ...12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний гэсэн хугацааг “36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний” гэж өөрчлөх	Эрдэм шинжилгээний ажилтны ажлын үр дүн, бүтээмж дээшилж, шинжлэх ухаан, технологийн салбарт ажиллах хүсэл сонирхолтой болж, нийгмийн баталгаа хангагдана. Оюуны хөдөлмөр эрхэлдэг онцгой салбарын ажилтны тэтгэлэг өндөр байх нь зохистой. Орчин үед нэг ажлын байранд тогтвортой удаан хугацаагаар ажиллах нь эрс багассан.
25	21 дүгээр зүйлийн 21.1.6	“Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөлөөр хангуулах” гэж шинээр нэмж оруулах	Эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн баталгаа хангагдах нөхцөл бүрдэнэ.
26	21 дүгээр зүйлийн 21.1.7	“Гүйцэтгэж байгаа албан үүргийнх нь шинж байдлыг	Төрийн албаны тухай хуулийн зүйл заалтуудтай уялдуулж хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

			харгалзан зохих журмын дагуу албаны унаа хэрэглэх, ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын зохих хэсгийг нөхөн авах” гэж шинээр нэмж оруулах	Судлаачдын ажил үүргээ гүйцэтгэж байхдаа гамшиг, осолд өртөх зэрэг эрсдлээс даатгалыг төрөөс хариуцаж байх эрх зүйн зохицуулалтыг бий болгох.
27	21 дүгээр зүйлийн 21.1.8		“Төрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх, энэ хугацаанд эрхэлж байгаа албан тушаалынхаа цалин хөлсийг авах” гэж шинээр нэмж оруулах	
28	22 дугаар зүйлийн 22.1.2-т		“...инноваци...” гэсэн үгийг нэмж оруулах	Өндөр үр ашиг, ач холбогдол бүхий инновацийг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлж ашигласан байгууллага, иргэнийг шагнаж урамшуулах нөхцөл бүрдэнэ.
29	23 дугаар зүйлийн 23.2-т		...1-ээс доошгүй хувийг гэснийг “10-аас доошгүй хувийг” гэж өөрчлөх	ШУТ бол аливаа улс орныг хөгжүүлэх тэргүүлэх салбар. Төсвийн болон санхүү татвар, хөрөнгө оруулалтын тухай хууль, холбогдох дүрэм журамтай уялдуулах
30	25 дугаар зүйлийн 25.1.2-т		...”Байгаль орчинд хортой нөлөөлөх” гэж нэмж, өөрчлөх	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 25 дугаар зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нийцүүлж өөрчлөх.

#### **Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт:**

- Хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах хэсэгт “Шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг батлах” гэж Их чуулганаар хэлэлцэх асуудалд нэмж оруулах
- Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “шинжлэх ухааны технологийн сангийн хөрөнгөөр” гэж нэмж оруулах
- ШУА-ийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зохицуулсан хуулийн 8 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн эрх, үүрэгт шинжлэх ухааны салбарын хөгжил болон төрийн бодлого, шийдвэр гаргах, эдийн засгийн үр ашигтай томоохон төсөл хөтөлбөрүүдэд шинжлэх ухааны холбогдох салбар, хүрээлэнгүүдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг өргөн хүрээнд хуульчилах
- Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад эрдэм шинжилгээ, судалгаа, төслийн ажлын үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд үйлдвэрлэгч, хувийн хэвшлийн санхүүгийн оролцоог хуулиар тусгайлан заах
- ШУА-ийг шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаатай холбоотойгоор шийдвэр гаргах статустай болгох
- ШУА-ийн статус, эрх үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох
- ШУА-ийн харьяа байгууллагуудын эрх, үүргийг хуульчилах.

#### **Инновацийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт:**

- Хуулийн 17 дугаар зүйлд инновацийн бүтээгдэхүүнд татварын хөнгөлөлт үзүүлж, ижил төсөөтэй импортын бараа бүтээгдэхүүний гаалийн татварыг нэмэх зэрэг баталгааг хуулиар зохицуулах
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлж буй өмчийн бүх хэлбэрийн байгууллага гэдэгт ямар ямар хуулийн этгээд ямар статустай оролцохыг хуулинд тодорхой зааж өгөх
- Хуулийн 21 дүгээр зүйлд инновацийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд ямар эрх, үүрэгтэй оролцох тодорхой зохицуулах

**Технологи дамжуулах тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт:**

- Хуулийн 11 дүгээр зүйлд Технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч болох иргэн, Аж ахуйн нэгж, байгууллага, эрх бүхий эрдэм шинжилгээний байгууллагын эрх зүйн байдлыг тодорхой зааж өгөх
- Хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт “технологи дамжуулах үйл ажиллагаанд оролцогч” гэж хэнийг ойлгох талаар тодорхой зохицуулах
- Хуулийн 15 дугаар зүйлд гэрээний төлбөрийн тусгайлсан зохицуулалтыг бий болгох
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хуульд шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх, хяналтын механизмыг бий болгож хуульчлах

## 1.2. ЭРХ ЗҮЙН АКТУУДАД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

**Хэм хэмжээний акт** гэдэг нь хуулиар тусгайлан олгогдсон эрх бүхий этгээдээс гаргасан, нийтээр дагаж мөрддөг, төсөөтэй тохилдолд дахин давтаж хэрэглэдэг, нийтлэг зохицуулалт бүхий гадагш чиглэсэн шийдвэрийг хэлнэ.

Хэм хэмжээний акт нь дор дурдсан шинжүүдийг бүгдийг нь заавал агуулсан байх бөгөөд эдгээр нь хэм хэмжээний актыг бусад эрх зүйн актаас ялгах үндсэн шалгуур болно.

**Нийтээр дагаж мөрдөх** – тухайн эрх зүйн актын үйлчлэл нийтэд эсвэл тодорхой хүрээнд үйлчилж байгааг,

**Төсөөтэй тохиолдолд дахин хэрэглэгддэг** – нэг удаагийн бус дахин давтсан буюу төсөөтэй болон ижил тохиолдлуудад нийтэд нь нэг мөр хэрэглэх,

**Зохицуулалт** – тодорхой эрх зүйн үр дагаварт чиглэсэн, эрх ба үүргийг үүсгэж, өөрчилж, дуусгавар болгосон эсвэл тогтоосон байх,

**Гадагш чиглэсэн** – захиргааны байгууллага дотоод хүрээндээ бус гуравдагч этгээд, байгууллагад холбогдолтой буюу тэдгээрийн эрх ашгийг хөндсөн байх,

**Хуулиар тусгайлан эрх олгогдсон эрх бүхий этгээд** – УИХ-аас хэм хэмжээ тогтоох эрхээ бусад этгээдэд хуулиар шилжүүлэх.

Хэм хэмжээний актын шинжүүд нь тийм ч тодорхой биш байдаг учир агуулгын хувьд задлан шинжлэх, тайлбарлах шаардлагатай байдаг.

### Нэг. Засгийн газрын тогтоолд хийсэн дүн шинжилгээ

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд зааснаар Засгийн газар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбогдуулан төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, мастер төлөвлөгөө, үндэсний хөтөлбөрийг батлах, судалгааны ажлын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээг тооцох зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэх бөгөөд дээрх чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд 2010-2016 онд гаргасан тогтоолд агуулгын болон эрх зүйн дүн шинжилгээ хийв.

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан нийт 11 тогтоолын 9 нь хэвийн мөрдөгдөж, “Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай” (ЗГ-ын 2010.07.07-ны өдрийн 174 тоот тогтоол), ОУ-ын Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (ЗГ-ын 2012 оны 56 тоот тогтоол), МУ-д үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх” (ЗГ-ын 2012 оны 306 дугаар тогтоол) гэсэн 3 тогтоолыг тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд хэрэгжих хугацаа дууссан боловч хүчингүй болголгүй орхижээ.

“Шинжлэх ухааны салбарыг дэмжих зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2010.07.07-ны өдрийн 174 тоот тогтоолын хавсралтаар баталсан “Шинжлэх ухаан, технологийн салбарын менежментийн шинэчлэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны уялдааг хангах, санхүүжилтийг боловсронгуй болгох, эрдэмтдийг дэмжих, залгамж халааг бэлдэх зорилтын хүрээнд 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусган, уг арга хэмжээг хэрэгжүүлэх хугацааг 2-3 жилээр тогтоож, хариуцах байгууллага, хүрэх үр дүнг тодорхой заасан боловч санхүүжилтийн эх үүсвэр, механизмыг орхигдуулснаас болж 3 жилийн хугацаанд хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн салбар дундын тулгамдсан томоохон асуудлыг шийдвэрлэх, төсөл хэрэгжүүлж, үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, шинжлэх

ухааны салбарт хувийн хэвшил болон гадаад оронтой хамтран шинжлэх ухааны парк, инкубатор байгуулах зэрэг томоохон зорилтууд шийдвэрлэгдээгүй үлдэж хоцорчээ.

Ер нь ЗГ-ын тогтоолуудаар тухайн үйл ажиллагаа хэрэгжих механизмыг нарийвчлан тодорхой зааж өгөөгүйгээс ялангуяа санхүүжилт болон үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хариуцах эзэн тодорхой бус байх, хэрэгжүүлээгүй субъектэд ямар хариуцлага ногдуулах гэхчлэн хариуцлагын механизм байхгүй буюу сул байх, эс бөгөөс хоёрдмол утгатай байх, хоёр субъектын дунд хариуцлагыг бүрхэгдүүлэн орхисон байх, хариуцсан албан тушаалтнууд солигдох, байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо тааруу нягт биш байх, эрх барьж буй улс төрийн хүчин, дээд тушаалын албан тушаалтнууд солигдсоноос хэрэгжилт удаашрах, мартагдах зэрэг олон шалтгаанаар тогтоол, шийдвэрийн хэрэгжилт тааруу буюу хүлээсэн үр дүндээ хүрэхгүй байх нь нийтлэг байна.

Бүтээн байгуулалтын ажлууд, томоохон хөрөнгө оруулалт, төсөв мөнгө шаардсан ажлууд хэрэгжилгүй үлдэж хоцордог байдал бараг жишиг болон тогтжээ.

ЗГ-ын тогтоолын хэрэгжих хугацаа дууссанаас үр дүнтэй хэрэгжиж байсан арга хэмжээ тасалдах, товлосон хугацаанд хэрэгжиж бүрэн дуусаагүй үлдэж хоцрох тохиолдлууд цөөнгүй гарч байна. Иймд тогтоолын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч хэрэгжүүлээгүй үлдсэн ажлыг хийж гүйцэтгэх хугацааг сунгах, эсвэл хугацаа дуусмагц шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр эргэх холбоотой ажиллах шаардлага тулгарчээ. “Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгасан ажлыг 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд нилээд ажил хийгдсэн боловч зорилгод үр дүндээ бүрэн хүрээгүй учир хөтөлбөрийг дахин шинэчлэн боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### Хүснэгт 1.2.1. Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийн байдал

<i>ЗГ-ын тогтоол</i>	<i>Тогтоолын хэрэгжилт</i>
<b>Хүчинтэй, хэрэгжилт хангалтгүй</b>	
<b>МУ-д Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр</b> <i>ЗГ-ын 2007 оны 306 дугаар тогтоол</i>	Мастер төлөвлөгөөнд тусгагдсан зорилго зорилт энэ хөтөлбөрөөр дамжин хэрэгжих бөгөөд Инновацийн тогтолцоог бүрдүүлэх, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, төрийн өмчит их сургуулийн эрдэм шинжилгээ, судалгаа боловсруулалтын ажлыг дэмжих, залуу судлаачдыг бэлтгэх, дэмжих гэсэн 4 дэд хөтөлбөртэй. Эдгээр хөтөлбөрт тусгагдсан гол арга хэмжээнүүдийг Мастер төлөвлөгөөний үе шатны төлөвлөлтөд тусган 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн. Эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлд нилээд ажил хийгдсэн. Дэд бүтцийг байгуулах, лабораторийн орчинг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэхэд 10 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн боловч зорилгод үр дүндээ бүрэн хүрээгүй. Хөтөлбөрийг дахин шинэчлэн боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай.
<b>ШУТ-ийн салбарын менежментийн шинэчлэлийн төлөвлөгөө</b> <i>ЗГ-ын 2010.07.07-ны өдрийн 174 дугаар тогтоол</i>	Төлөвлөгөө 2010-2015 онд хэрэгжиж дууссан боловч хүчин төгөлдөр хэвээр, хэрэгжилтийн талаарх дүн, мэдээлэл тодорхойгүй байна.
<b>Олон улсын Монгол судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр</b> <i>ЗГ-ын 2012 оны 56 дугаар тогтоол</i>	Хөтөлбөр 2012-2016 онд хэрэгжиж дууссан боловч хүчин төгөлдөр хэвээр байгаа.
<b>Хэвийн мөрдөгдөж байгаа</b>	
<b>МУ-ын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө</b>	Мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх 1, 2-р шатны төлөвлөлтийг гарган ажилласан. Бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлүүд үндсэндээ хэрэгжсэн. Хөрөнгө мөнгөтэй холбоотой арга хэмжээнүүд сайн хэрэгжээгүй.

<i>ЗГ-ын 2007 оны 2 дугаар тогтоол</i>	Салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалт нэмэгдсэн ч уг төлөвлөгөөнд тусгагдсан хэмжээнд хүрэхгүй байгаа. Уг төлөвлөгөөний III шатанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, “Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” БСШУС-ын сайдын 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн тушаалаар батлуулан хэрэгжүүлж байна. Энэхүү төлөвлөгөөг Мастер төлөвлөгөөний II шатны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн Монгол Улсын Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудтай уялдуулан боловсруулсан. Энэ шатны төлөвлөлт нь Мастер төлөвлөгөөний зорилгыг бүрэн хангахад чиглэгдсэн. Төлөвлөгөө хэрэгжсэнээр тус салбарын бодлого, эрх зүйн орчин бүрэн шинэчлэгдэж, шинжлэх ухаан, технологийн салбарын чадавхи, өрсөлдөх чадвар дээшилж, Үндэсний инновацийн тогтолцоог бүрдүүлэхэд чухал алхам болно.
<b>Монгол Улсын ШУТ-ийг 2015-2021 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологийн жагсаалт</b> <i>ЗГ-ын 2015 оны 368 дугаар тогтоол</i>	2011 оноос хэрэгжилтийг зохион байгуулж эхэлсэн бөгөөд одоогоор 10 гаруй төсөл хэрэгжүүлж байна. Нийт эрдэм шинжилгээний ажлын 70 шахам хувь нь тэргүүлэх чиглэл, цөм технологийг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна.
<b>Журам шинэчлэн батлах тухай /ШУТ-ийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам/</b> <i>ЗГ-ын 2014 оны оны 301 дүгээр тогтоол</i>	
<b>Шинжлэх ухаан, технологийн салбарын шагнал олгох журам</b> <i>ЗГ-ын 2012 оны 56 дугаар тогтоол</i>	
<b>Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн үлгэрчилсэн дүрэм</b> <i>ЗГ-ын 2006 оны 142 дугаар тогтоол</i>	Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн 8 нэгдэл байгуулагдсанаас 3 нь 2007 онд хувьчлагдсан. Одоо манай БСШУСЯ-ны харьяа 1 Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл үйл ажиллагаа явуулж байна.
<b>Нэрэмжит шагнал олгох журам</b> <i>ЗГ-ын 2012 оны 204 дүгээр тогтоол</i>	Академич Б.Ренчин, Ц.Дамдинсүрэн, Б.Ширэндэв нарын нэрэмжит шагнал олгох харилцааг зохицуулна.
<b>Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам</b> <i>ЗГ-ын 2014 оны 374 дүгээр тогтоол</i>	32 гарааны компани байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.
<b>Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын явцад бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам</b> <i>ЗГ-ын 2015 оны 267 дугаар тогтоол</i>	Журам хэвийн мөрдөгдөж байгаа бөгөөд оюуны өмчийн мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдэж байна.

<p><b>Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай</b> ЗГ-ын 2015.01.26 –ны өдрийн 27 дугаар тогтоол</p>	<p>Тогтоол хэвийн мөрдөгдөж байна.</p> <p>Шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар 1997 оноос 2016 он хүртэл 12 Засгийн газрын тогтоол гарсан бөгөөд үүнээс 7 нь тогтоол, 5 нь уг холбогдох тогтоолыг өөрчлөн найруулах, зарим хэсгийг хүчингүй болгох, нэмэлт оруулах чиглэлээр гарсан байна.</p>
---	--

## **Хоёр. БСШУСЯ-ны захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт хийсэн шинжилгээ**

Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн нь Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн хэм хэмжээний актыг тушаал хэлбэрээр гаргаж, биелэлтийг хангах үүргийг хүлээдэг.

Хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд сайд нь зөвхөн **шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай** холбогдуулан 1998 оноос 2016 онд гаргасан, гадагш чиглэсэн шийдвэрүүд болох 23 тушаалд агуулгын шинжилгээ хийж, хүчинтэй байгаа боловч *хэрэгжилт хангалтгүй, хэрэгждэггүй, хэвийн үйлчилж байгаа, нэн даруй өөрчлөлт оруулах шаардлагатай* эсэхээр ангилан авч үзэв. Үүнд:

Хүчин төгөлдөр үйлчилж буй боловч хэрэгжилт хангалтгүй 3, нэн даруй өөрчлөлт оруулах эсвэл шинээр батлах шаардлагатай 4, хэвийн мөрдөгдөж байгаа 16 тушаал байна.

Сайдын тушаалууд Шинжлэх ухаан, технологийн хууль, бусад холбогдох хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн хэм хэмжээг үндэслэсэн, хуулиар нэг бүрчлэн зохицуулах боломжгүй харилцааг зохицуулахад чиглэгдсэн учир утга, агуулга болон бичвэрийн хувьд давхардал илрээгүй.

Харин үндэслэл хэсэгт ишлэсэн зарим хууль, тогтоол хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан боловч тушаалд өөрчлөлт ороогүй хэвээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа зөрчил байна. Хэм хэмжээний актыг гаргахад үндэслэсэн заалт хүчингүй болсон, шинэчлэн найруулагдахдаа уг актын утга агуулгатай нийцэхээргүй болсон бол тухайн акт бүхэлдээ хүчин төгөлдөр бусад тооцогддог.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд Шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон засгийн газрын гишүүнд эрх олгосон заалт 25 байдаг бөгөөд эдгээр заалтуудыг үндэслэж үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, журам, хөтөлбөр, үлгэрчилсэн загвар батлах, санхүүжилтийн асуудал шийдвэрлэх зэрэг шийдвэрүүдээр хязгаарлагдаж байгаа бөгөөд, эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх, салбарын боловсон хүчнийг бэлтгэх зэрэг эрх олгосон заалтуудын хэрэгжилт сул байна.

Мэдээлэл цуглуулах явцад Сайдын тушаал, шийдвэрүүд тухайн яамын болон бусад байгууллагуудын цахим хуудас, эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан зэрэгт давхардаж нийтлэгддэг, цахим хуудасны шинэчлэл, хуучин мэдээллийн хадгалалт зэргээс шалтгаалж хүчингүй болсон, шинэчлэн найруулагдсан эсэхийг тодруулах шаардлагатай зэрэг хүндрэлүүд гарч байсан тул нэг мөр болгон цэгцлэх шаардлагатай байна.

## Хүснэгт 1.2.2. БСШУС-ын Сайдын тушаалын хэрэгжилтийн байдал

Сайдын тушаал	Тушаалын хэрэгжилтийн байдал
<b>ХҮЧИНТЭЙ, ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ</b>	
<p>Хөтөлбөр батлах тухай /ШУТ-ийн гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх үндсэн чиглэл хөтөлбөр (2008-2015)/ 2008.01.11-ны өдрийн 13 тоот тушаал</p>	<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа дууссан. Шинэчлэн боловсруулах шаардлагатай. Уг хөтөлбөрийн хугацаа дууссан боловч хүчин төгөлдөр хэвээр байгаа.</p>
<p>Журам, заавар батлах тухай /ШУТ-ийн зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журам/ 2008.04.09-ний өдрийн 167 тоот тушаал</p>	<p>Журам хүчин төгөлдөр үйлчилж байгаа. Сүүлийн жилүүдэд зэхэц ажил хэрэгжүүлээгүй учир хэрэгжилт хангалтгүй байна. ШУТ-ийн төслийн үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор 2001 оноос эхлэн хэрэгжүүлсэн. Нийтдээ 93 зэхэц ажлыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр санхүүжүүлж, 2 тэрбум гаруй төгрөг зарцуулсан. Одоо хэрэгжиж байгаа 39 ажил байна. Үлдэгдэл төлбөр 1 тэрбум 165 сая төгрөг.</p>
<p>Журам батлах тухай /Магистрант, докторант судалгааны тэтгэлэг олгох/ 2016.06.27-ны өдрийн А/65 тоот тушаал</p>	<p>Хэрэгжилт хангалтгүй учир БСШУСЯ-аас хүчингүй болгохоор төлөвлөж байгаа.</p>
<b>НЭН ДАРУЙ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ</b>	
<p>Журам батлах тухай /Технологийн түвшний үнэлгээ хийх нийтлэг журам/ 1998.12.10-ны өдрийн 271 тоот тушаал</p>	<p>2000 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн Гэгээрлийн сайдын “Журамд өөрчлөлт оруулах тухай” 135 дугаар тушаалаар 3.10, 3.11, 3.12 дугаар заалтад өөрчлөлт орсон. Тушаалын үндэслэл хэсэгт заасан ШУТГХ-ийн 7.1.1, 7.1.2 дахь хэсэг, хавсралтаар баталсан журмын хоёрдугаар зүйлийн 2.1 дэх хэсэг ишлэсэн заалтууд 2006 онд тус хуулийн шинэчлэн найруулга батлагдсантай холбогдон хүчингүй болсон. Эрх зүйн актын үндэслэл хэсэгт ишлэл авсан заалт хүчингүй болсон бол тухайн эрх зүйн акт бүхэлдээ хүчингүй болно.</p>
<p>Журам батлах тухай /ШУ-ны докторын зэрэг хамгаалуулах, олгох журам/ 2007.10.10-ны өдрийн 365 тоот тушаал</p>	<p>Журам хэвийн мөрдөгдөж байгаа боловч холбогдох зарим заалтууд агуулгын болон найруулгын зөрчил илэрсэн. Үүнд.</p> <p>► <b>Бичвэрийн найруулгын зөрчил:</b> Заалтаас харахад шинжлэх ухааны докторын зэрэгтэй, эсвэл докторын зэрэгтэй гэж хоёрдмол утгаар ойлгогдохоор байна.</p>
	<p>3.2.1. шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээлийг хүлээн авснаас хойш хуанлийн 30 хоногт багтаан уг бүтээлд тухайн шинжлэх ухааны 3-аас доошгүй <i>доктороор</i> хянан магадлагаа хийлгэж...” гэжээ. Энэ нь найруулгын хувьд хоёрдмол утгыг агуулсан байна.</p> <p>► <b>Хэл зүйн дүрмийн зөрчил:</b></p> <p>6.1.1. Зөвлөл нь энэ журмын 3.2.1-д заасны дагуу урьдчилсан хамгаалалтын өмнө өөрийн гишүүд болон тухайн чиглэлийн мэргэжлийн эрдэмтдээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж, гориллогчийн бүтээлийн онол, практикийн ач холбогдол, шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, шинэлэг тал, туршилтын хэсэг <i>бодитой, эсэх, гориллогчийн</i> нийтлүүлсэн бүтээл нь хамгаалж буй бүтээлийн агуулгад нийцэж <i>байгаа, эсэх, сэдэв</i> нь хамгаалуулах зөвлөлийн хэлэлцвэл зохих шинжлэх ухааны чиглэлд <i>тохирох, эсэх</i> талаар хянан магадлагаа хийлгэж, дүгнэлт гаргуулна.</p>
<p>Гэрээ актын үлгэрчилсэн загвар батлах тухай /Шинжлэх ухаан, технологийн төсөл</p>	<p>“Журам шинэчлэн батлах тухай” ЗГ-ын 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан “Шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэвт ажил хэрэгжүүлэх журам”-ын 39, 61 дэх заалтыг үндэслэн гаргасан бөгөөд уг тогтоол 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.</p>

хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ/  
2010.04.27-ны өдрийн 197 тоот тушаал

Эрх зүйн актын үндэслэл хэсэгт ишлэл авсан заалт хүчингүй болсон бол тухайн эрх зүйн акт бүхэлдээ хүчингүй болно.

Аргачлал батлах тухай /ШУТ-ийн төсөл, сэдэвт ажилд үнэлгээ өгөх, сонгон шалгаруулах аргачлал/  
2010.09.29-ний өдрийн 316 тоот тушаал

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 36 дугаар тогтоолын 30 дугаар зүйлийг үндэслэн гаргасан бөгөөд уг тогтоол 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолоор хүчингүй болсонд тооцсон.  
Эрх зүйн актын үндэслэл хэсэгт ишлэл авсан заалт хүчингүй болсон бол тухайн эрх зүйн акт бүхэлдээ хүчингүй болно.

### ХЭВИЙН МӨРДӨГДӨЖ БАЙГАА

Заавар батлах тухай /Технологи дамжуулах гэрээ байгуулах, түүнийг бүртгэх заавар/  
1999.03.15-ны өдрийн 46 тоот тушаал

Түүх, соёлын олдворыг үзэсгэлэнд тавьж сурталчлах, судалгаа шинжилгээнд ашиглуулах, түүнээс олсон орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, зарцуулах журам  
2002.02.08-ны өдрийн 40/36 тоот тушаал

Дүрэм батлах тухай /Эрдэм шинжилгээний ажилтны ёс зүйн дүрэм/  
2007.12.03-ны өдрийн 454 тоот тушаал

Нийтлэг шаардлага батлах тухай /Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын төрийн өмчийн байгууллагын ерөнхий менежрийг сонгон шалгаруулахад тавих нийтлэг шаардлага/  
2008.05.09-ний өдрийн 236 тоот тушаал

Туршилтын шалгуур үзүүлэлт батлах тухай /Эрдэм шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ – хийх, үнэлгээ өгөх туршилтын шалгуур үзүүлэлт/  
2008.12.24-ний өдрийн 162 тоот тушаал

Шинжлэх ухаан технологийн сангийн дүрэм батлах тухай  
2008.07.18-ны өдрийн 379 тоот тушаал

Санаачлагыг дэмжих тухай /Мал эмнэлэг, Биотехнологийн чиглэлийн докторант болон докторын эрдэм шинжилгээний шилдэг бүтээл шалгаруулах журам/  
2009.03.13-ны өдрийн 84 тоот тушаал

Сайдын нэрэмжит грант олгох тухай /Залуу судлаачдын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, грант олгох журам/  
2010.07.01-ний өдрийн 324 тоот тушаал

Журам шинэчлэн батлах тухай /Шинжлэх ухааны оны шилдэг бүтээл шалгаруулах журам/  
2010.11.01-ний өдрийн 479 тоот тушаал

Журам батлах тухай /Докторын дараах судалгаанд сайдын нэрэмжит инновацийн тэтгэлэг олгох журам/  
2011.06.14-ний өдрийн 222 тоот тушаал

Эрдэм шинжилгээний ажилтны зэрэг дэвийн тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг батлах тухай  
2012.10.25-ны өдрийн А/88 тоот тушаал

Нийтлэг шаардлага шинэчлэн батлах тухай /Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирлын ажлын байр/албан тушаал/-ын тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага/  
2015.06.11-ний өдрийн А/223 тоот тушаал

Үйл ажиллагааны чиглэл тогтоох тухай /Хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэл, бүтэц, зохион байгуулалт/  
2015.09.02-ны өдрийн А/337 тоот тушаал

Журам шинэчлэн батлах тухай /Эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам/  
2016.06.27-ны өдрийн А/279 тоот тушаал

Шинжлэх ухаан, технологийн төслийн өртөг, зардлыг тодорхойлох, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт тавих журам  
2016 оны А/278 тоот тушаал

Инновацийн төсөлд дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчийг ажиллуулах журам.  
2016 оны А/110 тоот тушаал

## Гурав. ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаалд хийсэн дүн шинжилгээ

“Хэм хэмжээний актад эрх олгосон хуулийн заалтыг ишлэн авсан байна, хэм хэмжээний акт нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд байна” гэсэн эрх зүйн шаардлага тавигддаг бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн (2015) 40 дүгээр зүйлийн 40.2.3 дахь хэсэгт “захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах”, 40.3 дахь хэсэгт “Захиргааны актын хууль зүйн үндэслэлд захиргааны байгууллага захиргааны акт гаргах эрх олгогдсон хуулийн зүйл, заалтыг тодорхой заана” гэсэн хуулийн зүйл заалтыг мөрдлөг болгон ШУА-ийн Их Чуулган, Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, ШУА-ийн ерөнхийлөгчийн тушаал зэрэг эрх зүйн актын тогтоох хэсэгт дүн шинжилгээ хийж үзэхэд тухайн хэм хэмжээ тогтоосон агуудын үндэслэх хэсэгт ямар ч хууль, эрх зүйн ишлэл байхгүй буюу эрх зүйн актад тавигдах нийтлэг шаардлага хангагдахгүй байна (Хүснэгт 1.3.1). Эдгээр шаардлага хангагдсанаар Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, бусад хууль, эрх зүйн актад нийцсэн хүчин төгөлдөр шийдвэр гарна. Иймд тухайн эрх зүйн актуудын үндэслэх хэсгийг тодорхой болгох шаардлагатай юм.

### Хүснэгт 1.3.1. ШУА-ийн эрх зүйн актуудын тогтоох хэсэгт хийсэн дүн шинжилгээ

ШУА-ийн тогтоолууд	Тогтоолын тогтоох хэсгийн үндэслэлийн талаарх тайлбар, дүгнэлт
ШУА-ийн ерөнхийлөгчийн сонгууль явуулах журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1996.10.10-ны өдрийн 01 тоот тогтоол</i>	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт “...академийн ерөнхийлөгчид эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа академийн гишүүнийг буюу докторын зэрэгтэй эрдэмтнийг нэр дэвшүүлж Их чуулганаас сонгоно...” гэсэн ишлэл байхад хэрэглэгүй байна.
ШУА-ийн тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг сонгох журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1996.11.16-ны өдрийн 01 тоот тогтоол</i>	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон эрдэмтэн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаагаар сонгох” гэсэн зүйл, хэсгийг ишлэх.
ШУА-ийн гишүүн сонгох журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1997.10.09-ний өдрийн 02 тоот тогтоол</i>	Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт академийн гишүүдийг сонгох гэсэн хэсгийг ишлэх.
ШУА-ийн Бага чуулганы дүрэм батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 2010.05.12-ны өдрийн 02 тоот тогтоол</i>	Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Академийн удирдах дээд байгууллага нь академийн бүх гишүүдийн чуулган /цаашид “Их чуулган” гэх/ мөн. Академи нь шинжлэх ухааны салбараар Бага чуулган /цаашид “Бага чуулган” гэх/-тай байж болно гэсэн зүйлээс өөр Бага Чуулганы дүрмийг Их Чуулган батална гэсэн зүйл заалт байхгүй байгаа тохиолдолд иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн II.15 дахь хэсэгт Их чуулган хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргана гэснийг үндэслэж болно.
ШУА-ийн Бага чуулганы гишүүнийг сонгох журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1997.04.16-ны өдрийн 01 тоот тогтоол</i>	Журмын тогтоох хэсэгт иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн гурав дугаар зүйлийн III.17 дахь хэсэгт Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчид гишүүд, тухайн салбарын академийн гишүүдээс бүрдсэн зөвлөлөөр нууц санал хураалтаар <u>Бага чуулганы гишүүдийг сонгоно</u> . Бага чуулганд академийн гишүүд таслах эрхтэй оролцоно. Бага чуулганы даргыг тухайн салбарыг төлөөлсөн академийн гишүүн нэр дэвшүүлж, Бага чуулганы гишүүд нууц санал хураалтаар сонгоно гэснийг үндэслэнэ.

<p><b>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлыг бэлтгэн явуулах, шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах журам батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 1997.05.23-ны өдрийн 18 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн гурав дугаар зүйлийн IV.22 дахь хэсгийн “б”-д “Их чуулганаар хэлэлцэх асуудлыг боловсруулж шийдвэрийг хэрэгжүүлэх” гэснийг үндэслэн тогтоол гаргах.</p>
<p><b>ШУА-ийн харьяа хүрээлэнгийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 1997.05.23-ны өдрийн 20 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн гурав дугаар зүйлийн IV.22 дахь хэсгийн “в”-д “Академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, бусад байгууллагыг байгуулах, татан буулгах, тэдгээрийн дүрмийг батлан үйл ажиллагааг зохицуулах” үндэслэж тогтоол гаргах.</p>
<p><b>ШУА-ийн Академийн шагналыг бий болгож, олгох журам батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2001.10.04-ний өдрийн 04 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4.4 дэх хэсэгт “өөрийн нэрэмжит шагнал бий болгож, түүний санг байгуулах” гэж заасныг ишлэх.</p>
<p><b>Эрдэм шинжилгээний тэргүүний залуу ажилтан шалгаруулах журам</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 1998.10.08-ны өдрийн 11 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн IV.22 дахь хэсгийн “л”-д “Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах” гэдгийг үндэслэх.</p>
<p><b>“Гэрээний үлгэрчилсэн загвар”, “Эрдэм шинжилгээний байгууллага ажилтанд грант олгох журам” батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2002.05.24-ний өдрийн 11 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн IV.22 дахь хэсгийн “л”-д “Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах” гэснийг үндэслэх.</p>
<p><b>ОХУ-д суралцаж байгаа аспирант, докторант нарт тэтгэлэг олгох журам батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2005.05.04-ний өдрийн 10 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн IV.22 дахь хэсгийн “л”-д “Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргах” гэдгийг үндэслэх.</p>
<p><b>Байгалийн шинжлэлийн нэгдсэн лабораторийн дүрэм, эрдмийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай</b>  <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2008.01.15-ны өдрийн 01/08 тоот тогтоол</i></p>	<p>Журмын тогтоох хэсэгт ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Академи харьяандаа өөрийн чиг үүрэг, зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, лаборатори, бусад нэгж ажиллуулж болно” гэснийг үндэслэх.</p>
<p><b>Бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлэхэд ШУА-ийн Бага чуулганы баримтлах журам батлах тухай</b>  <i>ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2000.04.14-ний өдрийн 78 тоот тушаал</i></p>	<p>Журмын тушаах хэсэгт иш татсан хэм хэмжээнээс ишлэх буюу ШУА-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн V.27 дахь хэсэгт “Академийн ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана” гэснийг үндэслэх.</p>
<p><b>Хандив тусламжийн хөрөнгийг хүлээн авах, захиран зарцуулах журам</b>  <i>ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2002.11.01-ний өдрийн 218 тоот тушаалын I хавсралт</i></p>	<p>Журмын тушаах хэсэгт ШУТТХ-ийн 14 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт “гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хуулийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж” гэж заасныг ишлэл болгох.</p>

Эрдэмтэн шугамаар эрдэмтэд гадаадын авах журам	солилцооны гадаад орнуудад илгээх болон эрдэмтэн хүлээн	Журмын тушаах хэсэгт ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт “Академийг дотоод, гадаадад төлөөлөх” гэснийг үндэслэл болгож
ШУА-ийн 2002.11.01-ний өдрийн 218 тоот тушаалын II хавсралт	Ерөнхийлөгчийн	

ШУА-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, хүрээлэн, төвийн шийдвэр нь иш татсан хэм хэмжээнээс ишлэх боломжгүй цаашлаад эдгээр шийдвэрүүд нь бүгд хууль бус шийдвэрүүд болж гарсаар байгаа тул ШУА-ийн Их Чуулганы тогтоол, Тэргүүлэгчдийн тогтоол, Ерөнхийлөгчийн тушаалуудын ишлэл, үндэслэх хэсгийг шинэчлэн найруулж өөрчлөх шаардлагатай байна.

Засгийн газрын 1997 оны 91 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол улсын ШУА-ийн дүрэм”-ийн 22 дугаар зүйлийн “в”-д “Академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, бусад байгууллагыг байгуулах, татан буулгах...” гэж заасан нь ШУТ-ийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.7 дахь заалт буюу Монгол Улсын Засгийн газарт олгосон бүрэн эрхтэй давхцаж байна.

Эдгээр ШУА-ийн эрх зүйн актууд нь хүчингүй болсон хуулийн зүйл заалт, давхардал, нэг утга агуулсан үг өгүүлбэр, тухайн шийдвэрийн зорилго, хамрах хүрээ тодорхой бус байгаа зэрэгт анхаарч, хоёрдмол утгагүй, өөр хоорондоо нягт уялдаа холбоо бүхий болгох шаардлагатай байна.

#### Хүснэгт 1.3.2 ШУА-ийн эрх зүйн актуудад хийсэн дүн шинжилгээ

№	Эрх зүйн актын нэр	Холбогдох зүйл заалт	Дүгнэлт, санал
<b>Холбогдох эрх зүйн актын зүйл заалттай давхардаж буй</b>			
1.	ШУА-ийн ерөнхийлөгчийн сонгууль явуулах журам батлах тухай <i>ШУА-ийн Их чуулганы 1996.10.10-ны өдрийн 01 тоот тогтоол</i>	1.Академийн ерөнхийлөгчид эрдэм судлалын ажлыг идэвхитэй хийж байгаа академийн гишүүнийг буюу докторын зэрэгтэй эрдэмтнийг нэр дэвшүүлнэ.	1.Академийн ерөнхийлөгчид эрдэм судлалын ажлыг идэвхитэй хийж байгаа академийн гишүүнийг нэр дэвшүүлнэ. МУ-ын ШУА-ийн гишүүн сонгох журмын 3 дугаар зүйлд <u>ШУА-ийн гишүүнээр шинжлэх ухааны докторын зэрэгтэй, Монгол улсын иргэнийг сонгоно гэж орсон тул давхардал байна.</u>
<b>Нэн даруй нэмэлт өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах</b>			
2.	ШУА-ийн тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг сонгох журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1996.11.16-ны өдрийн 01 тоот тогтоол</i>	3.Академийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа, академийн гишүүнийг буюу шинжлэх ухааны ёс зүйг хүндэтгэдэг эрдмийн зэрэг, цолтой эрдэмтнийг сонгоно.	<i>Тэргүүлэгчид бүгд эрдмийн зэрэг цолтой, Академийн гишүүд байхгүй байна.</i> <i>Мөн журмын 3 дугаар зүйл заалтыг</i> <b>3. Монгол улсын ШУА-ийн тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг ШУА-ийн Их Чуулганаар тогтоосон тоог үндэслэн Академийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа, академийн гишүүнийг буюу шинжлэх ухааны ёс зүйг хүндэтгэдэг эрдмийн зэрэг, цолтой эрдэмтнийг сонгоно гэж нэмэлт оруулах</b>
4.	ШУА-ийн гишүүн сонгох журам батлах тухай <i>ШУА-ийн Их Чуулганы 1997.10.09-ний өдрийн 02 тоот тогтоол</i>	2. Энэ журам нь Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.5, дүрмийн 3 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>■ ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3.5 дахь хэсэг гэж байхгүй буюу хэрэгжүүлэх зүйл заалт нь байхгүй байна.</li> <li>■ Мөн дүрмийн 3 дугаар зүйл заалт гэсэн нь яг юуны ямар дүрмийн талаар дурдаж байгаа нь тодорхойгүй байна. Эдгээрийг өөрчлөх шаардлагатай байна.</li> </ul>

<p>5. ШУА-ийн харьяа байгууллагуудын захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журам <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2016.12.21-ний өдрийн 12 тоот тогтоол</i></p>	<p>1.1. Энэхүү журмын зорилго нь “ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйл, ШУТ-ийн тухай хуулийн 11.2.1 дэх заалт, МУ-ын ШУА-ийн дүрмийн 29,30 дугаар заалтыг хэрэгжүүлж, ШУА-ийн харьяа байгууллагуудын захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөхөд баримтлах үндсэн зарчмыг тогтооход оршино.</p>	<p><i>Энэ журмын зорилгод ишлэсэн заалт Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн буруу зүйл заалт ишлэсэн байна</i> <i>Үүнд: Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.12. дахь хэсэгт Төрийн өмчид эрдэм шинжилгээний байгууллагын захирал (дарга)-ын ажлын байрны тодорхойлолтод тавигдах нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох: гэж тухайн журмын зорилгод нийцүүлж өөрчлөлт оруулах шаардлагатай.</i></p>
<p>6. ШУА-ийн харьяа хүрээлэнгийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 1997.05.23-ны өдрийн 20 тоот тогтоол</i></p>	<p>в/ олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын <b>нүүс</b>, компани, корпорациудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах;</p> <p>18. Захирал нь дор дурьдсан үүрэг хүлээнэ: а/ Монгол улсын хууль тогтоомжийн дагуу тушаал, шийдвэр гаргаж, хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 20. Хүрээлэнгийн захирлыг ШУА-ийн ерөнхийлөгч эрдмийн хамт олны саналыг үндэслэн тсмилох ба захирал нь эрдэмтэн нарийн бичгийн дарга, салбар нэгжийнхээ удирдлага, ажилтнуудыг томилно. д/ зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилтын түшиц цех байгуулах, курс дамжаа хичээллүүлэх, магистрантур, аспирантурын сургалт зохион байгуулах;</p>	<ul style="list-style-type: none"> <li>➤ <i>Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 605 хуульд нүүс гэдэг үг буюу хуулийн этгээдийн хэлбэр байхгүй байна.</i></li> <li>➤ <i>18.Монгол Улсын Үндсэн хууль болон түүнд нийцүүлэн гарсан бусад хууль тогтоомжийн дагуу тушаал, шийдвэр гаргаж, хүрээлэнгийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;</i></li> <li>➤ <i>Энд зөвхөн томилох талаар тусгасан боловч чөлөөлөх гэсэн асуудал орж ирээгүй байна.</i></li> <li>➤ <i>курс дамжаа хичээллүүлэх, магистрантур, аспирантурын сургалт зохион байгуулахгүй байгаа хэрэгжихгүй байгаа заалт</i></li> </ul>
<p>7. “Гэрээний үлгэрчилсэн загвар”, “Эрдэм шинжилгээний байгууллага ажилтанд грант олгох журам” батлах тухай <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2002.05.24-ний өдрийн 11 тоот тогтоол</i></p>	<p>1. Грант нь ШУТТХ-ийн 22 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу онолын суурь судалгааны сэдэвт ажлыг санхүүжүүлэх нэг хэлбэр юм.</p>	<p><i>ШУТТХ-ийн 22 дугаар зүйлийн 4 дэх хэсэг 2006 онд уг хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдон хүчингүй болсон тул тогтоолд холбогдох зүйл заалт буюу ШУТТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтад “грант гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсаны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг” гэж заасныг оруулах.</i></p>

<p>8. ОХУ-д суралцаж байгаа аспирант, докторант нарт тэтгэлэг олгох журам батлах тухай <i>ШУА-ийн Тэргүүлэгчдийн хурлын 2005.05.04-ний өдрийн 10 тоот тогтоол</i></p>	<p>2. Суралцагч нь <b>манай орны, эсвэл Монгол улсад</b> чухал ач холбогдолтой объектыг судлана.</p>	<p><i>Нэг утга агуулсан үгийг давхар хэрэглэсэн байгаа тул өөрчлөн найруулах шаардлагатай.</i></p>
<p>9. Бүтээлийг Төрийн шагналд нэр дэвшүүлэхэд ШУА-ийн Бага Чуулганы баримтлах журам батлах тухай <i>ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2000.04.14-ний өдрийн 78 тоот тушаал</i></p>	<p><i>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 8 дугаар зарлигаар батлагдсан Монгол Улсын төрийн шагналын дүрэм хүчингүй болж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2006 оны 302 дугаар зарлигаар шинэчлэн батлагдсан тул ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2000 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 78 дугаар тушаал/-оор батласан Бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлэх журмыг өөрчилж шинээр батлах</i></p>	
<p>10. Хандив тусламжийн хөрөнгийг хүлээн авах, захиран зарцуулах журам <i>ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2002.11.01-ний өдрийн 218 тоот тушаалын I хавсралт</i></p>	<p><i>ШУТТХ-ийн холбогдох заалтыг үндэслэн тус журамд нэмэлт өөрчлөлт оруулах 14 дүгээр зүйл. ШУТ-ийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэр</i>  <i>14.1.ШУТ-ийн үйл ажиллагааг дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:</i>  <i>14.1.1.улсын төсвөөс олгосон хөрөнгө;</i>  <i>14.1.2.орон нутгийн төсвөөс олгосон хөрөнгө;</i>  <i>14.1.3.гадаад улс, олон улсын байгууллагаас олгосон хөрөнгө;</i>  <i>14.1.4.гадаад улсын болон Монгол Улсын иргэн, байгууллага, хүүлийн этгээдээс олгосон хөрөнгө, хандив, тусламж;</i>  <i>14.1.5.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.</i></p>	
<p>11. Эрдэмтэн солилцооны шугамаар гадаад орнуудад эрдэмтэд илгээх болон гадаадын эрдэмтэн хүлээн авах журам <i>ШУА-ийн Ерөнхийлөгчийн 2002.11.01-ний өдрийн 218 тоот тушаалын II хавсралт</i></p>	<p><i>Тус журмыг Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ тарифын өөрчлөлтийг харгалзан Сангийн сайдын 2011 оны 9.12-ны өдрийн 188 дугаар тогтоолыг баримтлан шинэчлэн найруулж шинээр батлах</i></p>	

## II

---

### ШУ-НЫ САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, СТАТУС, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, САНХҮҮЖИЛТИЙН ТАЛААРХ ҮНЭЛГЭЭ, САНАЛ ДҮГНЭЛТ

#### ЭКСПЕРТИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

---

2.1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

2.2. ШУ-НЫ САЛБАР: СТАТУС БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН,  
ИНСТИТУЦИУДЫН УЯЛДАА ХОЛБОО

2.3. ШУ-НЫ САЛБАРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,  
ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.4 ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ

2.5. ШУТ-ИЙН АЖЛЫН ҮР ДҮН, НИЙГЭМ-ЭДИЙН  
ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ

## 2.1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

“ШУ-ны салбарын хууль эрх зүйн орчны шинжилгээ” төслийн хүрээнд энэхүү экспертийн судалгааг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Социологи, Нийгэм сэтгэл зүйн салбараас эрхлэн 2016 оны 12 дугаар сарын 14-өөс 12 дугаар сарын 28-ны хооронд явууллаа. ШУ-ны салбарын хууль эрх зүйн орчин болон салбарын санхүүжилт, салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргээ хэрхэн биелүүлж буй талаарх салбарын экспертүүдийн үнэлгээ дүгнэлтийг тодорхойлох зорилгоор тус салбарын бодлого тодорхойлогчид, ШУА-ийн тэргүүлэгчид, Бага чуулганы эрдэмтэн нарийн бичгийн дарга нар болон салбарын гол бүрэлдэхүүн хэсгийн төлөөлөл болох эрдэмтэн судлаачдаас бүрдсэн 105 экспертийг олон шатат санамсаргүй түүвэр болон зорилтот түүврийн аргаар сонгон судалгаанд хамруулж, үр дүнг гаргав. Экспертийн санал асуулгын судалгаанд ШУ-ны салбарын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, үр дүнгийн талаар гарсан ярилцлага, нийтлэлийн материал, хууль эрх зүйн баримт бичгүүдэд контент анализ хийсний үндсэн дээр экспертийн анкетыг боловсруулан, анкет сурвалжлагын аргаар үндсэн мэдээллийг цуглуулж, зарим экспертүүдтэй гүнзгийрүүлэн ярилцсан болно.

Хүснэгт 1.1 Эх олонлог, авахаар төлөвлөсөн түүврийн олонлог. ШУ-ны салбар, хүйс, зэрэг дэвээр

ШУ-ны салбарууд	Эх олонлог					Түүврийн олонлог				
	ШУС-ын эрэгтэй ЭША-нууд /дэд ажилтан, түүнээс дээш зэрэгтэй/									
	Удирдах	Тэргүүлэх	Ахлах	Дэд	Нийт	Удирдах	Тэргүүлэх	Ахлах	Дэд	Нийт
Анагаах	11	8	1	13	33	1/	-	-	1	2
Байгалийн	30	54	40	109	233	3	3	3	4	13
Нийгэм хүмүүнлэг	33	44	30	89	196	2	3	2	4	11
Техник технологи	28	16	14	41	99	2	1	1	2	6
ХАА-н салбар	15	15	14	48	92	1	1	1	2	5
<b>Нийт</b>	<b>117</b>	<b>137</b>	<b>99</b>	<b>300</b>	<b>653</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>13</b>	<b>37</b>

ШУ-ны салбарууд	Эх олонлог					Түүврийн олонлог				
	ШУС-ын эмэгтэй ЭША-нууд /дэд ажилтан, түүнээс дээш зэрэгтэй/									
	Удирдах	Тэргүүлэх	Ахлах	Дэд	Нийт	Удирдах	Тэргүүлэх	Ахлах	Дэд	Нийт
Анагаах	10	6	9	27	33	1	-	1	1	3
Байгалийн	12	33	42	138	225	3	3	3	4	13
Нийгэм хүмүүнлэг	11	9	10	81	111	1	2	1	3	7
Техник технологи	18	1	16	41	76	1	1	1	1	4
ХАА-н салбар	10	11	17	65	103	2	1	1	2	6
<b>Нийт</b>	<b>61</b>	<b>60</b>	<b>94</b>	<b>352</b>	<b>548</b>	<b>8</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>11</b>	<b>33</b>

Судалгааны түүврийн бүтцийг эх олонлогийн түүврийн бүтцийг харгалзан анагаах, байгалийн ухаан, нийгэм хүмүүнлэг ухаан, техник технологи, ХАА гэсэн ШУ-ны үндсэн 5


салбараас авах хүний тоо, хүйсийн харьцааг тодорхойлж, салбарын тулгамдсан асуудал, түүнийг шийдэх гарцыг олж харж чадах мэдлэг туршлага, үнэлгээ дүгнэлт хийх чадварыг нь үндсэн шалгуур болгосон учир тэдний эрдэм шинжилгээний ажлын туршлага, ажилласан жил, эрдмийн зэрэг цол, ажил албан тушаал, ЭШ-ний ажилтны зэрэг дэв зэрэг нь харгалзах шалгуур үзүүлэлтийн нэг болсон. Судалгааны мэдээлэл цуглуулах хугацаа давчуу байсантай холбоотойгоор сонгосон экспертүүд өвчтэй байх, гадаадад томилолтоор явсан, судалгааны ажилтай байх г.м хүндэтгэх шалтгаанаар судалгаанд оролцох боломжгүй байх тохиолдлууд гарсныг нөхөх бүлгээс дахин сонгож судалгааг авсан болно.

#### Хүснэгт 1.2 Түүврийн бүтэц, ШУ-ны салбар, ЭША-ны зэрэг дэвээр

ШУ-ны салбар	Тэргүүлэх		Ахлах		Дэд ажилтан		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Байгалийн ухаан	23	56.1	6	14.6	12	29.3	41	100
Техникийн ухаан	6	54.5	0	0	5	45.5	11	100
ХАА	6	46.2	3	23.1	4	30.8	13	100
Анагаах ухаан	4	50.0	1	12.5	3	37.5	8	100
Нийгмийн ухаан	5	35.7	4	28.6	5	35.7	14	100
Хүмүүнлэгийн ухаан	2	50.0	1	25.0	1	25.0	4	100
<b>Нийт</b>	<b>46</b>	<b>50.5</b>	<b>15</b>	<b>16.5</b>	<b>30</b>	<b>33.0</b>	<b>91</b>	<b>100</b>

Судалгаанд оролцсон экспертүүд салбарын олон жил ажилласан туршлагатай хүмүүсийг сонгох шалгуурын дагуу насны хувьд бүх насны төлөөлөл байгаа ч дунд, болон ахмад насныхан голлож байна. Үүнд: Дунд буюу 35-54 насныхан 42.9 хувь, ахмад насныхан мөн 46.7 хувь нь байв. Залуучуудын төлөөлөл (26-34 насныхан) 10.5 хувь нь байлаа.

#### Зураг 1.1 Судалгааны түүврийн бүтэц, нас хүйс, зэрэг цолоор



ШУ-ны салбарт нийт ажиллагсдын хүйсийн харьцаа 2014 оны статистик дүнгээр<sup>34</sup> эрэгтэй 48.2 хувь, эмэгтэй 51.8 хувьтай байв. Харин манай судалгаанд сонгогдох боломжтой буюу дэд ажилтнаас дээш зэрэг дэв бүхий болон удирдах ажилтнууд нийлсэн эх олонлогийн


<sup>34</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл. БСШУЯ. УБ., 2015. х149.

хүйсийн харьцаа эрэгтэй 54.4 эмэгтэй 45.6 юм. Экспертүүдийн хүйсийн харьцаа эрэгтэй 54.3 хувь, эмэгтэй нь 45.7 хувь байна.

2014 оны статистик судалгааны дүнгээр 46 академич, 135 доктор (Sc.D), 496 доктор (Ph.D), 890 магистр байгаагаас<sup>35</sup> судалгаанд эдгээр академичдын 41.3 хувь, шинжлэх ухааны докторын зэрэгтэй хүмүүсийн 8.1 хувь, доктор (Ph.D) хүмүүсийн 10.7 хувь, магистрын зэрэгтэй хүмүүсийн 2.5 хувь нь хамрагджээ. Судалгаанд оролцогчдын 21 хувь нь магистр, 50.5 хувь нь доктор (Ph.D), 10.5 хувь нь доктор (Sc.D), 18.1 хувь нь академич гэсэн эрдмийн зэрэг цол бүхий эрдэм шинжилгээний ажилтнууд, эрдэмтэн судлаачид байв.

Нийт экспертүүдийн 84.8 хувь нь эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдэд ажилладаг, 2.9 нь их дээд сургууль, БСШУСЯ-ны ШУТГ-ын удирдлага, мэргэжилтнүүд 5.7 хувь, ШУА-ийн тэргүүлэгчид, Бага чуулганы нарийн бичгийн дарга нар нийт 6.7 хувийг бүрдүүлсэн.

Зураг 1.2. Судалгааны түүврийн бүтэц, ажилладаг газар, ажлын газрын харьяаллаар




Гэхдээ байгууллагын харьяаллаар авч үзвэл ШУА-ийн харьяа хүрээлэн болон ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрынхан 59 хувь нь, Их сургуулиудын харьяа хүрээлэн, их сургуулиуд нийлээд 28.6 хувь нь болж байгаа бол яамны харьяаллын хүрээлэн, төвүүд 6.7 хувь, Засгийн газрын харьяаны буюу БСШУСЯ-хан 5.7 хувь нь болж байна. Засгийн газрын шийдвэрээр байгуулагдсан ШУА-ийн харьяаны 10, ХААИС-ийн 4, МУИС-ийн 2, ШУТИС-ийн 2, АШУУИС-ийн 1, БСШУС яамны харьяа 2, ЭМЯ-ны харьяа 1, ЗГХЭГ-ын харьяа 1, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн харьяаны 1, нийт 24 хүрээлэн ажилладгаас<sup>36</sup> судалгаанд 20 хүрээлэн, 2 их сургуульд ажилладаг эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачид хамрагдсан.

<sup>35</sup> Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээллийн эмхэтгэл. БСШУЯ. УБ., 2015. х149.

<sup>36</sup> Шинжлэх ухааныг жам ёсоор нь хөгжилж байж л ир шимийг нь хиртэнэ. БСШУС-ын сайд Ж.Батсуурьтай хийсэн ярилцлагаас. Сдрийн сонин. 2016.11.22.// <http://vip76.mn/content/43378>. 2016.12.28-ны сдрийн хандалт.

Зураг 1.3. Түүврийн бүтэц, ажиллаж буй ШУ-ны салбар, эрхлэж буй ажлаар



ШУ-ны 6 үндсэн салбарын төлөөллийг хамруулахдаа эх олонлогийн бүтцийг харгалзан түүврийн олонлогийг тогтоосныг дээр дурьдсан. Гэвч нийгэм хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарын төлөөллүүд гэхчлэн зарим хүрээлэнгүүд цөөн хүнтэй ажиллаж байх, тэдгээрийн дотроос судалгааны түүврийн шалгуурт тохирох хүмүүс олдохгүй байх, өвдсөн, гадагшаа явсан, судалгаанд явсан, ажлын зав боломж байхгүй гэхчлэн олон шалтгаанаар тухайн салбарын төлөөллүүд хамрагдвал зохих хэмжээнээс бага хамрагдахаас аргагүй байдалд хүрсэн гэхдээ нийт бүтцэд байгалийн ухаан, нийгэм, хүмүүнлэгийн ухаан хамгийн их ажиллагсадтай энэ бүтцээ хадгалж буй. Байгалийн ухааны салбарт ажиллагсад 41 хувь, нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарынхан тус бүр 19 хувь, техникийн ухаан 15.2 хувь, хөдөө аж ахуйн салбарын төлөөлөл 12.4 хувь, анагаах 7.6 хувийн төлөөлөлтэй хамрагджээ.

Зураг 1.4. Түүврийн бүтэц, ЭШ-ний ажил хийж буй хугацаа, зэрэг дэвээр



Судалгаанд оролцсон экспертүүд 4-55 жил эрдэм шинжилгээний ажил хийснээс дунджаар 24 жил эл салбарт ажилласан хүмүүс байв. Нийт хүмүүсийн 56.6 хувь нь 20-55 жил

эрдэм шинжилгээний ажил хийсэн салбарын тулгамдсан асуудал бэрхшээлийг тодорхойлж чадах, асуудлын гарц шийдлийг олж харах хүмүүс байж чадсан. Тиймээс тэдний эрдэм шинжилгээний ажлын зэрэг дэв харьцангуй өндөр тухайлбал, тэргүүлэх ажилтнууд 50.5 хувь, ахлах ажилтнууд 16.5 хувь, дэд ажилтан 33.0 хувь нь болжээ. БСШУСЯ-ны мэргэжилтнүүдийн хувьд зэрэг дэв, эрдэм шинжилгээний ажил хийсэн хугацаа гэсэн 2 асуулт тохирохгүй учир тэднийг энд хасаж авч үзлээ.

## 2.2. ШУ-НЫ САЛБАР: СТАТУС БА ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ИНСТИТУЦИУДЫН УЯЛДАА ХОЛБОО


### Нэг. Шинжлэх ухааны салбарын статус

МУ-ын Үндсэн хуулинд “...шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэсэн энэ заалтыг 2.9 хувь нь бүрэн хэрэгжиж байгаа, 21 хувь нь хэрэгжих талдаа гэж хариулсан бол 32.5 хувь нь хэрэгжихгүй талдаа, хэрэгждэггүй гэсэн сөрөг үнэлгээ өгчээ.

Үндсэн хуулийн энэхүү үзэл санаанд салбарын харилцааг зохицуулагч бусад холбогдох хуулиуд суурилж чадсан гэж **22.9 хувь нь** үзсэн. ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль ҮХ-ийн энэ санаанд нийцдэг гэж тодотгожээ. Нийт хүмүүсийн ихэнх нь салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудын талаар нарийн тодорхой хэлж мэдэхгүй байв. Энэ асуултанд 28.7 хувь нь мэдэхгүй гэж хариулсан.

ҮХ-ийн үзэл санаанд суурилж чадаагүй гэж **48.4 хувь** нь үзсэнээс “санаанд хүрээгүй, хэтэрхий ерөнхий тунхаглалын шинжтэй, тодорхой тусгах, сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай, тэр болгон тусгагдахгүй байна” (21.8 хувь), ҮХ-ийн үзэл санаанд суурилагдах бус харин ч гадаадын үзэл санаанд суурилагдах талтай байгааг сануулсан байна.

Зураг 2.1.1 Үндсэн хуулийн “...шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтын хэрэгжилтийн талаарх үнэлгээ



Үндсэн хуулийн үзэл санаанд суурилж чадаагүй гэж үзэгсэд мөн тодорхой хууль эрх зүйн актуудаар санаагаа батлан илэрхийлжээ. Тухайлбал, ШУ технологийн хуулинд ШУА-ийн эрх үүргийг тодотгох, ШУ технологийн хууль боловсон хүчин бэлтгэх асуудлыг өрөөсгөл тусгасан, ШУ-ны байгууллага, боловсролын хуулийн уялдаагүйгээс эрдэмтэд хамгаалалтгүй байна, дагалдаж гарсан эрх зүйн актууд нь энэ үзэл санааг нарийвчлан тодотгож чадаагүй гээд МУ-ын ЗГ-ын зарим шийдвэр (2012-2016), Соёлын өвийг хадгалах хууль (2014) судалгаа шинжилгээ явуулахад саад болж, ҮХ-ийн үзэл санаанд суурилж чадаагүй хэмээн дүгнэжээ.


Мөн ҮХ-ийн уг заалтын үзэл санаанд санхүүжилтийн зарчим зохицохгүй, төрөөс баримтлах бодлогод ШУ-нд үзүүлэх тусламж дэмжлэг хомс, санхүүжилт нь муу, төрийн өмч байх заалтанд нийцэхгүй байна гэж үзээд “Одоо бол төрийн бус шахуу харьяалалтай байна. Төр хамгаалалтандаа аваагүй, төрийн зүгээс эрдэмтдийн хийж буй ажлыг мэддэггүй ШУ, төр 2 тусдаа мэт оршиж байдаг (тухайлбал, ЭМЯ, анагаахын ШУ-ны салбар хоёр дэндүү салангид, бие биенийхээ үгийг тоодоггүй) учраас ҮХ-ийн энэхүү үзэл санаанд суурилж чадаагүй гэж үзэх боломжтой хэмээн дүгнэжээ.

ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн “МУ-ын ШУА нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн. Академи нь төрийн ивээлд байна” хэмээн заасан нь ШУА-ийн статустай нийцэж байна уу гэдгийг тодруулахад **50.0 хувь нь ШУА-ийн статустай нийцэхгүй байна** гэж үзэж, дараах ялгавартай байр суурийг илэрхийлсэн юм. Үүнд:

- ШУ-ны бодлого нь тусдаа биеэ даасан, “шинжлэх ухаан-технологийн” чанараа тусгаар хадгалж, боловсрол сургалтын бодлогоос дээгүүр тавигдах ёстой (3.0)
- ШУА бол яамны түвшний засгийн газрын нэгж байх хэрэгтэй (2.0)
- ШУА удирдлагын хувьд төв байгууллага байж чадахгүй байна (1.0)
- Төрийн үү, олон нийтийн байгууллага уу, нийгэмлэг байх уу гэдэг нь ойлгомжгүй байна. (2.0)
- Одоогийн бодит статустай нийцэхгүй байна. Төв байгууллагын хэмжээнд ажиллахын тулд санхүүгийн эрх мэдэл шаардлагатай. Үүгээр төрийн ивээлийн нэг хэсэг хангагдана. (1.0)
- Статус хэт ерөнхий учраас амьдрал дээр бодит статус болж чаддаггүй. (2.0)
- Эрх зүйн зохицуулалтаар статусыг нь нарийвчлах шаардлагатай (1.0) Эрх зүйн зохицуулалт хангалтгүй (2.0), Хууль, дүрмийн заалтыг нэгэн жигд болгох (2.0) Академи төрийн ивээлд байна гэсэн заалт байхгүйгээр бусад хуульд тодотгосон эрх үүргийн зохицуулалт байхад болно (1.0)
- ШУА нь төрийн ивээлд багтана хэмээн заасан ч ТАХ-ийн статуст багтдаггүй, ивээлээс гадуур шоовдорлогдож байдаг. Иймээс ТАХ-ийн зэрэглэлд багтаах (1.0)
- Заалт байгаа ч хэрэгжилт муу, ШУ-ыг сүүлийн хэдэн жил дэмжээгүй, бараг устах ирмэгт байна (7.0)
- ШУА-ийн эрх зүйн байдлыг зөв тусгасан гэхдээ ШУА-ийн ерөнхийлөгч ЗГ-ын тэргүүний зөвлөх байх тухай заалт ерөөсөө хэрэгждэггүй (2.0)
- ШУА ШУ-ны төв байгууллага мөн гэдэгтэй санал нэг байна. Төрийн ивээлд байна гэсэн заалт хэрэгжихгүй байна (3.0)

Нийт экспертүүдийн 15.0 хувь нь энэ талаар сайн мэдэхгүй байна гэсэн бөгөөд үлдсэн **32 хувь нь ШУА-ийн одоогийн статуст нийцэж байгаа, олон улсын жишигтэй нийцэж байгаа** гэж үзсэн. Энэ бүлэгт харьяалагдаж буй экспертүүд ШУА-ийн зохион байгуулалтын ерөнхий зарчим нь нийцсэн гэхдээ ШУА нь салбарын бүх байгууллагуудыг бүтэцдээ оруулах зохистой хэлбэрийг олох шаардлагатай. Төрийн ивээлд байх нь зөв ч улс төрөөс ангид байх хэрэгтэй. Хууль зүйн хувьд ШУА-ийн статусыг хангалттай гэж үзнэ. Түүнийг өөрчлөх оролдлого хийх хэрэггүй байх. Харин хуулийн заалт бодит амьдралд хэрэгжихгүй байна. үүнд анхаарч ажиллах ялангуяа яамдуудтай харьцааг идэвхжүүлэх хэрэгтэй гэсэн байр суурь бүхий байв.

**Зураг 2.1.2 ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн “...Академи нь төрийн ивээлд байна” хэмээх заалт нь хувийн статустай ШУБ, нэгжийг орхигдуулсан, ер нь ШУ бүхэлдээ төрийн ивээл, хамгаалалтад байж чадахгүй байгаа гэсэн бодомжтой санал нийлэх эсэх**



ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн “...Академи нь төрийн ивээлд байна” хэмээх заалт нь ШУ-ыг зөвхөн академиар хязгаарлан авч үзсэн мэт болсон, хувийн статустай шинжлэх ухааны байгууллага, нэгжийг орхигдуулсан, ер нь ШУ бүхэлдээ төрийн ивээл, хамгаалалтад байж чадахгүй байгаа гэдэгтэй 37.1 хувь нь бүрэн санал нийлж, 48.6 хувь нь зарим талаар тэгж үзэж болох юм гэжээ.

### ШУА-ийн эрх зүйн байдал

ШУА нь МУ-ын оюуны үйлдвэрлэлийн цөм байгууллага учир төрийн ивээлд байх нь зүйтэй ч санхүүжилт, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа нь төрөөс хараат болсон нь эргээд шинжлэх ухааны хөгжлийг боомилж байна хэмээх бодомжтой 46.5 хувь нь бүрэн санал нийлж, 44.6 хувь нь зарим талаар тийм байгааг хүлээн зөвшөөрчээ. Төрийн ивээл, хамгаалалтанд байна гэдэг төрөөс хараат, төрийн захиргаанд байна гэсэн үг биш. ШУ-ны байгууллага, ажиллагсдад судалгаа шинжилгээний ажлын эрх чөлөө бүрэн нээлттэй байж, ажиллах нөөц, нөхцөл боломжийг л төрөөс хангаж байх ёстой гэсэн үзэл бодолд 82.5 хувь нь санал бүрэн нэгдэж, 16.5 хувь нь зарим талаар санал нийлж байгаагаа илэрхийлсэн байна.

ШУА-ийг хувийн эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуультай адил статустай болгох нь зөв гэсэн байр суурийг 9.7 хувь нь илэрхийлсэн ч 65 хувь нь эсрэг байр суурьтай байлаа.

ШУА-ийн эрх хэмжээг ямархуу байдлаар тогтоож өгөх талаарх экспертүүдийн саналыг авч үзвэл: *нэгдүгээрт*, ШУ, ШУА төрийн ивээл, онцгой хамгаалалтанд байх гэхдээ удирдлага, санхүүжилтийн хувьд бие даасан статустай болгох (52.1) саналыг олонхи нь илэрхийлжээ.

*Хоёрдугаарт*, ШУА-ийг МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын шууд удирдлага дор ажилладаг агентлаг болгох, засгийн газрын бие даасан нэгж /яам, агентлаг/ байх хэрэгтэй гэсэн санал (22.0) удаалжээ.

*Гуравдугаарт*, ШУА-ийг үндэсний шинжтэй, нийт эрдэмтдийн нийгэмлэг хэлбэрээр байгуулах (14.2), ШУА-ийг төрд, ард түмэндээ зөвлөмж гаргаж өгдөг эрдэмтдийн клуб болгох (1.4) харьцангуй цөөн хүн санал нэгдсэн байна.

### ШУА-ийн хүрээлэнгүүдийн эрх зүйн байдал

Боловсролын тухай хуулинд боловсролын чиглэлээр ажилладаг ЭШ-ний байгууллагаас бусад ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийг хэрхэн зохицуулах талаар тусгаагүй учир хүрээлэнгүүдийг бие даасан статустай болгох нь зүйтэй гэж 66.3 хувь нь үзэж, 20 хувь нь зарим талаар тийм байж болох юм гэжээ.

ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийг ЗГ татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, үүсгэн байгуулах эрх бүхий байдгийг болиулж, ШУА, түүний ерөнхийлөгчийн эрх мэдлийн хүрээнд шилжүүлэх нь зүйтэй гэдэгт 54.9 хувь нь бүрэн санал нэгдэж, 32.4 хувь нь зарим талаар санал нийлнэ гэсэн байна.

ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн компани, ТББ, хувь иргэнтэй адилхан төсөл хэрэгжүүлэгч болгох (5.0), ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийг БШУСЯ-ны шууд харьяаны газар болгох (1.4), Хүрээлэнгүүд ШУА-д байх буюу одоогийнхоор нь байлгах, хүрээлэнгүүдийг суурь санхүүжилттэй, дээрээс нь сангуудаас төсөл авч хэрэгжүүлдэг болгох (2.1), ШУА-ийн байгалийн ухааны хүрээлэнгүүдийг “үндэсний” болгох(0.7) гэсэн санал зарим экспертүүд дэвшүүлжээ.

### Хоёр. Шинжлэх ухааны салбарын эрх зүйн орчин

Эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй байна гэж олонхи нь үзэж, 35.2 хувь нь эрх зүйн бүрдээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэжээ.


Зураг 2.2.1 ШУ-ны салбарын эрх зүйн байдлын үнэлгээ



ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудын уялдаа холбоо хангагдахгүй байгаагаас (14 хувь), тодорхой бус, хоёрдмол утгатай, орхигдуулсан заалтууд (9.1 хувь), хэт хийсвэр шинжтэй (6.4 хувь), албан тушаалтнууд хуулийг хэрэгжүүлдэггүй (0.3 хувь) зэргээс шалтгаалж хуулиудын хэрэгжилт тааруу байна гэж 29.8 хувь нь үзжээ.

ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудад ШУ-ны мэргэшсэн байгууллагуудын шийдвэр гаргах эрх мэдэл бага, ШУ-ны байгууллагын эрх мэдэл, тушаал шийдвэрт төр бүрэн оролцдог, шинжлэх ухааны үйл ажиллагаан дахь Засгийн газрын оролцоог хэт дөвийлгөсөн, судалгаа, туршилтын ажлын үр дүнг төрд тайлагнах хэмжээнд байхаар заасан зэрэг нь алдаа болж буйг экспертүүд (40.7%) гаргаж тавьжээ. Түүнчлэн салбарын гол хуулиудын бас нэг сул тал нь ЭШ-ний байгууллага, хувийн хэвшлийнхний харилцааг зохицуулалгүй орхисон (15.5 хувь), хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц тодорхой бус (7.4 хувь) байгаад оршиж байна гэжээ. МУ-д ШУ-ыг хөгжүүлэх тодорхой бодлого боловсрогдоогүй байгаатай уялдсан алдаа дутагдал илэрч байна гэсэн санал дүгнэлт нэг хүн илэрхийлсэн.

Зураг 2.2.2 ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудын сул тал



Тайлбар: 0.3 хувьтай хариултуудыг хасаж үзүүлэв.

ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай, ШУ, технологийн тухай, Технологи дамжуулах тухай, Инновацийн болон Дээд боловсролын тухай гэсэн гол 5 хуулийн агуулгын давхардал, заалтууд нь зөрчилдөх, хийдэл, уялдаа холбоогүй байдал, хоёрдмол тодорхойгүй утга санаа хэр байдгийг үнэлүүлэхэд дунджаар 50 гаруй хувь нь хуулийн зүйл заалтуудыг нарийн тодорхой мэдэхгүй байгаагаа илэрхийлээд хариулт өгөөгүй. Хариулт өгсөн хүмүүсийн хувьд ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль, ШУ, технологийн тухай хуулиудыг илүү сайн мэдэж байлаа.

Хүснэгт 2.2.1 ШУС-ын гол хуулиудын сул талын үнэлгээ, хуулиудаар

Хуулиуд	Агуулгын давхардалтай	Заалтууд зөрчилддөг	Хийдэлтэй	Уялдаа холбоогүй	Хоёрдмол, тодорхойгүй утга санаа бүхий
ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	48.1	40.9	40	48.5	40.0
Шинжлэх ухаан технологийн тухай	36.2	33.3	37.1	51.4	38.1
Технологи дамжуулах тухай хууль	38.1	37.2	34.3	40	34.3
Инновацийн тухай хууль	39.0	37.1	37.1	49.5	36.2
Дээд боловсролын тухай хууль	39.1	41.0	37.1	47.6	34.3

Эдгээр хуулиудад агуулгын давхардал, заалтууд зөрчилдөх, хийдэл, уялдаа холбоогүй байдал, хоёрдмол тодорхойгүй утга санаа бүхий заалтууд их бага ямар нэг хэмжээгээр бий гэж (33-51 хүртэлх хувь нь) үзжээ.

## Хүснэгт 2.2.2 ШУС-ын гол хуулиудын хэрэгжилтийн үнэлгээ, хуулиудаар

Хуулиуд	Маш сайн	Сайн	Дунд	Муу	Маш муу	Мэдэхгүй
ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	8.6	9.5	23.8	15.2	8.6	34.3
Шинжлэх ухаан технологийн тухай	4.8	14.3	22.9	13.3	7.6	37.1
Технологи дамжуулах тухай хууль	4.8	14.3	21.9	7.6	12.4	39.0
Инновацийн тухай хууль	8.6	11.4	17.1	13.3	14.3	35.2
Дээд боловсролын тухай хууль	6.7	11.4	15.2	12.4	16.2	38.1

Эдгээр хуулиудын хэрэгжилтийг 37 хувь нь үнэлж мэдэхгүй гэсэн бол 18.1-20 хувь нь сайн үнэлгээ өгч, 20-28.8 хувь нь хуулиудын хэрэгжилтийг муу, маш муу хэрэгжиж байна гэжээ.

ШУА-ийн эрх зүйн байдлыг сайжруулахаар дараах санааг хуулинд тусгаж оруулах шаардлагатай байна гэж үзжээ. Үүнд:

**Байгууллага, албан тушаалтны статусын талаар**

- Тусгай хуультай байгууллага тул бие даан ажиллах боломжийг нь олгох (61.5%)
- ШУА-ийн тухай хуулийг шинэчилж гаргах, түүнд Академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарын статусыг гаргаж өгөх, академич нарын статусыг ч шийдэх (1.0%)
- Төсөв, санхүүг захиран зарцуулах эрхийг ШУА-ийн Ерөнхийлөгчид шилжүүлэх (55.8%)

**Үйл ажиллагаа, эрх үүрэг, чиг үүргийн талаар**

- Төрийн бодлого, хөтөлбөрийг тодорхойлоход ШУА-ын үүрэг, оролцоог тодорхой тусгах (1.0%)
- Үндэсний хэмжээний томоохон төслүүдэд зөвлөх болон экспертийн үйлчилгээ үзүүлэх эрх, үүргийг хуулиар олгох (1.0%)
- ХАА-н ШУ-ны бодлогыг тодорхой болгож, харьяаллыг шийдэх (1.0%)
- Хувийн хэвшлийн ЭШ-ний байгууллагыг бодлогоор дэмжих (1.0%)
- Мэдлэгийн үнэн мөнийг тогтооход эцсийн хариуг өгдөг байх (1.0%)
- Шашны байгууллагатай ШУ-ыг төлөөлөн харьцдаг байх (1.0%)
- ШУА ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг хүлээх (1.0%)
- ШУА-ийн хариуцлагыг өндөржүүлэх (1.0%)
- Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих (1.0%)
- Докторантурт сургах талаар (1.0%)

**Санхүүжилт, санхүүжилтийн механизмын талаар**

- ШУТ-ийн санг ШУА-ийн бүтцэд байхаар зохион байгуулах (46.2%)
- ШУТС-г ОУ-ын жишгээр грант олгодог чиглэлээр өөрчлөн байгуулах /ЗГ-тай гэрээгээр ажилладаг ТББ хэлбэрт шилжүүлэх/ (1.0%)
- Төсөл, суурь судалгаа хоёрыг санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгах (72.1%)
- Инновацийн болон грантын судалгааг санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгаж, өөрчлөх (1.0%)
- ШУ-ны санхүүжилтийг ДНБ-ний 5 хувьд хүргэх (1.0%)

**Судалгаа, туршилтын ажлын үр дүн, түүнийг практикт нэвтрүүлэх талаар**

- ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн хэвшлийнхэн болон их, дээд сургуультай хамтарч ажиллах менежментийг бий болгох(69.2%)
- ШУ-ны парк, гарааны компани байгуулахад татвар, гаалийн бодлогоор дэмжих(69.2%)
- Үйлдвэрлэгч, судлаач, бодлого зохицуулагчдын хоорондын уялдаа холбоог хуулинд тодорхойлох (56.7%)
- Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хамтын ажиллагаатай үйлдвэрийн эдийн засгийн хөшүүрэг болгох(1.0%)
- Технологи патент худалдах хууль эрх зүйн акт бий болгох(1.0%)

шаардлагатай гэжээ.

## **Гурав. Шинжлэх ухааны академи ба бусад институци хоорондын уялдаа холбоо**

### **ШУА ба Ерөнхийлөгчийн институт**

Эдгээр институт хооронд өнөөгийн байдлаар хуулиар тогтоосон харилцаа, уялдаа холбоо бараг байхгүй. Ерөнхийлөгчийн нэрэмжит залуу эрдэмтэн судлаачдын тэтгэлэг шагнал жил тутам олгодгоос өөрөөр ШУА ерөнхийлөгчийн институт хооронд бодит уялдаа холбоо бараг байхгүй байгааг салбарын экспертүүд ярьж байв. 40 хувь нь ямар холбоо харилцаатай болохыг мэдэхгүй гэдгээ илэрхийлсэн.

Өнөөгийн байдлаар энэ 2 институцийн хооронд ямар ч уялдаа холбоо байхгүй гэж 14.3 хувь нь, маш бага буюу 1-5 хувийн уялдаа холбоо байна гэж 16.2 хувь нь, 10-15 хувийн харилцаатай гэж 21 хувь нь, 20-50 хувийн уялдаа холбоотой гэж 8.7 хувь нь тодорхойлжээ.

Харилцааны дундаж утга нь 8.4 буюу өөрөөр хэлбэл ШУА ба ерөнхийлөгчийн институцийн уялдаа холбоо харилцаа нь одоогийн байдлаар дунджаар 8 хувьтай л байна гэж дүгнэсэн байна.

ШУА ба Ерөнхийлөгчийн институци хоорондын холбоо хэлхээний талаар экспертүүдийн санаа бодол ялгавартай байв. Зарим нь ШУА ерөнхийлөгчийн юм уу ЗГ-ын шууд удирдлагад агентлаг хэлбэрээр ажиллах санал гаргасныг дээр дурьдсан гэтэл зарим хэсэг нь огт ийм харьяалалд орж болохгүй гэсэн байр суурь илэрхийлсэн. Ерөнхийлөгчийн институцитэй ШУА одоогийнхоос 2 дахин илүү харилцаа, уялдаа холбоотой байх нь зохимжтой гэсэн санал бүхий байна.

### **ШУА ба Засгийн газар**


Хуулиар тогтоосон эрх үүргийн харилцааг авч үзвэл хоорондоо босоо шугаман харилцаатай. Засгийн газрын тэргүүн нь ШУА-ийн сонгогдсон ерөнхийлөгчийг батламжилдаг. Хэрэв батламжлахгүй бол ШУА-ийн ерөнхийлөгчийг дахин сонгох болно. Гэвч нэг ч удаа батламжлаагүй тохиолдол гарч байгаагүй байна. Мөн ШУА-ийн ерөнхийлөгч нь Засгийн газрын тэргүүний ШУ, технологийн зөвлөх байна гэж заасан ч энэ нь биелэгддэггүй заалт гэж зарим экспертүүд үнэлсэн<sup>37</sup>. Жишээ нь гадаад улс орнууд руу явлаа гэхэд ШУА-ийн ерөнхийлөгчийг авч явж байгаагүй зэргээс нь энэ нь харагддаг гэх мэтээр тайлбарласан. Засгийн газар ШУА-ийн хүрээлэнгүүдийг байгуулах, өөрчлөн зохион байгуулах, татан буулгах эрхтэй. Энэ эрх үүргийн дагуу ч ШУА, түүний хүрээлэнгүүдийг өөрчлөх, татан буулгах асуудал Засгийн газар, эрх барьж буй намын байр суурь, бодлого, намын удирдагчдын

<sup>37</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 1. ЭШ-ний тэргүүлэх ажилтан, академич. 2016.12.16.

үзэл бодлоос шалтгаалан янз бүрээр тавигдаж, хөндөгдөж байдаг тогтворгүй асуудал болж хувирсан. ШУА, хүрээлэнгүүдийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт 2 ч удаа хийгдээд байгаа нь тийм ч үр дүнтэй арга хэмжээ болж чадаагүй юм. Энэ талаар тайлангийн дараагийн хэсэгт авч үзэх болно.

Өнөөгийн байдлаар ямар ч уялдаа холбоо байхгүй гэж 5.7 хувь нь, маш бага буюу 5 хувийн уялдаа холбоо байна гэж 11.4 хувь нь үзэж, 39 хувь нь хэр холбоо харилцаатай болохыг мэдэхгүй хэмээн хариулсан. Ер нь 0-60 хувиар уялдаа холбоог нь илэрхийлснээс ШУА ба Засгийн газар хоорондын одоогийн уялдаа холбоо харилцааг үнэлснийг дунджаар гаргавал 16 хувьтай л байна гэж дүгнэжээ.

**Зураг 2.3.1 ШУА ба бусад институт хоорондын харилцаа, уялдаа холбоо, өнөөгийн байдлын үнэлгээ ба зохимжит уялдаа холбоог хувиар илэрхийлсэн нь**



### ШУА ба БСШУСЯ

Тус яаман дээр ШУТГ ажиллаж, ШУТ-ийн бодлого боловсруулж, ШУА, хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны даалгавар эндээс батлагдан гарч, хянагдаж байдгаараа хамгийн нягт холбоо харилцаатай байдгийг хэлсэн. Гэхдээ мөн 39 хувь нь бодит амьдрал дээр хэр холбоо харилцаатай болохыг сайн мэдэхгүй байв. Ер нь 10-83 хувиар уялдаа холбоог нь илэрхийлснээс ШУА ба БСШУСЯ хоорондын одоогийн уялдаа холбоо харилцааг үнэлснийг дунджаар гаргавал 37.3 хувьтай байна.

### ШУА ба ШУТС

ШУ-ны салбарын санхүүжилт ШУТС-аар дамжиж явагдаж, суурь судалгааны төслүүдийн санхүүжилт, ШУТТ-ийн санхүүжилт авч, ажлын үр дүнг яам, болон санд тайлагнах, хүлээлгэн өгөх зэргээр хамгийн бодит харилцаа, уялдаа холбоог мэдэрч байдаг институци аж.

Хамгийн их холбоотой ажилладаг институт хэдий ч 40 хувь нь хэр холбоо харилцаатайг нарийн тодорхой мэдэхгүй байв. Ер нь 0-60 хувиар уялдаа холбоог нь илэрхийлснээс ШУА ба ШУТС хоорондын одоогийн уялдаа холбоо харилцааг дунджаар үнэлбэл 27.3 хувьтай гэж дүгнэсэн.

ШУА-ийн хүрээлэн төвүүдийн удирдлага, эрдэмтэн судлаачид, академичид ШУТС-нг одоогийн чиг үүрэг, санхүүжилтийн механизмын хүрээнд ажиллах юм бол шаардлагагүй, илүү бүтэц, механизм болоод байгааг<sup>38</sup> хэлж, үүнийг өөрчлөх, эс бөгөөс татан буулгах хэрэв байлгавал ШУТС зөвхөн ШУТ-ийн төсөл босгодог, санхүүжилт олон улсын төсөл юм уу өөр

<sup>38</sup> Мөн тэнд.

эх үүсвэрээс олдог бие даасан байгууллага болох, түүнээс улсын төсвөөс орж ирж буй мөнгийг дамжуулагч илүү дамжлага болж байх шаардлагагүй гэж үзсэн<sup>39</sup>. Мөн олон жил судалгаа шинжилгээний ажил хийж, нарийн мэргэшсэн эрдэмтэн судлаачдын ажлын үр дүнг тухайн ажлын талаар огт мэдлэггүй, мэргэжлийн бус хүмүүс (ШУТС-ийнхан) хянаж шалган, үнэлнэ гэдэг утгагүй хэмээн мэдэгдсэн<sup>40</sup> юм.

### ШУА ба их дээд сургууль

Их дээд сургуулийн төгсөгчид өнөөдөр эрдэм шинжилгээний байгууллагын шаардлагад нийцэхгүй, авч ажиллуулж буй хүмүүсийг дахин бэлтгэх хэрэгтэй болж байгаа, өнөөдөр эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд аливаа нэг шинжлэх ухааны салбар хэдхэн эрдэм шинжилгээний ажилтнууд дээр тогтож, гадны оронд судалгааны салбар, сектор, хүрээлэн судлаж буй бүхэл бүтэн судалгааны том салбар судлагдахууныг ганц судлаач мэргэшин судалж байна, хэрэв муугаар бодвол тэр хүнд ямар нэг юм тохиолдоход тэр салбар тэр чигтээ нурж, тухайн судалгааны ажлууд үгүй болж мэдэхээр байгаа. Судалгааны нарийсгаж гүн рүү нь ороход хүн хүч дутаж байна, ядаж багийн түвшинд тухайн судлах зүйлийг судлаж байж үр дүнд хүрнэ.<sup>41</sup> ЭШ-ний ажлын туршлага асар олон арван жилийн хүч хөдөлмөрөөр бий болж байдаг, туршлагатай эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээний ажлын хажуугаар ихэвчлэн их дээд сургуульд багшлаж, шавь бэлтгэж авахаар чармайж байгаа ч бэлтгэсэн хүүхдүүд магистр, бакалаврын ажил хамгаалаад л цааш судалгаагаа үргэлжлүүлэх боломжгүй орхиж байна. Учир нь их сургууль төгсөж буй хүүхдүүдээс чадвартай нэг нь цалин хөлс, ажлын нөхцөлийг голоод ирэхгүй, (*шинээр орсон залуу ажилтанд ажиллах компьютер ч байхгүй, ажиллах нөхцөл боломжоор хангаж чадахгүй байгаа явдал судалгаагаар явж байхад тааралдсан*) ирсэн ч орон тооны хязгаарлагдмал байдлаас цөөн хүн авах, мөн өөр чиглэлийн судалгаагаар мэргэшүүлэх шаардлагатай байдгаас судалгааны нэг чиглэлд хүн хүч дутагдсан хэвээр л үлдэж байгаа талаар<sup>42</sup> мөн их сургуулийн багш нартай судалгааны төсөлд хамтран ажиллах гэдэг амьдрал дээр жинхэнэ утгаар огт хэрэгждэггүй биелшгүй зүйл болоод байгаа талаар<sup>43</sup> судалгаанд оролцсон экспертүүд өгүүлсэн юм. Аль судалгааны төслийн удирдагч аль байгууллагынх байна, тэнд төсөл нь голлож хэрэгжээд нөгөө байгууллагын оролцогчийн үүрэг роль бараг байдаггүй, нэр төдий л оролцоотой болох нь нийтлэг болоод байгааг шүүмжилсэн. Энэ бүхэн ШУА их дээд сургуулийн уялдаа холбоо ямар тааруу түвшинд байгааг харуулах баримтууд юм.

ШУА ба их дээд сургуулийн хооронд эрдэмтэн судлаачид цагийн багш хийх, дипломын ажил удирдах, зөвлөх, шүүмжлэгчээр ажиллах, их дээд сургуулийн оюутнууд хүрээлэн, төвүүдэд ирж дадлага хийх, магистр, докторантурын сургалт, хамгаалах зөвлөл, эрдэм шинжилгээний хамтарсан хурал хийх зэргээр хязгаарлагдаж байна. Харин суурь судалгаа шинжилгээний хамтарсан ажлууд гүйцэтгэх, бие биенийхээ дутуу дундуурыг дүүргэн ШУ-ыг хөгжүүлэхэд цогц систем болж ажиллах үр дүнтэй уялдаа холбоо үгүйлэгдсээр байгаа юм.

Өнөөгийн байдлаар ямар ч уялдаа холбоо байхгүй гэж 10.5 хувь нь үзэж, 39 хувь нь хэр холбоо харилцаатай болохыг мэдэхгүй хэмээн хариулсан. Ер нь 0-60 хувиар уялдаа холбоог

<sup>39</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 2. ЭШ-ний хирээлэнгийн удирдах ажилтан, шинжлэх ухааны доктор. 2016.12.15.

<sup>40</sup> Мөн тэнд.

<sup>41</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 3. Хирээлэнгийн ЭШ-ний ахлах ажилтан, доктор (Ph.D). 2016.12.15.

<sup>42</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 3. Хирээлэнгийн ЭШ-ний ахлах ажилтан, доктор (Ph.D). 2016.12.15; Чанарын судалгаа. Ярилцлага 4. Хирээлэнгийн ЭШ-ний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D). 2016.12.15.

<sup>43</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 4. Хирээлэнгийн ЭШ-ний тэргүүлэх ажилтан, доктор (Ph.D). 2016.12.15.

нь илэрхийлснээс ШУА ба их дээд сургууль хоорондын одоогийн уялдаа холбоо харилцааг үнэлснийг нь дунджаар илэрхийлбэл 9.8 хувьтай гарчээ.

ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийг их дээд сургуультай нэгтгэх талаар экспертүүдийн дийлэнх олонх нь эсрэг байр суурь бүхий байна тухайлбал, нэгтгэх нь онолын суурь судалгааны чиглэл, судалгааны ажил, бэлтгэгдсэн боловсон хүчин үгүй болох эрсдэл дагуулж ирснийг (35.0%) Математикийн хүрээлэн их сургуультай нэгдээд бараг утсан жишээг дурьдан сануулаад хүрээлэнгүүдийг их дээд сургуультай нэгтгэхээс илүүтэй хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллах нь үр дүнтэй хэмээн үзсэн нь нийт саналын дотор хамгийн их жин (40.5) дарж байна. Мөн их дээд сургууль дээр ч ШУА, хүрээлэн төв, лаборатори дээр ч ШУ-ны судалгааг явуулж, тус тусад нь хөгжүүлэхийг (16.5%) дэмжжээ.

Хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэж, судлаачдын бүтээмжийг дээшлүүлэх хэрэгтэй, Graduate school нь хамтарсан судалгааны ажлын хэлбэр болно гэсэн нэгтгэхийг дэмжсэн саналууд 3.5 хувийг л эзлэж байна.

Хэрэв нэгтгэхэд хүрвэл их дээд сургуулийн дотоод бүтцийг мөн өөрчлөх хэрэгтэй. Хүрээлэнг аваачиж хавсаргах биш, хүрээлэнгийн судлаачид дээр түшиглэсэн профессорын баг байдлаар ажиллаж болно, Багш нар цаг ихтэй тул судалгаа руу гүн орж чаддаггүй, тиймээс тодорхой гэрээгээр орж ажиллах нь илүү үр дүнд хүрнэ, судлаачдыг уялдаа холбоотой ажиллуулах нь зүйтэй, Их, дээд сургуулиуд судалгааны сургууль бус оюутнуудаас мөнгө авах хэлбэртэй л байна, Их дээд сургуультай нэгтгэсэн туршлагаас харахад их дээд сургуулиуд огт дэмжиж ажиллахгүй байна, Нэг хэсэг хугацаанд их дээд сургуулиудын дэргэд ЭШ-ний хүрээлэн байгуулахыг татгалзах хэрэгтэй гэсэн саналуудыг дэвшүүлсэн.

Үүнээс гадна “Шинжлэх ухаан, технологийн асуудлыг тусгайлан авч үзэх, чиг үүргийн хувьд ондоо тул Соёл боловсролын яам, ШУ технологийн яам гэж бодлогын хувьд салангид авч үзэх нь бусад орны ШУ-ны бодлоготой хамтарч хөгжихөд түлхэц болох нэг гарц юм. ШУ, технологийн бодлогыг хэрэгжүүлэгч жанжин штаб болж ШУА ажиллах ёстой. Ямар ч нам гарлаа гэсэн улс орны хөгжлийн бодлого болсон ШУ, технологийн бодлогоо алдалгүй гуйвалтгүй барьж, тэдэнд сануулж байх ёстой хүмүүс нь эрдэмтэд, ШУ-ны салбарынхан байх ёстой, бизнесийн, нам, улс төрийн эрх ашгийн үүднээс гуйвж дайвсан, эрх барьж буй намыг дагаж өөрчлөгдөж байдаг бодлого улс орныг мөхөөх нь үүнийг дээрх өөрчлөлтөөр үгүй хийх боломжтой”<sup>44</sup> гэсэн байр суурь илэрхийлсэн.

Түүнчлэн ШУА магистр, доктор хамгаалуулах эрхээ авах, ШУА-д докторантурын сургалтын газартай болгож, хүрээлэнгүүдийн дэргэд докторантур нээх, зэрэг хамгаалуулах зөвлөл БШУСЯ-ны шийдвэрээр нэгдмэл байх нь зохимжтой. Шаардлагатай бол энэ талаар холбогдох хуулинд тусгах гэсэн саналыг мөн дэвшүүлсэн юм.

<sup>44</sup> Чанарын судалгаа. Ярилцлага 3. Хирээлэнгийн ЭШ-ний ахлах ажилтан, доктор (Ph.D). 2016.12.15.


## 2.3. ШУ-НЫ САЛБАРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

### Нэг. ШУ-ны салбарын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг

Монгол улсын шинжлэх ухааны салбар, тэр дундаа Шинжлэх ухааны академийн нийгэм эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор хоёр удаа бүтцийн шинжтэй өөрчлөлт хийсэн байдаг. Эхний удаагийнх нь 1997 онд Засгийн газрын 31 дүгээр тогтоолд үндэслэн Улсын эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийг нэгтгэж 23 хүрээлэн, төвтэй байхаар заасан. Хоёр дахь өөрчлөлтөөр өмнө баталсан 31 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, 2015 оны Засгийн газрын 27 дугаар тогтоолын хавсралтад үндэслэн хүрээлэн, төвүүдийг дахин нэгтгэж ШУА-ийг 11 хүрээлэн, төвтэй байхаар тогтоосон юм.

Харин энэхүү өөрчлөлтийн үр дүнг салбарын экспертүүдийн 85 хувь нь хэлбэр төдий, үр дүнгүй ажил болсон гэж дүгнэж байна. Тодруулбал, 56.2 хувь нь хүрээлэнгүүдийг нэгтгэн нийлүүлсэн нь механик өөрчлөлт л болсон бөгөөд үр дүн тодорхой бус байна гэсэн бол 28.8 хувь нь шаардлагагүй арга хэмжээ болсон гэжээ. Харин 15.1 хувь зөв зүйтэй өөрчлөлт болсон, цаашид үр дүн нь харагдах байх гэсэн хүлээлттэй байна. ШУА-ийн харьяа хүрээлэн болон харьяа бус хүрээлэн, төв (НЭМХ, АУЭШХ, Нэхмэлийн хүрээлэн, Уул уурхайн хүрээлэн г.м)-үүдэд ажиллаж буй экспертүүдийн хариултын үр дүн адил гарчээ.

Зураг 3.1 2015 онд хийгдсэн ШУА-ийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн үр дүнгийн үнэлгээ



ШУА-д хэрэгжүүлсэн энэхүү өөрчлөлтийг “шинжлэх ухааны байгууллагын удирдлага, зохион байгуулалт, менежментийг олон нийтийн оролцоонд суурилсан, ардчилсан, хараат бус, нээлттэй зарчимд шилжүүлэх”<sup>45</sup> гэсэн үзэл санаанд тулгуурлажээ. Агуулгын талаас харвал үүнд шинжлэх ухааны байгууллагад нийцэхээс илүүтэй үл нийцэх, цаашид анхаарвал зохих асуудал цөөнгүй бий аж. *Нэгдүгээрт*: нийгэмд бүхий л зүйлсийг олон нийтийн оролцоонд тулгуурлан шийдэх боломж хязгаарлагдмал бөгөөд улс орны хэрэгцээ, шинжлэх ухааны өөрийнх нь хөгжлийн аяс, олон нийтийн соёлын түвшин, дэлхийн чиг хандлага гэхчилэн олон

<sup>45</sup> “МУ-ын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах” тухай МУ-ын УИХ-ын тогтоол. №37. // <http://www.legalinfo.mn/law/details/8722> // 2016.12.26.

хүчин зүйл нөлөөлдөг. Гэхдээ нийгэм, олон нийтийн хэрэгцээнд суурилсан, хүсэл сонирхлыг нь хангах боломж, гарцыг хайх, тэдний оновчтой санал шүүмжийг үйл ажиллагаандаа тусгаж, байнгын шинэчлэл хийх замаар шинжлэх ухааныг хөгжүүлэх бололцоо бий. *Хоёрдугаарт*: ардчилсан зарчмаар шинжлэх ухааны байгууллагын удирдлагыг сонгох нь оновчтой байж болох ч салбарын удирдах албан тушаалтнуудыг хэсэг бүлэг хүмүүс (Sc.D, академичид)-ийн амин хувийн тохироо, нам улс төрийн хүчний нөлөөгөөр шийдвэрлэгдэг гэх хардлага байсаар ирсэн. Иймээс шинжлэх ухааны байгууллагын ажилтнуудын саналыг харгалзан үзэх нь зарчмын хувьд оновчтой байх талтай юм. *Гуравдугаарт*: шинжлэх ухааны байгууллага менежментийн хувьд ардчилсан зарчим ярихаас илүүтэй улс орон-нийгмийн хэрэгцээ, ойрын болон ирээдүйд үр өгөөжөө өгөх судалгаа, туршилтын ажил, суурь болон хавсарга судалгааны чиглэл гэхчилэн энэ салбарын хойшдын хөгжлийг илүү системтэйгээр харж, төлөвлөх нь зүйтэй юм. *Дөрөвдүгээрт*: өнөөдөр шинжлэх ухааны байгууллагын удирдлага, зохион байгуулалт болон үйл ажиллагааны хүрээнд хараат бус, нээлттэй зарчмаар үйл ажиллагаа явуулах хэрэгцээ маш их байгаа ч бүрэн хэрэгжихгүй байна. *Тавдугаарт*: ШУ-ны талаар баримтлаж буй аливаа үзэл санааг зөвхөн ШУА-ийн хүрээнд ярьж байна уу, эсвэл салбар академи, хувийн эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийг хамруулж байна уу гэдгийг мөн анхаарах нь зүйтэй юм. Наад зах нь үйл ажиллагааны зарчим, санхүүжилт, харьяалалд хамаарах бүтцийн хувьд харилцан адилгүй (салбар нэгжийн хувьд) газруудыг бүхэлчилж авч үзэх бололцоо бага юм. Эдгээрээс улс орны оюуны цөм болсон байгууллагын үйл ажиллагааг аль нэг намаас дэвшүүлж буй (*ажил хийсэн гэх нэр зүүсэн, хийсвэр ойлголтуудаас бүрдсэн, хэлбэр төдий шийдвэр*) үзэл баримтлалд тулгуурлан хөгжүүлэх нь цаг хугацааны хувьд боломж багатайгаас гадна тухайн салбартаа эрсдэлтэй юм. Иймээс харин урт хугацааны бодлогод тулгуурлан, маш тодорхой зорилт дэвшүүлэн түүндээ хүрэхийн төлөө ажиллах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам солигдоход өөрчлөгддөг, мөн хэт хийсвэр шинжтэй бодлого, хөтөлбөрөөс ангид байж шинжлэх ухааныг хөгжүүлнэ.

Дээрх баримтад үндэслэн эхний удаад ШУА-д өөрчлөлтийг ямар бүтэц дараалалтайгаар, хаанаас нь эхлэх вэ гэсэн асуудал урган гарна. Үүнтэй холбоотой ШУ-ны салбарын зохион байгуулалт, удирдлага, менежмент, хууль эрх зүйн орчинд хийх өөрчлөлтийн талаар тодруулж, хэв маягчлал үүсгэхэд дараах таван бүлэг асуудал болж байна. Үүнд:

1) ШУА-ийн эрх зүйн хүрээнд академийн статусыг тодорхой болгож, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлан тогтоох (төрийн институцүүдийн харилцаа, уялдаа холбоог зохистой болгох). Мөн хамаарах хуулиудын уялдаа холбоог хангах шаардлагатай гэж үзэж байна.

2) ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн бүтэц, зохион байгуулалт болон Их, Бага чуулганы бүтэц, үүрэг, хариуцлагыг өөрчлөх,

3) ШУА-ийн эрх хэмжээг шинэ түвшинд гаргах,

4) Санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, холбогдох журам, механизмыг өөрчлөх,

5) Нөөц бүрдүүлэх, идэвхижүүлэх тухай,

- Техник технологийн шинэчлэл хийх,
- Материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах,
- Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх,
- Оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэх,
- Ажиллах хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах,
- Цалин хөлсний сүлжээний шатлал дахь суурь цалин хөлсний хэмжээг ахиулах,
- ШУ, технологийн ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизмыг бүрдүүлэх,

Дундаж утгад үндэслэн ач холбогдлоор нь эрэмбэлэж үзвэл **ШУ-ны салбарт ажиллагсдын үнэлэмж, цалин хангамж, нийгмийн хамгааллыг сайжруулах** тухай асуудал (оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэх (3.80), цалин хөлсний сүлжээний шатлал дахь суурь цалин хөлсний хэмжээг ахиулах (3.76), материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах (3.74), боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх (3.70), ажиллах хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах (3.68)) хамгийн чухлаар тавигдаж байгаа бол үүний дараа **судалгаа, туршилтын ажлын үр ашгийг дээшлүүлэх** (ШУ, технологийн ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизмыг бүрдүүлэх 3.64: техник технологийн шинэчлэл хийх 3.63), **статус, эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох** (ШУА болон салбарын статусыг тодорхой болгох 3.53, эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах 3.47, эрх мэдлийн хуваарилалтыг хуулиар нарийвчлан тогтоох 3.41, ШУА-ийн эрх хэмжээг шинэ түвшинд гаргах 3.35), **санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, журмыг өөрчлөх** (санхүүжилтийн журам, механизмыг өөрчлөх 3.36, санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өөрчлөх 3.30), **ШУА-ийн дотоод бүтцийг өөрчилж, төрийн институциудын харилцаа холбоог зохистой болгох** (ШУА болон төрийн институциудын харилцаа, уялдаа холбоог зохистой болгох 3.34, ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг бүхэлд нь өөрчлөх 2.60, ШУА-ийн Их, Бага чуулганы бүрэлдэхүүн, хүлээх үүрэг хариуцлагыг өөрчлөх 2.92) асуудлыг чухалчлан авч үзжээ.

### Хүснэгт 3.1.1 ШУА-д өөрчлөлт хийх чиглэл, шаардлага (дундаж үзүүдэлтээр эрэмбэлсэн үр дүн)

	Зайлшгүй шаардлагатай /4/	Шаардлагагүй /3/	Нэг их шаардлагагүй /2/	Огт шаардлагагүй /1/	Дундаж утга
<b>ШУ-ны салбарт ажиллагсдын үнэлэмж, цалин хангамж, нийгмийн хамгааллыг сайжруулах</b>					
Оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэх	83.0	15.0	1.0	1.0	3.80
Цалин хөлсний сүлжээний шатлал дахь суурь цалин хөлсний хэмжээг ахиулах	77.0	22.0	1.0	-	3.76
Материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	77.8	19.2	2.0	1.0	3.74
Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх	72.7	24.2	3.0	-	3.70
Ажиллах хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах	70.4	27.6	2.0	-	3.68
<b>Судалгаа, туршилтын ажлын үр ашгийг дээшлүүлэх зам</b>					
ШУ, технологийн ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизмыг бүрдүүлэх	66.0	32.0	2.0	-	3.64
Техник технологийн шинэчлэл хийх	68.0	26.8	5.2	-	3.63
<b>Статус, эрх мэдлийн хуваарилалтыг тодорхой болгох</b>					
ШУА болон салбарын статусыг тодорхой болгох	64.3	28.6	3.1	4.1	3.53
Эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах	52.1	43.6	3.2	1.1	3.47
Эрх мэдлийн хуваарилалтыг хуулиар нарийвчлан тогтоох	53.7	36.8	6.3	3.2	3.41
ШУА-ийн эрх хэмжээг шинэ түвшинд гаргах	54.7	29.5	11.6	4.2	3.35
<b>Санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, журмыг өөрчлөх</b>					
Санхүүжилтийн журам, механизмыг өөрчлөх	49.5	37.6	11.8	1.1	3.36
Санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өөрчлөх	46.4	40.2	10.3	3.1	3.30
<b>ШУА-ийн дотоод бүтцийг өөрчилж, төрийн институциудын харилцаа холбоог зохистой болгох</b>					
ШУА болон төрийн институциудын харилцаа, уялдаа холбоог зохистой болгох	45.8	44.8	7.3	2.1	3.34
ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг бүхэлд нь өөрчлөх	20.2	29.8	39.4	10.6	2.60
ШУА-ийн Их, Бага чуулганы бүрэлдэхүүн, хүлээх үүрэг хариуцлагыг өөрчлөх	38.5	24.0	28.1	9.4	2.92

“Төсвийн бус эх үүсвэрээр хэрэгжиж буй судалгаа, хөгжлийн ажлын судалгаа” тайланд мөн л санхүүжилт, боловсон хүчин, бодлого хөтөлбөр, тоног төхөөрөмжийг сайжруулах гэсэн асуудлыг хөндөж байсан нь агуулгын хувьд дээр үзүүлсэн үр дүнтэй нийцэж байна.

**Хүснэгт 3.1.2 Монгол улсад шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэхэд төрийн зүгээс авбал зохих арга хэмжээ (Эрдэмтэн, судлаачдын асуулгын үр дүн)<sup>46</sup>**

Санал	Хувь
Санхүүжилтийг гадаадын хөгжилтэй, хөгжиж буй орны түвшинд хүргэх	37.4
Боловсон хүчний асуудалд анхаарах	10.3
Бодлого боловсруулах	10.3
ШУ-ны байгууллагын лабораторийг орчин үеийн багаж төхөөрөмжөөр хангах	7.5
Хувийн болон бусад байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, уялдаа холбоог сайжруулах	4.7
Инновацийн төсөл шинэлэг санааг тасралтгүй бий болгох	4.7
Төсөл, сэдвийн үр дүнг маш тодорхой болгож тооцдог байх	2.8
Хуулиа хэрэгжүүлсе	2.8
Шинжлэх ухаанаа бүрэн ойлгох хэрэгтэй	2.8
Суурь судалгааны баазыг бий болгох	1.9
Боловсруулсан төслийн ажилд үр дүнгийн үнэлгээ хийх	1.9
Технологи, инновацийн төслийг, удирдагчийг нээлттэй шалгаруулах	1.9
<b>Бусад</b>	<b>11</b>

ШУА-ийн удирдлага зохион байгуулалт, менежментийг одоогийнхоос сайжруулахын тулд дараах бүлэг асуудлуудад анхаарах шаардлагатай гэж судалгаанд оролцогчид үзэж байна.

**Нэгдүгээрт:** удирдлага, зохион байгуулалтын хувьд цаг үеийн шаардлагад нийцсэн байдлаар үйл ажиллагаа явуулах, академийн ерөнхийлөгчийн үйл ажиллагааг нийтэд ил тод болгох, удирдлагын бүтцэд залуу, мэргэжлийн боловсон хүчнийг томилох, сонгон шалгаруулалтаар удирдлагыг томилох зэрэг асуудлыг хөндөн тавьж байна. Мөн ШУА-ийн Их чуулганд залуучууд болон ажлын туршлагатай хүмүүсийг оруулж ажиллуулах, суурь судалгааны хүрээнд Бага чуулганы үүрэг ролийг нэмэх зэрэг асуудлыг хөндөн тавьж байлаа. Удирдлага, зохион байгуулалтын талаарх саналууд 39.1%-ийг эзлэж байна. Үүнд:

- ШУА-ийн ерөнхийлөгч, удирдлагууд хүрээлэн төв, судлаачидтай уулзаж тэдний санал санаачлага болон цаг үеийн тулгамдсан асуудлаар экспертүүдийн санал санаачлагыг сонсож байх, бодлого хөтөлбөрт тусгаж, хэрэгжүүлэх (11.8%)
- Академийн удирдлага хуулийн хүрээнд ил тод үйл ажиллагаа явуулах (7.8%)
- Удирдлагын бүрэлдэхүүнд мэргэжлийн, залуу, ёс зүйтэй боловсон хүчнийг ажиллуулах (7.8%)
- Академийн удирдлагын сонгуулийг шударга болгох, сонгон шалгаруулалт явуулдаг болох (3.4%)
- Их чуулганд залуу боловсон хүчин, ажлын туршлагатай хүмүүсийг түлхүү оролцуулах, дүрэм журмаа шинэчлэх (5.0%)
- Бага чуулганы үүрэг ролийг суурь судалгаанд өндөржүүлэх ёстой (3.3%)

<sup>46</sup> БСШУЯ, ШУА-ийн ФСЭЗХ. “Төсвийн бус эх үүсвэрээр хэрэгжиж буй судалгаа, хөгжлийн ажлын судалгаа” тайлан. УБ., 2013.

**Хоёрдугаарт: ШУА-ийн бүтэц, үйл ажиллагааны хүрээнд (22.9%)**

ШУА-ийг бүтэц, үйл ажиллагааны хувьд ААН, үйлдвэрлэлийн салбартай холбох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагааны зардлаас 2 дахин их үнэд хүрэх бүтээгдэхүүн бий болгох, ШУ-ны салбарыг нэгдсэн удирдлагаар хангах зэрэг асуудлыг дурдаж байлаа. Мөн цөөнгүй оролцогч одоогийн бүтэц, зохион байгуулалтаар ажиллах боломжтой гэж үзсэн юм.

- ААН, үйлдвэрлэлийн салбартай холбох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх (10.1%)
- Шинжлэх ухаанд х (икс) хөрөнгө зарцуулаад 2-оос дээш х (икс) хөрөнгөөр үнэлэгдэх бие бус оюуны, шинэ мэдлэгийн ба бие бүтээгдэхүүн буй болгох менежмент нэвтрүүлэх (1.7%)
- ШУ-ны салбарыг бүхэлд нь нэгдсэн зохион байгуулалтад оруулах (ХАА ШУА-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дэмжих) (3.4%)
- Одоогийн бүтэц, зохион байгуулалтаар ажиллах боломжтой (7.7%)

**Гуравдугаарт: ШУА-ийн статусыг шинэчлэх, тодорхой болгох чиглэлээр (21.8%)**

ШУА-ийн статусыг өөрчлөх шаардлагатай гэж ойролцоогоор таван хүн тутмын нэг нь үзсэн бөгөөд үүнтэй холбоотой стратеги бодлогод нөлөөлж чадахуйц ажил хийх, мөн Засгийн газрын бүтцэд оруулах, агентлагийн статустай дүйх хэмжээний эрх мэдэлтэй болгох гэсэн тодорхой саналуудыг хэлсэн байна.

- Стратеги, бодлогод нөлөөлж чадахуйц ажил хийх, бүтцээ өргөжүүлэх (5.0%)
- Засгийн газрын бүтцэд оруулж, ШУА-ийн ерөнхийлөгчийг хуралдаанд байнга оролцуулдаг болох (3.4%)
- Засгийн газрын агентлагийн хэмжээнд статустай болгох (1.7%)
- ШУА нь Германы МаксПланк нийгэмлэг үү эсвэл Германы ШУА Leopddina болох уу гэдгээс хамаарна (1.7%)


**Дөрөвдүгээрт:** Санхүүжилтийн хувьд ШУА-ийг удирдлага, санхүүжилтийнх нь хувьд бие даалгах, эсвэл санхүүжилт олгодог шат, дамжлагыг цөөрүүлэх, судалгааны ажлын үр дүнг практикт нэвтрүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг нэмж олгох нь зүйтэй гэсэн санаануудыг (8.4%) гаргаж тавьсан.

**Хоёр. ШУА-ийн үйл ажиллагааны үнэлгээ**

“Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай”<sup>47</sup> тухай хуулийн 1 бүлгийн 2 дугаар зүйлд “Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн. Академи нь төрийн ивээлд байна” гэж хуульчилсан бөгөөд энэ утгаар ШУА нь Монгол улсын оюуны үйлдвэрлэлийн цөм байгууллага юм. Харин ШУ-ны салбарт ажиллаж буй эрдэмтэд болон холбогдох төрийн захиргааны байгууллагад ажиллагсдын олонх нь ШУА-ийг үүргээ гүйцэтгэж л байна (76.2%) гэж үзэж байна. Хангалттай сайн гэж 12.9 хувь нь, өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна гэж 10.9 хариулжээ. Албан тушаал, эрдмийн зэрэг цол, харьяалагдах байгууллагаар нь харьцуулсан үр дүнгээс ялгаа ажиглагдаагүй.


<sup>47</sup> Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль. // <http://www.legalinfo.mn/law/details/93> // 2016.12.27

Зураг 3.2.1 ШУА-ийн үйл ажиллагаа, үр дүнгийн үнэлгээ



ШУА-ийн дотоод бүтцийн тухайд мөн л ийм дүр зураг харагдаж байна. “Их чуулган”, “Бага чуулган”-аар Монгол улсын шинжлэх ухааны салбарын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг. Тэгвэл судалгаанд оролцогчдын олонх нь “Их чуулган”, “Бага чуулган” үүргээ гүйцэтгэж л байна гэжээ. Гэхдээ “Их чуулган” (23.2%), “Бага чуулган” (26.3%)-ны үйл ажиллагаа өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна гэсэн үнэлгээ ШУА-ийн үйл ажиллагааны үнэлгээнээс даруй 2 дахин өндөр гарчээ.

Зураг 3.2.2 “Их чуулган”, “Бага чуулган”-ы үйл ажиллагаа, үр дүнгийн үнэлгээ



Энэ үр дүнгээс ШУА нь санаачлагч, манлайлагч байр суурьтай байгууллага бус гэх хандлага харагдаж байна. Үйл ажиллагааны хувьд уг байгууллагыг байлгалаа гэхэд нэг их буруудахгүй, салбар дундын үүрэг гүйцэтгэгч мэтээр аргацаан ажиллуулж байна. Ийн дүгнэж байгаа үндэслэлийг “ШУА-ийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 7 дугаар зүйлд тэмдэглэсэн үүрэг, тэдгээрийн агуулгаас харж болно. Тус хуулийн 7-ийн 1.1 (хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах), 1.2 (харьяа нэгж, лабораторийн үйл ажиллагааг зохицуулах, улсын захиалгатай судалгааны ажлыг үр дүнтэй гүйцэтгэх ажлыг зохион байгуулах)-д тусгасан үүрэг нь чиг үүргийн дагуу шууд хэрэгжих ажил гэж тооцож болох бол 1.3 (улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах), 1.4 (шинжлэх ухаан, технологийн бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлохтой холбогдсон дүгнэлт гаргах)-д заасан үүрэг харьцангуй бүтээлч шинжтэй, ШУ-ны салбарын үр өгөөжийг ашиглахад чиглэсэн үүрэгт оруулж тооцож болох юм. Харин 1.5-1.7 (7.1.5. шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгөх, хянан магадлагаа хийх; 7.1.6. салбарын шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, түвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, 7.1.7. эрдмийн зэрэг цолтой боловсон хүчин бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх)-д шинжлэх ухаанч гэхээс илүүтэй хавсарга, хамжлагын шинжтэй үүргийг тусгаж оруулсан нь харагдана. Өөрөөр хэлбэл, ШУА-ийн гүйцэтгэх үүргийг эрх зүйн хувьд хангалттай тусгаж өгөөгүй аж.

Бичиг баримтын судалгааны үр дүнд үндэслэн Монгол улсад ШУ-ны байгууллага, тэр дундаа ШУА-ийн гүйцэтгэвэл зохих үүргийг тодорхойлж, тэдгээрийн хэрэгжилт ямар түвшинд байгааг үнэлүүлээ. Судалгааны үр дүнгээс харахад ШУА нь мэдлэг, чадавхи бий болгох,

түгээх (5.96), судалгааны ажлын үр дүнг мэдээлэх, дамжуулах (5.66), шинэ бүтээгдэхүүн, технологийн судалгаа явуулах, хөгжүүлэх (5.25) тал дээр дундаж үзүүлэлтээс ялимгүй дээгүүр үнэлжээ. Харин улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд ШУ-ны үүднээс дүгнэж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлох (4.61), шинэ бүтээл, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх (4.44), төрд зөвлөх, бодлого тодорхойлох (4.25), улс орны томоохон төсөл хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгөх (4.08), улс орныг удирдан чиглүүлэх (3.34) үүрэг хангалтгүй гэж үзжээ.

### Хүснэгт 3.2.1 ШУА-ийн үүргээ хэрэгжүүлж буй байдал


Үүрэг	Дундаж утга
Мэдлэг, чадавхи бий болгох, түгээх	5.96
Судалгааны ажлын үр дүнг мэдээлэх, дамжуулах	5.66
Шинэ бүтээгдэхүүн, технологийн судалгаа явуулах, хөгжүүлэх	5.25
Улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдлыг ШУ-ны үүднээс дүгнэж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлох	4.61
Шинэ бүтээл, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх	4.44
Төрд зөвлөх, бодлого тодорхойлох	4.25
Улс орны томоохон төсөл, хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгөх	4.08
Улс орныг удирдан чиглүүлэх	3.34

**Тайлбар:** Маш муу-(1-2), Муу-(3-4), Дунд (5-6), Сайн (7-8), Маш сайн-(9-10) оноогоор үнэлүүлж, дундаж утгыг тооцож гаргав.

Ерөнхий хандлагын хувьд ШУА нийгэм-эдийн засаг, улс оронд чиглэсэн үүргээ гүйцэтгэж чадахгүй байна гэж дүгнэх үндэслэл харагдаж байна. Үүний шалтгаан нь удирдлага, бодлого, хөтөлбөр, харьяа хүрээлэн, төвүүдийн идэвхи, технологи, санхүүжилт зэрэг олон хүчин зүйлээс хамааралтай ч ШУА-ийн үйл ажиллагааг чиглүүлэгч бүтэц, бүрэлдэхүүнтэй зохих хэмжээгээр холбогдоно.

Монгол улсын ШУ-ны салбарт баримтлах бодлого чиглэл, улс орны нийгэм-эдийн засгийн чиг хандлагыг “Их чуулган”, “Бага чуулган” гэсэн хоёр түвшинд хэлэлцэж шийдвэрлэдэг. Харин энэ бүтцийн дагуу ШУА нь өмнөө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж чадаж байна уу, үгүй юу гэдэг нь чухал юм. Экспертүүдээс тодруулахад, ШУА-ийн бүтэц, зохион байгуулалтын энэ хэлбэрийг хадгалж үлдээд, зарчмын шинжтэй өөрчлөлт хийх шаардлагатай гэж 54.6 хувь нь хариулсан бол 33.3 хувь нь ШУ-ны асуудлыг Их чуулган, Бага чуулганы хуралдаанаар хэлэлцэж шийдэх нь оновчтой хувилбар гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл, 87.9 хувь нь Их чуулган, Бага чуулган байх нь зүйтэй гэж үзэж байгаа юм. Харин 12.1 хувь нь Их чуулган, Бага чуулганыг татан буулгаж, төр, хувийн хэвшил, их дээд сургууль, ШУА-ийн төлөөлөл бүхий хамтарсан зөвлөлөөр асуудлаа шийдэх хэрэгтэй гэсэн байр суурь илэрхийлжээ.

**Зураг 3.2.3 ШУА улс орны болон салбарын асуудлыг “Их чуулган”, “Бага чуулган”-аар хэлэлцэж шийддэгийг хэрхэн дүгнэж байна вэ?**



“Их чуулган”, “Бага чуулган”-ны үүргийн хэрэгжилтийг нарийвчлан тодруулж харъя. Судалгаанд оролцогчид “Их чуулган”-ны үүргээ биелүүлж буй байдлыг харвал:

*Нэгдүгээрт:* ШУА нь академийн үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэх (6.24), Бага чуулганаас оруулсан асуудлыг хэлэлцэх (6.01), академийн тэргүүлэгчид, харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх (5.26) зэрэг үүргээ дундаж түвшинд гүйцэтгэж байгаа гэж үнэлсэн,

*Хоёрдугаарт:* Улсын захиалгат судалгааны ажлын хөтөлбөр, төслийг хэлэлцэж, санал зөвлөмж гаргах (5.13) үүргийг дундаж гээд МУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, Зөвлөмж гаргаж УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-т өргөн барих (4.64), Академийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж Засгийн газраар батлуулах (4.54), Эрдэм шинжилгээний төсөлт ажлын үр дүн, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх (4.48), ШУТ-ийн тодорхой салбар чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх (4.35) зэрэг үүргийн хэрэгжилтийг дундаас доогуур түвшинд байна гэж дүгнэжээ. Үүнээс эхний гурван үүрэг буюу салбарын үйл ажиллагаатай холбоотой хэлэлцүүлэг, үнэлгээ дүгнэлт өгөх үйл явцыг харьцангуй сайн гэж үнэлжээ.

**Хүснэгт 3.2.2 Их чуулганы үүрэг, түүний хэрэгжилт**

Үүрэг	Дундаж утга
Академийн үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэх	6.24
Бага чуулганаас оруулсан асуудлыг хэлэлцэх	6.01
Академийн тэргүүлэгчид, харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх	5.26
Улсын захиалгат судалгааны ажлын хөтөлбөр, төслийг хэлэлцэж, санал зөвлөмж гаргах	5.13
МУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-т өргөн барих	4.64
Академийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж Засгийн газраар батлуулах	4.54
Эрдэм шинжилгээний төсөлт ажлын үр дүн, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	4.48
ШУТ-ийн тодорхой салбар чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх	4.35

Харин нийгэмд ШУ-ны судалгаа туршилтын ажлын үр өгөөжийг таниулах, сурталчилах, хэрэглээ болгох, технологи нэвтрүүлэх, Засгийн газраас шууд болон дам байдлаар дэмжлэг авах зэрэг салбарын үйл ажиллагааг хөгжүүлэхтэй холбоотой үүргийн

биелэлт тааруу байгаа нь ШУА-ийн “Их чуулган” энэ чиглэлийн үйл ажиллагаандаа илүү анхаарч ажиллах шаардлагатайг харуулж байна.

“Бага чуулган”-ы хувьд ШУ-ны салбар бүр дэх асуудлыг тухайлан хэлэлцэж, тодорхой чиглэл өгөх нэлээд ач холбогдол бүхий бүтэц хэдий ч түүний үүрэг, ролийг хэт хязгаарлагдмал байдлаар эрх зүйн баримт бичигт томъёологджээ. Хуулинд тусгасан үүргийн хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэхэд: салбарын дотоод асуудал (*дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад шилжүүлэх, тухайн салбарын чиглэлээр хийж байгаа судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх*)-ыг хэлэлцэх үүргээ дундаж түвшинд гүйцэтгэж байна гэж үнэлж байгаа бол эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх талаар санал гаргах гэсэн үүргийг дунджаас доогуур гэж үнэлжээ.

### Хүснэгт 3.2.3 Бага чуулганы үүрэг, түүний хэрэгжилт

Үүрэг	Дундаж утга
Эрдэм шинжилгээний дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад шилжүүлэх	6.05
Тухайн салбарын чиглэлээр хийж байгаа судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх	5.73
Эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх талаар санал гаргах	4.29

Их, Бага чуулганы үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой судалгаанд оролцогчид Их чуулган, Бага чуулганы үүрэг хариуцлагыг нь өндөржүүлэх, чуулганы гишүүдийн үүрэг хариуцлагыг нь дээшлүүлэх орчин бий болгох шаардлагатай гэж үзэж байна. Бага чуулганы үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой санал илүү дэвшүүлж байлаа. Үүнд:

- Бага чуулганы үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх (34.5%)
- Бага чуулганы гишүүдийн тоог нэмж, квотыг нь ШУ-ны бүх салбараар тогтоож, нэгжид ногдох квотыг ихэсгэх (23.9%)
- Менежментийн өндөр чадвартай залуучуудыг бага чуулганд оруулах (2.3%)
- Биологи-ХАА-н бага чуулган болгон нэгтгэх (1.2%)
- ШУ-ны бүх салбарыг хамруулах (0.6%)
- 4 жил тутамд гишүүдийн 20-25 хувийг сольж байх (0.6%)
- Бага чуулганы цар хүрээг өргөтгөхдөө нэг хүрээлэн, төвөөс илүүтэйгээр гадны мэргэжлийн хүмүүсийг оролцуулбал илүү үр дүнтэй. Өмнө хэлэлцсэн тайланг дахин сонсох болдог тул идэвх муутай оролцдог (0.6%)
- Яам төсөл хөтөлбөрөө харьяалагдах бага чуулганаар хэлэлцүүлсэний баталж байх (0.6%)

Судалгаанд оролцогчдын зүгээс гаргасан зарим саналыг онцолбол: Засгийн газар, яам, агентлагийн түвшинд хэлэлцэж буй томоохон төсөл хөтөлбөрийг Бага чуулганаар хэлэлцүүлсэний дараа баталж байх нь чуулганы үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэхэд зохих нөлөө үзүүлэхийн дээр томоохон төсөл хөтөлбөрийн үр ашгийг дээшлүүлэх боломжтой болно. Мөн залуу судлаачдын төлөөллийг тодорхой квот тогтоон Бага чуулганд оруулах, гишүүдийн тодорхой хувийг 4 жил тутамд өөрчилж байх, гадны мэргэжилтнүүдээс оролцуулах зэргээр царцанги байдлаас гарах боломжтой гэж үзэж байна.

## 2.4 ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН САНХҮҮЖИЛТ

Аливаа улс орны шинжлэх ухааны хөгжлийн нэг түлгуур чулуу нь санхүүжилт байдаг. “2014 оны байдлаар дэлхийн улс орнууд шинжлэх ухаандаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 0.2-4.2 хувийг зарцуулсан гэх судалгаа бий. Тухайлбал, Израйл улс 4.2, АНУ 2.8, Япон 3.4, Африкийн орнууд дунджаар 0.2 хувийг зарцуулжээ. Гэтэл манай улс 2012 онд ДНБ-ий 0.2 хувь, 2013 онд 0.20 хувь, 2014 онд 0.18 хувийг шинжлэх ухаан, технологийн арга хэмжээнд зарцуулсан байна. Эндээс харахад манайх Африкийн орнуудын төвшинд, түүнээс ч бага мөнгө шинжлэх ухаанд зарцуулж байна. Шинжлэх ухаан судлалд аливаа улс орны судалгаа боловсруулалтад зарцуулж буй зардлын хэмжээ нь ДНБ-ний 0.4 хувиас доош байвал шинжлэх ухаан нийгэм, соёлын үзэгдэл төдий, 0.8 хувиас доош байвал танин мэдэхүйн төвшинд, нэг хувиас дээш байвал улс үндэстнийхээ хөгжилд тус нэмэр болдог гэж үздэг. Тиймээс ч ЮНЕСКО-гийн зүгээс Африкийн орнуудад 1.0 хувьд хүргэх, ШУА-иуд байгуулахыг зөвлөмж болгосоор байдаг юм”<sup>48</sup> хэмээн дэд ерөнхийлөгч асан академич Т.Доржийн ярьсанчлан МУ-д шинжлэх ухаанд зарцуулж буй мөнгөний хэмжээ хөгжил буурай Африкийн оронтой жишиж очихуйц байна.

2014 онд ДНБ-ий 0,18 хувийг зарцуулсан бол 2016 онд 0,16 хувь болтлоо буурсныг салбарын сайд онцолжээ. Тэрбээр ярилцлагандаа “Шинжлэх ухааны санхүүжилт 2016 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 30.5 тэрбум төгрөг байна. Энэ нь дотоодын нийт бүтээгдэхүүний 0.16 хувь хувь болно. Үүнээс 9,1 тэрбум төгрөгийг эрдэм шинжилгээний ажилд буюу нийт 432 төсөлд, бусад хөрөнгө мөнгийг цалин, нийгмийн даатгалын шимтгэл зэрэгт зарцуулж байна. Өндөр хөгжилтэй АНУ дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ (ДНБ) 2.7 хувь буюу 473.4 тэрбум доллар. Хятад улс ДНБ-ийхээ 2.1 хувь буюу 409 тэрбум доллар, шинжлэх ухаанаа хөгжүүлж үр шимийг нь хүртэж байгаа жижиг Израйл улс ДНБ-нийхээ 4.1% буюу 11.2 тэрбум доллар зарцуулж байхад манай улс ДНБ-нийхээ 0.16% буюу 15 сая орчим доллар зарцуулж байгаа нь шинжлэх ухаанаа эрчимтэй хөгжүүлэх боломж, бололцоогоор хангаж чадахгүй байна гэсэн үг. Энэ нь маш бага санхүүжилт учраас аль болох нэмэгдүүлэх арга замыг эрэлхийлж ажиллана”<sup>49</sup> хэмээн мэдэгдсэн байна.

Санхүүжилтийн энэхүү тарчиг байдал экспертийн судалгааны үр дүнд мөн тусгалаа олжээ. Шинжлэх ухааны доорх санхүүжилтийн байдлыг байхгүй болон маш багатайд тооцжээ. Үүнээс байдаггүй хийгээд туйлын багад дийлэнх эксперт 1) ШУТ-ийн үр дүнг практикт нэвтрүүлэх зардал (67,3%), 2) Тоног төхөөрөмж, лабораторийн хангамж (55,5%), 3) Түүхий эд, материал хэрэглэгдэхүүний зардал (51,5%) -ыг тооцжээ.

Хүснэгт 4.1 Ажиллаж буй ШУ-ны салбарын санхүүжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ, %

	Байхгүй	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилт	5.0	40.6	27.7	18.9		1
Тоног төхөөрөмж, лабораторийн хангамж	13.9	41.6	29.7	10.9	2.0	2.0
Түүхий эд, материал хэрэглэгдэхүүний зардал	9.1	42.4	29.3	15.2	3.0	1.0
Ажиллагсдын цалин хөлс	3.9	42.1	20.6	22.5	7.8	3.0

<sup>48</sup> Э.Орхонсүрэн. "Зууны мэдээ" сонинд академич Т.Доржийн өгсөн ярилцлага. Ахмад эрдэмтдийг ширээ сандал бөглөгчид гэх нь ёс зүйгүй юм. 2014 оны 12 сарын 25. Полит.мн улс төрийн мэдээллийн порталаас авав. 28.12.2016 нэвтрэв //http://www.polit.mn/content/56519.htm  
http://vip76.mn/content/43378.


<sup>49</sup> Шинжлэх ухааныг жам ёсоор нь хөгжүүлж байж л үр шимийг нь хүртэнэ. БСШУСЯ-ны сайд Ж.Батсуурийн өгсөн ярилцлага. Өдрийн сонин. 2016.11.22. //ВИП 76 мэдээллийн http://vip76.mn/content/43378.

Шинэ болон шинэчилсэн бүтээлийг урамшуулах	7.8	42.2	26.5	12.7	10.8	-
Ажилтнуудын нийгмийн хамгаалал	15.8	33.7	30.7	11.9	8.0	-
ШУТ-ийн үр дүнг практикт нэвтрүүлэх зардал	18.8	48.5	21.8	7.0	3.0	1.0

Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааг үлдэгдлийн зарчмаар хомс санхүүжүүлж байгаа нь 2007-2020 онд хэрэгжүүлэх ШУТ-ийн мастер төлөвлөгөөг баталж байсан 2007 оны байдлаас дээрдэхгүй байна. Мастер төлөвлөгөөнд шинжлэх ухаан, технологийн арга хэмжээний зардлын ДНБ-д эзлэх хувь 2015, 2020 оны түвшинд 0.37-оос хэтрэхгүй байвал Мастер төлөвлөгөөний бодлогын зорилт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжгүй тул санхүүжилтийн хэмжээг 2015 он гэхэд 1.2 хувь, 2020 гэхэд 1.5 хувьд хүргэхээр тооцсон болно.

ШУ-ны салбарын санхүүжилтийн механизмыг өөрчлөх шаардлагатай байгаа нь тэдний хариултаас мэдрэгдэж байна. “Суурь болон хэрэглээний судалгааны төслийн санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгаж үзэх хэрэгтэй. Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх харьцангуй давуу эрхийг суурь судалгааны хүрээлэнгүүдэд олгох нь зөв” гэсэн саналыг экспертүүдийн 65,7 хувь нь, “зөвхөн улсын төсвийн дэмжлэгээ Төрийн санд үлдээгээд, үйл ажиллагааны орлогоороо санхүүгийн менежмент хийх боломж олгох” саналыг 55,2 хувь нь дэмжсэн байна.

Зураг 4.1 Санхүүжилтийн механизмыг өөрчлөх хувилбарын талаарх байр суурь



ШУТ-ийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмыг өөрчлөх боловсронгуй болгох талаар дараах саналуудыг дэвшүүлжээ:

Хүснэгт 4.2 ШУТ-ийн үйл ажиллагааны санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмыг өөрчлөх боловсронгуй болгох санал

Санхүүжилтийн эрх мэдлийг байгууллага нэгжийн удирдлагад олгох	
▪ ШУА төсвийн ерөнхийлөн захирагч байх	4.6
▪ Хүрээлэн төвүүдийн төсвийн шууд захирах эрхийг тодорхой зохицуулалттай болгох	4.6
▪ Хүрээлэн төвийн захиралд илүү эрх мэдэл олгох	1.5
▪ Хүрээлэн төвүүдэд санхүүжилтийг эрхийг нь өөрсдөд нь олгох	1.5
▪ ШУА-ийн мэдэлд санхүүжилтийг шилжүүлж, захиран зарцуулах эрхийг өгөх	4.6
▪ Хүрээлэнгүүдийг институтцийн хувьд бэхжүүлэхийн тулд суурь санхүүжилтийг байгууллага санхүүжүүлэх зарчмаар болгох	1.5

<b>ШУТС-аар санхүүжилтийг дамжуулахгүй олгох, төсвийг тусад нь болгох, төсвийн бус данстай болгох</b>	
▪ ШУТС-аар дамжуулахгүй шууд олгох, төсөл санхүүжүүлэх мөнгө босгохгүй, одоогийн хэлбэрээр байх юм бол ШУТС байх шаардлагагүй байна	4.6
▪ Төсвийг тусад нь болгох	1.5
▪ Төсвийн бус данстай болгох	4.6
▪ ЭШ-ний зардал, томилолт, цалин нэмэгдүүлэх	
▪ Байгалийн ухааны хүрээлэн төвүүдийн санхүүжилтийг сайжруулах, дотоод томилолт ЭШЗ-аас гадна тусад нь олгох	1.5
▪ Томилолтын нэмэгдүүлэх, хоногийн 12000 төгрөг нь 1 таваг хоолны мөнгөөр томилолт олгож байгаа нь хүрэлцэхгүй байна. Байгаль дээр хүнд хэцүү нөхцөлд амралтын өдөргүй ажилладаг.	1.5
▪ Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг өөрчлөх	1.5
<b>Санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүжилтийн олон эх үүсвэртэй болох</b>	
▪ Улсын төсөвт шинжлэх ухаанд зарцуулах төсвийг жил бүр тодорхой хувиар нэмэгдүүлэх	1.5
▪ Санхүүжилтийн хэмжээг хуульд заасан хэмжээнд хүргэх	1.5
▪ Хүрээлэнгүүдийн суурь санхүүжилтийг нэмэгдүүлэх	3.1
▪ Хөрөнгө оруулалтыг тогтмол нэмэгдүүлэх	1.5
▪ Санхүүгийн олон эх үүсвэртэй болгох	4.6
▪ Одоогийн санхүүжилтийг хэвээр хадгалан, нэмэлт санхүүжилт олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх	3.1
▪ Суурь санхүүжилттэй болгох	1.5
▪ ЭШ-ний зардлыг нэмэгдүүлэх	1.5
▪ Суурь судалгааг төрөөс санхүүжүүлдэг байх	1.5
<b>Санхүүжилтийн журам, механизмын талаар</b>	
▪ Санхүүжилт олгох журам дэндүү удаашралтай болхи байна.	3.1
▪ Оюуны өмчийн хамгаалалтын системийг сайжруулах түүгээр дамжуулан инновацийн ашиг орлогоороо санхүүжилт хийх боломжийг бүрдүүлэх	1.5
▪ Үйл ажиллагааны орлогоос татвар аваад менежмент хийх боломжийг хүрээлэнд өгөх	1.5
▪ Улсын захиалгат ажил, цалин хөлсөө ТС-аас санхүүжүүлээд, бусад зардал төсвөө үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх нь зөв	1.5
▪ Салбар хүрээлэнгүүдийн дэргэд төрийн өмчит бус хүрээлэн эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаанд нь оролцдог үйлдвэрийн газруудыг ажиллуулах	1.5
▪ Төр, хувийн хэвшлийн төвүүдтэй чөлөөтэй хамтран ажиллах бололцоог нээж, санхүүгийн нэмэлт хөшүүргийг нэмэгдүүлэх	4.6
▪ Санхүүжилтийн журмыг боловсронгуй болгох хэрэгтэй. Зорилтот хөтөлбөр дээр хүрээлэнгүүд нэгдэж ажиллах хэлбэрийг нэвтрүүлэх	1.5
▪ Санхүүжилтийн журам механизмыг боловсронгуй болгохдоо төсөл сэдвийн хүрээнд гүйцэтгэлээр урамшуулал, цалинг, олгох, хавтгайруулахгүй байх	1.5
▪ Төслийн гүйцэтгэлийг үечилсэн үр дүнгээр санхүүжил, урамшуулал олгох байдлаар	1.5
▪ Эрдэмтдэд санхүүжилт олгож, үр дүнг тооцдог байх нь чухал (үр дүнд суурилсан санхүүжилт)	3.1
▪ Хувийн хэвшлийн ЭШ-ний байгууллагуудад зэхэц ажлын зээл олгох гэх мэтээр санал, санаачлагад чиглүүлж санхүүжүүлэх	1.5
<b>Төсөл хэрэгжүүлэх, төслийн зардал, зарцуулалтын талаар</b>	
▪ Хүрээлэнгүүдэд төсөл хэрэгжүүлэх квот өгөх	1.5
▪ Хүн бүр төсөл дэвшүүлж байгаа нь хэт үрэлгэн хүч нь тарамдсан байдалтай байна	1.5
▪ Сэдэв, төслийн удирдагч нарын эрдэм шинжилгээний зардлын зарцуулалтад хяналт тавих	1.5
▪ Гарааны компани байгуулах, төсөл хөтөлбөрт оролцох	1.5
▪ ЭШ-ний ажилтнууд сэдэв, төсөл санаачлах, удирдахад зэрэг дэв, удирдлага мөн эсэхээс хамааралгүй тэгш оролцох боломжтой байх	1.5
▪ Төсөл сонгон шалгаруулах	1.5
▪ ЭШБ-ыг тендерт оролцох эрх олгох	1.5
▪ Орон тоогоор санхүүжүүлэх	1.5
▪ Суурь судалгааны төслийг багаар өгч байх	1.5
▪ Төслийн хэлбэрээс хамааруулан тэдгээрийг сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулах	1.5
<b>Бусад</b>	
▪ Судлаачдын идэвх санаачлага үгүйлэгдэж байна	1.5
▪ Татварын эрх зүйн орчинг сайжруулах	1.5
▪ ШУА салбарын яамдуудтай нягт уялдаатай ажиллах хэрэгтэй	3.0

▪ Эрдэмтдийн саналыг дэмжих	1.5
<b>Бүгд</b>	<b>100.0</b>

Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд мөн доор дурьдсан арга хэмжээг авах шаардлагатай гэжээ.

**Хүснэгт 4.3. ШУА-ийн үйл ажиллагааны санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд хийх арга хэмжээний талаарх санал /давхардсан хариулттай асуулт/**

Санал	Хувь
Төрөөс олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх	79.4
Гадаадын байгууллагуудтай хамтарсан төслийг төрөөс дэмжих	73.5
Үйл ажиллагааны орлогоороо санхүүгийн менежмент хийх боломж олгох	68.6
Улс орны томоохон төсөл хөтөлбөрт ШУА-ийн хүрээлэнгүүдэд зөвлөх, экспертний үйлчилгээ үзүүлэх эрх олгох	67.6
Судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх зардал мөнгө төлөвлөж байх	61.8
Судалгаа, туршилтын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх	61.8
Хувийн хэвшлийн байгууллагуудыг ШУ-ны салбарт оруулсан хөрөнгө оруулалтаар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх	57.8
Санхүүжилтийн олон эх үүсвэртэй болохыг эрэлхийлэх, мөнгөн бус хэлбэрийн дэмжлэгийг сайшаах, харилцан тусалж хамтдаа хөгжих хэлбэрийг ашиглах	52.9
Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	52.0
ШУА-ийн Ерөнхийлөгчийг хүрээлэнгүүдийн төсвийн ерөнхийлөн захирагч болгох	40.2
Гадаадтай хамтарсан төслийн хууль эрхийн тэнцвэрт байдлыг хангах	1.0
Хүрээлэнгүүдэд тогтмол суурь санхүүжилт, төсөв өгч түүнийг захиран зарцуулах эрх мэдлийг олгох	1.0
Судалгааны үр дүн, бүтээгдэхүүн борлуулдаг өөр байгууллага байх хэрэгтэй	1.0
ОУ-ын мега төслүүдэд монгол эрдэмтдийн оролцоог төрөөс бодлогоор дэмжих	1.0
Салбарын яамд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төлөвлөгөөг санхүүжилтийн хамт жил бүр гаргаж, хэрэгжүүлж байх	1.0

## 2.5. ШУТ-ИЙН АЖЛЫН ҮР ДҮН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ

Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд байгалийн ухаан (29,6%), техник, технологи (23.1%), хөдөө аж ахуй, хүнс (18.7), нийгэм, хүмүүнлэг (15%), анагаах ухаан, нийгмийн эрүүл мэнд (7.5%)-ийн шинжлэх ухааны салбарт илүү анхаарал хандуулах, хөрөнгө оруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Хүснэгт 5.1 МУ-ын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхээр анхаарал хандуулж, хөрөнгө оруулах салбарууд**

	Хувь
<b>Байгалийн шинжлэх ухаанд</b>	<b>29.6</b>
1 Геологийн ухаан	1.8
2 Байгалийн ухаан	17.9
8 Биологийн ухаан	1.3
10 Ургамал судлал	0.4
11 Биотехнологи	2.7
13 Хими технологи	2.2
15 Геофизик	0.4
23 Молекул биологи	0.4
24 Генетик, генийн инженерчлэл	0.4
29 Палентологи	0.9
31 Материал судлал	0.4

34	Экологи	0.4
35	Нанотехнологи	0.4
<b>Техник технологийн шинжлэх ухаанд</b>		<b>23.1</b>
7	Техник технологи	11.6
20	Уул уурхай	2.2
5	Мэдээллийн технологи, ИТ	1.8
27	Инноваци, өндөр технологи	3.1
30	Электроник	0.4
14	Эрчим хүч, нарны эрчим хүч г.м сэргээгдэх эрчим хүч	0.9
16	Үйлдвэр технологи, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, МАА-н түүхий эд боловсруулах үйлдвэр	1.8
18	Хөнгөн үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн боловсруулах салбарт	1.3
<b>ХАА, хүнс</b>		<b>18.7</b>
12	Хөдөө аж ахуй /МАА, Газар тариалан/	17.4
22	Мал эмнэлэг	0.9
39	Хүнс	0.4
<b>Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаанд</b>		<b>15.0</b>
3	Нийгэм, хүмүүнлэг	8.9
4	Эдийн засаг	2.2
38	Монгол судлал	0.4
25	Боловсрол	0.9
6	Хууль эрх зүй	0.4
17	Аялал жуулчлал	2.2
<b>Анагаах ухаан, нийгмийн эрүүл мэндэд</b>		<b>7.5</b>
9	Анагаах ухаан	5.8
36	Нийгмийн эрүүл мэнд	0.9
37	Уламжлалт анагаах ухаан	0.4
28	Био-анагаах ухаан	0.4
<b>Бусад</b>		<b>5.2</b>
21	Аль илүү бүтээмжтэй ажиллаж байгаа салбарт нь хөрөнгө оруулах	0.4
26	Бүх салбарт	1.3
32	Онолын суурь судалгааны салбар	2.2
33	Хэрэглээний судалгаа	1.3
<b>Бүгд</b>		<b>100.0</b>

ШУ-ны салбарын нийгэм-эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд авах арга хэмжээ, хийх алхмыг экспертүүд дараах байдлаар харж байна. Үүнд:

Нэн тэргүүнд хийх алхамд дараах ажлуудыг оруулжээ:

- Инновацийг хөгжүүлэх, дэмжих хөшүүргийг сайжруулах
- ШУА-ын дотоод бүтцэд анхаарч, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж ажиллах
- Шинжлэх ухааны парк (Science Park) байгуулах
- Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох /шинэчлэн найруулах г.м/
- Хууль эрх зүй, бодлогын баримт бичгийг мөрдөж, хэрэгжүүлэх тал дээр анхаарах
- Судалгааны төв, хүрээлэнгүүдэд түшиглэсэн гарааны компани олноор байгуулах
- ШУ салбарт санхүүжилтийн олон эх үүсвэр, төрөл хэлбэрийг ашиглах боломжийг бүрдүүлэх, дэмжих
- ШУ-ны болон тухайн салбарт ажиллагсдын талаарх нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх
- ШУ-ны оюуны бүтээл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг бодитой үнэлэх, оюуны үнэлэмжийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах

Дараагийн алхамд хийх шаардлагатай ажлууд нь:

- Үйлдвэрлэгч, ААН-ийг эрдэмтэн судлаачидтай төр холбож өгөх
- ШУТ-ийн үр дүн, ололт, нээлтийг практикт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх

- Техник технологийн үндэсний хэмжээний асуудлыг мэргэшсэн хүрээлэн хариуцан ажиллаж, судалгааны үр дүнг бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэлд нэвтрүүлэх тусгай менежмент хийх багийг тухайн хүрээлэнгүүд дээр байгуулах
- ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн хэвшлийнхэн болон их, дээд сургуультай хамтарч ажиллах менежментийг бий болгох

Салбарын санхүүжилтийг ДНБ-ний 1 хувьд хүргэх, тэргүүлэх чиглэлээ өөрчилж мөрдөх, статусаа баталгаажуулах, Хүний хүчин зүйл чухлыг дэмжих, үнэлэх зэрэг саналуудыг тус бүр нэг хүн дэвшүүлжээ.

## ДҮГНЭЛТ

Монгол Улсын шинжлэх ухааны салбарын харилцааг зохицуулж, оюуны үндэсний чадавхийг хөгжүүлэх, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль тогтоомжийн өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ нь цаашид анхаарвал зохих эрх зүйн хэд хэдэн дүгнэлт хийхэд хүргэж байна. Энд юуны түрүүнд Үндсэн хуулийн “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна. Иргэний туурвисан оюуны үнэт зүйл бол зохиогчийнх нь өмч, Монгол Улсын үндэсний баялаг мөн” гэсэн заалтын агуулга, түүний хэрэгжилтийн талаархи товч дүгнэлтээс эхлэх нь зүйтэй гэж үзлээ. Энэ бол Үндсэн хуулийн суурь заалт боловч амьдралд бүрэн дүүрэн хэрэгжиж хэвшээгүй явж ирсэн “тунхаг”-ийн шинжтэй цөөн заалтын нэг мөн гэж дүгнэж болмоор байна. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухааны хөгжлийн бодлогыг төр тодорхойлж, шинжлэх ухааны байгууллага, эрдэм шинжилгээний ажилтны бүтээл туурвилын эдийн засгийн баталгааг хангах, судалгааны лаборатори, кабинетийг шаардагдах тоног төхөөрөмж, материаллаг баазаар бэхжүүлэх, судлаач мэргэжилтнүүдийг бэлтгэх асуудлыг төрийн бодлогын анхаарлын төвд байлгаж, хамгаалж хэвшээгүй, урсгалаар явж ирснээс улбаатай юм.

Шинжлэх ухааны бүтээлийн үр шимийг хүртэх явцад бүтээл туурвилаас дур зоргоороо ашиг хүртэх, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хувилж завших, орчуулах, хэвлэх, хуулах, өмчлөх хэрэг зөрчил бидний амьдралд ердийн үзэгдэл мэт гарсаар байна. Энэ бол “соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална” гэсэн Үндсэн хуулийн заалтыг тууштай хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэл хууль сахиулагчдын дунд байхгүй, нөгөө талаар шинжлэх ухааны нээлт, бүтээлийн үр шимийг хүртэх аятай нөхцөл, сэтгэл зүйн таатай уур амьсгал нийгэмд хэвшиж бүрдээгүйг харуулж байна.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Технологи дамжуулах тухай хуулиуд нь тухайн салбарын харилцааг зохицуулж ирсэн. Гэвч ойлгомжгүй, тодорхойгүй, системгүй, зохицуулалтгүй орхигдсон зүйлүүд цөөнгүй байгаагийн нэг нь шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа байна. Шинжлэх ухааны аль салбарт ямар бодлого баримталж, хэрхэн зохицуулж байгааг одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудаас олж харах боломж хомс байна. Мөн төрөөс шинжлэх ухааны салбарыг хэрхэн дэмжиж, хөгжүүлэх нь мөн л тодорхой тусгагдаагүй байна.

*Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар* ШУА-ын үйл ажиллагааны хүрээг хуулиар тогтоогоогүй байна. ШУА нь шинжлэх ухааны төв байгууллага болохынхоо хувьд шинжлэх ухааны аль салбарт ямар бодлого баримтлах, мөн салбарын эрдэм шинжилгээний ажил, түүний үр дүнг хэрэглээнд оруулах чиглэлд ямар үйл ажиллагаа эрхлэх талаарх зохицуулалт байхгүй байна.

Харин “улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашидын чиглэл, арга замыг тодорхойлсон үндэслэл боловсруулах” гэж заасан нь ШУА-ын үйл ажиллагааны үндсийг хангасан зохицуулалт болсон. Энэхүү зохицуулалтыг “үүрэг” болгон оруулахаас илүүтэйгээр үйл ажиллагааны хүрээнд хамруулбал зохистой гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл ШУА-ын үйл ажиллагаа хязгаарлагдмал

байдлыг эвдэх үүднээс, цаашид шинжлэх ухааны салбарын эрх зүйн байдлын тухай хуулийг хянан үзэх хэрэгцээ шаардлага гарч ирж байна.

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулийг 1996 онд баталж мөрдөж эхэлснээс хойш 10 жилийн дараа Шинжлэх ухаан, технологийн тухай хууль гарч үйлчилжээ. Ийнхүү Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг зах зээлийн харилцаанд шилжиж эхэлснээс хойш 16 жилийн дараа буюу 2006 оны 12 дугаар сарын 28-ны өдөр баталж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулж эхэлсэн байна. Тус хуулийн “Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын эрдэм шинжилгээний ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэх” гэсэн зүйл заалт нь огт хэрэгждэггүйн дээр “Эрдэм шинжилгээ, туршилт зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх”, “Эрдэм шинжилгээний байгууллага нь зориулалтын барилга, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл болон туршилт явуулах бусад нөхцөлөөр хангагдсан байх бөгөөд ийнхүү хангах үүргийг үүсгэн байгуулагч хүлээнэ” гэсэн зүйл заалтууд нь одоо хүртэл хэрэгжихгүй, шийдвэрлэх арга зам нь тодорхойгүй байна. Тэрчлэн “Эрдэм шинжилгээний ажил болон бүтээлээ бодитойгоор үнэлүүлж, тохирсон шагнал, урамшуулал хүртэх, хуульд заасан хөнгөлөлт эдлэх”, “Захиалагч үүргээ биелүүлээгүй бол гэрээг цуцлах санал тавьж шийдвэрлүүлэх” зэрэг зах зээлийн зарчмын заалт үндсэндээ мартагджээ. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай, Патентын тухай, Инновацийн тухай хуулийн зохицуулалтаас харахад ШУ-ныг хөгжүүлэх харилцааг зохицуулсан эрх зүйн зохицуулалт дутмаг, түүний хэрэгжилт тааруухан явж ирсэн байна. Энэ бол шинжлэх ухааны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх механизм байхгүй, түүний эдийн засаг, улс төрийн соёл, орчин бүрдээгүйг харуулж байна.

Тиймээс шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлогын зарчим, бүтэц, бодлого боловсруулж хэрэгжүүлэх арга, хэлбэрийн тухай тодорхой хуульчилж, судалгааны ажлын өрсөлдөх чадвар, үр ашигт маркетингийг төлөвшүүлэх, хувь судлаачийн ахуй амьдрал, боловсролын хэмжээг тууштай сайжруулах, бүхий л хэвшлийн судалгааны байгууллагын ухаалаг менежмент, оновчтой зохицуулалт бүхий үзэл баримтлалыг боловсруулж мөрдөх шаардлагатайг бидний хийсэн судалгааны дүн харуулж байна.

Холбогдох хуулиудын зохицуулалтаас үзэхэд шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаанд оролцогчдыг эрх зүйн байдлаар нь дараахь ерөнхий төрөлд багцалж болохоор байна. **“Шинжлэх ухаан, технологийн сан”** нь эрх зүйн байдлын хувьд төрийн бус байгууллага байх бөгөөд бүтэц, зохион байгуулалт нь тодорхойгүй байна. Тиймээс ШУТС-гийн хөрөнгөөр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлж ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлж мөрдөх хэрэгтэй байна.

Мэргэжлийн оролцогчдын хувьд гол байгууллага болох ШУА-ийн эрх зүйн байдлыг Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиар *“...тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн. Академи нь төрийн ивээлд байна”* гэж тодорхойлжээ. Энэ нь захиргааны байгууллагын бүрэн эрхийг эдлэхгүй байх тул эрх зүйн байдлыг тусгайлан зохицуулсан хуультай онцгой статус бүхий байгууллага байна. Гэвч холбогдох хуульд ШУА-ийн эрх хэмжээ хумигдмал, үйл ажиллагааны төрөл, цар хүрээ явцуу байхаар зохицуулжээ. Хуулиар ШУА-ийг зөвхөн “зөвлөмж гаргах”, “зөвлөх эрхтэй оролцох” гэх мэтчилэн идэвхгүй үйл ажиллагаатай болгон хуульчилсныг өөрчилж, шинжлэх ухааны салбарын аливаа үйл ажиллагаатай холбоотойгоор шийдвэр гаргах статустай болгох нь чухал болохыг шинжилгээний дүнгээс харж болно.

Энэ бүхнээс үндэслэн ШУА нь “шинжлэх ухааны төв байгууллага мөн” гэсэн статусыг тодорхой болгож **“ШУА бол шинжлэх ухааны төрийн төв байгууллага мөн”** хэмээн зааж, түүний үндсэн чиг үүрэгт **“иргэдийг соён гэгээрүүлэх, төрийн төв байгууллагад шинжлэх ухааны мэдээллээр үйлчлэх”** гэж оруулж болох юм гэдэг санал судалгааны дүнгээс гарч байна.

Шинжлэх ухааны салбарын хууль тогтоомжоор хуульчилсан байгууллагуудын эрх, үүргийг харьцуулан судлаж үзлээ. Энэ нь нэг талаас тэдгээрийн эрх зүйн байдлыг тодруулах, нөгөө талаас шинжлэх ухааны салбарууд дахь оролцогчийн эрх, үүрэг давхардаж байгаа эсэхийг судлан тогтооход ач холбогдолтой юм. Юуны өмнө эдгээр хуулийн зохицуулалтаас үзэхэд шинжлэх ухааны салбар дахь захиргааны байгууллагуудын бүрэн эрхийг нарийвчлан хуульчилсан боловч мэргэжлийн байгууллагуудын бүрэн эрх, эрх, үүргийг хангалттай хуульчилж өгөөгүй байна. Тодруулж хэлбэл, шинжлэх ухааны салбар дахь захиргааны байгууллагуудын оролцоо хэтэрхий их, харин мэргэжлийн байгууллын оролцоо, эрх үүрэг хумигдмал байгаа нь тус салбарын хөгжилд бэрхшээл учруулж байгаа байдал ажиглагдаж байна.

Шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх мэдлийн хуваарилалтыг салбарын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан байдлаас үзэхэд юуны өмнө оролцогчдын эрх, үүргийг хуульчлахдаа захиргааны байгууллагууд болох Засгийн газар, яам, яамны шинжлэх ухаан технологийн зөвлөл, ШУ-ны Паркийн удирдлагын “бүрэн эрх”, ШУА болон бусад ЭШБ-ын “эрх”, “үүрэг”, ШУ-ны Паркийн “чиг үүрэг” гэх мэт нэр томъёог ашигласан нь эрх зүйн статусыг тодотгож байна. Нөгөө талаас ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1-д заасан ШУА-ийн үүрэг гэдэгт бүрэн эрхийн шинжтэй заалтуудыг оруулсан нь хууль хэрэглэх шатанд зөрчил үүсгэх үндэслэл болж болохоор байгааг анхаарах нь зүйтэй.

Шинжлэх ухааны салбарын харилцааг голлон зохицуулж буй салбарын хууль тогтоомжид хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх талаар ямар нэгэн зохицуулалт байхгүй байна. Тэрчлэн ШУА нь төрийн болон төрийн бус байгууллагын тодорхойгүй статустай, “зөвлөх байр суурь...” төдийхнөөр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж ирсэн явдал шинжлэх ухааны салбарын хөгжилд бодит дэмжлэг үзүүлэхэд саад болж ирснийг арилгах цаг нь болсон гэдэгтэй санал нэгдсэн.

Шинжлэх ухаан, технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний **шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаатай** холбогдуулан гаргасан гадагш чиглэсэн, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүд утга, агуулгын хувьд давхардах магадлал байхгүй. Харин тушаалын үндэслэл хэсэгт ишлэсэн зарим хууль, тогтоол хүчингүй болж, шинэчлэн найруулагдсан боловч тушаалд өөрчлөлт ороогүй хэвээр байгаа зөрчил байна.

ШУА-ийн Их чуулган, Тэргүүлэгчдийн хурлын тогтоолоор баталсан дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар ШУА-ийн гишүүдийг сонгох, хасах, хүрээлэнгийн захирлыг хамт олноор хэлэлцүүлж томилох, салбарын шагналын журмыг шинэчлэх нь зүйтэй гэж салбарын ажиллагаагаас санал гаргасныг анхаарч үзэх нь зүйтэй.

Эцэст нь тэмдэглэхэд, Монгол Улсын шинжлэх ухааны хууль тогтоомжууд нь дэлхийн шинжлэх ухаан, технологийг дэмжин дэлгэрүүлэхэд чиглэсэн олон улсын гэрээ, конвенцийн жишигт бүрнээ нийцсэн байна. Шинжлэх ухааны салбарын үндэсний эрх зүйн тогтолцоо төлөвшиж тогтсон. Харин хууль тогтоомжийн хэрэгжилтэд анхаарч ажиллах шаардлагатай байна. Хорь гаруйхан жилийн хугацаанд зах зээлийн харилцааны зарчмууд төлөвшсөн манай орны хувьд оюуны амьдралын салбар эдийн засгийн салбарынхнаас ямар нэг байдлаар хоцорч байгаагаар холбогдуулан эдийн засгийн хөшүүрэг, урамшууллын системийг шинжлэх ухааны харилцааг зохицуулж буй хууль тогтоомжид суулгаж өгөх бүрэн боломжтойг онцолж байна. Ер нь шинжлэх ухааны үйл ажиллагаа, оюуны үнэлэмжийг зах зээл хөгжсөн орныхтой харьцуулан судалж, нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг зах зээлийн зарчмаар тооцох, судалгааны ажлын эдийн засаг, нийгмийн баталгаа, соёлын түвшинг тодорхойлох, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах арга хэлбэрийн талаар тайланд тусгасан болно. Тэрчлэн шинжлэх ухааны салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд эдүгээ хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн чадамжийг шинжиж үзэв. Эдгээрийн үндсэн дээр шинжлэх ухаан, технологийн ажлын үр дүн, түүний нийгэм-эдийн засгийн үр нөлөөний талаархи эрх зүйн дүгнэлтийг хийлээ. ШУА-ын хүрээлэнгүүдийн бие даасан үйл ажиллагаа, тэдгээрийн удирдлагын гаргаж буй шийдвэрийн шинжлэх ухаанч чанарыг дээшлүүлэх, өөрийн үйл ажиллагаанаас олж буй орлогоо захирч зарцуулахад уян хатан хандах механизмыг нэвтрүүлэх зэрэг олон санал амьдралд хэрэгжүүлэх бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

### III

---

## ХАВСРАЛТУУД

---

- 3.1 Экспертэд хамаарах хүмүүсийн ХМХ-д нийтлэгдсэн нийтлэл, ярилцлагад хийсэн контент анализ**
- 3.2 ШУ-ны салбарын хууль эрх зүйн орчин, статус, бүтэц, зохион байгуулалт, санхүүжилтийн талаарх үнэлгээ, санал дүгнэлт экспертийн судалгааны нэгдсэн дүн /үр дүнгийн хүснэгтээр/**
- 3.3 Дэлхийн улс орнуудын үндэсний ШУА-уудын статус, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, санхүүжилтийн харьцуулсан шинжилгээ**
- 3.4 Шинжлэх ухааны докторын цол зэргийн талаарх олон улсын жишиг**

### 3.1. Экспертэд хамаарах хүмүүсийн ХМХ-д нийтлэгдсэн нийтлэл, ярилцлагад хийсэн контент анализ

Судлагдахуун	<p>ШУА, хүрээлэнгүүдийн бүтэц зохион байгуулалт, үүрэг, үр дүнг үнэлэх, санхүүжилт, төр шинжлэх ухааны харилцаа, хөгжлийн чиг хандлага</p>
Баримт бичиг	<p>Ш.Болд. “Ямба, ял хоёрыг нь үүрүүлж” шинжлэх ухааны “эрх чөлөөг” хангах нь монгол улс хөгжих гол гарц мөн. Ярилцлага.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=446:science-progress&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=446:science-progress&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn</a></p> <p>С.Даваа. Суурь судалгаа хогийн ургамал шиг зүйл үү? Өгүүлэл.  <a href="http://www.mas.ac.mn/images/content/basic_research_davaa.pdf">http://www.mas.ac.mn/images/content/basic_research_davaa.pdf</a></p> <p>А.Гантөмөр. Мэдлэгийн эдийн засгийг бий болгоно. Ярилцлага.</p> <p>Г.Чулуунбаатар. Иргэн нь тархиндаа, төр нь шинжлэх ухаандаа тулгуурлаж байж л үндэстэн оршин тогтноно. Ярилцлага.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=24">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=24</a></p> <p>Шинжлэх ухаанаас хэмнэлт хийхийг эрдэмтэд эсэргүүцэж байна. Зууны мэдээ сонин.</p> <p>Т.Галбаатар. Шинжлэх ухааны байгууллагыг их сургуультай нэгтгэх нь салбараа үгүй хийх эрсдэлтэй. Ярилцлага. Өдрийн сонин.</p> <p>Ш.Баяр. ШУА-ийг устгахыг эсэргүүцсэн ч өөрчлөх, шинэчлэхийг хүлээн зөвшөөрч байгаа. Зууны мэдээ сонин.</p> <p>Д.Амарсайхан. Эрдмийн ажил гэдэг бол залуу хүний булчин шөрмөсийн хүч чадлаар хийчихдэг эд биш. Ярилцлага.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=515:2015-01-10-05-00-43&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=515:2015-01-10-05-00-43&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn</a></p> <p>О.Төмөртоогоо. Шинжлэх ухааныг хохироодог гашиун түүх давтагдах ёсгүй. Нийтлэл.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=18">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=18</a></p> <p>Б.Энхтүвшин. ШУА зөвхөн 21 хүрээлэн удирддаг байгууллага биш. Ярилцлага.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12</a></p> <p>А.Болд. Эх орны бахархал эрдэмтэн мэргэд, эцэг эхийн бахархал үр хүүхэд гэдэг шүү. дээ.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=520:2015-01-19-00-33-19&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=520:2015-01-19-00-33-19&amp;catid=38&amp;Itemid=142&amp;lang=mn</a></p> <p>С.Нарангэрэл. Аливаа улс орны хөгжил дэвшилийн залуур нь шинжлэх ухаан юм. Ярилцлага. /“TV5” тв 2015.01.19-ний “Цаг мэдээллийн хөтөлбөр”-Зочны цаг/</p> <p>М.Золзаяа. Шинжлэх ухааны ертөнц дэх эрдэмтэн. Нийтлэл.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12</a></p> <p>Саарал ордноос шинэчлэлийн зорилго байшин болж харагдаж байна. Ярилцлага.  <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=category&amp;layout=blog&amp;id=38&amp;Itemid=142&amp;lang=mn&amp;limitstart=12</a></p> <p>Т.Дорж. Ахмад эрдэмтдийг ширээ сандал бөглөгчид гэх нь ёс зүйгүй юм. Ярилцлага.  <a href="http://www.polit.mn/content/56519.htm">http://www.polit.mn/content/56519.htm</a></p> <p>Д.Рэгдэл. 1997 оноос хойш шинжлэх ухааны салбарт дорвитой өөрчлөлт хийгээгүй. Ярилцлага.  <a href="http://news.gogo.mn/r/157096">http://news.gogo.mn/r/157096</a></p> <p>Ж.Батсуурь. Шинжлэх ухааныг жам ёсоор нь хөгжүүлж байж л үр шимийг нь хүртэнэ. Ярилцлага.</p>

<http://vip76.mn/content/43378>

Ц.Дэмбэрэл. ШУА-д ардчилал хэрэгтэй. Ярилцлага.

<http://www.polit.mn/content/54894.htm>

Ц.Дэмбэрэл.ШУ-ны салбар социалист үеийнхээрээ байна. Ярилцлага.

<http://review.time.mn/content/34195.shtml>

Ц.Дэмбэрэл.Ерөнхий сайдын санаачлага хүрээлэнгүүдийг аврах гарц.

Ярилцлага.

<http://www.info.mn/news/59739.htm>

Г.Эрдэнэжав. Шинжлэх ухааныг уналтаас аврах гарц бол дампуурсан ШУА-ийг татан буулгах

<http://tsagtur.mn/%D1%88%D0%B8%D0%BD%D0>

Д.Баатар, С.Дагдаваа, Ц.Жамц. Шинжлэх ухаанд архагшсан өвчнийг анагаах цаг болсон. Ярилцлага.

<http://news.gogo.mn/r/136107>

Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэхийг хүсч ил захидал илгээжээ. Ерөнхий сайд, УИХ-ын гишүүдэд. Ил захидал.

<http://politics.news.mn/content/200217.shtml>

Чиглэл

Эерэг болон сөрөг, шүүмжлэлт хандлагаар авч үзсэн

Зорилго

Шинжлэх ухааны академийг өөрчлөх, бодлого, бүтэц, удирдлага, зохион байгуулалтыг шинэчлэх санал, хувилбарыг дэвшүүлэх, шинжлэх ухааны санхүүжилтийн байдал, хэрхэн шийдвэрлэх хувилбарыг дэвшүүлэх, шинжлэх ухааны хөгжлийн цаашдын хандлагыг тодорхойлох

Бүлэг

**Нэгдүгээр бүлэг, ШУА-ийг бие даасан байдлаар хөгжүүлэх нь зөв гэж үзсэн үндсэн**

Арга

хоёр бүлэг, **Хоёрдугаар бүлэг, ШУА-ийг их сургуультай нэгтгэх нь зөв гэж үзсэн,** Төр болон ШУ хоорондын харилцаа, ШУ-ны гүйцэтгэх үүрэг, ШУА, түүний хүрээлэнгүүдийн ажлын үр дүн, үнэлгээний талаар, ШУ-ны санхүүжилт, ШУА-ийн бүтэц, зохион байгуулалт, удирдлага менежмент, ШУ-ны үр дүнг практикт хэрхэн нэвтрүүлэх тухай саналууд, ШУ-ны эрх зүйн орчин, ШУ-ны цаашдын хөгжил гэсэн агуулгаар ярилцлагыг авч үзсэн.

Зөрчилдөөн

Асуудал бүрээр бүлгүүдийн зөрчилтөд болон нэгдмэл байр суурийг гаргахыг зорьсон.

Ярилцлага өгөгч

**Нэгдүгээр бүлэгт хамаарах хүмүүс:** Академич Ш.Болд, МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн захирал, профессор С.Даваа, УИХ-ийн гишүүн, БСШУ-ны сайд Л.Гантөмөр, Философийн хүрээлэнгийн захирал, академич Г.Чулуунбаатар, ШУА-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга, академич Т.Галбаатар, ШУА-ийн Үйлдвэрчний эвлэлийн дарга Ш.Баяр, Академич Д.Амарсайхан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич, геологи-эрдэс судлалын шинжлэх ухааны доктор (Sc.D) О.Төмөртоогоо, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, академич Л.Болд, Хууль зүйн ухааны доктор, академич С.Нарангэрэл, ШУА-ийн Бага чуулганы гишүүн, Философийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Золзаяа, БСШУЯ-ны Шинжлэх ухаан, бодлого зохицуулалтын газрын дарга Ж.Даваасамбуу, ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл, академич Т.Дорж, БСШУС-ын сайд Ж.Батсуурь, ардын багш, доктор, профессор С.Галсан, доктор профессор,

**Хоёрдугаар бүлэгт хамаарах хүмүүс:** гавьяат эдийн засагч Н.Дашзэвэг, гавьяат багш, доктор, профессор Ц.Дэмбэрэл, Г.Эрдэнэжав, Д.Баатар, С.Дагдаваа, Ц.Жаму.

**Шинжилгээ №1. Төр болон шинжлэх ухаан хоорондын харилцаа**

- ⊗ Улс төрчид шинжлэх ухааныг хөгжүүлэх ажилд оролцдоггүй харин санхүүжилтийг нь л шийдэж өгдөг.
- ⊗ Төр засаг нь өөрийн бодлого шийдвэрийг бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэхдээ шинжлэх ухааныг дээд зэргээр ашигладаг. Ингэхдээ шинжлэх ухааны гол бодлого, үндсэн чиглэлтэйгээ төр засгийнхаа бодлогоо уялдуулан шийдвэрлэх асуудлаа эрэмбэлдэг юм билээ. Бид ч ийм замаар явах нь зүйтэй.
- ⊗ Ер нь хүн уураг тархиндаа, төр нь шинжлэх ухаандаа түшиглэж чадвал үндэстэн оршин тогтнож, бие даан хөгжиж чадна гэж би ойлгодог. Ер нь шаардлагатай хэмжээнд анхаарч, зохих арга хэмжээ авах, санхүүгийн болон бодлогын дэмжлэг үзүүлэх тал дээр бодох юм бий.
- ⊗ Академи нь төрийн ивээлд гэхдээ тусгаар байх ёстой.
- ⊗ Шинжлэх ухаан төрийн хамгаалалтад байх тухай ч заасан нь бий.
- ⊗ ШУ улс төржиж болохгүй.
- ⊗ Аливаа улс орны хөгжил дэвшлийн үндэс нь төрийн бодлого шинжлэх ухааны үндэстэй байх ёстой. Тэгэхээр төрийн ивээлд байгаад барахгүй төрийн онцгой хамгаалалтад байлгах ёстой юм.
- ⊗ Төр, нийгэм суурь шинжлэх ухаантай байна гэвэл шинжлэх ухаанд өөрийгөө зориулсан эрдэмтдийг дэмжих шаардлагатай. Эрдэмтдийн шинэ нээлт, дүгнэлт, санаа төрөх боломж нөхцөлийг бүрдүүлж байж улс орны хөгжлийн тухай ярина.
- ⊗ Төр тодорхой эрсдлийг даагаад энэ хоёр салбарыг ойртуулахгүй бол хоёр тийшгээ харчихаад байна. Итгэлцэл бий болсны дараа үйлдвэрлэлийн шатанд технологийн суурь сайжирдаг. Тэгээд эрдэмтдийн бүтээлд хандах нийгмийн хандлага сайжирдаг. Яваандаа төрийн оролцоо ч багасч, шинжлэх ухаан болон бизнес нягтарна гэсэн үг.
- ⊗ Академи бол төрийн өмчид суурилсан шинжлэх ухааны төв байгууллага.
- ⊗ Төр эрдэмтэд, бизнес эрхлэгчдийн хоорон дахь илтгэлцлийг нэмэгдүүлж, нийлүүлэх ёстой. Төр энэ талаар дорвитой ажиллах цаг болсон.

*Эдгээр ярилцлагуудад ШУ, төр хоёрын харилцааг анхаарч үзэх шаардлагатай гэж дийлэнх нь үзжээ.*

*Эрдэмтдийн дүгнэж байгаагаар өдгөө ШУА бол төр засаг, нам, улс төрөөс хараат бус байгаа цөөн хэдэн институтын нэг юм. Түүнчлэн ШУА-ийг өөрчлөн шинэчлэх үйл явц нь ч гэсэн улс төрөөс хараат бус байх нь чухлыг онцолжээ.*

*Ярилцлагад оролцогч хоёр бүлгийн эрдэмтэд төр болон ШУ хоорондын харилцааг ямар байх ёстой талаар нэгдмэл байр сууриа илэрхийлжээ. Үүнд:*

- *ШУ төрийн ивээлд, онцгой хамгаалалтанд гэхдээ бие даасан тусгаар байх ёстой.*
- *ШУ улс төрөөс хараат бус, улс төржилтөөс ангид байх ёстой.*
- *Төр ШУ-ныг удирдлагаар хангах бус санхүүгийн дэмжлэг үзүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх үүрэгтэй.*
- *Төр ШУ-ыг сурталчилах, ШУ болон бизнесийн байгууллагуудыг холбох гүүр болох ёстой.*
- *Төр ШУ-ны судалгаа, ололт, амжилтыг бодлого, шийдвэр, үйл ажиллагаандаа тусгаж, төрийн бодлого шинжлэх ухааны үндэстэй байх ёстой.*

**Шинжилгээ №2. ШУ-ны гүйцэтгэх үүрэг**

- ⊗ Аливаа улсын шинжлэх ухаан улс орондоо мэдлэг, чадавх бий болгох үүрэгтэй. Манай улсын шинжлэх ухааны салбар эх орондоо энэ үүргээ, зарцуулж байгаа багаахан хөрөнгө мөнгөтэйгөө харьцуулахад “гайгүй” сайн гүйцэтгэж байгаа гэж үзэж болно.
- ⊗ Иргэдийнхээ оюуны хэрэгцээнд үйлчлэх, төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулахад суурь судалгааны хүрээлэнгүүдийн ажлын гол үр дүн чиглэх ёстой. Миний бодлоор манай шинжлэх ухааны байгууллага, хүрээлэнгүүд иргэдийнхээ оюуны үйлдвэрлэлд бүтээгдэхүүн нийлүүлэх үүргээ боломжийн сайн хэрэгжүүлж байгаа. Харин төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүрэг нь хэрэглэгч, захиалагчаас хамааралтай байдаг учраас хангалттай сайн гэж хэлж чадахгүй.
- ⊗ Бага Чуулган нь шинжлэх ухаан-технологийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэхээс гадна, шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажлуудын үр дүнгүүдийг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх гол үүрэгтэй. Харин Их чуулган нь ШУА-ийн удирдах дээд байгууллага бөгөөд энэ чуулганы гишүүдийг академич нар гэдэг. Их чуулган шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнгүүдийг хэлэлцэхээс гадна, судалгааны тодорхой чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гарган, улмаар УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих гол чиг үүрэгтэй.
- ⊗ Монгол Улсын Шинжлэх ухааны академи нь дэлхийн бусад академиудын нэгэн адил төрд зөвлөмж гаргах, эрдэмтдийн хүчийг төвлөрүүлэх, судалгаа шинжилгээ хийх үндсэн үүрэгтэй.
- ⊗ Шинжлэх ухаан гэдэг бол туурга тусгаар тогтносон улсын хамгийн чухал зүйл. Нэгдүгээрт үндэсний аюулгүй байдалтай холбоотой. Дээр нь аливаа улс орны хөгжил дэвшлийн залуур нь шинжлэх ухаан.
- ⊗ Шинжлэх ухааны институтийн уламжлал нь өмнөх үеийн эрдэмтдийн хуримтлуулан өвлүүлсэн чиг хандлага, академик соёл, мэдлэг, шинжлэх ухааны нийгэмлэг гэдгийг олон нийтэд ойлгомжтой тодорхой болгоход шинжлэх ухааны хэлний асуудал сөхөгдөнө.
- ⊗ Орхиж болохгүй зүйл бол суурь судалгаа. Үүнийг нийгэм захиалдаггүй. Математикийг хэн ч захиалахгүй. Дэлхийн мэдлэгийн үйлдвэрлэлд монголчуудын оруулж байгаа хувь нэмэр гэдэг утгаар нь суурь шинжлэх ухаандаа харьцангуй эрх чөлөө өгөх ёстой.
- ⊗ ШУА гурван ажил хийдэг. Монгол Улсын хөгжлийн бодлого, хоёрт Монгол Улсын том төсөлд эксперт хийх ёстой.
- ⊗ ШУА-ийн Эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд шинжлэх ухааны үүднээс дүгнэлт гаргаж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлон боловсруулах үүрэгтэй.
- ⊗ Шинжлэх ухаан, технологийн бодлогын чиглэлийг тодорхойлох, дүгнэлт гаргах, шинжлэх ухаан, технологийн хөтөлбөр, төсөлд үнэлгээ өгч хянан магадлагаа хийдэг. Шинжлэх ухааны хөтөлбөр, чиглэл, төвшинд тогтоосон хугацаанд үнэлгээ, дүгнэлт өгөх эрх үүргийн хүрээнд ажиллаж, үйл ажиллагааныхаа талаар Байнгын хороонд жил бүр танилцуулдаг.
- ⊗ Монгол Улсын эдийн засаг, нийгэм, улс төрийн харилцааны байдлын талаар судалгаа явуулж, нийгэм, эдийн засгийн хөгжилд холбогдох асуудлаар санал санаачлагуудыг гаргаж, зөвлөгөөг өгч ажилладаг.

**ШУ-ны гүйцэтгэх үүргийн талаарх байр суурь**

- ШУ улс орондоо мэдлэг, чадавх бий болгох үүрэгтэй.
- Иргэдийн оюуны хэрэгцээнд үйлчлэх, төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүрэгтэй.
- ШУ нь улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, улсын хөгжил дэвшлийн залуур болох ёстой.
- ШУ-ны институт нь академик соёл, мэдлэг, чиг хандлага, шинжлэх ухааны нийгэмлэг, хэлийг олон нийтэд таниулах үүрэгтэй.

- Хэрэглээний болон суурь судалгааг зэрэгцүүлэн хөгжүүлэх, тэр тусмаа суурь судалгаанд анхаарах нь чухал.

#### **ШУА, их болон бага чуулганы үүрэг**

- Бага чуулган нь шинжлэх ухаан-технологийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг хэлэлцэхээс гадна, шинжлэх ухаан, технологийн төсөл, суурь судалгааны сэдэвт ажлуудын үр дүнүүдийг хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөх гол үүрэгтэй.
- Их чуулган нь ШУА-ийн удирдах дээд байгууллага бөгөөд энэ чуулганы гишүүдийг академич нар гэдэг. Их чуулган шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнүүдийг хэлэлцэхээс гадна, судалгааны тодорхой чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх, Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, зөвлөмж гарган, улмаар УИХ, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих гол чиг үүрэгтэй.
- Монгол Улсын Шинжлэх ухааны академи нь дэлхийн бусад академиудын нэгэн адил төрд зөвлөмж гаргах, эрдэмтдийн хүчийг төвлөрүүлэх, судалгаа шинжилгээ хийх үндсэн үүрэгтэй.
- ШУА нь Монгол Улсын хөгжлийн бодлогыг тодорхойлоход судалгаагаар хангах, Монгол Улсын том төсөлд эксперт хийх ёстой.

#### **Үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаарх үнэлгээ**

Нэгдүгээр бүлэгт хамаарах эрдэмтийн үзэж байгаагаар:

- Манай улсын шинжлэх ухааны салбар, хүрээлэнгүүд мэдлэг, чадавх бий болгох, иргэдийн оюуны хэрэгцээнд үйлчлэх зэрэг үүргээ хангалттай сайн биелүүлж байгаа гэж дүгнэсэн байна.
- ШУА-ийн хувьд улсын хөгжлийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүргээ харьцангуй сайн биелүүлж байгаа боловч энэ нь захиалагч, хэрэглэгчээс хамааралтай тул бүрэн хангаж байгаа гэж хэлэхэд хүнд. Харин төрийн томоохон төслүүдэд эксперт хийх эрх нь байдаггүй тул хэрэгждэггүй.

Хоёрдугаар бүлэгт хамаарч буй эрдэмтдийн хувьд энэ талаар байр сууриа илэрхийлээгүй байна.

#### **Шинжилгээ №3. ШУА ба хүрээлэнгүүдийн ажлын үр дүн, үнэлгээний талаарх асуудал**

- ⊗ Жирийн хүмүүс бол аливаа ажлын үр дүнг тэр дор нь харахыг хүсдэг гэвч шинжлэх ухааны үр дүн урт удаан хугацааны дараа гардаг.
- ⊗ Манай эрдэмтэд 2014 онд 145 ном, нэг сэдэвт бүтээл (гадаадад 30), эрдэм шинжилгээний өгүүлэл 812 (гадаадад 277, дотоодод 535), эрдэм шинжилгээний илтгэл 754 (гадаадад 244, дотоодод 510), нийт 1711 бүтээл хэвлэн нийтлүүлсэн байна. Түүнчлэн патент 7, технологи 5, стандарт 25, аргачлал, заавар, зөвлөмж 44, зохиогчийн эрх 12, ТЭЗҮ, зураг, каталог 118-г гаргасан ба өнөөдрийн байдлаар ШУА нийт 102 патент, мөн тооны технологи, стандарт эзэмшиж байна. Түүнчлэн “Соёлын өвийн тухай хууль”-ийн хүрээнд нийт 63 удаагийн авран хамгаалах хайгуулын судалгааг эрхлэн гүйцэтгэсэн байна. Томсон ройтерс /Thomson Reuters/-ийн Веб ої сайнс /WoS/ сайтын мэдээгээр Монголоос гадаадын мэргэжлийн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлийн 52,5 хувийг ШУА-ийн эрдэмтэд гаргажээ. Мөн монголын эрдэмтдийн гадаадад хэвлүүлсэн бүтээлээс авсан нийт ишлэлийн 74 хувь нь ШУА-ийн эрдэмтдийн бүтээлээс ишлэл авсан байна.
- ⊗ Жилээс жилд ШУА-ийн эрдэмтдийн гадаадын нэр хүндтэй сэтгүүлд хэвлэгдэх илтгэл, өгүүллийн тоо болон ишлэгдэх байдал багасч харин их дээд сургуулийн багш нарын тоо өсч байна.
- ⊗ Шинжлэх ухааны ихэнх үр дүн таамаглалын шинжтэй. Шинжлэх ухааны үр дүнг хэдэн ном, өгүүлэл, илтгэл, биет бүтээгдэхүүн гэсэн тоо биш, тухайн үр дүнд хүрсэн онол, арга зүйгээр үнэлж тодорхойлох нь зүй зохистой.

- ⊗ Монгол Улсын шинжлэх ухааны салбар эдийн засгийн өгөөжгүй байна гэдэгтэй би санал нэгдэнэ. Гэтэл дэлхийн мэдлэгийн үйлдвэрт оруулж байгаа өгөөжийг яаж үнэлдгийг бид мэддэггүй. Үүгээр үнэлж үзэх ёстой.
- ⊗ Академийн эрдэмтэд төсөл хэрэгжүүлээд тайлангаа өгөхөө бүр больсон. 2008 онд ШУА-ийн авч хэрэгжүүлсэн тайлангаа огт өгдөггүй төслийн тоо 65 байж. Гэтэл 2011 онд 121 болсон байна.
- ⊗ Их хурлаар хэлэлцүүлж баталсан Бэлчээрийн тухай хууль, Байгаль орчны тухай багц хууль, Инновацийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал зэрэгт манай эрдэмтдийн зөвлөмж, санал дүгнэлт туссан байдаг.
- ⊗ ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдээс сүүлийн дөрвөн жилд байгалийн ухаан, техник технологи, нийгмийн ухааны чиглэлээр 199 нэгж судалгаа явуулсан. Мөн бодлого боловсруулах шийдвэр гаргах үйл ажиллагаанд чиглэсэн 180 гаруй үр дүнг холбогдох газруудад хэрэгжүүлж байна.
- ⊗ Судалгааны ажлын үр дүн эхний ээлжинд эрдэм шинжилгээний өгүүлэл, төслийн тайлан хэлбэрээр гарч ирдэг. Эдгээрт шинэ нээлт, онолын тайлбар, шинэ технологи, шинэ бүтээгдэхүүн, шинэ үйлчилгээний тухай мэдээлэл агуулдаг. Эрдэм шинжилгээний өгүүллийг аль болох гадаадын нэр хүндтэй “Импакт фактор” бүхий сэтгүүлд хэвлүүлэх нь судалгааны ажлын сайн үр дүнгийн илэрхийлэл юм.
- ⊗ **“Шинжлэх ухааны салбар нэр хүндээ алдаж байна. Олон эрдэмтэд байдаг хэр нь тэд дорвитой судалгааны ажил хийдэггүй гэсэн ойлголт нийгэмд зонхилсон гэж ярьдаг”.** Энэ бол хоёр талтай. Нэгдүгээрт, манай эрдэмтэд хийж байгаа ажлаа сурталчилж огт чадахгүй байгаа. Яаж сурталчилдаг вэ гэдгээ мэдэхгүй. Нөгөө талаас сурталчлахын тулд мөнгө хэрэгтэй. Жишээлбэл, сонинд нэг нүүр материал тавья гэхэд дор хаяж 500 мянган төгрөг хэрэгтэй. Телевизээр нэг цагийн нэвтрүүлэг гаргая гэхээр хамгийн багадаа хоёр сая төгрөг нэхнэ. Мөнгөгүйгээс ажлаа сурталчилж чадахгүй байгаа. Мөн нийгмийн шилжилтийн үйл явцаас улбаатай ард түмний амьдрал маш их доройтсон. Ийм үед хүмүүс шинжлэх ухаанд итгэхээс илүү элдэв мунхруулга, мухар сүсэгт итгэж байна. Нийгэмд шинжлэх ухааныг хүлээж авдаг уур амьсгал сүүлийн 20 гаруй жилд их муудсан. Манай улсын хувьд шинжлэх ухаанд маш багыг зарцуулдаг, эрдэмтэн судлаачид цөөхөн. Эрдэмтдийн тоо Азийн дунджаас гурав дахин цөөн. Азид нэг сая хүнд ногдох судлаачдын тоо нэг сая хүнд 1500 байна. Манайд бол сая хүнд 500 судлаач ногдож байна. Ийм цөөн судлаач, бага төсөвтэй үед том үр дүн угаасаа гарахгүй. Үүнийгээ бид илэн далангүй хэлж байх хэрэгтэй. Гэхдээ манай суурь судалгаан дээр ажилладаг эрдэмтдийн бүтээл дэлхийн томоохон эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд цөөнгүй хэвлэгддэг. Хүний тоо, мөнгөндөө харьцуулахад ашигт үйлийн коэффициентийн хувьд дэлхийн дунджаас өндөр байгаа. Хоёр дахь үзүүлэлт нь үйлдвэрлэлд нэвтрүүлэх тал дээрээ дунд зэргийн хөгжилтэй орноос ч их хоцорч байгаа. Ийм л хоёр өөр дүр зураг гараад байна.

ШУ-ны үр дүнгийн талаарх иргэдийн хандлага болон бодит нөхцөл: Иргэд олон нийт бол ШУ-ны судалгаа, ажлын үр дүнг шууд нүдэнд баригдаж, харагдах ёстой гэж үздэг. Харин судалгаа, шинжилгээний ажлын үр дүн тэр бүр нүдэнд харагдаж, баригдаад байх нь ховор. Ялангуяа суурь судалгааны үр дүн цаг хугацаа их зарцуулж, бусад хэрэглээний судалгаа, шинжилгээний суурь болох зэргээр илэрдэг, нийгмийн шилжилтийн үйл явцаас улбаатай ард түмний амьдрал маш их доройтсон. Ийм үед хүмүүс шинжлэх ухаанд итгэхээс илүү элдэв мунхруулга, мухар сүсэгт итгэж байна. Нийгэмд шинжлэх ухааныг хүлээж авдаг уур амьсгал сүүлийн 20 гаруй жилд их муудсан болон эрдэмтэд мөнгөгүйгээс ажлаа сурталчилж чадахгүй байгаагаас өрөөсгөл дүгнэлт өгөхөд хүргэж байна гэж нэгдүгээр бүлэгт хамаарах эрдэмтэд үзжээ. Мөн ШУ-ны салбар ажиллаж буй хүний тоо, мөнгө санхүүжилттэйгээ харьцуулахад ашигт үйлийн коэффициентийн хувьд дэлхийн дунджаас өндөр байгаа ч үйлдвэрлэлд нэвтрүүлэх тал дээрээ дунд зэргийн хөгжилтэй орноос ч их хоцорч байна гэж дүгнэжээ.

ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны талаарх үнэлгээ: ШУА болон түүний хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн талаар зөрчилтөд хоёр байр суурь байна. Нэгдүгээр

бүлэгт хамаарах эрдэмтэд, ШУА-ийн хүрээлэнгүүдийн ажлын үр дүнг сайн гэж үнэлэж байна. Хоёрдугаарт бүлэгт багтаж буй эрдэмтдийн хувьд, ШУА-ийн хүрээлэнгүүдийн ажлын үр дүн буурч байгаа бөгөөд үнэлгээ тааруу байна.

ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг үнэлэх талаарх саналууд: Нэгдүгээр бүлгийнхний хувьд, ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа, үр дүнг гадаад, дотоодод хэвлүүлсэн өгүүлэл, илтгэлийн тоо, эзэмшиж байгаа патент, технологи, стандартын тоогоор үнэлэхээс аргагүй. Хоёрдугаар бүлгийнхний хувьд, ШУ-ны үр дүнг хэдэн ном, өгүүлэл, илтгэлийн тоогоор бус үр дүнд хүрсэн онол, арга зүйгээр үнэлэх хэрэгтэй. Мөн ШУ-ны үр дүнг үнэлэхдээ зөвхөн дотоодод гаргасан амжилт, нөлөөлөл, үр ашиг зэргийг харалгүй гадаадад, дэлхийн шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, гаргасан амжилтаар нь үнэлэх нь зүйтэй.

#### **Шинжилгээ №4. ШУ-ны санхүүжилт**

- ⊗ Шинжлэх ухааны санхүүжилт тааруухан байгаа. Шинжлэх ухааны санхүүжилт сүүлийн жилүүдэд ойролцоогоор дотоодын нийт бүтээгдэхүүний 0.2 - 0.26 орчим хувь байна. Хэрэв шинжлэх ухааныг ашиглаж улс орноо хөгжүүлье гэвэл энэ санхүүжилтийг эрс нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Шинжлэх ухааны санхүүжилт нь дотоодын нийт бүтээгдэхүүний 1% -д хүрэхэд тэр улсын шинжлэх ухаан нь нийгэм, эдийн засагтаа мэдэгдэхүйц үр ашгаа өгдөг байна. Манай улсын хуулиар бол дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 1.5 %-иас дээш зарцуулах ёстой байгаа юм.
- ⊗ Европын орнуудад дотоодын нийт бүтээгдэхүүний 3 хувийг шинжлэх ухаанд зарцуулдаг бол манайд 0.16 хувь байна.
- ⊗ Санхүүжилттэй холбоотой ажилтнуудын цалин, судалгааны санхүүжилт, материаллаг бааз нь ямагт бусад салбараас хоцрогдонгуй явж ирлээ дээ. ЭША-ууд олигтойхон компанийн үйлчлэгчийн хэмжээний цалинтай, дунджаар 500 мянга орчим төгрөг шүү дээ.
- ⊗ ШУА, түүний хүрээлэнгүүдийн төсөв, санхүүг Төрийн сангийн тогтолцооноос гаргачихмаар байгаа юм. Болохгүй бол зөвхөн улсын төсвийн дэмжлэгээ Төрийн сандаа үлдээгээд үйл ажиллагааны орлогоороо санх үүгийн менежмент хийх боломжийг нь олгоод арилжааны банкинд данстай болгох боломж бий.
- ⊗ ШУА-ийн ерөнхийлөгчийг харьяа хүрээлэнгүүдийнхээ төсвийн ерөнхийлөн захирагч нь болгочихмоор байна. Бүр арга ядахад БШУ-ны сайд, ШУА-ийн ерөнхийлөгчид эрх шилжүүлэх гэрээ байгуулахдаа тусгай захиалгатай бүтээгдэхүүн, хүрээлэнгүүдийн суурь судалгааны төсвийн эрх мэдлийг хамтад нь шилжүүлж болмоор байна. Сонгон шалгаруулалтаас эхлээд төсөл хэрэгжиж дуусах бүх шатанд ШУА, түүний салбарын Бага чуулгануудын оролцоо, үүргийг байхгүй болгож, суурь судалгааны хүрээлэнгүүд нь хувийн компани, ТББ, хувь иргэнтэй адилхан төсөл хэрэгж үүлэгч л байхаар болгосон. Төсөл, суурь судалгаа хоёрыг санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгах ёстой.
- ⊗ ШУА бол тийм ч их төсөв зарцуулдаг данхар бүтэцтэй газар биш. ШУ-ны байгууллагыг төсөв мөнгө хэмнэх нэрийдлээр механикаар нэгтгэвэл шинжлэх ухааны салбараа өөрсдийн гараар самрах эрсдэлтэй.
- ⊗ Монгол Улсын хэмжээнд 63 академич бий. Тэд насаараа шинжлэх ухаанд өөрсдийгөө зориулж бүтээл туурвисныхаа хариуд нэмэгдэл гэж 530 мянган төгрөг авдаг юм.
- ⊗ Академичийн хийж буй судалгааны ажилд тэтгэлэг буюу грант болгон өгч байгаа мөнгө. Судалгаа хийхэд асар их зардал гардаг. ШУА-ийн хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтнуудын дундаж цалин маш хөөрхийлөлтэй. 300-400 мянган төгрөг байна. Дээд тал нь 800 мянган төгрөг орчим байх жишээтэй.
- ⊗ Өнөөдөр эрдэмтдийн хамгийн тулгамдсан асуудал судалгааны санхүүжилт. Санхүүжилтийн янз бүрийн эх үүсвэрийг ашиглаж байгаа туршлага байна. Гэхдээ хэрэглээний судалгааг голловол угтаа шинжлэх ухааны рациональ мөн чанарыг тоомсорлохгүйд хүргэнэ эсвэл шинжлэх ухааны ажлыг зөвхөн санхүүжүүлэгчийн хэрэгцээнд тохируулах нь буруу гэсэн шүүмжлэл дагуулж байгаа нь ч үндэстэй юм. Судалгааны ажлын зардал ба чанар нь шууд хамааралтай. Зарим судалгаанд урт хугацааны хөрөнгө оруулалт, зардал шаарддаг.

- ⊗ ДНБ-ний 0.17 хувийг л шинжлэх ухаанд өгдөг. Үүнээс ч илүү юм хэмнэвэл яах вэ. Балбын вант улс манайхаас дор ч шинжлэх ухаандаа ДНБ-нийхээ 0.66 хувийг өгдөг. Ази тив ДНБ-нийхээ хоёр хувийг шинжлэх ухаандаа зориулдаг. Манай шинжлэх ухаанд олон эх үүсвэртэй санхүүжилт хэрэгтэй. Өөрчлөлтийн гол зорилго тэр лүү явах ёстой.
- ⊗ ДНБ-нийхээ нэг хувиас дээш хэмжээний хөрөнгө зарж байж шинжлэх ухаанаас эдийн засгийн бодитой үр дүн гардаг.
- ⊗ Хэсэг эрдэмтэд бие биедээ академич гэдэг цол өгөөд сарын 650 мянган төгрөгийн тэтгэмж авдгийг болиулъя. Боловсон дээрэм биш үү. ШУА-ийн одоогийн цалингийн систем их буруу. Цаасан тайлангаар хуурдаг.
- ⊗ Шинжлэх ухааны санхүүгийн салбарын менежментийг бодлогын яам хийгээд байгаа биз дээ. Төр бол хамгийн муу менежер гэж нэг үг бий дээ.
- ⊗ Гарааны компани байгуулах асуудлыг Засгийн газрын түвшинд 2014 онд шийдсэн. Гарааны компанид холбогдох журмыг батлаад, нэлээн хэдэн компани байгуулсан юм. Шинжлэх Ухааны Академийн дэргэд дөрвөн компани байгуулагдсан.
- ⊗ Монголд жилд нэг удаа болдог ШУА-ийн чуулгандаа суудаггүй, оролцдоггүй хүмүүс сар бүр 500 мянган төгрөг зүгээр аваад сууж байна. Тэр ямар хүмүүс вэ гэвэл, дандаа социалистууд, философич, түүхч, хуульч, нийгмийн ухааныхан. Тэд социализмыг хамгаалагчид, ярьдаг юм нь бүгд ардчилал, зах зээлийн эсрэг. Номоо ч тэгж бичдэг, олон ч ном гаргаж буй. Манайхан юм уншдаггүй учраас мэдэхгүй байна. Тэд бол өнгөрсөн жилүүдэд бидний олсон ардчилал, зах зээлийн амжилтыг ар хударгаар нь, хөрсөөр нь эвдэж, дарь бэлтгэж буй нөхөд. Баабар “Монголын эдийн засгийг эдийн засагчид л онхолдуулсан” гэсэн. Тэгвэл тэр хүмүүс өнөөдөр академич болчихоод сар бүр 500 мянга, жилд зургаан сая төгрөг аваад зүв зүгээр сууж байна.
- ⊗ ШУА -ёён гишүүн гэх хуульд захирагддаггүй хүмүүс буй болжээ. Тэдний дотор УИХ-н гишүүд байдаг нь байдлыг бүр ч утгагүй болгож байна. Одоогоор тэд сар бүр академич цолны нэмэгдэл 500 мянга, дээр нь шинжлэх ухааны докторын нэмэгдэл 137 мянга, бас профессор цолны нэмэгдэл 68 мянга, захирал салбарын эрхлэгчийг хавсарсаны 320 мянга, нийт 1025 мянган төгрөгийг зүгээр л авдаг.
- ⊗ 2014 оны байдлаар дэлхийн улс орнууд шинжлэх ухаандаа дотоодын нийт бүтээгдэхүүнийхээ 0.2-4.2 хувийг зарцуулсан гэх судалгаа бий. Тухайлбал, Израиль улс 4.2, АНУ 2.8, Япон 3.4, Африкийн орнууд дунджаар 0.2 хувийг зарцуулжээ. Гэтэл манай улс 2012 онд ДНБ-ий 0.2 хувь, 2013 онд 0.20 хувь, 2014 онд 0.18 хувийг шинжлэх ухаан, технологийн арга хэмжээнд зарцуулсан байна. Эндээс харахад манайх Африкийн орнуудын төвшинд, түүнээс ч бага мөнгө шинжлэх ухаанд зарцуулж байна. Шинжлэх ухаан судлалд аливаа улс орны судалгаа боловсруулалтад зарцуулж буй зардлын хэмжээ нь ДНБ-ий 0.4 хувиас доош байвал шинжлэх ухаан нийгэм, соёлын үзэгдэл төдий, 0.8 хувиас доош байвал танин мэдэхүйн төвшинд, нэг хувиас дээш байвал улс үндэстнийхээ хөгжилд тус нэмэр болдог гэж үздэг. Тиймээс ч ЮНЕСКО-гийн зүгээс Африкийн орнуудад 1.0 хувьд хүргэх, ШУА-иуд байгуулахыг зөвлөмж болгосоор байдаг юм.
- ⊗ ШУА-д Удирдах зөвлөл гэж байдаггүй. Харин Их, Бага чуулган, тэргүүлэгчид гэж бий. УИХ-ын гишүүдээс төрийн төлөөлөөр сонгогдсон ШУА-ийн тэргүүлэгч гишүүд байдаг ч тэд сар бүр 600 мянган төгрөг байтугай, ганц төгрөг ч авдаггүй.
- ⊗ 013, 2014, 2015 оны төсөв нэг хэвээр байгаа. Сүүлийн гурван жилийн инфляцийг бодоод үзэхэд 30 орчим хувь байна. Тэгэхээр урсгал төсөв бодит хэрэг дээрээ 30 хувь танагдсан гэсэн үг л дээ.
- ⊗ Манай улсын шинжлэх ухаандаа зарцуулж байгаа төсвийн хэмжээ Азийн дундаж болох ДНБ 2%-иас 12 дахин бага байгаа юм.
- ⊗ Шинжлэх ухаанд зарцуулах Ази тивийн улс орнуудын дундаж төсөв ДНБ-ий хоёр хувьд хүрлээ. Америк тив бол хоёр хувиас дээш гарсан. Харин Европ тивийн дундаж хоёр хувьтай байна. Ази тивийн шинжлэх ухаанд зарцуулах мөнгө асар их нэмэгдэж байгаа. 2013 оноос хойш тивийн хэмжээнд шинжлэх ухаанд оруулсан мөнгөн дүнгээрээ Америк тивийн урд орж ирсэн. 2013 оноос хойш нэгдүгээрт, Ази, Америк хоёрдугаарт, Европ гуравдугаарт орж

- байна. Хятад бол шинжлэх ухаан оруулж буй мөнгөний хэмжээгээрээ 2013 онд Америкийн дараа орж ирсэн. 2021 онд Америкийн өмнө орно гэж байгаа.
- ⊗ Дэлхий даяар хийж байгаа судалгаануудаас харахад хэрэв шинжлэх ухааны салбартаа өгч байгаа мөнгө 0.4 хувиас бага бол энэ салбар чинь нийгмийн үзэгдэл төдий гэж байна. Манай улс 0.4 хувиас хоёр дахин бага байгаа шүү дээ. Шинжлэх ухаан байна, эрдэмтэд байна. Судалгаа хийж байна, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж байна. Гэхдээ нийгэмд бодитой нөлөө байхгүй. 0.8 хувиас дээш гарч байж ашиг өгдөг. Нэг өгвөл эдийн засагт тогтмол эерэг нөлөө үзүүлдэг гэсэн судалгааг 2001 онд НҮБ-аас тусгай Ажлын хэсэг гараад, Ажлын хэсгийг АНУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч Брюс Альбертс гэж бидний сайн танил том эрдэмтэн удирдан ажиллаж ийм зөвлөмж гаргасан. Хөгжиж байгаа бүх орны Төрийн тэргүүнүүд рүү явуулсан. Манай Ерөнхийлөгчид 2002 онд ирсэн л байх. Тэр нь шинжлэх ухааны салбарын зардлаа ойрын жилүүдэд ДНБ-ий нэг хувьд хүргээч. Тэгвэл танай улсын хөгжилд бодитой нөлөө үзүүлнэ гэсэн. Одоо ч тэр зөвлөмж мартагдсан байх аа.
  - ⊗ Азид нэг сая хүнд ногдох судлаачдын тоо нэг сая хүнд 1500. Манайд бол сая хүнд 500 судлаач ногдож байна. Ийм цөөн судлаач, бага төсөвтэй үед том үр дүн угаасаа гарахгүй. Үүнийгээ бид илэн далангүй хэлж байх хэрэгтэй.
  - ⊗ Манай улсын Ерөнхий сайд хийсэн хүмүүс сүүлийн 20-иод жилд Монгол Улс шинжлэх ухаандаа тулгуурлан хөгжин<sup>9</sup> гэж хэлэхгүй байгаа.Хятадын манай сумтай дүйцэх хэмжээний нэгжид очиход дарга нь манай сум шинжлэх ухаанд суурилан хөгжин<sup>9</sup> гэж яриад байгаа. Түүн шиг бүх шатны удирдлагуудын толгойд суулгаж байж хөгжих ёстой шүү дээ. Манайхан бол шинжлэх ухаан ч яах вэ, ахиухан нүүрс гадагш нь гаргачихъя л гэж бодоод байх шиг.
  - ⊗ Төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагуудад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, захиалгат, хамтарсан судалгааны ажил гүйцэтгэх таатай орчинг бүрдүүлнэ.
  - ⊗ Шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт байхгүй байсныг өөрчлөн 2017 онд 1 тэрбум орчим төгрөг болгон нэмэгдүүлж байна.

*ШУ-ны ажилд зарцуулагдаж буй төсвийн талаарх хандлага*

- *Ярилцлагад оролцогчдын дийлэнх нь ШУ, ШУ-ны байгууллагад олгогдож буй санхүүжилт бага, үүнийг зохих хэмжээнд хүртэл нэмэгдүүлэх дээр санал нэгтэй байлаа. Түүнчлэн эрдэм шинжилгээний ажилчдын цалингийн дундаж их дээд сургуулийн багш нарын цалингийн дунджаас даруй 2-3 дахин бага байна гэж үзжээ. ШУА-д эерэг болон сөрөг үнэлгээ өгч буй хоёр бүлэг эрдэм шинжилгээний ажилтнуудын цалинг өсгөх хэрэгтэй гэсэн байр суурьт санал нэгдсэн байлаа.*
- *Судалгааны ажлын санхүүжилт, чанар үр дүн хоёр хоорондоо шууд хамааралтай. Цөөн судлаач, бага төсөв санхүүжилттэй үед том үр дүн угаасаа гарахгүй.*

*ШУ-ны ажилд зарцуулагдаж буй төсвийн хэмжээ*

- *Ярилцлагад оролцогчид шинжлэх ухааны санхүүжилт дотоодын нийт бүтээгдэхүүний 0,16 - 0,26 орчим хувьтай буюу барагцаагаар 30 тэрбум төгрөг байна.*

*ШУ-ны ажилд зарцуулвал зохих санхүүжилтийн тухай*

- *Олон улсын жишгээр улс орнууд шинжлэх ухааныхаа санхүүжилтэнд дотоодын нийт бүтээгдэхүүний 0,66-4.2 хувийг зарцуулдаг. Шинжлэх ухааны санхүүжилт дотоодын нийт бүтээгдэхүүний 0.8 хувиас дээш гарч байж ашиг өгдөг.*
- *Манай улсын холбогдох хууль тогтоомжид шинжлэх ухааны санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5 хувьтай тэнцэхээр байна гэж заасан байдаг байна.*

- *Эрдэмтдийн үзэж байгаагаар шинжлэх ухааны санхүүжилтийг дунджаар 3 – 5 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.*
- *Шинжлэх ухааны салбарт хөрөнгө оруулалт байхгүй байсныг өөрчлөн 2017 онд 1 тэрбум орчим төгрөг болгон нэмэгдүүлж байна.*

#### *Санхүүгийн менежментийн талаар*

- *ШУА болон ШУА-ийн хүрээлэнгүүдийн төсвийг төрийн сангийн тогтолцооноос гаргах; эсвэл зөвхөн улсын төсвийн дэмжлэгээ төрийн санд үлдээж үйл ажиллагааныхаа орлогоор санхүүгийн менежмент хийх боломжийг нь бүрдүүлж арилжааны банкинд данстай болгох хэрэгтэй.*
- *ШУА-ийн ерөнхийлөгчийг харьяа хүрээлэнгүүдийн төсвийн шууд захирагч болгох.*

#### *Академич нарт олгодог мөнгөний талаар*

- *Монгол Улсын хэмжээнд 63 академич бий. Тэд насаараа шинжлэх ухаанд өөрсдийгөө зориулж бүтээл туурвисныхаа хариуд нэмэгдэл гэж 300-530-800 мянган төгрөг авдаг.*
- *Энэ мөнгийг нэг хэсэг нь академич нарын хэрэгжүүлж буй төсөлд грант болгон өгч байгаа мөнгө, хэсэг хүмүүс бие биенээ академич гэж өргөмжлөөд мөнгө авч байгаа нь боловсон дээрэм, олон жил судалгаа шинжилгээ хийсэн эрдэмтдэд тэтгэлэг болгон өгч буй мөнгө гэх зэргээр ялгавартай хандаж байна.*

#### **Шинжилгээ №5. ШУА-ийн бүтэц, зохион байгуулалт**

- ⊗ *Аль ч академид байдаг нэг гол үүрэг бол төр засагт зөвлөмж өгөх юм. Манай академи жилд 5-7 зөвлөмж Засгийн газар, УИХ-д өгдөг. Үндэсний хэмжээний төслүүдэд эксперт хийдэг үүрэг, функцийг манай ШУА-д хуулиар олговол үнэхээр чухал.*
- ⊗ *ШУА, эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг татан буулгах нь буруу. Их сургуулиуд дээр байгуулагдах шинэ хүрээлэн, үндэсний судалгааны төвүүдийг дэс дараатай, үе шаттайгаар байгуулж, өдөрт 8 цаг судалгааны ажил хийдэг 2500-3000 орон тооны эрдэм шинжилгээний ажилтнуудтай болгож, хөрөнгө, санхүүгээр дэмжмээр байна.*
- ⊗ *ШУ-ны тодорхой чиглэлд мэргэшсэн, тэргүүлэх эрдэмтнээр удирдуулсан баг, байгууллага тогтвортой байснаар мэдлэгийг тасралтгүй дамжуулах боломж бүрднэ.*
- ⊗ *Барууны орнуудад их дээд сургуулиудаас гадна ШУА, Төв лаборатори, хүрээлэн, нийгэмлэгүүд дээрээ шинжлэх ухааны судалгаа хийдэг юм.*
- ⊗ *ШУА, их сургуулиуд хоорондын хамтарсан төслүүдийг Төр, засгаас илүүтэй санаачлан дэмжиж, уг төслүүд дээр нэг талаас ШУА-ийн эрдэмтэд, судлаачид, нөгөө талаас их сургуулиудын багш, оюутнууд орж, хамтран ажиллах явдал юм.*
- ⊗ *ШУА нь ИХ сургуулиудаас тусгаар бие даасан байгууллага байх нь зүйтэй.*
- ⊗ *Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг өөр зорилго, үүрэг бүхий байгуулагатай нэгтгэнэ гэдэг алс хэтдээ төрийн бодлогыг сулруулж, энэ нь та бидний ярих дуртай “туурга тусгаар” амьдрах хувь заяанд маань хүртэл нөлөөлчих юм биш байгаа*
- ⊗ *Их, дээд сургуулиудийн нэгдүгээр зорилго бол сургалт явуулах, бакалавр, магистр, доктор бэлтгэх байдаг. Харин шинжлэх ухаан бол хоёр, гуравдугаарт нь байдаг. Тэгэхээр ШУА-ийг их сургуулиудтай нэгтгэх нь буруу.*
- ⊗ *Судалгааны ажил үндэсний шинж чанартай хүрээлэнгүүд дээр бас хийгддэг. Нэгийг нөгөөгөөр нь үгүйсгэж огт болохгүй.*
- ⊗ *Академийн хүрээлэнгүүд анхнаасаа онолын судалгааны чиглэлээр байгуулагдсан.*
- ⊗ *Монгол Улс ч гэсэн дэлхийн шинжлэх ухааны үр ашигтай загвар болох их дээд сургуулиудтай нэгтгэх загварт шилжих ёстой. Энд судалгаа хийнэ гэж цаг алдах хэрэггүй. ШУА, их сургууль хоёртоо зэрэг шинэчлэл хийе. Хүрээлэнг их сургуульд нэгтгэж, эрдэмтдийн хүчийг төвлөрүүлье. Хүрээлэнгүүдийг их сургуультай нэгтгэнэ гэдэг бол судалгааны үндэслэлтэй гарсан шийдвэр.*
- ⊗ *Ер нь шинжлэх ухааныг их сургуульд суурилуулах зарчмаас хазайж огт болохгүй.*

- ⊗ ШУА-ийг Монголын бүх эрдэмтдийн төрийн бус байгууллага болгоё.
- ⊗ ШУА-ийн бүтэц, зохион байгуулалт социализмын үеийнхээрээ байгаа нь зах зээлийн зарчимтай зөрчилдөж, улс төр, эдийн засгаасаа 23 жилээр хоцрогдсон байна.
- ⊗ Монголын шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлэхийн тулд бүтцийн маш гүнзгий өөрчлөлт хийх хэрэгтэй. Тэгэхгүйгээр Монголын шинжлэх ухаан урагшаа алхаж чадахгүй.
- ⊗ Дээд сургууль, хүрээлэнгүүдийн харилцан уялдаа холбоог бэхжүүлэх, академийн болон их, дээд сургуулийн шилдэг эрдэмтдийг холбож ажиллах менежмент байхгүй юм шиг санагддаг
- ⊗ "Шинжлэх ухаан технологийн сан" гэдэг өөдтэй ажил хийдэггүй, хөрөнгө дамжуулах төдий үүрэгтэй бас нэг илүү эрхтэн рудимент байна.
- ⊗ Зах зээлийн тогтолцоо, менежментийг бий болгохоор Шинжлэх ухаан технологийн санг санаачилсан. Америкт үндэсний шинжлэх ухааны сан гэж агентлагийн эрхтэй бие даасан байгууллага бий. Шинжлэх ухаан, судалгаа шинжилгээний ажилд зарцуулах хөрөнгийг энэ санд өгч, дэвшүүлсэн төслийг мэргэжлийн экспертүүд судлаад тухайн төслийг санхүүжүүлэх эсэхээ шийддэг журамтай. Ийм байдалд оруулах санаатай Шинжлэх ухаан технологийн сан байгуулсан боловч бие даасан байдалгүй, БШУЯ-ны харьяаны газар болчихсон юм.
- ⊗ Хүрээлэнг их сургуультай нийлүүлэх давуу талууд буюу үндэслэлүүд байна. Үүнд, судлаачдын хүчийг нэгтгэж, хоршвол бүтээмж дээшилнэ. Сургалт судалгаа, бизнесийн ажлыг зохистой удирдах боломж бүрдэнэ. Багш нар судалгааны ажилд өргөнөөр оролцоно. Хичээлийг судалдаг сэдвээр нь эрдэмтэд заах учир чанар сайжирна. Багш, судлаачид аль аль нь гарааны компани байгуулах боломж нээгдэнэ.
- ⊗ Шинжлэх ухааны талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2015 оны нэгдүгээр сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоол гарсан. Шинжлэх ухаан бол улсын хэмжээний нэг том салбар. Үүний нэг хэсэг нь манай ШУА. Энэ салбарт орон тоогоор ажиллаж байсан 1800 хүний 50 орчим хувь нь ШУА-ийн хүрээлэнгүүдэд ажилладаг. Засгийн газрын тогтоолын үр дүнгээр манай улсад эрдэм шинжилгээний 49 хүрээлэн байсан бол 23 бол шинээр эмхлэн зохион байгуулагдлаа. Үүний 10 нь ШУА-ийн харьяанд, хоёр нь төрийн яамдын харьяалалд, бусад нь их сургуулиудын харьяалалд байгуулагдсан. Тэгэхээр үндсэндээ эрдэм шинжилгээний байгууллагуудын харьяалаар нь гурав ангилж болно.
- ⊗ 1800-гаад хүнээс 200 гаруй хүн цомхтгогдсон. Ид ажил хийх насны эрдэм шинжилгээний ажилтнууд цомхтголд цөөхөн орсон. Ингэж цомхтгосны үр дүнд 1.4 тэрбум орчим төгрөгийн төсөв хэмнэгдэнэ гэсэн тооцоо гаргасан байна.
- ⊗ Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг нэгтгэсэн нь хөндлөнгөөс харахад механик нийлүүлэлт юм шиг боловч явуулж буй үйл ажиллагаа, судалгааны үндсэн чиглэлээр íү нэгтгэсэн. Тийм учраас механик нэгдэл биш гэж ойлгож байгаа.
- ⊗ ШУА-ийн том, жижиг, хуучин шинэ, ашиглалтын хугацаа нь дууссан байшингуудыг нийлүүлбэл Улаанбаатарт 14-15 объект бий. Ерөнхийд нь харахад бүтнээрээ сулрах байшин алга. 200 хүн цомхтгогдож байгаагийн нэлээд хэсэг нь гэрээт ажилтан. Байнга сууж ажилладаггүй хүмүүс. Ер нь энэ салбарт өөрийн гэсэн байргүй хүрээлэн нэлээд хэд байдаг. Харин өөрчлөлтийн хүрээнд тэдгээр хүрээлэнгүүд байртай болох боломж нээгдэж байна.
- ⊗ Шинжлэх ухааны байгууллагын удирдах дээд байгууллагын хувьд шинжлэх ухаан, технологийн асуудал хариуцсан одоогийн БСШУ яам эсвэл тусдаа шинжлэх ухаан, технологийн яам, ерөнхийлөгч/ерөнхий сайдын шууд удирдлага дор ажилладаг агентлаг ч байж болох талтай.
- ⊗ Хятадын ШУА-ийн гишүүдийн дундаж нас 40 гаран, харин технологийн академийнх нь 30 гаран болжээ. Хятад ШУА асар их залуужсан байна. Манай ШУА-д энэ тоо 70 ààс цааш. Монгол ШУА асар их хөгширсөн байна.
- ⊗ ШУА-ийн жинхэнэ гишүүдийн мэргэжлийн чиглэлээрх бүтцэд нийгмийн ухаан 27 хувь, байгаль, техник, хөдөө аж ахуй, анагаах ухаан 73 хувийг эзэлдэг.
- ⊗ 783 эрдэм шинжилгээний ажилтныг эрдмийн зэрэг, цолоор нь авч үзвэл 25 академич, 253 доктор, 322 магистр, 181 бакалаврын зэрэгтэй судлаач байна. Манай шинжлэх ухааны

системд залуу судлаачдын эзлэх хувийн жин 2009 оноос хойш тогтвортой нэмэгдэж одоо эрдэм шинжилгээний ажилтны дундаж нас 38 болж 35 хүртэл насны судлаачид нийт ажилтны 54 хувийг эзэлж байна.

- ⊗ ШУА-ийн харьяа 22 хүрээлэн төв нь төрийн болон хувийн хэвшлийн 15 их дээд сургуулийн 47 тэнхим, профессорын багтай ажил төрлийн шууд холбоотой ажиллаж, тэдгээрт ШУА-ийн харьяа хүрээлэнгийн 240 гаруй эрдэмтдийн 57 хувь нь цагаар багшилж, баклавр, магистр, докторын сургалтад оролцож байна. ШУА-ийн Хүрээлэнгийн захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга, секторын эрхлэгч нарын таван хувь нь их сургуулийн тэнхимийн эрхлэгчийг хавсран ажилладаг. Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн байнгын гишүүдийн 16.7 хувь нь академийн хүрээлэнгүүдэд ажиллаж буй эрдэмтдийн төлөөлөл байна.
- ⊗ Засгийн газраас шинжлэх ухааны байгууллагуудыг зөв бүтэцтэй болгон эрчимтэй хөгжүүлэх зорилгоор 1997, 2015 онуудад салбарт бүтцийн томоохон өөрчлөлт хийсэн. Эдгээр өөрчлөлт шинжлэх ухааны салбарын бүтэц, удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог хөгжлийн чиг хандлагад нийцүүлсэн, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг олон улсын жишигт хүргэсэн гэж үзэхэд учир дутагдалтай болсон нь одоо харагдаж байна.
- ⊗ Бүтцийн өөрчлөлт хийсэн нэг томоохон шалтгаан нь их сургууль дээр л шинжлэх ухаан хөгждөг, өөр газар хөгждөггүй, сургалт эрдэм шинжилгээний ажил хол хөндий байна гэсэн өнгөц, өрөөсгөл ойлголтоос үүдэлтэй. Их сургууль, хүрээлэнгүүдийн хамтын ажиллагааг сайжруулах, үр ашигтай хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх нь чухал.

ШУА-ийн бүтцийн талаарх хандлага: ШУА, ШУА-ийн хүрээлэнгүүдийн бүтцийг өөрчлөн, сайжруулах хэрэгтэй гэдэгт ярилцлагад оролцогчдын ихэнх нь санал нэгтэй байна. Энэ талаар гурван хандлага байна.

*Хоёрдугаар бүлэгт багтах эрдэмтдийн үзсэнээр:*

*ШУА-ийн хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэх, ШУА-ийг Их, дээд сургууль, хүрээлэнгүүд, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг хамааруулсан, бүх эрдэмтдийн нэгдсэн ТББ байгууллага болгох,*

*Нэгдүгээр бүлэгт багтах эрдэмтдийн үзсэнээр:*

*Нэгд, ШУА, ШУА-ийн хүрээлэнгүүдийг бие даасан хэлбэрээр нь үлдээж харин давхардлыг арилган зарим ижил, төстэй судалгаа хийдэг хүрээлэнгүүдийг нэгтгэх байдлаар бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх хэрэгтэй,*

*Хоёрт, ШУА, түүний хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэлгүй бие даасан хэлбэрээр үлдээж, харин их дээд сургуулиудын харъяд шинэ хүрээлэн, судалгааны төвүүдийг дэс дараатай байгуулах хэрэгтэй.*

ШУА, түүний хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэхийн давуу болон сүл талыг үнэлсэн байдлыг авч үзвэл:

*Нэгдүгээр бүлэгт хамаарах эрдэмтдийн үзсэнээр:*

*ШУА-ийн зарим хүрээлэнгүүдийг тухайлбал математикийн хүрээлэнг их сургуультай нэгтгэж байсан түүхтэй. Гэвч тэдгээр хүрээлэнгүүд сайжран, хөгжих нь битгий хэл хаалгаа барьж татан буусан байдаг. Ийм ирээдүй бусад хүрээлэнгүүдийг хүлээж байх эрсдэлтэй.*

*Хоёрдугаар бүлэгт хамаарах эрдэмтдийн үзсэнээр:*

*ШУА, түүний хүрээлэнгүүдийг их сургуультай нэгтгэсэнээр эрдэмтдийн хүчтэй баг бий болох, ингэснээр эрдэм шинжилгээний ажлын бүтээмж, үр дүн сайжрах боломжтой.*

Хүний нөөцийн талаарх байр суурь: ШУ-ны хүний нөөцийн асуудал ярилцлагуудад нэлээд хөндөгдсөн байна. Ингэхдээ хоёр бүлэг хоёулаа хүний нөөц, дутмаг, эрдэм шинжилгээний ажилтнуудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг дээр санал нэгтэй байлаа.

**Шинжилгээ №6. ШУА-ийн удирдлага, менежмент**

- ⊗ Өнөө үед ШУА-ийн төрөлжсөн салбар академиуд, бага чуулганууд шинжлэх ухааны бодлогыг боловсруулах, эрдэм шинжилгээний ажлыг сонгон шалгаруулах хамгийн гайгүй зөв бүтэц юм. Эдгээр бага чуулгануудад эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд, их сургуулиудын тэргүүлэх эрдэмтэн судлаачид орсноос гадна төрийн байгууллага, хувийн хэвшлээс ч төлөөлөл байдаг.
- ⊗ Үүнээс гадна салбарын яамдын шинжлэх ухаан, технологийн зөвлөл салбарынхаа шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцох оролцоог давхар авч үзэх шаардлагатай. Эрдэм шинжилгээний ажлыг сонгон шалгаруулах нэг байгууллага бол Шинжлэх ухаан, технологийн сан байж болно.
- ⊗ Монголын шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын асуудал байна гэж үзсэн.
- ⊗ ШУА-д үнэний төлөө чөлөөтэй ажиллах боломж байхгүй. Учир нь, ШУА-ийг төр хатуу хянадаг, төр хажуунаас нь ороод, бүгдэд мөнгө өгөөд та нар дув дуугүй байвал энэ мөнгийг нэмнэ, эсвэл татна гэхээр яах юм бэ юу ч хийлгэхгүй байна.
- ⊗ Энэ муухай хяналт ардчилсан гэх тодотголтой шинэчлэлийн гэх хаягтай энэ төрийн үед бүр ч даамжирч, Сталинч арга руу шилжлээ. Төрөөс санхүүжилт аваад яг ижилхэн сэдэв судалдаг эрдэмтэд цөөн бус. Маш их давхардал бий. Тэдний талаар ШУА ганц ч үг ганхийхгүй, яагаад гэвэл, дургүйлхсэн эрдэмтэн ШУА-ийн булхайг олонд дэлгэнэ.
- ⊗ Төрийн соёрхолт, Н.Нацагням ШУА-ийг ОЮУНЫ ВИРУС гэжээ
- ⊗ Одоогийн ШУА хэдэн хүрээлэнг дарангуйлж захирдаг тоталитар байгууллага болоод байна. Их сургуулиуд, хувийн секторынхан ШУА-ийн гадна гээгдэн хоцорчээ. Гэтэл энд шинжлэх ухааны гол хүч хуримтлагдсан.
- ⊗ Зах зээлийн үед ШУА үндсэн хоёр үүрэгтэй байдаг. Нэгд, тухайн оронд шинжлэх ухаан, технологийн бодлого хэрхэн явах талаар чиглэл боловсруулдаг. Өөрөөр хэлбэл, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг. Тэр нь Засгийн газарт төдийгүй хувийн секторт их хэрэгтэй юм. Хоёрт, тухайн эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэн, эрдэмтэд хоорондоо өрсөлдөн янз бүрийн нээлт, судалгаа хийж материалууд гаргаж ирдэг. Түүнд нь эксперт хийдэг шинжээчийн үүрэгтэй. Манайд ийм зүйлүүдийг огт хийдэггүй. Манай ШУА хүрээлэнгүүдийн тайланг нэгтгэдэг байгууллага болчихсон
- ⊗ Эксперт хийхийн тулд ШУА бүрэн биеэ даасан, чөлөөт эрдэмтдийн индэр, жинхэнэ оюуны хүч үздэг цэвэр номын байгууллага байх ёстой. Манай шударга академичид ШУА бол үндэсний шинжтэй хамгийн ардчилсан байгууллага байх ёстой гэдэг. Би үүнтэй 100 хувь санал нэг байна.
- ⊗ ШУА улс орны хөгжлийн бодлогын асуудал огтоос ярьдаггүй нь ийм учиртай, тойроод л байдаг, их л бодож, хэдэн хүрээлэнгийн ажлын тайланг ярьдаг.
- ⊗ Ерөнхийлөгч Д.Баатар “ШУА-ийг шинэчлэх цаг нь болсон, хүрээлэнгүүдийг нэгтгэмээр байна, хэдэн хөгшин хүний дарамтаас залуусыг гаргая” гэж ил тод хэлсээр байгаа.
- ⊗ ШУА -н салбарын бага чуулганыг одоо татан буулгах хэрэгтэй. Эрх мэдэл байхгүй, алаг цоохор бүрэлдэхүүнтэй, сэтгэлгээний хоцрогдолтой, нийгэм, эдийн засаг, байгаль орчныг хамгаалах зэрэг улсын чанартай асуудлыг шийдвэрлэх өндөр мэргэжлийн бүрэлдэхүүнгүй байна.
- ⊗ Эрдэм шинжилгээний жирийн ажилтан гадаадад явж туршлага судлах, гаднын лабораторид очиж ажиллах боломж хаалттай. Лав л манай нийгмийн шинжлэх ухааны салбарт хаалттай байна. Хэн явдаг вэ гэхээр захирал нь л явдаг.
- ⊗ ШУА-д гишүүнээр элсэх гарааны босгууд нь өөр өөр болсон нь таарамжгүй хэрэг. Гэтэл насаараа шинжлэх ухаанд зүтгэсэн, Монголын шинжлэх ухаанд асар их юм хийчихсэн хүнийг ШУА гишүүнээрээ авдаггүй нь дэндүү шударга бус зүйл.
- ⊗ Хариуцлага, албан тушаал хүлээж чадаж байгаа нөхцөлд ямар нутгийнх байх нь уг нь хамаагүй. Нутгархаж бүлэглэлгүй ажлаа л хийх ёстой. Харамсалтай нь ингэхгүй байна. Ерөөсөө ШУА-д жижиг, дунд феодалууд олширчихсон. Тэд өөрийн дор байгаа эрдэм шинжилгээний ажилтнуудыг дарангуйлдаг, дарамтлагчид болж хувирчээ.
- ⊗ Сүүлийн жилүүдэд ШУА -д нийгмийн хөгжлөө дагаад олигтой шинэчлэл хийгдэхгүй, олон улсын жишгээр өөрчлөгдөхгүй, социализмын үеийнх шигээ бахь байдгаараа байсаар байна. Зарим талаар өмнөх үеэсээ ч дорджээ. Энэ бүгд удирдлагын буруу юм.

- ⊗ ШУА-ийн удирдлага бидний төсвийг битгий хасаач, бид нар ажилгүй болох гээд байна “гэсэн амин хувиа бодсон элдэв шаардлага нийтлэл захиалгаар бичүүлж, сонинд нийтлүүлэхээс өөр ажил хийхээ больжээ.
- ⊗ Тэд хэзээ ч өөрсдөө юм бичихгүй, харин харьяа хүрээлэнгүүдэд үүрэгдэн явуулж хариуг нь бичүүлж аваад өөрсдөө нэрээ тавьж илгээдэг л ажилтай. Үүнийгээ их ажил хийчихлээ гэж боддог бололтой.
- ⊗ ШУА-ийн удирдлагад буй өөр нэг дампуурал бол судалгааны төсөл юм. БСШУЯ-ны Технологийн сангаас шалгаруулдаг төслөөр тэд хангалуун амьдардаг гэж хэлэхэд хилсдэхгүй. Харьяа хүрээлэн болон их сургуулиудын оруулж ирсэн төслийг хэлэлцээд цөөнгүй хэсгийг нь унагана. Төслөө дэмжүүлэхийн тулд эрдэмтэд удирдлагад буй тэдгээр хүмүүсийн нэрийг төслийн удирдагч болгон тавиад дараа жил нь дахин оруулж ирнэ. Ингээд уг төсөл батлагдаж, тэр дарга цалин дээрээ төслийн цалин нэмж авна. (Энэ бол жинхэнэ авилга мөн). Төслөөр хийсэн судалгааны нүсэр ажилд ганц ч үг ган хийгээгүй байж хэвлэгдсэн ном товхимол дээр нь даанч нэг ичихгүй нэрээ тавиулна.
- ⊗ Тэр ч байтугай залуу эрдэм шинжилгээний ажилтнуудад өгөх ёстой бичил төсөл гэгддэг бага хэмжээний ажлыг хүртэл удирдлагад буй хүмүүс хуу хаман дээрэмдээд авчихсан тууж явдаг. (Авилга бүр цагаандаа гарчээ). Түүнээсээ ичиж зовж байгаа юм огт байхгүй.
- ⊗ ШУА-ийн удирдлагад буй удаахь дампуурал бол Академич ба түүнийг тойрсон бүхэл бүтэн архагшсан тогтолцоо юм. Ямарч үнээр хамаагүй академич болох гэсэн шуналт хүсэл газар авч, тэр хэрээр шинжлэх ухааныг гутаан доромжилж байна. Албан тушаалаа ашиглаж, бас нэр сүрээр далайлгаж болсон академичид, хийсэн олигтой ном, эрдмийн ажил бүтээлгүй атлаа санал өгдөг өвгөн академич нарыг мөнгөөр худалдан авч академич болсон хүмүүс гээд зүй бус үйлдлүүд бидний нүдэн дээр ил тод явагдсаар тун удаж байна”
- ⊗ ШУА -ийн сүүлийн хориод жилийн удирдлага гэж урагшгүй, шинжлэх ухааны менежментийг гадарладаггүй шахам, хувийн доголдолтой, санаачлага муу нөхдүүд байна.
- ⊗ ШУА гэдэг байгууллагын бүх юм утгаа алдсан. Энхтүвшин ерөөсөө мэдэхгүй байна л даа. Би өөрт нь хэлээд ад болсон хүн. Ийм байдалтай эвлэрч болохгүй. Мафи болчихсон, цаагуураа яриад л, тэрүүхэндээ хэдэн хүн хуйвалдаад асуудлыг шийддэг байх жишээтэй.
- ⊗ Шинжлэх ухааны хүрээлэн, төвүүдийг удирдах чадамж боломжоо ШУА өнөөдөр нэгэнт алджээ. Ширэндэв гуайн үед өөр байсан, түүний дараах ерөнхийлөгч нарын үед ч өөр байсан. ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулиас хойш ШУА-ийн удирдлагад байсан хүмүүс шинжлэх ухааныг урагшдуулчих хэмжээний юм хийж чадаагүй. Ингэж хэлбэл уурладаг л юм гэсэн. Уурлаад яах вэ, эх орны төлөө ярьж байгаа болохоос хэдхэн хүний тухай яриагүй. Манай Монголд тэр өөрчлөлтийг хийхэд маш амархан. Одоо Засгийн газрын тогтоол гаргаад бүх хүрээлэн, төвийг БШУЯ-ны харьяанд шилжүүлэх хэрэгтэй. Төр өөрийнхөө юмыг өөртөө авах хэрэгтэй шүү дээ. Тэгвэл бүх асуудал өөрийнхөө горимоор явагдана.
- ⊗ ШУА -н үеийн удирдлагуудын үйл ажлыг ерөнхийлөн дүгнэвээс: Б. Ширэндэв. 1961-1982 он. ШУА -г залуусаар бэхжүүлж, хөл дээр нь босгосон хүн. ШУА-н алтан үе. Ч.Цэрэн. 1983-1986 он. ШУА -д өөрчлөлт хийх шинж илэрсэн. Д.Содном, 1987-1990 он. ШУА-ийн ажлыг зогсонги байдалд оруулсан "унтаа" ерөнхийлөгч. Д.Баатар. 1990 - 1995 он. Зогсонги байдал хэвээр үргэлжилсэн, Б.Чадрээ 1995 - 2008 он. ШУА-н уналтыг эхлүүлж, эмх замбараагийг нь алдуулж, бантагнуулсан овжин хүн. ШУА -г арга залиар удирдаж болохгүй ээ. Б.Энхтүвшин 2009-2014 он. ШУА -н үйл ажиллагааг дуусгавар болгож буй, эрдмийн хамт олонд гологдсон хүн.
- ⊗ Одоо бол “Үнэхээр мундаг эрдэмтэн ШУА-ийн гишүүн-академич болжээ” гэх хүн алга болж. Яагаад гэвэл бохир замаар гишүүн болдог болсон учраас. Хээл хахууль, нутгархах, бүлгэрхэх арга хэрэглэх, хор найруулах замаар гишүүн болдгийг хэн хүнгүй мэдэх болжээ. ШУА-д ийм муухай байдал бий болсныг академич Норовсамбуу багш маань ихэд харамсан ярьдаг байсан. Сумъяабаатар, Хүрэлбаатар (Хэл зохиолын хүрээлэнд ажиллаж байсан нэртэй эрдэмтэд) хоёр шиг жинхэнэ эрдэмтдийг цаадуул чинь хэзээ ч гишүүн болгохгүй дээ гэдэг байж билээ.

**Шинжилгээ №7. ШУ-ныг практикт нэвтрүүлэх талаарх саналууд**

- ⊗ Шинжлэх ухааны ололт амжилтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг Монгол Улсад шинжлэх ухааны парк (Science Park) байгуулах замаар шийдэх нь хамгийн зөв зам болно. Эл шинжлэх ухааны парк нь зээл, татвар болон гаалийн нэн таатай орчинд ажиллах шаардлагатай юм. Үүнийг л төр засаг бодлогоороо хийж дэмжиж өгөх хэрэгтэй болоод байна. Ийм таатай орчин бүрдсэн тохиолдолд манай эрдэмтэн судлаачид аяндаа өөрсдөө компаниа байгуулаад, эрсдэлээ үүрээд үйл ажиллагаагаа эрхлээд шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлээд явчихна. Шинжлэх ухааны паркаа байгуулах нь хамгийн зөв зам. Даанч энэ асуудал мөн л цаасан дээр гацчихлаа.
- ⊗ Судалгааг үйлдвэрлэлийн салбарынхан иноваци гэж үздэг бол суурь судалгааныхан хөгжил гэж хардаг.
- ⊗ Монгол эрдэмтний санаачилсан технологиор бүтээгдэхүүн хийе гэхэд манайд үйлдвэрийн бааз байхгүй. Эрсдэл гаргаад өндөр түвшний технологиор сайн бүтээгдэхүүн хийх түвшинд манай бизнесмэнүүд хүрээгүй байна. Хамгийн гайгүй компани нь гадаадын сайн гэсэн технологийг импортолдог. Түүнээс доод түвшнийх нь гаднын энгийн, хуучирсан технологийг оруулж ирдэг.
- ⊗ Манай үйлдвэр, бизнесийн салбар технологийн мэдрэмж суугаагүй байна. Энэ ашигтай шинэ технологи байна. Үүнийг аваад нэвтрүүлье гэсэн бодолтой үйлдвэрлэгч байхгүй. Үйлдвэрлэгч, бизнесмэнүүд ямар нэг үйлдвэрлэл эхлэхдээ гадаадаас техник, шугамтай нь авчирч тавиад л хийнэ гэсэн сэтгэхүй давамгайл байна. Жишээлбэл, Төв аймгийн Дэрст хотгор хэмээх газарт цагаан сарын өмнө утаагүй шахмал түлшний үйлдвэр ашиглалтад орсон шүү дээ. Улаанбаатар хотын утаагүй түлшний 50-иас дээш хувийг хангах хүчин чадалтай үйлдвэр. Олон тэрбум төгрөгөөр үйлдвэр байгуулсан ч түлш нь гарахгүй гацаж байна. Монголынхоо нүүрсийг судалсан эрдэмтдээ оруулахгүй, тэр үйлдвэр нь Монголын нүүрс хэрэглэхэд яаж тохирохыг судлаагүйгээс ийм байдалд хүрч байна. Технологийн мэдрэмжтэй хүн бол монгол нүүрсийг яаж утаагүй болгох вэ, яаж барьцалдуулах вэ, яаж утаагүй болгох вэ гэдгээ бодох ёстой. Хятадад хэвийн ажиллаж байсан үйлдвэрийг Монголд оруулахад нүүрс нь тохирохгүйгээс үйлдвэр нь ажиллахгүй байна. Тийм сайхан санаа гаргаж хөрөнгө оруулалт хийсэн нь үр дүнгээ үзэж чадахгүй болж байгаа нь харамсалтай. Энэ бүхэн бизнесийнхэнд технологийн мэдрэмж суугаагүйтэй шууд холбоотой. Гэтэл нэг инженер залуу Химийн хүрээлэнд ямарч цалингүй хоёр жил ажиллаад, нүүрсэн дээр ажилладаг хүмүүсийн асуух юмаа асуугаад хамтарч технологи боловсруулаад шахмал түлшний жижигхэн үйлдвэр байгуулсан. Тэр түлшний чанарын түвшин маш сайн. Энэ өвөл ганцхан тэр үйлдвэрийн түлш маш сайн борлогдсон. Галд түлэхэд маш сайн асна, хортой утаа бага, бутарч үйрэхгүй. Энэ мэт Монголынхоо түүхий эдэд суурилсан үйлдвэрлэл цаашаа явах төлөвтэй байна. Агаарын бохирдлыг бууруулах “Цэвэр агаар” сангаас ахиухан мөнгө өгвөл ирэх өвөл Улаанбаатар хотын нүүрсний хэрэгцээний арван хувийг хангах үйлдвэрлэл явуулмаар байна гээд л яваад байгаа. Том бизнесмэнүүд ийм төсөл дээр хамтраад ажиллавал улсдаа ч, хувь хүндээ ч, Улаанбаатарын иргэдийн уушгинд ч ашигтай. Ийм жишээ олон байна. Нүүрсээр жишээлэхэд л ийм байна
- ⊗ Улс орны эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, дэлхийн шинжлэх ухааны ололт амжилтыг ашиглаж байгаа байдал, ирээдүйн чиг хандлага зэргийг үнэлж цэгнэж үзээд манай судлаачдын нэгэнт бий болсон технологиудыг ашиглах, гадаадын өндөр технологийг нутагшуулан шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, шинэ үйлчилгээ бий болгох зорилгоор эх орондоо шинжлэх ухааны парк байгуулах нь энэ салбарын өнөөдрийн нэн тэргүүний зорилго болоод байна.

**Шинжилгээ №8. Эрх зүйн орчны талаар**

- ⊗ Инновацийг бүрэн хэмжээнд идэвхжүүлэх эрх зүйн орчин манайд байхгүй. Гарааны компани эрх зүйн орчноос болоод хөгжиж чадахгүй байна. Инновацийг хөгжүүлбэ гэж зоригловол юуны өмнө дэлхийн жишигт нийцсэн хууль гаргах ёстой. Гарааны компаниуд байгуулаад хоёр жил болсон ч яг тэр шугамаасаа цааш алхаж чадахгүй байгаа.

- ⊗ "ШУА-ын статусын хууль" нь Монгол улсын суурь хэдэн хуулиудыг зөрчиж буй "Монополь байгууллагын хууль" болсон байна. Монгол улсад тусгай хуультай, төрөөс санхүүждэг байгууллага ШУА-аас өөр алга. Энэ хуулиар ШУА төрийнх ч юм шиг, биш ч шиг, ТББ мөн ч юм шиг, биш ч юм шиг болгожээ.
- ⊗ Шинжлэх ухааны хэдэн зуун докторыг дотор нь "хязгааргүй онцгой эрхтэй хэдэн академич", "эрх, хүндэтгэл, хөнгөлөлт, тэтгэлэг байхгүй докторууд" болгож 2 хуваасан. Энэхүү алдаатай хуулийг ардчилсан нийгэм, эдийн засгийн шинэ уур амьсгал бүрдсэн өнөөдрийн нөхцөлд хүчингүй болгох ёстой.
- ⊗ Шинжлэх ухаан, технологийн тухай" хууль хэт ерөнхий, агуулга султай учраас өнөөдрийн гажуудал, анархи байдал үүсэхэд дөхөм үзүүлэв. Түүнд ШУА-ийн статусын хууль бүр ч нэрмээс болсон. Муу хуулиудаас болж ажил завхардаг аж.
- ⊗ ШУА-ийн гишүүн сонгодог хуучин тогтолцооны 1964 оны журмыг хүчингүй болгож ардчиллын ил тод систем рүү шилжүүлэх шаардлагатай. Одоогийн нууц санал хураалтын журам нь тооллогын комиссын далд үйл ажиллагааны будлиан, хуйвалдаан хээл хахууль, авилгалын эх үүсвэр болов.
- ⊗ БШУЯ -аас хийх гэж буй шинэчлэлтэйгээ уялдуулан ШУА-ийн дүрэм, журам, хууль эрхзүйн баримт бичгүүдийг эргэн харж хүчингүй болгох асуудлыг УИХ, Засгийн газарт өргөн барьж болох байна. Ер нь ШУА гэдэг хоёрдмол байдалтай, утгагүй байгууллага байхын хэрэг байна уу, үгүй юу гэдгийг эрдэмтдийн референдумээр шийдвэрлэхэд болохгүй нь юу байна.
- ⊗ Аливаа нийгэм хууль, эрх зүйн орчин нь сайн байж хөгжиж дэвждэг. Шинжлэх ухааны салбарт ч адил. Өнөөдрийн байдлаар эл салбарын эрх зүйн баримт бичгүүд болох Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Технологи дамжуулах тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль, Инновацийн тухай хууль, Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө, Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр зэрэг нь харьцангуй сайн боловсрогдсон.
- ⊗ Ойрын үед Төрөөс шинжлэх ухаан. Технологийн талаар баримтлах бодлогыг шинэчлэх, Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг боловсруулан Засгийн газарт оруулж батлуулах ажил хийгдэнэ. Монгол Улсад үндэсний инновацийн тогтолцоог 2008-2015 онд хэрэгжүүлэх хөтөлбөр хэрэгжиж дууссан тул шинэчлэх шаардлагатай байгаа.

#### **Шинжилгээ №9. ШУ-ны цаашдын хөгжил**

- ⊗ Шинжлэх ухааныг хөгжүүлэх гол бодлого, чиглэлийг тэр салбарт ажиллаж байгаа “жаргал, зовлонг” нь гадарладаг тэргүүний эрдэмтэн, судлаачид л тодорхойлдог.
- ⊗ 1996 оны биш 2006 онд ЮНЕСКО-гийн зөвлөмж дахиад ирсэн. Тэр чиглэлээр явъя гэж бид Отгонбаярыг сайд байхад яамандаа санал тавьсан. Тэр бол илүү орчин үеийн чиг хандлага тусгасан зөвлөмж. Гол зорилго нь шинжлэх ухааны салбараас улс орны эдийн засагт оруулж байгаа хувь нэмрийг нэмэгдүүлэх л явдал.
- ⊗ Шинжлэх ухааныг эрэлтэд тулгуурлаж хөгжүүлмээр байна.
- ⊗ Хүрээлэнгүүдийг Их сургуулиудад нэгтгэснээр эрдэмтдийн нэгдсэн хүчирхэг баг бий болно. Ингэснээр бүтээмжийг дээшлүүлэх боломжтой.
- ⊗ Урагшаа хөгжихийн тулд ирээдүйг л харах хэрэгтэй. ШУА-ийг Их сургуулиудтай нэгтгэх нь зөв.
- ⊗ Академийг Үндсэн хуулийн заалтад нийцсэн чиглэлээр төрийн бус болгочихвол тэгээд боллоо.
- ⊗ Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн.
- ⊗ Төр тодорхой эрсдийг даагаад энэ хоёр салбарыг ойртуулахгүй бол хоёр тийшээ харчихаад байна. Итгэлцэл бий болсны дараа үйлдвэрлэлийн шатанд технологийн суурь сайжирдаг. Тэгээд эрдэмтдийн бүтээлд хандах нийгмийн хандлага сайжирдаг.
- ⊗ Хэзээ ч суурь судалгааг компаниуд захиалдаггүй л байхгүй юу. Зөвхөн эрэлт хэрэгцээний үндсэн дээр шинжлэх ухааныг хөгжүүлнэ гэдэг нь суурь судалгаа хийх газаргүй болно гэсэн үг. Суурь судалгаа гэдэг олон жилийн дараа үр дүн нь гардаг ч орхиж болохгүй чухал зүйл.

- ⊗ Төр, нийгэм суурь шинжлэх ухаантай байна гэвэл шинжлэх ухаанд өөрийгөө зориулсан эрдэмтдийг дэмжих шаардлагатай.
- ⊗ Дэлхий дээр байгалийн шинжлэл болон шинжлэх ухааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын жагсаалт гарсан. Үүнийг дүгнэхдээ СС гэсэн индексээр тухайн байгууллагын ажил, судалгааны материалыг үнэлдэг. Дэлхийн шилдэг 200 байгууллагыг зарлалат тэнд нь Монгол улсын ШУА багтаж чадаагүй. Тэр ч байтугай Азийн шилдэг 200 байгууллагад ч багтаж чадаагүй. Энэ нь манай ШУА-ийн ажил хангалтгүй, шинжлэх ухааны салбар дорой байгааг харуулж байгаа юм л даа.
- ⊗ Манай эрдэмтэд маань улсынхаа төлөө, нийтийн төлөө дуугарахаар түүнийг нь дэмждэг хүн, байгууллага үндсэндээ алга.
- ⊗ Монголын шинжлэх ухааныг эрчимтэй хөгжүүлэхийн тулд бүтцийн маш гүнзгий өөрчлөлт хийх хэрэгтэй. Тэгэхгүйгээр Монголын шинжлэх ухаан урагшаа алхаж чадахгүй.

Үүнээс үзвэл ШУ-ныг хөгжүүлэх бодлого, гол чиглэлийг тодорхойлоход эрдэмтэд, судлаачдын санаа бодолд суурилах, ШУ-ыг хөгжүүлэхэд суурь судалгааг анхаарч, орхихгүй авч явах, эрдэмтдийг дэмжих, ШУ-ыг эрчимтэй хөгжүүлэхийн тулд бүтцийн гүнзгий өөрчлөлтийг хийх, ШУ-ны судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах, үүний тулд төр бизнесийн болон шинжлэх ухааны салбарыг холбож өгөх, ШУ-нд зарцуулж буй санхүүжилтийг нэмэгдүүлэх гэсэн байр суурийг илэрхийлжээ.

ШУ-ны хөгжлийг бүтцийн өөрчлөлттэй холбон авч үзэж буй **хоёрдугаар бүлэгт хамаарах хүмүүсийн хувьд ШУА-ийг бүх эрдэмтдийн нэгдсэн ТББ болгон ШУА-ийн хүрээлэнгүүдийг Их сургуулиудтай нэгтгэх, эрдэмтдийг нэг дор цуглуулж хүчтэй баг бүрдүүлэх нь судалгааны бүтээмжийг дээшлүүлнэ гэж үзсэн бол нөгөө бүлэг нь ШУ-ны салбарыг эдийн засгийн эрэлт нийлүүлэлтийн дагуу удирдах, суурь судалгааг орхигдуулахгүй авч явах, ШУ-ны судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэнд оруулах, үүний тулд төр бизнесийн болон шинжлэх ухааны салбарыг холбож өгөх, ШУ-нд зарцуулж буй санхүүжилтийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзжээ.**

- ШУ эрчимтэй хөгжүүлж, үр ашиг бүтээмжийг нь сайжруулахад бүтцийн шинэчлэл хамгийн чухал нөлөөтэй.
- ШУ-ыг хөгжүүлэхэд ШУ-д зарцуулж буй санхүүжилтийг нэмэгдүүлэх нь чухал нөлөөтэй.
- ШУ-ныг хөгжүүлэхэд ШУ-ны салбарт ажиллаж буй эрдэмтэн, судлаачдыг дэмжих нь чухал нөлөөтэй.

### **Зөрчилтэй байр суурь**

**Нэгдүгээр бүлэг, ШУА-ийг бие даасан байдлаар хөгжүүлэх нь зөв гэж үзсэн бүлэг**

**(Бүлэгт хамаарах хүмүүс:** Академич Ш.Болд, МУИС-ийн Цөмийн судалгааны төвийн захирал, профессор С.Даваа, УИХ-ийн гишүүн, БСШУ-ны сайд А.Гантөмөр, Философийн хүрээлэнгийн захирал, академич Г.Чулуунбаатар, ШУА-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга, академич Т.Галбаатар, ШУА-ийн Үйлдвэрчний эвлэлийн дарга Ш.Баяр, Академич Д.Амарсайхан, Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, академич, геологи-эрдэс судлалын шинжлэх ухааны доктор (Sc.D) О.Төмөртогтоо, Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, академич Б.Энхтүвшин, Шинжлэх ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал, академич Л.Болд, Хууль зүйн ухааны доктор, академич С.Нарангэрэл, ШУА-ийн Бага чуулганы гишүүн, Философийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга М.Золзаяа, БСШУЯ-ны Шинжлэх ухаан, бодлого зохицуулалтын газрын дарга Ж.Даваасамбуу, ШУА-ийн тэргүүн дэд ерөнхийлөгч, академич Д.Рэгдэл, ардын багш, доктор, профессор С.Галсан)

1. ШУА-ийн бүтэц зохион байгуулалтын талаарх санал

**Нэгд,** ШУА, ШУА-ийн хүрээлэнгүүдийг бие даасан хэлбэрээр нь үлдээж харин давхардлыг арилган зарим ижил, төстэй судалгаа хийдэг хүрээлэнгүүдийг нэгтгэх байдлаар бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх хэрэгтэй,

**Хоёрт,** ШУА, түүний хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэлгүй бие даасан хэлбэрээр үлдээж, харин их дээд сургуулиудын харьяанд шинэ хүрээлэн, судалгааны төвүүдийг дэс дараатай байгуулах хэрэгтэй.

**Гуравт,** ШУА-ийн зарим хүрээлэнгүүдийг тухайлбал математикийн хүрээлэнг их сургуультай нэгтгэж байсан түүхтэй. Гэвч тэдгээр хүрээлэнгүүд сайжран, хөгжих нь битгий хэл хаалгаа барьж татан бууяйсан байдаг. Ийм ирээдүй бусад хүрээлэнгүүдийг хүлээж байх эрсдэлтэй.

2. ШУ-ны санхүүжилт, санхүүгийн менежментийн талаарх санал

**Нэгд,** ШУ, ШУ-ны байгууллагад олгогдож буй санхүүжилт бага байгаа бөгөөд эрдэм шинжилгээний ажилчдын цалингийн дундаж их дээд сургуулийн багш нарын цалингийн дунджаас даруй 2-3 дахин бага байна гэж үзжээ. ШУА-д эерэг болон сөрөг үнэлгээ өгч буй хоёр бүлэг эрдэм шинжилгээний ажилтнуудын цалинг өсгөх хэрэгтэй гэсэн байр суурьт санал нэгдсэн байлаа.

**Хоёр,** Судалгааны ажлын санхүүжилт, чанар үр дүн хоёр хоорондоо шууд хамааралтай.

**Гурав,** ШУ-ны ажилд зарцуулагдаж буй төсвийн хэмжээг дотоодын нийт бүтээгдэхүүний 0,16 - 0,26 орчим хувьтай байна. Олон улсын жишгээр улс орнууд шинжлэх ухааныхаа санхүүжилтэнд дотоодын нийт бүтээгдэхүүний 0,66-4.2 хувьтай тэнцэх хэмжээтэй байдаг байна. Манай улсын холбогдох хууль тогтоомжид шинжлэх ухааны санхүүжилтийг дотоодын нийт бүтээгдэхүүний 1,5 хувьтай тэнцэхээр байна гэж заасан байдаг байна. Эрдэмтдийн үзэж байгаагаар шинжлэх ухааны санхүүжилтийг дунджаар 3-5 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

**Дөрөв,** Санхүүгийн менежментийн хувьд ШУА болон ШУА-ийн хүрээлэнгүүдийн төсвийг төрийн сангийн тогтолцооноос гаргах; эсвэл зөвхөн улсын төсвийн дэмжлэгээ төрийн санд үлдээж үйл ажиллагааныхаа орлогоор санхүүгийн менежмент хийх боломжийг нь бүрдүүлж арилжааны банкинд данстай болгох хэрэгтэй. ШУА-ийн ерөнхийлөгчийг харьяа хүрээлэнгүүдийн төсвийн шууд захирагч болгох.

**Тав,** Академич нарт олгодог мөнгөний талаар Монгол Улсын хэмжээнд 63 академич бий. Тэд насаараа шинжлэх ухаанд өөрсдийгөө зориулж бүтээл туурвисныхаа хариуд нэмэгдэл гэж 300-530-800 мянган төгрөг авдаг. Энэ бол олгох ёстой мөнгө тэтгэлэг, хэрвээ энийг өгөхгүй гэж байвал академич гэдгээ хураагаад авчихсан нь дээр.

3. ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үнэлгээ, үр дүнгийн талаар

**Нэгдүгээр бүлэгт хамаарах эрдэмтэд:**

**Нэгд,** Иргэд олон нийт бол ШУ-ны судалгаа, ажлын үр дүнг шууд нүдэнд баригдаж, харагдах ёстой гэж үздэг. Харин судалгаа, шинжилгээний ажлын үр дүн тэр бүр нүдэнд харагдаж, баригдаад байх нь ховор. Ялангуяа суурь судалгааны үр дүн цаг хугацаа их зарцуулж, бусад хэрэглээний судалгаа, шинжилгээний суурь болох зэргээр илэрдэгийг иргэд тэр бүр ойлгохгүй, энэ талаарх ойлголт хомс байна.

**Хоёрт,** нийгмийн шилжилтийн үйл явцаас улбаатай ард түмний амьдрал маш их доройтсон. Ийм үед хүмүүс шинжлэх ухаанд итгэхээс илүү элдэв мунхруулга, мухар сүсэгт итгэж байна. Нийгэмд шинжлэх ухааныг хүлээж авдаг уур амьсгал сүүлийн 20 гаруй жилд их муудсан.

**Гуравт,** эрдэмтэд мөнгөгүйгээс ажлаа сурталчилж чадахгүй байгаагаас нийгмийн үнэлэмж тааруу, олон нийт энэ салбарын талаар өрөөсгөл дүгнэлт өгөхөд хүргэж байна.

**Дөрөвт,** Монгол Улсын шинжлэх ухааны салбар эдийн засгийн өгөөжгүй байна. Гэтэл дэлхийн мэдлэгийн үйлдвэрт оруулж байгаа өгөөжийг яаж үнэлдгийг бид мэддэггүй. Үүгээр үнэлж үзэх ёстой.

**Тав,** ШУ-ны салбар ажиллаж буй хүний тоо, мөнгө санхүүжилттэйгээ харьцуулахад ашигт үйлийн коэффициентийн хувьд дэлхийн дунджаас өндөр байгаа ч үйлдвэрлэлд нэвтрүүлэх үзүүлэлтийн хувьд дунд зэргийн хөгжилтэй орноос ч их хоцорч байна.

**Зургаа,** ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг сайн гэж үнэлэж байна. ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг үнэлэхдээ үр дүнг гадаад, дотоодод хэвлүүлсэн өгүүлэл, илтгэлийн тоо, эзэмшиж байгаа патент, технологи, стандартын тоогоор үнэлэхээс аргагүй.

4. ШУА, их болон бага чуулган үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар үнэлэхдээ

**Нэгд,** Манай улсын шинжлэх ухааны салбар, хүрээлэнгүүд мэдлэг, чадавч бий болгох, иргэдийн оюуны хэрэгцээнд үйлчлэх зэрэг үүргээ хангалттай сайн биелүүлж байгаа гэж дүгнэсэн байна.

**Хоёр,** ШУА-ийн хувьд улсын хөгжлийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах үүргээ харьцангуй сайн биелүүлж байгаа боловч энэ нь захиалагч, хэрэглэгчээс хамааралтай тул бүрэн хангаж байгаа гэж хэлэхэд хүнд. Харин төрийн томоохон төслүүдэд эксперт хийх эрх нь байдаггүй тул хэрэгждэггүй.

**Хоёрдугаар бүлэг, ШУА-ийг их сургуультай нэгтгэх нь зөв гэж үзсэн бүлэг**

**(Хоёрдугаар бүлэгт хамаарах хүмүүс:** гавьяат эдийн засагч Н.Дашизэвэг, гавьяат багш, доктор, профессор Ц.Дэмбэрэл, Г.Эрдэнэжав, Д.Баатар, С.Даидаваа, Ц.Жамц)

1. ШУА-ийн бүтэц зохион байгуулалтын талаарх санал

**Нэгд,** ШУА-ийн хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэх, ШУА-ийг Их, дээд сургууль, хүрээлэнгүүд, хувийн хэвшлийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг хамааруулсан, бүх эрдэмтдийн нэгдсэн ТББ байгууллага болгох,

**Хоёрт,** ШУА, түүний хүрээлэнгүүдийг их сургуультай нэгтгэснээр эрдэмтдийн хүчтэй баг бий болох, ингэснээр эрдэм шинжилгээний ажлын бүтээмж, үр дүн сайжрах боломжтой.

2. ШУ-ны санхүүжилт, санхүүгийн менежментийн талаарх санал

**Нэгд,** ШУ, ШУ-ны байгууллагад олгогдож буй санхүүжилт бага байгаа бөгөөд эрдэм шинжилгээний ажилчдын цалингийн дундаж их дээд сургуулийн багш нарын цалингийн дунджаас даруй 2-3 дахин бага байна гэж үзжээ. ШУА-д эерэг болон сөрөг үнэлгээ өгч буй хоёр бүлэг эрдэм шинжилгээний ажилтнуудын цалинг өсгөх хэрэгтэй гэсэн байр суурьт санал нэгдсэн байлаа.

**Хоёрт,** Хэсэг хүмүүс бие биенээ академич гэж өргөмжлөөд мөнгө авч байгаа нь боловсон дээрэм, ийм мөнгө өгөх нь байж болохгүй зүйл, үүнийг болиулах шаардлагатай.

3. ШУА, хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны үнэлгээ, үр дүнгийн талаар

**Нэгд,** ШУА-ийн хүрээлэнгүүдийн ажлын үр дүн буурч байгаа бөгөөд үнэлгээ тааруу байна. ШУА-ийн үр дүн, үйл ажиллагааг үнэлэхдээ хэдэн ном, өгүүлэл, илтгэлийн тоогоор бус үр дүнд хүрсэн онол, арга зүйгээр үнэлэх хэрэгтэй. Мөн ШУ-ны үр дүнг үнэлэхдээ зөвхөн дотоодод гаргасан амжилт, нөлөөлөл, үр ашиг зэргийг харалгүй гадаадад, дэлхийн шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмэр, гаргасан амжилтаар нь үнэлэх нь зүйтэй.

**Нэгдмэл байр суурь**

**Хүний нөөцийн талаар байр суурь:** ШУ-ны хүний нөөцийн асуудал ярилцлагуудад нэлээд хөндөгдсөн байна. Ингэхдээ хоёр бүлэг хоёулаа хүний нөөц дутмаг, эрдэм шинжилгээний ажилтнуудын тоог нэмэгдүүлэх шаардлагатай гэдэг дээр санал нэгтэй байлаа.

**ШУ-ны ажилд зарцуулагдаж буй төсвийн талаарх хандлага:** Ярилцлагад оролцогчдын дийлэнх нь ШУ, ШУ-ны байгууллагад олгогдож буй санхүүжилт бага байгаа дээр санал нэгтэй байлаа. Түүнчлэн эрдэм шинжилгээний ажилчдын цалингийн дундаж их дээд сургуулийн багш нарын цалингийн дунджаас даруй 2-3 дахин бага байна гэж үзжээ. ШУА-д эерэг болон сөрөг үнэлгээ өгч буй хоёр бүлэг эрдэм шинжилгээний ажилтнуудын цалинг өсгөх хэрэгтэй гэсэн байр суурьт санал нэгдсэн байлаа. Төр болон ШУ хоорондын харилцаа холбоо ямар байх ёстой талаарх байр суурийн хувьд нэгдмэл байна. Ингэхдээ ШУ нь төрөөс хараат бус, улс төржилтөөс ангид байх ёстой гэж үзжээ.

## 3.2. Экспертийн асуулгын нэгдсэн дүн

Σ=105

## 1.Таны нас:

№	Насны бүлэг	Давтамж	Хувь
1	26-34	11	10.5
2	35-44	23	21.9
3	45-54	22	21.0
4	55-64	28	26.7
5	65-аас дээш /77/	21	20.0
6	Бүгд	105	100

## 2. Хүйс:

		Давтамж	Хувь
1	Эрэгтэй	57	54.3
2	Эмэгтэй	48	45.7
	Бүгд	105	100.0

## 3. Эрдмийн зэрэг, цол

		Давтамж	Хувь
1	Магистр	22	21.0
2	Доктор (Ph.D)	53	50.5
3	Доктор (Sc.D)	11	10.5
4	Академич	19	18.1
	Бүгд	105	100.0

## 4. Таны ажилладаг байгууллага, газар?

код		Давтамж	Хувь
1	Хүрээлэн төв	89	84.8
2	Их, дээд сургууль	3	2.9
5	БСШУСЯ	6	5.7
6	ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар	7	6.7
	Бүгд	105	100.0

## 4.1. Ажиллаж буй байгууллагын харьяалал

код		Давтамж	Хувь
1	ШУА	62	59.0
2	ШУТИС	17	16.2
5	БСШУСЯ	1	1.0
6	ЭМЯ	6	5.7
7	ХААИС	12	11.4
8	АҮШУИС	1	1.0
9	Засгийн газар	6	5.7
	Бүгд	105	100.0

## 5.Таны ажиллаж буй шинжлэх ухааны салбар

		Давтамж	Хувь
1	Байгалийн ухаан	43	41.0
2	Техникийн ухаан	16	15.2
3	Хөдөө аж ахуй	13	12.4
4	Анагаах ухаан	8	7.6
5	Нийгмийн ухаан	16	15.2
6	Хүмүүнлэгийн ухаан	4	3.8
	Бүгд	100	95.2
	Хариулаагүй	5	4.8
	Бүгд	105	100.0

## 5.1 Таны ажиллаж буй судалгааны чиглэл

		Давтамж	Хувь
1	Шувуу судлал	1	1.0
2	Геологи, ашигт малтмал, эрдэс судлал	5	4.8
3	Биологи	3	2.9
4	Ургамал судлал, хог, ургамал судлал	4	3.8
5	Ойн судалгаа, ойн тооллого, модны механик шинж..	3	2.9

6	Нүүрс ус, занар, органик түүхий эд	1	1.0
7	Хими, байгалийн нэгдлийн хими, химийн инженер технологи	6	5.7
8	Газар хөдлөлт	1	1.0
9	Хэл шинжлэл, аман зохиол	5	4.8
10	Астраноми	1	1.0
11	Хөнгөн үйлдвэрийн судалгаа /нэхмэлийн үйлдвэрлэлийн хими-технологийн боловсруулалт,/	3	2.9
12	Уул уурхайн параметруудийг тооцох г.м	5	4.8
13	Мод боловсруулах техник, технологи	3	2.9
14	Чулуун зэвсгийн судалгаа	1	1.0
15	Цөмийн физик	1	1.0
16	Бодисын бүтцийн тухай физик онол	1	1.0
17	Физик	4	3.8
18	Нанотехнологи	1	1.0
19	Цацрагийн дозиметр	1	1.0
20	Геофизик	2	1.9
21	Археологи	1	1.0
22	Түүх	3	2.9
23	Улс төр	4	3.8
24	Газар зүй, геоэкологи	4	3.8
25	Соёл, угсаатан судлал	1	1.0
26	Олон улс судлал	4	3.8
27	Байгаль орчны доройтол, нөхөн сэргээлт	1	1.0
28	Философи, нийгэм, улс төрийн бодлого	1	1.0
29	Цахилгаан систем	1	1.0
30	Өвчлөлд уялдаат генийн хайлт	1	1.0
31	Нийгмийн эрүүл мэнд	1	1.0
32	Техник	2	1.9
33	Мал эмнэлэг, эм судлал, микробиологи, физиологи	3	2.9
34	Мал, амьтны халдваргүй өвчин судлал	1	1.0
35	Бэлчээр, тэжээл	1	1.0
36	МАА	2	1.9
37	Дотрын өвчин судлал	1	1.0
38	Малын тэжээлийн ургамлын генофонд	1	1.0
39	Халдваргүй эндемик өвчин судлал	1	1.0
40	Биотехнологи, молекул биологи	1	1.0
41	Мэдрэл судлал	1	1.0
42	Дотоод шүүрэл	1	1.0
43	Палентологи эртний амьтан ургамал, үр тоосонцор судлал	2	1.9
44	Үлэг гүрвэл	1	1.0
45	Эрчим хүч, дулааны эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, үйлдвэрийн экологи	1	1.0
	Бүгд	93	88.6
	Хариулаагүй	12	11.4
<b>Бүгд</b>		<b>105</b>	<b>100.0</b>

#### 6. Эрдэм шинжилгээний салбарт ажиллаж буй хугацаа

		Давтамж	Хувь
1	9 хүртэлх жил	14	13.3
2	10-19 жил	26	24.8
3	20-29 жил	19	18.1
4	30-39 жил	18	17.1
5	40-өөс дээш жил	15	14.3
	Бүгд	92	87.6
	Хариулаагүй	13	12.4
<b>Бүгд</b>		<b>105</b>	<b>100.0</b>

#### 7. Таны эрхэлдэг ажил, албан тушаал, зэрэг дэв?

	А. Ажил, албан тушаал	Давтамж	Хувь
1	Захирал	10	9.5

2	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	8	7.6
3	Салбар, нэгжийн эрхлэгч	23	21.9
4	Эрдэм шинжилгээний ажилтан	44	41.9
5	Гэрээт ажилтан	3	2.9
6	Зөвлөх	3	2.9
7	Их сургуулийн багш	1	1.0
8	БСШУСЯ-ны ШУТГ-ын мэргэжилтнүүд, удирдлага	6	5.7
9	ШУА-ийн тэргүүлэгчид, БЧ-ны ЭНБД нар	7	6.7
Бүгд		105	100.0

	Б. Зэрэг дэв	Давтамж	Хувь
1	Тэргүүлэх	46	43.8
2	Ахлах	15	14.3
3	Дэд ажилтан	30	28.6
	Бүгд	92	87.6
	Асуулт тохирохгүй	13	13.4
Бүгд		105	100.0

### ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР: ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

8. МУ-ын Үндсэн хуулинд “...шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” хэмээн заасан байдаг. Төрийн хамгаалалтад байна гэсэн энэ заалт хэрхэн хэрэгжиж байна вэ?

		Давтамж	Хувь
1	Бүрэн хэрэгжиж байгаа	3	2.9
2	Хэрэгжих талдаа	22	21.0
3	Хэрэгжих, хэрэгжихгүй аль аль нь байгаа	43	41.0
4	Хэрэгжихгүй талдаа	29	27.6
5	Огт хэрэгжихгүй байгаа	5	4.8
6	Хэлж мэдэхгүй байна	3	2.9
Бүгд		105	100.0

9. Салбарын харилцааг зохицуулагч бусад холбогдох хуулиуд Үндсэн хуулийн энэхүү үзэл санаанд суурилж чадсан эсэх талаарх Таны санал бодол, байр суурь?

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	Санаанд хүрээгүй, хэтэрхий ерөнхий, тодорхой тусгах шаардлагатай (тунхаглалын шинжтэй), тэр болгон тусгагдахгүй байна	11.9	12.6
2	ШУ технологийн хуулинд ШУА-ийн эрх үүргийг тодотгох	2.0	2.1
3	ҮХ-ийн үзэл санаанд нийцэж чадсан	13.9	14.7
4	Орсон боловч сайжруулах, боловсронгуй болгох шаардлагатай	9.9	10.5
5	ҮХ-ийн үзэл санаанд суурилагдах бус харин ч гадаадын үзэл санаанд суурилагдах талтай	1.0	1.1
6	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль нийцдэг	2.0	2.1
7	ШУ технологийн хууль боловсон хүчин бэлтгэх асуудлыг өрөөсгөл тусгасан	1.0	1.1
8	ҮХ-ийн үзэл санаанд суурилж чадаагүй	10.9	11.6
9	Төрөөс баримтлах бодлогод ШУ-нд үзүүлэх тусламж дэмжлэг хомс, санхүүжилт муу	1.0	1.1
10	Хуулиудын хоорондын уялдаа холбоог анхаарах	3.0	3.2
11	Хуулиудын авцалдаа муугаас салбар дундын харилцаа муу	1.0	1.1
12	ШУ-ны байгууллага, боловсролын хуулийн уялдаагүйгээс эрдэмтэд хамгаалалтгүй байна	1.0	1.1
13	Бичиг баримт хангалттай ч санхүүжилт гацдаг	1.0	1.1
15	Санхүүжилтийн зарчим зохицохгүй	2.0	2.1
16	Дагалдаж гарсан эрх зүйн актууд нь энэ үзэл санааг нарийвчлан тодотгож чадаагүй	2.0	2.1
17	ЭМЯ анагаахын ШУ-ны салбар хоёр дэндүү салангид, бие биенийхээ үгийг тоодоггүй.	2.0	2.1
18	Хууль байлаа ч хэрэгжүүлэхдээ муу	1.0	1.1
19	Төр хамгаалалтандаа аваагүй, төрийн зүгээс эрдэмтдийн хийж буй ажлыг мэддэггүй	1.0	1.1
20	Чадсан	1.0	1.1

21	МУ-ын ЗГ-ын зарим шийдвэр (2012-2016), Соёлын өвийг хадгалах хууль (2014) судалгаа шинжилгээ явуулахад саад болж, ҮХ-ийн үзэл санаанд суурилж чадаагүй	1.0	1.1
22	Төрийн өмч байх заалтанд нийцэхгүй байгаа. Одоо бол төрийн бус шахуу харьяалалтай байна.	1.0	1.1
23	ШУ, төр 2 тусдаа мэт оршиж байдаг учраас ҮХ-ийн энэхүү үзэл санаанд суурилж чадаагүй гэж үзэх боломжтой	1.0	1.1
99	Хэлж мэдэхгүй	28.7	30.5
	Бүгд	100.0	106.3

**10. ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн “МУ-ын ШУА нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага мөн. Академи нь төрийн ивээлд байна” хэмээн заасан нь ШУА-ийн статустай нийцэж байна уу, энэ талаар Та ямар бодолтой байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	ШУА-ийн статустай нийцэхгүй байгаа	24.0	25.3
2	ШУА бол засгийн газрын нэгж байх хэрэгтэй, яамны түвшний	2.0	2.1
3	Академи төрийн ивээлд байна гэсэн заалт байхгүйгээр бусад хуульд тодотгосон эрх үүргийн зохицуулалт байхад болно	1.0	1.1
4	ШУА удирдлагын хувьд төв байгууллага байж чадахгүй байна	1.0	1.1
5	Заалт байгаа ч хэрэгжилт муу, ШУ-ыг сүүлийн хэдэн жил дэмжээгүй, бараг устах ирмэгт байна	7.0	7.4
6	ШУ-ны бодлого нь тусдаа биеэ даасан, “шинжлэх ухаан-технологийн” чанараа тусгаар хадгалж, боловсрол сургалтын бодлогоос дээгүүр тавигдах ёстой	3.0	3.2
7	ШУА-ийн эрх зүйн зөв тусгасан гэхдээ ШУА-ийн ерөнхийлөгч ЗГ-ын тэргүүний зөвлөх байх тухай заалт ерөөсөө хэрэгждэггүй	2.0	2.1
8	Нийцэж байгаа	22.0	23.2
9	ШУА ШУ-ны төв байгууллага мөн гэдэгтэй санал нэг байна. Төрийн ивээлд байна гэсэн заалт хэрэгжихгүй байна	3.0	3.2
10	Нийцдэг ч ШУА нь бүх байгууллагуудыг бүтэцдээ оруулах зохистой хэлбэрийг олох шаардлагатай.	1.0	1.1
11	Төрийн ивээлд байх нь зөв. Гэхдээ улс төрөөс ангид байх хэрэгтэй.	4.0	4.2
12	Хууль, дүрмийн заалтыг нэгэн жигд болгох	2.0	2.1
13	Төрийн үү, олон нийтийн байгууллага уу, нийгэмлэг байх уу гэдэг нь ойлгомжгүй байна.	2.0	2.1
14	Статус хэт ерөнхий учраас амьдрал дээр бодит статус болж чаддаггүй.	2.0	2.1
15	ШУА-ийн зохион байгуулалтын ерөнхий зарчим нь нийцсэн.	1.0	1.1
16	Эрх зүйн зохицуулалтаар статусыг нь нарийвчлах шаардлагатай. Эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна	3.0	3.1
17	Одоогийн бодит статустай нийцэхгүй байна. Төв байгууллагын хэмжээнд ажиллахын тулд санхүүгийн эрх мэдэл шаардлагатай Үүгээр төрийн ивээлийн нэг хэсэг хангагдана.	1.0	1.1
18	Хууль зүйн хувьд ШУА-ийн статусыг хангалттай гэж үзнэ. Түүнийг өөрчлөх оролдлого хийх хэрэггүй байх. Харин хуулийн заалт бодит амьдралд хэрэгжихгүй байгаад анхаарч ажиллах. Ялангуяа яамдуудтай харьцааг идэвхжүүлэх хэрэгтэй	1.0	1.1
19	ОУ-ын жишигтэй нийцэж байгаа	1.0	1.1
20	ШУА нь төрийн ивээлд багтана хэмээн заасан ч ТАХ-ийн статуст багтдаггүй, ивээлээс гадуур шоовдорлогдож байдаг. Иймээс ТАХ-ийн зэрэглэлд багтаах	1.0	1.1
99	Хэлж мэдэхгүй	15.0	15.8
	Бүгд	100.0	105.3

**11. ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн “...Академи нь төрийн ивээлд байна” хэмээх заалт нь ШУ-ыг зөвхөн академиар хязгаарлан авч үзсэн мэт болсон, хувийн статустай шинжлэх ухааны байгууллага, нэгжийг орхигдуулсан, ер нь ШУ бүхэлдээ төрийн ивээл, хамгаалалтад байж чадахгүй байгаа гэдэгтэй Та санал нийлэх үү?**

		Давтамж	Хувь
1	Санал бүрэн нийлнэ	39	37.1
2	Зарим талаар тэгж үзэж болох юм	51	48.6
3	Санал нийлэхгүй	11	10.5

	Бүгд	101	96.2
	Хариулж мэдэхгүй	4	3.8
	<b>Бүгд</b>	<b>105</b>	<b>100.0</b>

**12. Та ШУА-ийн эрх зүйн байдлын талаарх дараах бодомжуудын алинтай нь санал нийлэх үү?**

		Санал бүрэн нийлнэ	Зарим талаар санал нийлнэ	Санал огт нийлэхгүй
1	ШУА нь МУ-ын оюуны үйлдвэрлэлийн цөм байгууллага учир төрийн ивээлд байх нь зүйтэй ч санхүүжилт, удирдлага зохион байгуулалт, үйл ажиллагаа нь төрөөс хараат болсон нь эргээд шинжлэх ухааны хөгжлийг боомилж байна.	46.5	44.6	8.9
2	Төрийн ивээл, хамгаалалтанд байна гэдэг төрөөс хараат, төрийн захиргаанд байна гэсэн үг биш. ШУ-ны байгууллага, ажиллагсад судалгаа шинжилгээний ажлын эрх чөлөө бүрэн нээлттэй байж, ажиллах нөөц, нөхцөл боломжийг л төрөөс хангаж байх ёстой.	82.5	16.5	1.0
3	ШУА-ийг хувийн эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургуультай адил статустай болгох нь зөв	9.7	25.2	65.0
4	Боловеролын тухай хуулинд боловеролын чиглэлээр ажилладаг ЭШ-ний байгууллагаас бусад ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийг хэрхэн зохицуулах талаар тусгаагүй учир бие даасан статустай болгох нь зөв	66.3	20.0	13.7
5	ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийг ЗГ татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, үүсгэн байгуулах эрх бүхий байдгийг болиулж, ШУА, түүний ерөнхийлөгчийн эрх мэдлийн хүрээнд шилжүүлэх	54.9	32.4	12.7

**13. Та ШУ-ны салбарын эрх зүйн байдлыг хэрхэн дүгнэх вэ?**

		Давтамж	Хувь
1	Эрх зүйн орчин бүрдсэн, хуулийн хэрэгжилт сайн байгаа	4	3.8
2	Эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч хэрэгжүүлэх тал дээр хангалтгүй байна	58	55.2
3	Эрх зүйн орчин бүрдээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй	37	35.2
	Хэлж мэдэхгүй	6	5.7
	<b>Бүгд</b>	<b>105</b>	<b>100.0</b>

**14. Таны бодлоор ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудад ямар сул тал, үйлчлэхгүй заалт байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч хуулиудын хоорондын уялдаа холбоо хангагдахгүй байгаа учраас хэрэгжихгүй байна	14.0	46.0
2	ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч хуулиудад тодорхой бус, хоёрдмол утгатай, орхигдсон, зөрчилдсөн заалтуудаас болж байна.	9.1	30.0
3	Эдгээр хууль нь агуулгын хувьд давхардал ихтэй	5.8	19.0
4	ШУ-ны үйл ажиллагаанд Засгийн газрын оролцоог хэт дөвийлгөсөн	10.3	34.0
5	ШУ-ны мэргэшсэн байгууллагуудын шийдвэр гаргах эрх мэдэл бага	22.8	75.0
6	Хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын бүтэц тодорхой бус	7.6	25.0
7	Хуулиуд дахь зүйл, заалт хэт хийсвэр шинжтэй	6.4	21.0
8	Судалгаа, туршилтын ажлын үр дүнг төрд тайлагнах хэмжээнд байхаар заасан	7.0	23.0
9	ЭШ-ний байгууллага, хувийн хэвшлийнхний харилцааг зохицуулалгүй орхисон	15.5	51.0
10	МУ-д ШУ-ыг хөгжүүлэх тодорхой бодлого боловсрогдоогүй	0.3	1.0
11	ШУ-ны байгууллагын эрх мэдэл, тушаал шийдвэрт төр бүрэн оролцдог	0.6	1.0
12	Албан тушаалтнууд хуулийг хэрэгжүүлдэггүй	0.3	1.0
99	Хэлж мэдэхгүй	0.3	1.0
	<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>329.0</b>

**15. ШУ-ны салбарын харилцааг зохицуулагч гол хуулиудад дараах сул тал хэр байгаа болон хэрэгжилт нь ямар байгааг үнэлнэ үү?**

**Агуулгын давхардал**

	Хуулиуд	Байхгүй /0/	Маш бага /1/	Бага /2/	Дунд /3/	Их /4/	Маш их /5/	Мэдэхгүй	Дундаж утга
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	0.5	0.5	4.8	13.3	2.9	6.7	51.4	2.75
2	Шинжлэх ухаан технологийн тухай	9.5	4.8	6.7	14.3	2.9	7.6	54.3	3.05
3	Технологи дамжуулах тухай хууль	6.7	9.5	9.5	11.4	2.9	4.8	55.2	2.58
4	Инновацийн тухай хууль	6.7	11.4	7.6	14.3	1.9	3.8	54.3	2.46
5	Дээд боловсролын тухай хууль	7.6	8.6	8.6	8.6	5.7	7.6	53.3	2.88

**Заалтууд зөрчилдөх**

	Хуулиуд	Байхгүй /0/	Маш бага/1/	Бага /2/	Дунд /3/	Их /4/	Маш их /5/	Мэдэхгүй	Дундаж утга
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	8.6	11.4	6.7	13.3	3.8	5.7	50.5	2.65
2	Шинжлэх ухаан технологийн тухай	10.5	8.6	5.7	11.4	5.7	1.9	56.2	2.60
3	Технологи дамжуулах тухай хууль	5.7	6.7	1.4	1.4	4.8	2.9	57.1	2.62
4	Инновацийн тухай хууль	6.7	10.5	7.6	7.6	6.7	4.8	56.2	2.67
5	Дээд боловсролын тухай хууль	5.7	8.6	7.6	13.3	2.9	8.6	53.3	2.88

**Хийдэл**

	Хуулиуд	Байхгүй /0/	Маш бага/1/	Бага /2/	Дунд /3/	Их /4/	Маш их /5/	Мэдэхгүй	Дундаж утга
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	5.7	10.5	5.7	11.4	2.9	9.5	54.3	2.88
2	Шинжлэх ухаан технологийн тухай	4.8	5.7	7.6	10.5	4.8	8.6	58.1	3.08
3	Технологи дамжуулах тухай хууль	6.7	6.7	8.6	6.7	4.8	7.6	59.0	2.94
4	Инновацийн тухай хууль	6.7	5.7	7.6	10.5	4.8	8.6	56.2	3.08
5	Дээд боловсролын тухай хууль	4.8	8.6	8.6	8.6	2.9	8.6	58.1	2.85

**Уялдаа холбоогүй байдал**

	Хуулиуд	Байхгүй /0/	Маш бага/1/	Бага /2/	Дунд /3/	Их /4/	Маш их /5/	Мэдэхгүй	Дундаж утга
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	6.7	17.1	1.9	14.3	4.8	10.5	44.8	2.78
2	Шинжлэх ухаан технологийн тухай	2.9	11.4	6.7	11.4	11.4	10.5	45.7	3.06
3	Технологи дамжуулах тухай хууль	5.7	6.7	10.5	11.4	6.7	4.8	54.3	2.81
4	Инновацийн тухай хууль	3.8	9.5	10.5	11.4	5.7	12.4	46.7	3.02
5	Дээд боловсролын тухай хууль	5.7	10.5	7.6	15.2	3.8	10.5	46.7	2.92

**Хоёрдмол, тодорхойгүй утга санаа**

	Хуулиуд	Байхгүй /0/	Маш бага/1/	Бага /2/	Дунд /3/	Их /4/	Маш их /5/	Мэдэхгүй	Дундаж утга
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	5.7	13.3	7.6	5.7	6.7	6.7	54.3	2.64
2	Шинжлэх ухаан технологийн тухай	6.7	12.4	6.7	7.6	6.7	4.8	55.2	2.60
3	Технологи дамжуулах тухай хууль	7.6	4.8	10.5	9.5	1.9	7.6	58.1	2.92
4	Инновацийн тухай хууль	7.6	5.7	9.5	9.5	5.7	5.7	56.2	2.89
5	Дээд боловсролын тухай хууль	7.6	7.6	6.7	13.3	1.0	5.7	58.1	2.72

**Хэрэгжилт**

	Хуулиуд	Маш ióó/1/	Íóó /2/	Дунд /3/	Ñàéí /4/	Маш ñàéí /5/	Мэдэхгүй	Äóíáàæ óòää
1	ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хууль	8.6	9.5	23.8	15.2	8.6	34.3	3.09
2	Шинжлэх ухаан технологийн тухай	4.8	14.3	22.9	13.3	7.6	37.1	3.08
3	Технологи дамжуулах тухай хууль	4.8	14.3	21.9	7.6	12.4	39.0	3.14
4	Инновацийн тухай хууль	8.6	11.4	17.1	13.3	14.3	35.2	3.21
5	Дээд боловсролын тухай хууль	6.7	11.4	15.2	12.4	16.2	38.1	3.32

**16. ШУА-ийн эрх зүйн байдлыг сайжруулахаар хуулинд дараах санааг тусгаж оруулах хэрэгтэй гэвэл Та санал нийлэх үү?**

		Хариултын хувь	Тохироллын хувь
1	Тусгай хуультай байгууллага тул бие даан ажиллах боломжийг нь олгох	10.6	61.5
2	Төсөв, санхүүг захиран зарцуулах эрхийг ШУА-ийн Ерөнхийлөгчид шилжүүлэх	9.6	55.8
3	ШУТ-ийн санг ШУА-ийн бүтцэд байхаар зохион байгуулах	7.9	46.2
4	Төсөл, суурь судалгаа хоёрыг санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгах	12.4	72.1
5	Төрийн бодлого, хөтөлбөрийг тодорхойлоход ШУА-ын үүрэг, оролцоог тодорхой тусгах	11.6	67.3
6	Үндэсний хэмжээний томоохон төслүүдэд зөвлөх болон экспертийн үйлчилгээ үзүүлэх эрх, үүргийг хуулиар олгох	11.3	65.4
7	ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн хэвшлийнхэн болон их, дээд сургуультай хамтарч ажиллах менежментийг бий болгох	11.9	69.2
8	ШУ-ны парк, гарааны компани байгуулахад татвар, гаалийн бодлогоор дэмжих	11.9	69.2
9	Үйлдвэрлэгч, судлаач, бодлого зохицуулагчдын хоорондын уялдаа холбоог хуулинд тодорхойлох	9.8	56.7
10	Докторантурт сургах талаар	0.7	3.8
11	Хариуцлагыг өндөржүүлэх	0.2	1.0
12	ШУ-ны санхүүжилтийг ДНБ-ний 5 хувьд хүргэх	0.2	1.0
13	Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг хамтын ажиллагаатай үйлдвэрийн эдийн засгийн хөшүүрэг болгох	0.2	1.0
14	Инновацийн болон грантын судалгааг санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгаж, өөрчлөх	0.2	1.0
15	ХАА-н ШУ-ны бодлогыг тодорхой болгож, харьяаллыг шийдэх	0.2	1.0
16	Хувийн хэвшлийн ЭШ-ний байгууллагыг бодлогоор дэмжих	0.2	1.0
17	ШУТС-г ОУ-ын жишгээр грант олгодог чиглэлээр өөрчлөн байгуулах /ЗГ-тай гэрээгээр ажилладаг ТББ хэлбэрт шилжүүлэх/	0.2	1.0

18	ШУА ёс зүйн хэм хэмжээг сахиулах үүрэг хүлээх	0.2	1.0
19	Мэдлэгийн үнэн мөнийг тогтооход эцсийн хариуг өгдөг байх	0.2	1.0
20	Шашны байгууллагатай ШУ-ыг төлөөлөн харьцдаг байх	0.2	1.0
21	Эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавих	0.2	1.0
22	Технологи патент худалдах хууль эрх зүйн акт бий болгох	0.2	1.0
23	ШУА -ийн тухай хуулийг шинэчилж гаргах, түүнд Академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарын статусыг гаргаж өгөх, академич нарын статусыг ч бас шийдэх	0.2	1.0
99	Хэлж мэдэхгүй	0.2	1.0
	Бүгд	100.0	580.8

**17. Та ШУА-ийн эрх хэмжээг ямар байдлаар тогтоож өгөх нь зүйтэй гэж үзэж байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	ШУ, ШУА төрийн ивээл, онцгой хамгаалалтанд байх гэхдээ удирдлага, санхүүжилтийн хувьд бие даасан статустай болгох	52.5	72.5
2	ШУА-ийг МУ-ын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын шууд удирдлага дор ажилладаг агентлаг болгох	22.0	30.4
3	ШУА-ийг үндэсний шинжтэй, нийт эрдэмтдийн нийгэмлэг хэлбэрээр байгуулах	14.2	19.6
4	ШУА-ийг төрд, ард түмэндээ зөвлөмж гаргаж өгдөг эрдэмтдийн клуб болгох	1.4	2.0
5	ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийг БШУСЯ-ны шууд харьяаны газар болгох	1.4	2.0
6	ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн компани, ТББ, хувь иргэнтэй адилхан төсөл хэрэгжүүлэгч болгох	5.0	6.9
7	ШУА бол засгийн газрын бие даасан нэгж байх /яам, агентлаг/	0.7	1.0
8	Хүрээлэнгүүд ШУА-д байх	0.7	1.0
9	ШУА-ийн байгалийн ухааны хүрээлэнгүүдийг “үндэсний” болгох	0.7	1.0
11	Хүрээлэнгүүдийг суурь санхүүжилттэй, дээрээс нь сангуудаас төсөл авч хэрэгжүүлдэг болгох	0.7	1.0
12	Одоогийн хуулинд заасны дагуу буюу одоогийнхоор нь байлгах	0.7	1.0
	Бүгд	100.0	138.2

**18.1. ШУА ба төрийн бусад институт хоорондын өнөөгийн харилцаа, уялдаа холбоог үнэлж саналаа хувиар илэрхийлнэ үү?**

**ШУА ба Ерөнхийлөгчийн институт**

	Харилцаа холбооны хувь	Давтамж	Хувь
1	0 хувь	15	14.3
2	1-5 хувь	17	16.2
3	10 -15 хувь	22	21.0
4	20-50 хувь	9	8.7
5	Мэдэхгүй	42	40
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		8.41
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		10.00

**ШУА ба Засгийн газар**

	Харилцаа холбооны хувь	Давтамж	Хувь
1	0	6	5.7
2	5	12	11.4
3	8-10	19	18.1
4	15-20	12	11.5
5	25-ээс дээш /60/	15	14.4
6	Мэдэхгүй	41	39.0
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		16.3
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		10.00

**ШУА ба БСШУСЯ**

	Харилцаа холбооны хувь	Давтамж	Хувь
1	10-20	13	12.4
2	25-30	18	17.2

3	32-40	13	12.5
4	45-50	12	11.4
5	60-83	8	7.7
6	Мэдэхгүй	41	39.0
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		37.3
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		30.00

**ШУА ба их дээд сургууль**

	Харилцаа холбооны хувь	Давтамж	Хувь
1	0	11	10.5
2	2-7 хувь	9	8.6
3	10 хувь	28	26.7
4	12-20 хувь	13	12.4
5	25-30 хувь	3	2.9
6	Мэдэхгүй	41	39.0
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		9.80
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		10.00

**ШУА ба ШУТС**

	Харилцаа холбооны хувь	Давтамж	Хувь
1	0	1	1.0
2	2 хувь	1	1.0
3	10-12 хувь	12	11.5
4	20-27 хувь	13	12.5
5	30-35 хувь	23	22.0
6	40-60 хувь	13	12.5
	Мэдэхгүй	42	40.0
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		27.3
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		30.00

**18.2 ШУА ба төрийн бусад институт хоорондын харилцаа уялдаа холбоо ямар байх нь зохистой талаарх саналаа хувиар илэрхийлнэ үү?****ШУА ба Ерөнхийлөгчийн институт**

	Харилцаа холбооны зохимжит хувь	Давтамж	Хувь
1	0 хувь	7	6.7
2	4-5 хувь	14	13.4
3	10 хувь	18	17.1
4	15-20 хувь	25	23.8
5	23-100 хувь	9	8.8
6	Мэдэхгүй	32	30.5
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		15.6
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		20.00

**ШУА ба Засгийн газар**

	Харилцаа холбооны зохимжит хувь	Давтамж	Хувь
1	0	4	3.8
2	5-10 хувь	18	17.2
3	15-20 хувь	29	27.6
4	25-70 хувь	25	24.1
5	Мэдэхгүй	29	27.6
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		21.9
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		20.00

**ШУА ба БСШУСЯ**

	Харилцаа холбооны зохимжит хувь	Давтамж	Хувь
1	0	3	2.9
2	5-10	14	13.4
3	15-20	23	21.9
4	25-30	18	17.2
5	40-70	17	16.3

6	Мэдэхгүй	30	28.6
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		25.7
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		20.00

**ШУА ба их дээд сургууль**

	Харилцаа холбооны зохимжит хувь	Давтамж	Хувь
1	0	1	1.0
2	5-10 хувь	19	18.1
3	15-20 хувь	37	35.3
4	25-60 хувь	18	17.2
5	Мэдэхгүй	30	28.6
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		19.3
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		20.00

**ШУА ба ШУТС**

	Харилцаа холбооны зохимжит хувь	Давтамж	Хувь
1	0	9	8.6
2	2-10 хувь	23	22.0
3	15-20 хувь	28	26.7
4	25-50 хувь	15	14.5
5	Мэдэхгүй	30	28.6
	Бүгд	105	100.0
	<i>Дундаж утга</i>		16.98
	<i>Хамгийн их давтагдсан утга</i>		20.00

**19. ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийг их дээд сургуультай нэгтгэх талаар Та ямар байр суурьтай байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	Хүрээлэнгүүдийг өөр зорилго, үүрэг бүхий байгууллагатай нэгтгэх нь алсдаа ШУ-ны онолын судалгааны чиглэлийг үгүй хийх эрсдэлтэй	34.5	65.7
2	Их дээд сургуулиудаас гадна ШУА, төв, лаборатори, нийгэмлэгүүд дээр ШУ-ны судалгаа хийх байдлаар тус тусад нь хөгжүүлэх нь зөв	16.5	31.4
3	Хүрээлэнгүүдийг их дээд сургуультай нэгтгэхээс илүүтэй хамтарсан судалгааны төсөл, хөтөлбөрийг дэмжиж ажиллах нь үр дүнтэй.	40.5	77.1
4	Хүрээлэнгүүдийг их дээд сургуулиудтай нэгтгэж, судлаачдын бүтээмжийг дээшлүүлэх хэрэгтэй.	3.0	5.7
5	Нийлснээр бэлтгэгдсэн боловсон хүчин, судалгааны ажил устаж үгүй болдог. Жишээ нь: математикийн хүрээлэн их сургуультай нэгдээд бараг утсан	0.5	1.0
6	Чиг үүргийн хувьд ондоо тул Соёл боловсролын яам, ШУ технологийн яам гэж бодлогын хувьд салангид авч үзэх нь бусад орны ШУ-ны бодлоготой хамтарч хөгжихөд түлхэц болох нэг гарц юм	0.5	1.0
7	Нэгтгэхэд хүрвэл их дээд сургуулийн дотоод бүтцийг мөн өөрчлөх хэрэгтэй. Хүрээлэнг аваачиж хавсаргах биш, хүрээлэнгийн судлаачид дээр түшиглэсэн профессорын баг байдлаар ажиллаж болно.	0.5	1.0
8	Багш нар цаг ихтэй тул судалгаа руу гүн орж чаддаггүй, тиймээс тодорхой гэрээгээр орж ажиллах нь илүү үр дүнд хүрнэ	0.5	1.0
9	Graduate school нь хамтарсан судалгааны ажлын хэлбэр болох	0.5	1.0
10	Их, дээд сургуулиуд судалгааны сургууль бус оюутнуудаас мөнгө авах хэлбэртэй	0.5	1.0
11	Академи магистр, доктор хамгаалуулах эрхээ авах	0.5	1.0
12	Судлаачдыг уялдаа холбоотой ажиллуулах	0.5	1.0
13	Их дээд сургуультай нэгтгэсэн туршлагаас харахад их дээд сургуулиуд огт дэмжиж ажиллахгүй байна	0.5	1.0
14	Нэг хэсэг хугацаанд их дээд сургуулиудын дэргэд ЭШ-ний хүрээлэн байгуулахыг таггалзах хэрэгтэй	0.5	1.0
15	ШУА-д докторантурын сургалтын газартай болгож хүрээлэнгүүдийн дэргэд докторантур нээх, зэрэг хамгаалуулах зөвлөл БШУСЯ-ны	0.5	1.0

шийдвэрээр нэгдмэл байх нь зохимжтой. Шаардлагатай бол энэ талаар холбогдох хуулинд тусгах		
Бүгд	100.0	190.5

### ШУА-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЧИГ ҮҮРЭГ

20. 2015 онд Засгийн газрын тогтоолоор ШУА-ийн хэмжээнд хийгдсэн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хэр зэрэг үр дүнтэй болсон бэ?

	Давтамж	Хувь
1 Зөв зүйтэй өөрчлөлт болсон, цаашдаа үр дүн нь харагдах байх	13	12.4
2 Хүрээлэнгүүдийг нэгтгэн нийлүүлэх механик өөрчлөлт л болсон, үр дүн тодорхой бус байна.	54	51.4
3 Шаардлагагүй арга хэмжээ болсон, үр дүн гарахгүй	23	21.9
4 Хэлж мэдэхгүй байна	15	14.3
Бүгд	105	100.0

21. ШУА-д бүтэц зохион байгуулалт, удирдлага менежмент, хууль эрх зүйн орчинд дараах өөрчлөлтийг хийх шаардлага бий эсэх талаар Таны санал бодол ямар байна вэ?

№		Зайлшгүй шаардлагаг ай /4/	Шаардлагатай /3/	Нэг их шаардлагагүй /2/	Огт шаардлагагүй /1/	Дундаж утга
1	ШУА болон салбарын статусыг тодорхой болгох	64.3	28.6	3.1	4.1	3.53
2	Эрх мэдлийн хуваарилалтыг хуулиар нарийвчлан тогтоох	53.7	36.8	6.3	3.2	3.41
3	Эрх зүйн орчныг сайжруулж, холбогдох хуулиудын уялдаа холбоог хангах	52.1	43.6	3.2	1.1	3.47
4	ШУА болон төрийн институциудын харилцаа, уялдаа холбоог зохистой болгох	45.8	44.8	7.3	2.1	3.34
5	ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн бүтэц, зохион байгуулалтыг бүхэлд нь өөрчлөх	20.2	29.8	39.4	10.6	2.60
6	ШУА-ийн эрх хэмжээг шинэ түвшинд гаргах	54.7	29.5	11.6	4.2	3.35
7	ШУА-ийн Их, Бага чуулганы бүрэлдэхүүн, хүлээх үүрэг хариуцлагыг өөрчлөх	38.5	24.0	28.1	9.4	2.92
8	Санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг өөрчлөх	46.4	40.2	10.3	3.1	3.30
9	Санхүүжилтийн журам, механизмыг өөрчлөх	49.5	37.6	11.8	1.1	3.36
10	Техник технологийн шинэчлэл хийх	68.0	26.8	5.2	-	3.63
11	Материаллаг бааз, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах	77.8	19.2	2.0	1.0	3.74
12	Боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх	72.7	24.2	3.0	-	3.70
13	Ажиллах хүчний нийгмийн хамгааллыг сайжруулах	70.4	27.6	2.0	-	3.68
14	Цалин хөлсний сүлжээний шатлал дахь суурь цалин хөлсний хэмжээг ахиулах	77.0	22.0	1.0	-	3.76
15	ШУ, технологийн ажлын үр дүнг практикт нэвтрүүлэх механизмыг бүрдүүлэх	66.0	32.0	2.0	-	3.64
16	Оюуны бүтээлийн үнэлэмжийг дээшлүүлэх	83.0	15.0	1.0	1.0	3.80

22. ШУА дараах үүргээ хэр хэрэгжүүлж байгааг үнэлнэ үү?

	Хуулиуд	Маш бага /1-2/	Бага /3-4/	Дунд /5-6/	Их /7-8/	Маш их /9-10/	Дундаж утга	ХИДУ
1	Улсын ЭЗ, нийгэм, улс төрийн харилцааны хөгжлийн байдалд ШУ-ны үүднээс дүгнэж, цаашдын чиглэл, арга замыг тодорхойлох	20.0	25.3	35.8	12.6	6.4	4.61	5.00

2	Шинэ бүтээгдэхүүн, технологийн судалгаа явуулах, хөгжүүлэх	11.8	25.8	36.6	16.9	9.0	5.25	5.00
3	Шинэ бүтээл, технологи үйлдвэрлэлд нэвтрүүлэх	13.7	39.2	33.3	10.8	3.0	4.44	5.00
4	Мэдлэг, чадавхи бий болгох, түгээх	6.8	20.6	33.3	21.5	17.6	5.96	5.00
5	Судалгааны ажлын үр дүнг мэдээлэх, дамжуулах	7.0	26.2	30.4	25.2	11.1	5.66	5.00
6	Улс орныг удирдан чиглүүлэх	36.4	38.4	17.2	6.0	2.0	3.34	1.00
7	Төрд зөвлөх, бодлого тодорхойлох	26.4	34.3	19.6	12.8	6.8	4.25	3.00
8	Улс орны томоохон төсөл, хөтөлбөрт үнэлэлт дүгнэлт өгөх	28.5	35.3	17.6	14.7	3.9	4.08	4.00

**23. ШУА улс орны болон салбарын асуудлыг “Их чуулган”, “Бага чуулган”-аар хэлэлцэж шийддэг. Бүтэц, зохион байгуулалтын энэ хэлбэрийг Та хэрхэн дүгнэж байна вэ?**

		Давтамж	Хувь
1	Их чуулган, Бага чуулганаар ШУ-ны асуудлыг шийдвэрлэх нь хамгийн оновчтой хувилбар мөн	33	31.4
2	Их, Бага чуулганы бүтэц, зохион байгуулалтыг хадгалах ч зарчмын өөрчлөлт хийх шаардлагатай.	54	51.4
3	Их чуулган, Бага чуулганыг татан буулгаж, төр, хувийн хэвшил, их дээд сургууль, ШУА-ийн төлөөлөл бүхий хамтарсан зөвлөлөөр асуудлаа шийдэх хэрэгтэй.	12	11.4
	Бүгд	99	94.3
	Хариулж мэдэхгүй	6	5.7
	<b>Бүгд</b>	<b>105</b>	<b>100.0</b>

**24. ШУА-ийн Их, Бага чуулган үүргээ хэрхэн биелүүлж байна гэж Та үзэх вэ? /1-Маш муу, 10-маш сайн/**

**Их чуулган**

		Маш бага /1-2/	Бага /3-4/	Дунд /5-6/	Их /7-8/	Маш их /9-10/	Дундаж утга	Хамгийн их давтагдсан утга
1	Эрдэм шинжилгээний төсөлт ажлын үр дүн, түүнийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	15.1	36.5	32.3	13.0	3.3	4.48	3.00
2	ШУТ-ийн тодорхой салбар чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх	19.0	39.0	28.4	8.5	5.3	4.35	3.00
3	МУ-ын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, Зөвлөмж гаргаж УИХ, Ерөнхийлөгч, ЗГ-т өргөн барих	19.1	31.9	29.8	12.7	6.4	4.64	3.00
4	Академийн дүрэм, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэж Засгийн газраар батлуулах	17.2	33.4	33.3	10.8	5.4	4.54	3.00
5	Улсын захиалгат судалгааны ажлын хөтөлбөр, төслийг хэлэлцэж, санал зөвлөмж гаргах	7.5	30.1	36.6	19.4	6.5	5.13	5.00
6	Академийн тэргүүлэгчид, харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх	17.8	23.3	20.0	32.2	6.6	5.26	8.00
7	Академийн үйл ажиллагааны жилийн тайланг хэлэлцэх	9.7	17.2	23.7	28.0	21.5	6.24	8.00

8	Бага чуулганаас оруулсан асуудлыг хэлэлцэх	5.5	24.4	28.9	23.4	17.8	6.01	8.00
---	--	-----	------	------	------	------	------	------

**Бага чуулган**

1	Тухайн салбарын чиглэлээр хийж байгаа судалгаа, шинжилгээний ажлын явц, үр дүнг шүүн хэлэлцэх	8.4	23.1	25.2	29.4	13.7	5.73	5.00
2	Эрдэм шинжилгээний дууссан төслийн тайланг хэлэлцэн үнэлгээ, дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад шилжүүлэх	8.4	20.8	24.0	32.3	14.6	6.05	8.00
3	Эрдмийн зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх талаар санал гаргах	24.0	32.3	25.0	14.6	4.1	4.29	3.00

**25. ШУА-ийн үйл ажиллагаа, үр дүнг бүхэлд нь үнэлбэл Та ямар үнэлгээ өгөх вэ?**

		Хангалттай сайн /3/	Үүргээ гүйцэтгэж л байна /2/	Өнөөгийн шаардлагад нийцэхгүй байна /1/	Дундаж утга
1	ШУА	12.9	76.2	10.9	2.02
2	Их чуулган	10.5	66.3	23.2	1.87
3	Бага чуулган	10.2	63.3	26.5	1.84
4	Харьяа хүрээлэн, төвүүд	32.3	63.6	4.0	2.28

**26. ШУА-ийн Их, Бага чуулганы үйл ажиллагааг сайжруулах талаарх санал бодол?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	Бага чуулганы гишүүний тоог нэмэгдүүлж, 1 хүрээлэн, нэгжид ногдох квотыг ихэсгэх	21.5	39.6
2	Бага чуулганы үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх	34.5	63.5
3	Их чуулганы үүрэг хариуцлагыг өндөржүүлэх	34.5	63.5
4	Хуучнаар Биологи-ХАА-н бага чуулган болгон нэгтгэх	0.6	1.0
5	Бага чуулганы эрхийг нэмэгдүүлэх шаардлагатай. Салбараа мэддэг бага чуулганаар төсөл хөтөлбөрөө хэлэлцүүлж байж яам дараа нь батлах хэрэгтэй. Юу хийхийг нарийн мэдэхгүй байж яам баталж байгаа нь буруу болж байна.	0.6	1.0
6	Чадварлаг, харилцааны соёлтой, мэдрэмжтэй, санаачлагатай, дайчин, менежментийн авьяастай залуу боловсон хүчний бүрэлдэхүүнээр үйл ажиллагааг цаашид удирдан явуулах нэн шаардлагатай байна	1.7	3.1
7	Төрийн соёрхол болон ШУА ба Их дэд сургуулиудын хамтран хэрэгжүүлэх судалгааны ажлуудыг шүүн хэлэлцдэг хуучны дэг журмыг сэргээх	0.6	1.0
8	ЗГ-т ямар зөвлөмж гаргасныг хүртээл болгох	0.6	1.0
9	Бага чуулган шаардлагагүй	0.6	1.0
10	4 жилд гишүүдийн 20-25 хувийг сольж байх	0.6	1.0
11	Ажил үүргийн ялгаа байгаа ч гэсэн БШУЯ авч хэлэлцдэггүй	0.6	1.0
12	ШУ-ны бүх салбарыг хамруулах	0.6	1.0
13	Ил тод, нээлттэй салбарын төлөөллийг бүрэн хамруулах	0.6	1.0
14	Төлөөллийн квотыг салбараар тогтоох	0.6	1.0
15	Мэргэжлийн өндөр чадвартай боловсон хүчний тоог нэмэх	0.6	1.0
16	Их, бага чуулганы экспертийн үүргийг нэмэгдүүлэх орчин бий болгох	0.6	1.0
17	Бага чуулганы цар хүрээг өргөтгөхдөө нэг хүрээлэн, төвөөс илүүтэйгээр гадны мэргэжлийн хүмүүсийг оролцуулбал илүү үр дүнтэй байдаг. Жнь: Нэг хүрээлэнгээс олон хүн байхаар тайлан сэдвийг хэлэлцэхэд сонсчихсон байдаг учир идэвх оролцоо нь муу байдаг	0.6	1.0
18	Улс орны том том асуудлын шинжлэх ухааны хангамжийн талаар хэлэлцэж чиглэл өгөх ажлыг зохион байгуулах	0.6	1.0
	Бүгд	100.0	184.4

**27. ШУА-ийн удирдлага зохион байгуулалт, менежментийг сайжруулах талаарх Таны санал бодол?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
--	--	----------------	-----------------

1	ШУА-ийн ерөнхийлөгч, бүх удирдлагууд хүрээлэн нэгжтэй байнга харьцаатай байх менежмент бий болгох	3.3	3.4
2	Бүх асуудлыг яам шийддэг нь буруу, ШУА-ийн үүрэг ролийг дээшлүүлэх хэрэгтэй	3.3	3.4
3	Үндсэн чиг үүргийнхээ дагуу хөгжлийн стратеги, бодлогод нөлөөлж чадахуйц цар хүрээтэй ажлыг хуваарилаж, хүрээлэн бүтцээ өргөжүүлж, шинэ шатанд шинэ мэдлэгээр, шинэ арга барилаар ажиллая	5.0	5.2
4	ШУА-ийн ерөнхийлөгчийг ЗГ-ын хуралдаанд оролцуулдаг болох	1.7	1.7
5	Одоогийн удирдлага, зохион байгуулалт, менежментээр явах боломжтой	1.7	1.7
6	Бага чуулганы үүрэг ролийг суурь судалгаанд өндөржүүлэх ёстой	3.3	3.4
7	Засгийн газрын бүтцэд оруулах	1.7	1.7
8	Хүрээлэнгүүдтэйгээ уялдаа холбоо сайтай ажиллах, судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх, бие даасан санхүүжилттэй болгох	3.3	3.4
9	Бүх салбарт ШУ-ны хуурмаг мэдрэмж бий болсон. Мэргэжлийн удирдлагуудын тогтолцоо бүрэн алдагдсан	1.7	1.7
10	Техник технологи, үйлдвэрлэлийн салбаруудад төсөл хөтөлбөр хэрэгжүүлж бодит зүйл хийх	1.7	1.7
11	ШУА гэх хаалттай орчинг өөрчлөх, их дээд сургуулийн эш өрсөлдөхүйц болгох	1.7	1.7
12	Их чуулганд залуу боловсон хүчин, ажлын туршлагатай хүмүүсийг түлхүү оролцуулах, дүрэм журмаа шинэчлэх	5.0	5.2
13	Батлагдсан хуулинд заасан эрхүүд, үүргүүдийг чанд баримтлан ажиллах	1.7	1.7
14	Судлаач нарын гүнд нь орж ажиллах, хувь хүн бүрийн идэвх чармайлт, ажлын өгөөжийг хянаж байх	1.7	1.7
15	Шинэ удирдлага хуулиа мөрдлөг болгон ажиллах	1.7	1.7
17	ШУА нь Германы МаксПланк нийгэмлэг үү эсвэл Германы ШУА Leopoldina болох уу гэдгээс хамаарна	1.7	1.7
18	ШУА-ийн удирдлагад залуу боловсон хүчнээс багийн бүрэлдэхүүнд оруулах	1.7	1.7
19	Бүх эрдэмтний оролцоог тэгш бодолцох	1.7	1.7
20	Олон улсын түвшинд байр сууриа эзлэх талаар бодлого боловсруулах, хэрэгжүүлэх	1.7	1.7
23	Хамт олны оролцоо муу, дарга удирдлага сонгох жижиг асуудлыг шийдвэрлэхэд яам, академи оролцдог	1.7	1.7
24	Эрдэм шинжилгээний ажилтны цалинг нэмэх, нийгмийн хангамжийг сайжруулах	1.7	1.7
25	ШУА-ийн удирдлага өөрсдийн хийсэн ажлаа тайлагнадаг байх	1.7	1.7
26	ШУА-ийг ЗГ-ын агентлагийн хэмжээнд статустай болгох	1.7	1.7
28	Үйл ажиллагааг ил тод болгох	1.7	1.7
29	Төр хувийн хэвшлийн харилцааг өргөжүүлэх	1.7	1.7
30	Менежментийн баг хэрэгтэй, менежментийг эрс дээшлүүлэх	3.3	3.4
31	ШУ, цаг үеийн хөгжил 2-г уялдуулах	1.7	1.7
32	Ажилладаг механизмыг үр өгөөжтэй болгох	1.7	1.7
33	Шинжлэх ухаанд х (икс) хөрөнгө зарцуулаад 2-оос дээш х (икс) хөрөнгөөр үнэлэгдэх бие бус оюуны, шинэ мэдлэгийн ба бие бүтээгдэхүүн буй болгох менежмент нэвтрүүлэх	1.7	1.7
34	ХАА ШУА-ийн үйл ажиллагааг жигдрүүлж, дэмжих	1.7	1.7
35	Мэргэжлийн боловсон хүчнээр багаа бүрдүүлж, хариуцлага тооцож ажиллах	1.7	1.7
36	ШУА зөвхөн харьяа хүрээлэнгүүдээ удирдах, зохицуулах	1.7	1.7
37	ШУ-ны салбарыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах	1.7	1.7
38	ШУ-ны бүтээлийг хялбаршуулан нийтийн хүртээл болгох	1.7	1.7
39	Албан тушаалын сонгуулийг шударга болгох	1.7	1.7
40	Төсөв санхүүжилтийн олон дамжлага, шатыг цөөрүүлэх	1.7	1.7
41	ШУА-ийн статусыг шинэчлэх, тодорхой болгох	5.0	5.2
42	Өндөр мэдлэг боловсролтой, ёс зүйтэй баг бүрдүүлж төлөвлөгөөтэй ажиллах	1.7	1.7
43	Санхүүгийн менежмент бүрдүүлэх орчин нөхцөлийг эхний ээлжинд бүрдүүлэх	1.7	1.7
44	ШУА-ийн удирдлага, санхүүжилтийг бие даалгах ШУА-ийн эрх чөлөөг нэмэгдүүлж байж ажил нь сайжирна	1.7	1.7

45	Шинэ удирдлагууд хүрээлэн төвүүдийн захирал, ЭНБД, зарим судлаачид эрдэмтэдтэй уулзаж, тэдний саналыг сонсох, тэднээс авах, хэрэгжүүлэх гоц саналуудыг ажил хэрэгтээ тусгах, хэрэгжүүлэх	1.7	1.7
46	ШУА-ийг бие даасан статустай болгох	1.7	1.7
47	Одоогийн бүтэц зохистой, хувь хүний идэвх санаачлагыг сайжруулах	3.3	3.4
48	Хүний нөөц боловсон хүчин болон хамтарсан судлаачдын багийг бий болгох	1.7	1.7
49	Сонгон шалгаруулалтаар удирдлагын бүтцийг бүрдүүлэх	1.7	1.7
50	ШУ-ны онол, гүйцэтгэлийг үйлдвэрлэлд, ААН-үүдтэй холбох менежментийг сайжруулах	1.7	1.7
51	Үе үе тулгамдсан асуудлаар экспертийн комисс томилж, түүний мэдээллийг сонсож байх.	1.7	1.7
52	Академийн гишүүдээс мэргэжлийн яамдын бодлого тодорхойлоход оруулах үүрэг, үйл ажиллагааг идэвхжүүлэх менежмент хийх	1.7	1.7
	Бүгд	100.0	103.4

**САНХҮҮЖИЛТ****28. Өөрийн ажиллаж буй салбарын санхүүжилтийн өнөөгийн байдлыг хэрхэн дүгнэх вэ?**

		Байхгүй /0/	Маш бага /1-2/	Бага /3-4/	Дунд /5-6/	Их /7-8/	Маш их /9-10/	Дундаж утга	ХЭАӨ
1	ҮӨ, судалгааны ажлын санхүүжилт	5.0	40.6	27.7	18.9	7	1	3.24	1.00
2	Тоног төхөөрөмж, лабораторийн хангамж	13.9	41.6	29.7	10.9	2.0	2.0	2.87	1.00
3	Түүхий эд, материал хэрэглэгдэхүүний зардал	9.1	42.4	29.3	15.2	3.0	1.0	3.01	1.00
4	Ажиллагсдын цалин хөлс	3.9	42.1	20.6	22.5	7.8	3.0	3.49	1.00
5	Шинэ болон шинэчилсэн бүтээлийг урамшуулах	7.8	42.2	26.5	12.7	10.8	-	3.21	1.00
6	Ажилтнуудын нийгмийн хамгаалал	15.8	33.7	30.7	11.9	8.0	-	3.26	1.00
7	ШУТ-ийн үр дүнг практикт нэвтрүүлэх зардал	18.8	48.5	21.8	7.0	3.0	1.0	2.61	1.00

**29.1. ШУТ-ийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмын талаарх дараах эсрэгцэн байр суурийн алиныг нь Та дэмжих вэ?**

		Давтамж	Хувь
1	Суурь судалгааны төсөл сонгон шалгаруулах журмаар суурь судалгааны хүрээлэнгүүд нь хувийн компани, ТББ, хувь иргэнтэй адилхан статустай төсөл хэрэгжүүлэгч байхаар болгосон нь зүйтэй. Өрсөлдөөнийг бий болгох нь шударга хэрэг.	17	16.2
2	Суурь судалгааны төслийг хэрэглээний судалгааны төслийн санхүүжүүлэх, сонгон шалгаруулах зарчмыг ялгаж үзэх хэрэгтэй. Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх харьцангуй давуу эрхийг суурь судалгааны хүрээлэнгүүдэд олгох нь зөв	69	65.7
	Бүгд	86	81.9
	Хариулж мэдэхгүй	19	18.1
	<b>Бүгд</b>	<b>105</b>	<b>100.0</b>

**29.2 ШУТ-ийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмын талаарх дараах эсрэгцэн байр суурийн алиныг нь Та дэмжих вэ?**

		Давтамж	Хувь
1	ШУА, хүрээлэнгүүдийн төсөв санхүүг Төрийн сангийн тогтолцооноос гаргах	30	28.6
2	Зөвхөн улсын төсвийн дэмжлэгээ Төрийн санд үлдээгээд, үйл ажиллагааны орлогоороо санхүүгийн менежмент хийх боломж олгох	58	55.2
	Бүгд	88	83.8
	Хариулж мэдэхгүй	17	16.2
	<b>Бүгд</b>	<b>105</b>	<b>100.0</b>

**30. ШУТ-ийн үйл ажиллагаанд санхүүжилт олгох журам, санхүүжүүлэх механизмыг өөрчлөх боловсронгуй болгох өөр ямар санал Танд байна вэ?**

	Хариултын хувь	Тохиолдлын хувь

1	ШУА төсвийн ерөнхийлөн захирагч байх	4.6	5.7
2	Хүрээлэн төвүүдийн төсвийн шууд захирах эрхийг тодорхой зохицуулалттай болгох	4.6	5.7
3	ШУТС-аар дамжуулахгүй шууд олгох, төсөл санхүүжүүлэх мөнгө босгохгүй, одоогийн хэлбэрээр байх юм бол ШУТС байх шаардлагагүй байна	4.6	5.7
4	Байгалийн ухааны хүрээлэн төвүүдийн санхүүжилтийг сайжруулах, дотоод томилолт ЭШЗ-аас гадна тусад нь олгох	1.5	1.9
5	Хүрээлэн төвүүдэд санхүүжилтийг эрхийг нь өөрсдөд нь олгох	1.5	1.9
6	ШУА-ийн мэдэлд санхүүжилтийг шилжүүлж, захиран зарцуулах эрхийг өгөх	4.6	5.7
7	Хүрээлэнгүүдийн суурь санхүүжилтийг нэмэгдүүлэх	3.1	3.8
8	Хөрөнгө оруулалтыг тогтмол нэмэгдүүлэх	1.5	1.9
9	Санхүүжилт олгох журам дэндүү удаашралтай болхи байна.	3.1	3.8
10	Төслийн гүйцэтгэлийг үечилсэн үр дүнгээр санхүүжил, урамшуулал олгох байдлаар	1.5	1.9
11	Оюуны өмчийн хамгаалалтын системийг сайжруулах түүгээр дамжуулан инновацийн ашиг орлогоороо санхүүжилт хийх боломжийг бүрдүүлэх	1.5	1.9
12	Санхүүжилтийн хэмжээг хуульд заасан хэмжээнд хүргэх	1.5	1.9
13	Санхүүгийн олон эх үүсвэртэй болгох	4.6	5.7
14	Татварын эрх зүйн орчинг сайжруулах	1.5	1.9
15	Улсын захиалгат ажил, цалин хөлсөө Төрийн сангаас санхүүжүүлээд, бусад зардал төсвөө үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх нь зөв	1.5	1.9
16	Салбар хүрээлэнгүүдийн дэргэд төрийн өмчит бус хүрээлэн эрх мэдлийн хүрээнд үйл ажиллагаанд нь оролцдог үйлдвэрийн газруудыг ажиллуулах	1.5	1.9
17	Төр, хувийн хэвшлийн төвүүдтэй чөлөөтэй хамтран ажиллах бололцоог нээж, санхүүгийн нэмэлт хөшүүргийг нэмэгдүүлэх	4.6	5.7
18	Эрдэм шинжилгээний ажилтны цалингийн сүлжээг өөрчлөх	1.5	1.9
19	Хүрээлэнгүүдэд төсөл хэрэгжүүлэх квот өгөх	1.5	1.9
20	Хүн бүр төсөл дэвшүүлж байгаа нь хэт үрэлгэн хүч нь тарамдсан байдалтай байна	1.5	1.9
21	Сэдэв, төслийн удирдагч нарын эрдэм шинжилгээний зардлын зарцуулалтад хяналт тавих	1.5	1.9
22	Гарааны компани байгуулах, төсөл хөтөлбөрт оролцох	1.5	1.9
23	ЭШ-ний ажилтнууд сэдэв, төсөл санаачлах, удирдахад зэрэг дэв, удирдлага мөн эсэхээс хамааралгүй тэгш оролцох боломжтой байх	1.5	1.9
24	Үйл ажиллагааны орлогоос тодорхой татвар аваад менежмент хийх боломжийг хүрээлэнд өгөх	1.5	1.9
25	Улсын төсөвт шинжлэх ухаанд зарцуулах төсвийг жил бүр тодорхой хувиар нэмэгдүүлэх	1.5	1.9
26	Салбар яамдтай нягт холбоотой ажиллах	1.5	1.9
27	Орон тоогоор санхүүжүүлэх	1.5	1.9
28	Төсөл сонгон шалгаруулах	1.5	1.9
29	Хувийн хэвшлийн ЭШ-ний байгууллагуудад зэхэц ажлын зээл олгох гэх мэтээр санал, санаачлагад чиглүүлж санхүүжүүлэх	1.5	1.9
30	Эрдэмтдийн саналыг дэмжих	1.5	1.9
31	Эрдэмтдэд санхүүжилт олгож, үр дүнг тооцдог байх нь чухал (үр дүнд суурилсан санхүүжилт)	3.1	3.8
32	Суурь судалгааг төрөөс санхүүжүүлдэг байх	1.5	1.9
33	ШУА салбарын яамдуудтай нягт уялдаатай ажиллах хэрэгтэй	1.5	1.9
34	Төсвийг тусад нь болгох	1.5	1.9
35	Төсвийн бус данстай болгох	4.6	5.7
36	Хүрээлэн төвийн захиралд илүү эрх мэдэл олгох	1.5	1.9
37	Төслийн хэлбэрээс хамааруулан тэдгээрийг сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулах	1.5	1.9
38	Хүрээлэнгүүдийг институтцийн хувьд бэхжүүлэхийн тулд суурь санхүүжилтийг байгууллага санхүүжүүлэх зарчмаар болгох	1.5	1.9
39	Судлаачдын идэвх санаачлага үгүйлэгдэж байна	1.5	1.9

40	Одоогийн санхүүжилтийг хэвээр хадгалан, нэмэлт санхүүжилт олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх	3.1	3.8
41	ЭШБ-ыг тендерт оролцох эрх олгох	1.5	1.9
42	Томилолтын нэмэгдүүлэх, хоногийн 12000 төгрөг нь 1 таваг хоолны мөнгөөр томилолт олгож байгаа нь хүрэлцэхгүй байна. Байгаль дээр хүнд хэцүү нөхцөлд амралтын өдөргүй ажилладаг.	1.5	1.9
43	Суурь санхүүжилтэй болгох	1.5	1.9
44	ЭШ-ний зардлыг нэмэгдүүлэх	1.5	1.9
45	Суурь судалгааны төслийг багаар өгч байх	1.5	1.9
46	Санхүүжилтийн журмыг боловсронгуй болгох хэрэгтэй. Зорилтот хөтөлбөр дээр хүрээлэнгүүд нэгдэж ажиллах хэлбэрийг нэвтрүүлэх	1.5	1.9
47	Санхүүжилтийн журам механизмыг боловсронгуй болгохдоо төсөл сэдвийн хүрээнд гүйцэтгэлээр урамшуулал, цалинг, олгох, хавтгайруулахгүй байх	1.5	1.9
	Бүгд	100.0	122.6

**31. Шинжлэх ухааны академийн үйл ажиллагааны санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийн тулд юу хийх шаардлагатай гэж бодож байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	ШУА-ийн Ерөнхийлөгчийг хүрээлэнгүүдийн төсвийн ерөнхийлөн захирагч болгох	6.5	40.2
2	Үйл ажиллагааны орлогоороо санхүүгийн менежмент хийх боломж олгох	11.0	68.6
3	Төрөөс олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх	12.8	79.4
4	Санхүүжилтийн олон эх үүсвэртэй болохыг эрэлхийлэх, мөнгөн бус хэлбэрийн дэмжлэгийг сайшаах, харилцан тусалж хамтдаа хөгжих хэлбэрийг ашиглах	8.5	52.9
5	Судалгааны үр дүнг практикт нэвтрүүлэх зардал мөнгө төлөвлөж байх	9.9	61.8
6	Судалгаа, туршилтын ажлын үнэлэмжийг дээшлүүлэх	9.9	61.8
7	Улс орны томоохон төсөл хөтөлбөрт ШУА-ийн хүрээлэнгүүдэд зөвлөх, экспертийн үйлчилгээ үзүүлэх эрх олгох	10.9	67.6
8	Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх	8.4	52.0
9	Хувийн хэвшлийн байгууллагуудыг ШУ-ны салбарт оруулсан хөрөнгө оруулалтаар нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх	9.3	57.8
10	Гадаадын байгууллагуудтай хамтарсан төслийг төрөөс дэмжих	11.8	73.5
11	Гадаадтай хамтарсан төслийн хууль эрхийн тэнцвэрт байдлыг хангах	0.2	1.0
12	Хүрээлэнгүүдэд тогтмол суурь санхүүжилт, төсөв өгч түүнийгээ захиран зарцуулах эрх мэдлийг олгох	0.2	1.0
13	Судалгааны үр дүн, бүтээгдэхүүн борлуулдаг өөр байгууллага байх хэрэгтэй	0.2	1.0
14	ОУ-ын мега төслүүдэд монгол эрдэмтдийн оролцоог төрөөс бодлогоор дэмжих	0.2	1.0
15	Салбарын яамд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төлөвлөгөөг санхүүжилтийн хамт жил бүр гаргаж, хэрэгжүүлж байх	0.2	1.0
	Мэдэхгүй	0.2	1.0
	Бүгд	100.0	621.6

**ШУТ-ИЙН АЖЛЫН ҮР ДҮН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨ**

**32. Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд шинжлэх ухааны аль салбарт илүү анхаарал хандуулах, хөрөнгө оруулах шаардлагатай гэж үзэж байна вэ?**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	Геологийн ухаан	1.8	4.0
2	Байгалийн ухаан	17.9	39.6
3	Нийгэм, хүмүүнлэг	8.9	19.8
4	Эдийн засаг	2.2	5.0
5	Мэдээллийн технологи, ИТ	1.8	4.0
6	Хууль эрх зүй	0.4	1.0

7	Техник технологи	11.6	25.7
8	Биологийн ухаан	1.3	3.0
9	Анагаах ухаан	5.8	12.9
10	Ургамал судлал	0.4	1.0
11	Биотехнологи	2.7	5.9
12	Хөдөө аж ахуй /МАА, Газар тариалан/	17.4	38.6
13	Хими технологи	2.2	5.0
14	Эрчим хүч, нарны эрчим хүч г.м сэргээгдэх эрчим хүч	0.9	2.0
15	Геофизик	0.4	1.0
16	Үйлдвэр технологи, аж үйлдвэр, боловсруулах үйлдвэр, МАА-н түүхий эд боловсруулах үйлдвэр	1.8	4.0
17	Аялал жуулчлал	2.2	5.0
18	Хөнгөн үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн боловсруулах салбарт	1.3	3.0
20	Уул уурхай	2.2	5.0
21	Аль илүү бүтээмжтэй ажиллаж байгаа салбарт нь хөрөнгө оруулах	0.4	1.0
22	Мал эмнэлэг	0.9	2.0
23	Молекул биологи	0.4	1.0
24	Генетик, генийн инженерчлэл	0.4	1.0
25	Боловсрол	0.9	2.0
26	Бүх салбарт	1.3	3.0
27	Инноваци, өндөр технологи	3.1	6.9
28	Био-анагаах ухаан	0.4	1.0
29	Палентологи	0.9	2.0
30	Электроник	0.4	1.0
31	Материал судлал	0.4	1.0
32	Онолын суурь судалгааны салбар	2.2	5.0
33	Хэрэглээний судалгаа	1.3	3.0
34	Экологи	0.4	1.0
35	Нанотехнологи	0.4	1.0
36	Нийгмийн эрүүл мэнд	0.9	2.0
37	Уламжлалт анагаах ухаан	0.4	1.0
38	Монгол судлал	0.4	1.0
39	Хүнс	0.4	1.0
	Бүгд	100.0	221.8

**33. Таны бодлоор ШУ-ны салбараас нийгэм-эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд ямар алхмыг нэн даруй хийвэл зохих вэ?**

		Дээд доод утга	ХЕАӨ	Дундаж утга
1	Шинжлэх ухааны парк (Science Park) байгуулах	1,13	1.00	3.90
2	Инновацийг хөгжүүлэх, дэмжих хөшүүргийг сайжруулах	1,12	2.00	3.39
3	Судалгааны төв, хүрээлэнгүүдэд түшиглэсэн гарааны компани олноор байгуулах	1,13	2.00	4.10
4	Үйлдвэрлэгч, ААН-ийг эрдэмтэн судлаачидтай төр холбож өгөх	1,13	3.00	5.07
6	ШУА-ийн хүрээлэн, төвүүдийг хувийн хэвшлийнхэн болон их, дээд сургуультай хамтарч ажиллах менежментийг бий болгох	1,14	3.00	4.44
7	ШУА-ын дотоод бүтцэд анхаарч, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж ажиллах	1,10	1.00	3.77
8	ШУ салбарт санхүүжилтийн олон эх үүсвэр, төрөл хэлбэрийг ашиглах боломжийг бүрдүүлэх, дэмжих	1,14	2.00	4.05
9	ШУ-ны болон тухайн салбарт ажиллагсдын талаарх нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх	1,10	3.00	4.23
10	ШУ-ны оюуны бүтээл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг бодитой үнэлэх, оюуны үнэлэмжийг дээшлүүлэх талаар арга хэмжээ авах	1,11	4.00	4.00
11	ШУТ-ийн үр дүн, ололт, нээлтийг практикт нэвтрүүлэх, хэрэгжүүлэх механизм бүрдүүлэх	1,13	7.00	5.00
12	Техник технологийн үндэсний хэмжээний асуудлыг мэргэшсэн хүрээлэн хариуцан ажиллаж, судалгааны үр дүнг бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэлд нэвтрүүлэх тусгай менежмент хийх багийг тухайн хүрээлэнгүүд дээр байгуулах	1,14	6.00	5.19

13	Хууль эрх зүй, бодлогын баримт бичгийг мөрдөж, хэрэгжүүлэх тал дээр анхаарах	1,12	6.00	6.42
14	Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, /шинэчлэн найруулах г.м/	1,13	1.00	5.07
15	ШУА-ийн хүрээлэнгүүдийн Их дээд сургуулиудтай өрсөлдөх чадварыг дээшлүүлэх	11,11	11.00	11.0
16	Статусаа баталгаажуулах	7,7	7.00	7.00
17	Тэргүүлэх чиглэлээ өөрчилж мөрдөх	2,2	2.00	2.00
18	Хүний хүчин зүйл чухлыг дэмжих, үнэлэх	5,5	5.00	5.00
19	Салбарын санхүүжилтийг ДНБ-ний 1 хувьд хүргэх	1,1	1.00	1.00

**34. Танд судлан буй асуудлын хүрээнд холбогдох өөр бусад санал бодол, нэмж хэлэх зүйлээ бичнэ үү.**

		Хариултын хувь	Тохиолдлын хувь
1	ШУА-ийг улс төржүүлэхгүй	1.4	2.5
2	Засгийн газрын нэгж /яам агентлаг/ болгон статусыг өндөрсгөх	1.4	2.5
3	Хууль эрх зүйн орчныг шинэчлэх	1.4	2.5
4	ШУА-ийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, хүрээлэн төвүүдийн олсон орлогыг өөрсдөд нь буцаан зарцуулж, орчин үеийн тоног төхөөрөмжтэй болгох	1.4	2.5
5	ШУА дэргэдээ магистрантур, докторантурт сургадаг зөвлөлтэй болох	2.7	5.0
6	Боловсон хүчин, мэргэжилтэн бэлтгэхэд анхаарах хэрэгтэй	1.4	2.5
7	Гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөр олноор хэрэгжүүлэх	1.4	2.5
8	Залуучуудын мэдлэг боловсролыг дэмжих зорилгоор гадаад томилолтыг бүрэн шийдэж байх	1.4	2.5
9	Санхүүгийн бодит нөхцөлд баригдсан, бүтэц орон тооны механик тоонд баригдсан, сэтгэн бүтээх сэтгэлгээг хязгаарласан, ШУ-ны залгамж халаа алдагдаж буй тул тухайн салбар хөгжлийн бодлогоо өөрөө тодорхойлох нь чухал байна	4.1	7.5
10	Аль ч засаг аль ч намаас ангид ШУ хөгжих тогтвортой бодлого зориудаар улс үндэсний эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх хэрэгтэй	1.4	2.5
11	Боловсрол, спорт, урлагийн бодлогоос ангид ШУ технологийн яам бүхий цогц “жанжин штаб” байдлаар ШУА ажиллавал ойлгомжтой болно.	1.4	2.5
12	ШУА-д Геологийн хүрээлэнг сэргээн ажиллуулах, ажлын байраар хангах, лабораторижуулах	1.4	2.5
13	ЭША-гны зэрэглэлийг нарийвчлан тогтоож, цалингийн системийг эрс зөрүүтэй болгосноор судалгааны ажлын түвшинг ахиулах шинэ системд орох	2.7	5.0
14	Гадаадтай хамтарсан төсөл хөтөлбөрт улсаас дэмжлэг туслалцаа байвал сайн байна	2.7	5.0
15	Залуу судлаачдыг дэмжиж ажиллах	2.7	5.0
16	ШУА нь төсөв санхүүг захиран зарцуулах эрхтэй болж, зохион байгуулалт, менежментийг сайжруулах шаардлагатай байна	4.1	7.5
17	Санхүүжилтийг сайжруулж, материаллаг баазыг дээшлүүлэх, эцсийн үр дүн гаргах боломжтой лаборатори бий болгох хэрэгтэй	4.1	7.5
18	ЭШ-ний ажилтны нийгмийн асуудалд анхаарал түлхүү хандуулах	1.4	2.5
19	Эрдэм шинжилгээний зардлыг нэмэглүүлэх талаар менежмент хийх цаг болсон	1.4	2.5
20	Судалгааны ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	1.4	2.5
21	Бүтээлийн нийлүүлэлтээр цалин урамшуулал олгох	1.4	2.5
22	Оюуны бүтээлийг үнэлэх, оюуны өмчийн хамгаалалтыг сайжруулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох	1.4	2.5
23	Монгол улсын төрийн тогтолцоог сайжруулахад ШУ өөрөө үнэ цэнээ тогтоох ёстой	1.4	2.5
24	Байгалийн ухааны судалгааны шинэ үр дүнгүүдийг салбараар нь тусгайлан авч үзэх хэрэгтэй. Суурь судалгааны шинэ үр дүнг ойлголгүй үлддэг	1.4	2.5
25	Дэлхийн олон улсын төвүүдийн үйл ажиллагааг загвар болгон авах	1.4	2.5
26	Нийтийн боловсрол, дунд боловсролын судалгаа нь нэг цогц, нэгдсэн нэг улаан шугамаар явуулах ёстой	1.4	2.5

27	Хүмүүжил, боловсрол, шинжилгээ нэгэн нэгдсэн зүй тогтолтой байх ёстой	2.7	5.0
28	Сурах бичгийн чанар муу байгаа тохиолдолд ирээдүйд шинэ санаа, ШУ-ны мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэх нь хоосон зүйл болно	1.4	2.5
29	Олон улсын хамтын ажиллагаанд оролцон ажиллаж буй эрдэмтэд, багийн эзэмшсэн технологийг бусад салбаруудад нэвтрүүлэх	2.7	5.0
30	Олон газарт хэрэгжүүлж буй ижил төстэй сэдвүүдийг зохицуулах	1.4	2.5
31	Тодорхой асуудлыг олон талаас нь шийдэх төслийг удирдах	1.4	2.5
32	Судалгааны профессор цол олгох	1.4	2.5
33	ШУА-ийн грант төслийн төсөв, үр дүнг нэмэгдүүлэх	1.4	2.5
34	Аттестатчилал тодорхой болгох	2.7	5.0
35	ШУА-ийн шилдэг бүтээлийг үе шаттай шалгаруулах	1.4	2.5
36	ШУ-ы шилдэг бүтээлээр нь академичид нэр дэвшүүлэх	1.4	2.5
37	Нийгэм, хүмүүнлэгийн ухааны салбарын шинжлэх ухааны бүтээлийг инноваци болгох бодлого боловсруулах	2.7	5.0
38	Гадаад хурал цуглаанд оролцох зардлыг төсөвт тусгах	1.4	2.5
40	Урт хугацаанд хэрэгжиж үр дүн сайтай байхаар сэдэв, төслүүдийг сонгох, өрсөлдөөний баримт бичигтэй болох	2.7	5.0
41	ШУА дахь зөв дотоод ардчиллыг дэмжих	1.4	2.5
42	Тэргүүлэгч гишүүдийн эрх үүргийг нэмэгдүүлэх	1.4	2.5
43	Хүрээлэн төвүүдийн хамтын ажиллагааг өргөтгөхөд бодлого баримтлах	1.4	2.5
44	Системийг өөрчлөх	1.4	2.5
45	Нөхөн сэргээх үйл ажиллагааг гарааны компани байгуулах замаар шийдэх. Эхний удаад төрөөс дэмжиж дараа нь бие даах нөхцөлийг хангах	1.4	2.5
46	ШУ-ныг зохистой хөгжүүлэхэд шаардлагатай бодлого, эрх зүйн орчинг бий болгож цогцоор нь 1-2 жилд багтаан цэгцлэх	1.4	2.5
47	ШУА-ийг “Монгол улсын ШУ-ны төв байгууллага мөн” гэсэн статусыг бодитой болгох	1.4	2.5
48	ЭШ-ий ажилтны цалинг 50-100 нэмэгдүүлэхэд чиглэн оюуны бүтээл, хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэх	1.4	2.5
49	Үүрэг тодорхой байж менежмент, хариуцлага, үнэлэмж сайн байх	1.4	2.5
50	Суурь ба хавсарга ШУ-ны судалгааны чиглэлээ тогтоох	1.4	2.5
51	Өнгөрсөн хугацаанд судалсан ажлуудыг бүртгэн нэгтгэн дүгнэдэг ШУ-ны фонд байгуулах	1.4	2.5
52	ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдтэй уялдаа муутай ажилладаг	1.4	2.5
53	УХЭШХ нь ХААЯ-ны төслөөр санхүүжилт босгодог бөгөөд БСШУЯ зөвхөн бичиг цаас нэхдэг газар	1.4	2.5
54	Инновацийн сан байгуулах	1.4	2.5
55	Мал, амьтны халдваргүй өвчний салбарт анхаарал хандуулж, төсөл хөтөлбөрөөр дэмжих	1.4	2.5
56	ШУ-ныг тэргүүлэх чиглэл болгох	1.4	2.5
58	Салбарын онцлогийг харгалзан журам, дүрмийг өөрчлөх (ХАА)	1.4	2.5
59	ШУ-ны аливаа салбарын хуралдаан, хууль, дүрэмд анагаахын салбарыг төлөөллийг оролцуулах	1.4	2.5
60	Монголын бэлчээрийн 70 хувь нь доройтсон тул бэлчээрийг сайжруулах талаарх судалгааны санхүүжилтийг шийдвэрлэх	1.4	2.5
61	Судалгааны үр дүнг сайжруулах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхийн тулд чадварлаг баг, менежмент хэрэгтэй. Үүний тулд хийдгээ хийсэн ч алдаа гаргадаггүй хашир туршлагатайгаас илүү удирдлан зохион байгуулах, сорилт туршилтыг давж чадах удирдлагын залуу хамт олон хэрэгтэй байна	1.4	2.5
62	Суурь судалгааны сэдэв, хавсарга судалгааны сэдэвт ажил улс орны тулгамдсан асуудалтай уялдаа муутай		
	Бүгд	100.0	185.0

**Судалгаа авсан газар**

код		Давтамж	Хувь
1	Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэн	7	6.7
2	Геологи, палентологийн хүрээлэн	8	7.6
3	Одон орон, геофизикийн хүрээлэн	4	3.8

4	Түүх, археологийн хүрээлэн	4	3.8
5	Хэл, зохиолын хүрээлэн	5	4.8
6	Хими, хими технологийн хүрээлэн	4	3.8
7	Физик, технологийн хүрээлэн	8	7.6
8	Хөнгөн үйлдвэрлэлийн судалгаа хөгжлийн хүрээлэн	3	2.9
9	ШУТИС	2	1.9
10	Уул уурхайн хүрээлэн	6	5.7
11	Ой модны хүрээлэн	5	4.8
12	Философийн хүрээлэн	5	4.8
13	Газар зүй, геоэкологийн хүрээлэн	5	4.8
14	Нүүдлийн соёл, иргэншлийн хүрээлэн	2	1.9
15	Олон улсын харилцааны хүрээлэн	4	3.8
16	Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн	3	2.9
17	Анагаах ухааны хүрээлэн	3	2.9
18	Ургамал хамгааллын ЭШ-ний хүрээлэн	2	1.9
19	МАН-н ЭШ-ний хүрээлэн	6	5.7
20	Мал эмнэлгийн хүрээлэн	4	3.8
21	АУШУИС	1	1.0
22	БСШУСЯ	6	5.7
23	ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар	7	6.7
24	Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн	1	1.0
	Бүгд	105	100

### 3.3. Дэлхийн улс орнуудын үндэсний Шинжлэх ухааны академиудын статус (бүтэц, зохион байгуулалт), үйл ажиллагаа, санхүүжилтийн харьцуулсан шинжилгээ

Дэлхийн улс орнуудын үндэсний Шинжлэх ухааны академиудын статус (бүтэц, зохион байгуулалт), үйл ажиллагаа, санхүүжилтийн харьцуулсан шинжилгээнд багтсан улс орнуудын мэдээлэл-лавлагааг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тусгаар тогтносон улс орнуудын нийт хүн амын нягтаршил болон НҮБ-ын 2015 оны дэлхийн хүн амын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээлэлд тулгуурлан гаргадаг. Дэлхийн хүн амын хэгийн төлөвд хийсэн шинжилгээг үндэслэн, НҮБ-ын Статистикийн хэлтсээс бэлтгэсэн дэлхийн улс орнуудын газар нутгийн байршлын газарзүйн схемчлэлээр хийгдсэн тоо баримтад тулгуурласан тоо баримтыг ашиглан боловсруулав.

Харьцуулсан шинжилгээнд багтсан хүн амын тоонд НҮБ-ын гишүүн 191 орноос 37 орныг тусгайлан сонгож, улмаар тухайн орнуудын "дундаж орлого"-ын зохицлыг тодруулан гаргах байдлаар улс орнуудын газар нутгийн хэмжээ, тив, дэлхийн хүн амын тоонд эзлэх хувь болон засаглалын хэлбэрийн хувьд 'нэгдсэн-unitary countries' ба 'холбооны-federal countries' гэсэн ангиллаар хувааж үзсэний зэрэгцээ эл ангиллаар тухайн улс орнуудыг хүн амын нягтаршил, газар нутгийн болон ДНБ-ний эзлэх хувийн жингээр тус тус дэд ангилал үүсгэн харьцуулалт хийж, үсгийн дарааллаар ангилал үүсгэж бэлтгэв.

Мэдээллийн эх сурвалжийн хувьд олон улсын шинжлэх ухааны академийн нэгдсэн сан болох ([www.interacademies.net](http://www.interacademies.net)) –д бүртгэгдсэн мэдээлэл болон тухайн улсын ШУА, түүний холбогдох мэдээллийн сайт, статистикийн мэдээллийн сан зэрэгт хайлт хийж цуглуулав. Харьцуулсан шинжилгээнд багтсан улс орнуудын төсвийн зарцуулалтын ДНБ-ний эзлэх хувиар тооцсон мэдээллийг (Төр улсуудын засгийн газар: Дэлхийн улс орнуудын улс төрийн тогтолцооны гарын авлага. Орч. Цэрэннадмид Ч, Билгээ Г, Долгорсүрэн Ч. УБ., 2012) хэмээх товхимлоос эх сурвалж болгон ашигласан.

Хүснэгтэн мэдээлэл дэх бүх улс орнуудын хүн амын тоог 2016 оны 12-р сарын байдлаарх НҮБ-ын статистик мэдээгээр бэлтгэж орууллаа.

#### 1.АВСТРАЛИ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Далайн эргийн/Австрали, Шинэ Зеланд
Хүн амын тоо	0.325%
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	24,339,700
Засаглалын хэлбэр	нэгдмэл, бүгд найрамдах улс

<p><b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b></p>	<p><i>Австралийн ШУА (The Australian Academy of Sciences)</i> Эзэн хааны Лондоны нийгэмлэг Австралийн судлаачид 1954 онд тус Академийг үүсгэн байгуулж тухайн үеийн нэрт физикч Сэйр Марк Олифант ерөнхийлөгчөөр томилогдож байжээ. Эзэн хааны зарлигаар байгуулагдсан тус академи нь засгийн газраас хараат бус бие даасан байгууллагын статустай. Академийн эрх зүйн байдлын тухайн ерөнхий хууль нь Эзэн Хааны Лондоны Нийгэмлэгийн дүрэм, эрх зүйн байдлын дүрэмтэй ижил. Энэ нь өөрийн үйл ажиллагааг боловсруулан хэрэгжүүлэхдээ Засгийн газраас тодорхой хэмжээний татаас, тэтгэлэг авахыг хуулиар тогтоосон байна. Академийн зорилго нь орон нутагт эрдэм шинжилгээ, судалгааны болон шинжлэх ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, мөн шинжлэх ухааны салбарыг дэмжин хөгжүүлэхэд дараах дөрвөн үндсэн чиглэлээр а) шинжлэх ухаанч ололтуудыг хөгжлийн үйл явцад хувь нэмэр болгон ашиглах, хүлээн зөвшөөрөх; б) боловсрол, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх; в) шинжлэх ухаанч бодлогыг түгээх, зохицуулах; г) Олон улсын харилцааг өргөжүүлэхэд оршино.</p>
<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Австралийн судалгаа шинжилгээний төвүүд, сургалт-судалгааны олон хөтөлбөрүүдэд ажиллаж байгаа судлаачдын хувьд хүмүүнлэг, нийгмийн болон байгалийн шинжлэх ухааны салбар бүрт хамтын ажиллагааг харилцааны нэг чухал зүйл хэмээн үзэж салбарын судлаачид харилцан уялдаатай үйл ажиллагааг өрнүүлдэг. Тухайлбал судалгааны хамтын бүтээл гаргах, үр дүнд суурилсан аналитик шинжилгээ хийх, түүнчлэн судалгааны үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах, шинжлэх ухааны ололтуудыг сурталчлах, үр дүнг хүртээмжтэй болгох зорилгоор ард нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр бодлогын болон шинжлэх ухааны суурь судалгааг хийж гүйцэтгэдэг. Мөн төр засгийн болон судалгааны байгууллагуудын хоорондын харилцааг өргөжүүлэх, хамтран ажиллах, зөвлөмж өгөх зэргээр хамтран ажилладаг байна. Академийн эрх зүйн болон дотоод дүрэм журам нь Лондоны Эзэн хааны нийгэмлэгийн нэгэн адил хэлбэрээр ажиллах бөгөөд засгийн газарт албан ёсоор шууд харьяалагдахгүй, үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийг засгийн газрын захиалга, грант ажлын хэлбэрээр гүйцэтгэдэг байна.</p> <p>Үндэсний ШУА нь улс орны шинжлэх ухааны ололт амжилтыг ард түмний өдөр тутмын үйл ажиллагаа болон тодорхой хөтөлбөр арга хэмжээний хүрээнд шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд 21 Үндэсний комиссоор дамжуулан үндсэн зорилгоо биелүүлэхийн төлөө дараах чиглэл, хөтөлбөрүүдийг нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх үүрэгтэй.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Австралийн шинжлэх ухааны ололт амжилтыг мэдлэг суурилсан бодлого хөтөлбөрийн хүрээнд хөгжүүлэх, чадавхийг дээшлүүлэх,</li> <li>- Австралийн шинжлэх ухааны арга зүй, бүтээн байгуулалтыг олон улсын төвшинд түгээх, түүнийг хөгжүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй үр дүнг түгээн дэлгэрүүлэх, мэдлэгийг түгээх,</li> <li>- Шинжлэх ухааны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн ухамсрыг нэмэгдүүлэхэд идэвхтэй санаачилгатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх,</li> <li>- Хараат бус бие даасан байдлыг хамгаалах, шинжлэх ухааны заавар зөвлөмжийг түгээх, боловсронгуй болгоход үндсэн чиг үүргээ чиглүүлдэг.</li> </ul>

<b>ЭША-нуудын тоо</b>	Эзэн хааны Лондоны нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр байгуулагдсан Австралийн ШУА 500 гаруй эрдэм шинжилгээний ажилтантай. Тус академи ашгийн бус бие даасан статустайгаар засгийн газарт боловсрол, эрдэм шинжилгээ, олон улсын харилцаа, бодлогын судалгааны чиглэлээр шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого боловсруулах, шийдвэр гаргахад чиглэгдсэн зөвлөх үйлчилгээ үзүүлж байна. Эдгээр арга хэмжээг нэгдсэн зохион байгуулалтаар хангахад Академийн Тамгын газар 65 хүний бүрэлдэхүүнтэйгээр ШУА-ийн Ерөнхийлөгчийн шууд удирдлага дор ажиллаж байна. Нийтдээ тус академийн хэмжээнд 565 эрдэм шинжилгээний ажилтан байгаа нь нийт хүн амын 0.0023 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 23213 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Австрали Улсын төсвийн зарцуулалтын 4.8% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Академи нь Хойд Америк, Европ, Зүүн Хойд Азийн олон улсын шинжлэх ухаан, технологийн хөгжүүлэх олон улсын шинжлэх ухааны хамтын ажиллагааны хөтөлбөрийг санаачлан хэрэгжүүлдэг. Шинжлэх ухааны академиас санаачлан хэрэгжүүлж буй аливаа төсөл хөтөлбөрүүд нь Австралийн Инноваци, аж үйлдвэрийн яам, Засгийн газрын болон олон улсын шинжлэх ухааны хамтын байгууллагуудаас санхүүждэг.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.abs.gov.au/AUSSTATS/abs@.nsf/Web+Pages/Population+Clock?opendocument/">http://www.abs.gov.au/AUSSTATS/abs@.nsf/Web+Pages/Population+Clock?opendocument/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Australia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Australia.aspx</a> <a href="https://www.science.org.au/">https://www.science.org.au/</a>

## 2. АВСТРИ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Баруун Европ
<b>Хүн амын тоо</b>	8,767,919
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.117%
<b>Засаглалын хэлбэр</b>	холбооны, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Австрийн ШУА (Austrian Academy of Sciences)</i> Австрийн ШУА нь Европын ууган академиудын нэг бөгөөд 1847 онд байгуулагджээ. Академи нь Австрийн тэргүүлэх их сургуулийн харьяанд бус бие даасан байгууллага болохын хувьд бусад шинжлэх ухааны нийгэмлэгийг тэргүүлж байна. Академи одоогоор 28 эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнтэй. Австрийн ШУА бол Австрийн Холбооны улсын төрийн хамгаалтад байх хуулийн этгээд мөн бөгөөд түүний эрхэм зорилго бол шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн ухааны бүхий л салбарыг дэмжин хөгжүүлж, улмаар суурь судалгааг бэхжүүлэн хөгжүүлэхэд оршино. Академи нь математик ба байгалийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ба нийгмийн шинжлэх ухааны үндсэн хоёр салбарт хуваагдана. 1960-иад оны дунд үеэс их дээд сургуулиудын суурь судалгааны салбарыг тэргүүлэн ажиллах болсноор эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжлийн байгууллага болон төлөвшихөд ихээхэн хүчин чармайлт гаргасан байна.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Австрийн ШУА нь Европын бусад улс орнуудын нэгэн адил шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг, мэдээллийг олон нийтэд түгээх улмаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг практикт нэвтрүүлэх зорилгыг чухалчлан үзэхийн

	зэрэгцээ их дээд сургуулиудаас хараат бус бие даасан статустай. Тус академийн харьяанд 65 эрдэм шинжилгээний хүрээлэн хамрагдах бөгөөд үндсэн хоёр салбарт буюу Математик, Байгалийн ухааны салбар, Хүмүүнлэг, Нийгмийн шинжлэх ухааны салбарт хуваагдана. ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулиар Австрийн ШУА нь одоогийн байдлаар 90 хүртэлх тооны жинхэнэ гишүүдтэй (салбар тус бүрээс 45 эрдэмтэн сонгуулийн журмаар сонгогдоно), сурвалжлагч гишүүдийн тоо 250 (салбар тус бүрээс 125 эрдэмтэн сонгогдохоос Австриас 55, гадаад орнуудаас 70 эрдэмтэн сонгогдоно, чингэхдээ эдгээр гишүүд нь насны хувьд 70 наснаас доош байна). Одоогийн байдлаар тус академийн нийт гишүүдийн тоо 600 гаруй байна.
<b>ЭША-нуудын тоо</b>	Австрийн ШУА болон түүний харьяа 28 эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд 1.400 эрдэм шинжилгээний ажилтнууд ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.016 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 1596 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Австри Улсын төсвийн зарцуулалтын 6.3%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Австрийн ШУА нь бүтцийн шинэ зохион байгуулалтын дагуу суурь болон хавсарга судалгаануудыг төрийн болон хувийн хэвшлийн шууд хөрөнгө оруулалт, олон улсын хэмжээний томоохон суурь болон онолын судалгааны санхүүжилтээр гүйцэтгэж байна.
<b>Тайлбар</b>	Австрийн ШУА-ийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололт амжилтыг улс орны хөгжилд хандуулахаас гадна Австрийн гадаад харилцааг өргөжүүлэх, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг ойртуулах үүднээс Женев дэх судалгаа, шинжилгээний төвийг байгуулан ажиллаж байна. Одоогоор тус академи нь ЕХ-ны орнуудын 43 улсын 47 ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй хамтран ажиллаж эрдэмтэн солилцоо, судалгааны мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулж байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.statistik.at/web_de/statistiken/menschen_und_gesellschaft/bevoelkerung/">http://www.statistik.at/web_de/statistiken/menschen_und_gesellschaft/bevoelkerung/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Austria.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Austria.aspx</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Austria/12271.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Austria/12271.aspx</a>

### 3. АЗЕРБАЙЖАН УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази/Баруун Ази
<b>Хүн амын тоо</b>	9,784,600
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.13%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, олон намын ардчилсан хагас-ерөнхийлөгчийн засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<b>Азербайжан Улсын Үндэсний ШУА (Azerbaijan National Academy of Sciences)</b> 1920-иод оны эхээр Азербайжаны эрдэм шинжилгээ, судалгааны гол төв Бакугийн Улсын Их Сургуульд төвлөрч байв. 1920-22 оны үед Хүмүүнлэг, анагаах ухаан, байгалийн шинжлэх ухааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны мэргэжлийн холбоод байгуулагдаж эхэлжээ. 1945 онд Азербайжан Улсын Шинжлэх ухааны академи нь нийслэл Баку хотод байгуулагдаж,

	улмаар тус улсын шинжлэх ухааны төв байгууллага боллоо хөгжсөн байна. 2001 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн Азербайжан Улсын төрийн тэргүүний зарлигаар Азербайжаны ШУА-ийг Азербайжаны Үндэсний ШУА болгон өөрчлөн зохион байгуулжээ. Үндэсний ШУА нь Физик, математик, техникийн шинжлэх ухааны салбарт физикийн (675); удирдлагын системийн (332); математик-механикийн (221); радио-долгионы (281); астрологийн ажиглалтын (142); мэдээлэл-технологийн (500), биофизикийн (165) хүрээлэнгүүд (ЭША-2316) багтана.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	<b>Химийн шинжлэх ухааны салбарт</b> Петро-химийн процессийн (546); Катализатор болон органик бус химийн (495); Химийн нэмэлт хангамж үйлдвэрлэлийн (226); Полимер материал үйлдвэрлэлийн (263) хүрээлэнгүүд (ЭША-1530) багтана. <b>Дэлхий судлалын шинжлэх ухааны салбарт</b> Байгалийн хий, газрын тосны (206); Газар зүйн (207); Геологи, геофизикийн (533); Газар хөдлөлийн судалгааны төв (403)-үүд (нийтдээ 1349 ЭША) багтана. <b>Биологи, анагаахын шинжлэх ухааны салбарт</b> Молекул биологи, биотехнологийн (211); Ботаникийн (276); Амьтан судлалын (227); Физиологийн (170); Микробиологийн (78); Ботаникийн төв цэцэрлэг (128); Дендрологийн (168); Хөрс судлал, агро-химийн (202); Генетикийн нөөцийн судалгааны (323) хүрээлэнгүүд (нийтдээ 1644 ЭША) багтана. <b>Хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарт</b> Эх бичиг судлалын (243); Архитектур, урлаг судлалын (120); Ардын аман зохиол судлалын (211); Азербайжаны Утга зохиолын Үндэсний музей (189); Утга зохиолын (243); Хэл шинжлэлийн (138) хүрээлэнгүүд (нийтдээ 1019 ЭША) багтана. <b>Нийгмийн шинжлэх ухааны салбарт</b> Археологи, угсаатны зүйн (269); Философийн (220); Эдийн засгийн (177); Эрх зүй, хүний эрхийн (75); Шинжлэх ухааны түүхийн (20); Кавказ судлалын (26); Азербайжаны Үндэсний түүхийн музей (186); Түүхийн (275); Дорно дахины (149) хүрээлэнгүүд (нийтдээ 1397 ЭША) багтана.
<b>ЭША-нуудын тоо</b>	Одоогийн байдлаар тус улсын ШУА-д 7000 эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачид ажиллаж байна. Азербайжаны үндэсний ШУА-ийн жинхэнэ гишүүн буюу академичид 63, сурвалжлагч гишүүд 61, шинжлэх ухааны доктор 335, боловсролын доктор 1080 ажиллаж байна. Нийтдээ тус академийн хэмжээнд 7000 эрдэм шинжилгээний ажилтан байгаа нь нийт хүн амын 0.071 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 715 хүн ногдог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Азербайжан улсын төсвийн зарцуулалтын (ДНБ-ний эзлэх хувиар) 1.8% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг байна. Азербайжаны Үндэсний ШУА, түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь улсын төсвөөс санхүүждэг төсвийн байгууллага бөгөөд БН Азербайжан Улсын Ерөнхийлөгчийн шууд ивээл дор үйл ажиллагааг явуулдагараа онцлог. Академийн хүрээлэнгүүд нь олон улсын төсөл хөтөлбөрүүдэд оролцож сонгон шалгаруулалтын дүнд бусад нэмэлт санхүүжилтийг олохоос гадна үндэсний томоохон байгууллагуудын захиалгат судалгааг гүйцэтгэх замаар санхүүгийн нэмэлт эх үүсвэрээ бүрдүүлдэг.
<b>Тайлбар</b>	Улмаар ШУА-ийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгож өөрчилснөөр ШУА нь үндэсний хэмжээний статустай, шууд Ерөнхийлөгчийн ивээл дор ажиллахын зэрэгцээ Академийн нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлага үлэмж нэмэгдэж, шинэ зорилт, хөтөлбөрийг дэвшүүлэн ажиллах боломжийг бий болгожээ.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://news.lent.az/news/259568">http://news.lent.az/news/259568</a> <a href="http://science.gov.az/">http://science.gov.az/</a>

## 4.АРМЕНИ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Ази/Баруун Ази
Хүн амын тоо	2,993,900
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.04%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, парламентын засаглалтай бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>БН Армени Улсын Үндэсний ШУА (National Academy of Sciences of Armenia/NAS RA)</i> Армений Үндэсний Шинжлэх ухааны академи нь 1943 онд бие даасан хараат бус шинжлэх ухааны төв байгууллагын статустай байгуулагджээ. Үндэсний ШУА нь 50 гаруй хүрээлэн, технологийн төвүүдийг өөртөө нэгтгэсэн бөгөөд байгаль, техникийн болон хүмүүнлэгийн ухааны чиглэлээр суурь болон хавсарга судалгааг хийдэг. Тус академи Физик, математик, техникийн шинжлэх ухаан, Байгалийн шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн шинжлэх ухааны төлөөллөөс бүрдсэн бөгөөд шинжлэх ухааны солилцооны хөтөлбөр зохион байгуулж, дэлхийн шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажилладаг.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Армени Үндэсний ШУА нь шинжлэх ухаан, судалгааны хүрээлэнгүүдтэй төрийн ивээлд үйл ажиллагаа явуулдаг байгууллага бөгөөд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар, түүний харьяа 34 эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны төвүүдээс бүрддэг байна. Тус академи нь шинжлэх ухааны дараах үндсэн 5 салбарт хуваагдаж судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулдаг байна. Математик, техникийн шинжлэх ухааны салбар Физик, астро-физикийн салбар Байгалийн шинжлэх ухааны салбар Хими-дэлхий судлалын шинжлэх ухааны салбар Армени судлал, нийгмийн шинжлэх ухааны салбарт хуваагдах бөгөөд хэд хэдэн хүрээлэн нь туршилтын болон тусгай загварчилсан болон нарийвчилсан судалгааны лаборатори, ботаникийн цэцэрлэгтэй. Түүнчлэн ШУА-ийн Тэргүүлэгчдийн газар нь шинжлэх ухааны төрөлжсөн эрдэм шинжилгээний номын сан, шинжлэх ухаан-мэдээллийн төв, шинжлэх ухаан-боловсролын олон улсын төв, эрдэм шинжилгээний хэвлэлийн үйлдвэр зэрэг бусад үйлчилгээний салбаруудыг багтаан ажилдаг.
ЭША-нуудын тоо	Армений ШУА-д нийтдээ 4100 эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид ажилладаг бөгөөд тэдний дунд 54 академич, 58 сурвалжлагч гишүүн, 360 орчим шинжлэх ухааны доктор, 1100 гаруй боловсролын доктор, 4 хүндэт гишүүн, 136 гадаад гишүүд, 52 хүндэт докторууд багтаж байна. Үндэсний ШУА-ийн Их чуулганы гишүүд нэг удаа 3 жилийн хугацаатай сонгогдоно. Армений үндэсний ШУА-ийн салбарт 4100 эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид байгаа нь нийт хүн амын 0.13 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 136 хүн ногддог байна.
Санхүүжилтийн байдал	БН Армени Улсын төсвийн зарцуулалтын 2%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Үндэсний шинжлэх ухаан, технологийн сангаас шууд санхүүжих бөгөөд олон улсын бусад тэтгэлгийн сангаас санхүүгийн нэмэлт

<b>(Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	эх үүсвэрийг бүрдүүлнэ. Үндэсний ШУА нь үндсэндээ улсын төсвөөс санхүүжих бөгөөд үйл ажиллагааны нэмэлт санхүүжилтийг бусад эх үүсвэрээс буюу хувийн судалгааны сан болоод Армений болон олон улсын бусад ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн академиудтай байгуулсан гэрээний хүрээнд гүйцэтгэсэн төсөл, грант ажлуудаас олдог байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.armstat.am/en/?nid=126&amp;id=19001&amp;submit=Search">http://www.armstat.am/en/?nid=126&amp;id=19001&amp;submit=Search</a> <a href="http://www.sci.am/">http://www.sci.am/</a> ; <a href="http://www.sci.am/">http://www.sci.am/</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Armenia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Armenia.aspx</a> ;

### 5.АФГАНИСТАН УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази/Өмнөд Ази
<b>Хүн амын тоо</b>	27,657,145
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.37%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, ерөнхийлөгчийн засаглалтай, Исламын БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Афганистаны ШУА (Academy of Sciences of Afghanistan/ASA)</i> нь одоогоос 80 жилийн өмнө буюу 1922 онд Гази Аманулах Ханы хаант улсын үед анхны шинжлэх ухааны байгууллага "Пашто Мрака" нэртэйгээр байгуулагдсан нь тус улсад шинжлэх ухааны салбар үүсэх үндсийг тавьжээ. 1928 онд тус байгууллага татан буугдсан хэдий ч 1930 онд Кабулын шинжлэх ухааны нийгэмлэг (the Kabul Academic Association), 1932 онд Хераг болон Паштын Шинжлэх ухааны нийгэмлэг (Herat Academic Association and Pashto Academic Association) тус тус байгуулагдсан байна. Пашто Толени бол Кабулын Шинжлэх ухааны нийгэмлэгийг үндэслэсэн нэгэн бөгөөд хожим тус академийг Кандахарын шинжлэх ухааны нийгэмлэгтэй 1937 онд дахин нийлүүлжээ. Афганистаны ШУА нь 1978 онд Пашто Толени нийгэмлэг болон Афганистаны түүхийн нийгэмлэг, Ариенагийн нэвтэрхий толины төв болон Паштогийн олон улсын судалгааны төвийн судлаачид хамтран үүсгэн байгуулсан түүхтэй.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Афганистаны ШУА нь Засгийн газрын Хэрэгжүүлэгч агентлагийн статустай ажилдаг бөгөөд Пашто, Дари перс хэлээр яригчдын хувьд судалгаа шинжилгээний үйл ажиллагаа явуулах тохиолдолд Тажикстан, Иран улсын Засгийн газрын агентлагуудын эрх зүйн баримт бичгийг баримталдаг байна. Мөн академи нийгмийн шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухаан, ислам шашин судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа гүйцэтгэнэ. Афганистаны ШУА нь нийгмийн шинжлэх ухааны судлал, байгалийн шинжлэх ухааны судлал, ислам судлал гэсэн 3 салбарт эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа гүйцэтгэдэг. Салбар тус бүр нь хэд хэдэн эрдэм шинжилгээний төвүүдтэй бөгөөд төвүүд дотроо хүрээлэнгүүдэд, хүрээлэнгүүд нь салбар нэгжүүдэд хуваагддаг байна.
<b>ЭША-нуудын тоо</b>	Афганистаны ШУА нь одоогоор 300 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид байгаа нь нийт хүн амын 0.0010 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 10847 хүн ногддог байна.

Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)	Афганистан улсын төсвийн зарцуулалтын 2% -ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг.
Тайлбар	Иргэний дайны үед Афганистаны шинжлэх ухаан салбар уналтад орж, дэд бүтэц, лаборатори, техник хэрэгслийн дутагдалтайгаар бодит үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй тулгарч эхэлсэн хэдий ч үүнийг бэхжүүлэхийн төлөө, мөн эрдэм шинжилгээний ажилтнуудын тоог нэмэгдүүлэхэд тодорхой алхмуудыг гүйцэтгэж байна.
Эх сурвалж	<a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Afghanistan.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Afghanistan.aspx</a>

## 6. БЕЛАРУСЬ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Зүүн Европ
Хүн амын тоо	9,505,200
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.127%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>БН Беларусь Улсын Үндэсний ШУА (National Academy of Sciences of Belarus/NASB)</i> нь 1929 онд тус улсын бүх салбарын авьяаслаг, тэргүүлэх зэргийн эрдэмтэд, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагын ажилтнуудын санаачилгаар байгуулагджээ. ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтнууд үндэсний дээд боловсрол, нийгэм-эдийн засгийн хөгжлийн инерцийг түргэсгэх, улмаар аж үйлдвэр, ХАА-н салбарт шинжлэх ухааны ололтыг нэвтрүүлэх, эрүүл мэнд, анагаах ухаан, нийгмийн ухааны бүх салбарт эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнд суурилсан үнэн бодит, баталгаатай үр өгөөжийг нэвтрүүлэх, ард иргэдийг шинжлэх ухааны үнэн бодит ололтоор гэгээрүүлэхэд чухалчлан анхаарна.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Беларусийн Үндэсний ШУА-ийн эрдэм шинжилгээний үйл ажиллагааны чиглэл нь онолын болон суурь судалгаа байхын зэрэгцээ нийгэм-хүмүүнлэгийн ухааны үндсэн чиглэл болох философи, гүн ухааны антропологи, нийгмийн экологи, ёс зүй, гоо зүйн судалгаа түүний арга зүйн асуудал, нийгэм, оюун санааны, соёл, шинжлэх ухааны дэвшлийн шинэлэг стратегийг боловсруулах, орчин үеийн нийгэм-улс төр, соёлын хөгжлийн бодит байдал, төлөвшлийн судалгаа, үндэсний гүн ухааны сэтгэлгээний ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, судалгаа шинжилгээний практик хэрэглээг дэмжихэд чиглэнэ.
ЭША-нуудын тоо	Академийн ажилтнууд болон түүний харьяа эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад нийтдээ 5.900 гаруй судлаачид, эрдэм шинжилгээний болон техникийн 11.200 ажилчид нийтдээ 17.100 ажилтан ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.17 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 179 хүн ногддог байна.
Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)	БН Беларусь Улсын төсвийн зарцуулалтын 5.6% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. ШУА болон түүний харьяа хүрээлэнгүүд нь төрийн санхүүжилтээр бүрэн санхүүжих бөгөөд суурь судалгааны сэдвийг Академийн зүгээс сонгон шалгаруулах зарчмаар нэмэлт санхүүжилтээр санхүүжих боломжтой.

Эх сурвалж	<a href="http://www.belstat.gov.by/en/">http://www.belstat.gov.by/en/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Belarus.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Belarus.aspx</a> <a href="http://nasb.gov.by/">http://nasb.gov.by/</a>

## 7.БНХАУ

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Ази/Зүүн Ази
Хүн амын тоо	1,381,150,000
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	18.5%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, нам төвт засаглалтай БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<p>Хятадын Шинжлэх ухааны академи нь (цаашид ШУА гэх) 1920 онд үүсгэн байгуулагдсан Бэйпингийн шинжлэх ухааны академи болон Синицийн академид суурилан 1949 оны 11 дүгээр сард үүсгэн байгуулагдсан. ШУА нь Хятадын байгалийн шинжлэх ухааны салбарын анхдагч академи бөгөөд тус улсын ШУА-ийн хүрээлэнгүүд болон бусад салбар хүрээлэн, нэгжүүд нь Хятад улсын 23 аймагт байрладаг байна. ШУА нь бүтцийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Академийн 6 салбар,</li> <li>• Академийн 6 салбарын харьяаны мерит зарчимд суурилсан 104 судалгааны хүрээлэн,</li> <li>• өөрийн шууд харьяаны 124 хүрээлэн,</li> <li>• 5 их сургууль,</li> <li>• дэмжлэг үзүүлэх хүрээлэнгүүд,</li> <li>• 3 нэгж,</li> <li>• 12 төлөөлөгчийн газар (үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг),</li> <li>• 25 хуулийн этгээд,</li> <li>• ШУА-ийн 22 хөрөнгө оруулалтын хувьцаат компанитай.</li> </ul> <p>ШУА-ийн хүрээлэн болон голлох салбар байгууллага бүр нь бие даасан, хараат бус хуулийн этгээд байна.</p>
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>ШУА-ийн удирдлагын төв нь Бээжин хотод байрлах бөгөөд академи болон түүний хүрээлэнгүүд, харьяа байгууллагуудыг бүхэлд нь академийн Ерөнхийлөгч удирдана. ШУА-ийн хууль ёсны төлөөлөгч болон гүйцэтгэх удирдлага нь ШУА-ийн эрдэм шинжилгээний салбаруудын Тэргүүлэгчдийн хурал байна. ШУА-ийн ерөнхийлөгч нь ажлаа Төрийн Зөвлөлийн (засгийн газар) өмнө шууд хариуцан тайлагнана. ШУА-ийн 12 төлөөлөгчийн газар нь хотууд болон ШУА-ийн хүрээлэнгүүд олноор төвлөрсөн газар байрлана. Эдгээр салбар нь орон нутгийн захиргааны</p>

	<p>байгууллагуудтай ШУА-ыг төлөөлөн харилцах бөгөөд тэдэнд зөвлөгөө болон бусад үйлчилгээ үзүүлнэ. БНХАУ-ын ШУА нь дараах 6 салбартай:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Математик, физикийн салбар</li> <li>• Хими технологийн салбар</li> <li>• Амьдралын шинжлэх ухаан, анагаах ухааны салбар</li> <li>• Эх дэлхий судлалын шинжлэх ухааны салбар</li> <li>• Мэдээллийн технологийн шинжлэх ухааны салбар</li> <li>• Технологийн шинжлэх ухааны салбар</li> </ul> <p>Мөн ШУА-ийн Ерөнхийлөгч, Тэргүүлэгчдийн даргын харьяанд түр хороо байх бөгөөд тэдгээр нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсролын хороо</li> <li>• Стратеги судлалын хороо</li> <li>• Академийн ажлын алба</li> <li>• Хөгжлийн стратегийн хороо байна.</li> </ul>
<b>ЭША-нуудын тоо</b>	<p>ШУА-ийн харьяа болон салбар хүрээлэнгүүдэд 63.000 албан хаагч, 49.000 мэргэшсэн судлаачид, ойролцоогоор 19.000 судалгааны профессор болон сурвалжлагч гишүүн профессоруудаас бүрдэнэ. Үүнээс ШУА-ийн мэрит зарчимд суурилсан нийгмийн шинжлэх ухааны 71 гадаад гишүүн, 744 гишүүн жинхэнэ гишүүн байна. Нийтдээ тус улсын шинжлэх ухааны салбарт 131.815 эрдэм шинжилгээ, судалгааны, техникийн ажилчид, албан хаагчид ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.0095 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 954.407 хүн ногддог байна. Шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь өөрсдийн үйл ажиллагаанд хамаарах хуулийн зохицуулалтын хүрээнд судалгаа шинжилгээний үйл ажиллагаа эрхлэхдээ хууран мэхлэх, залилах үйлдлийг гаргах, мухар сүсгийг дэмжих, оролцохыг хуулиар хориглоно.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>БНХАУ улсын төсвийн зарцуулалтын (ДНБ-д эзлэх хувиар) 2.3%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Төрийн санхүүжилтээр байгуулагдсан шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь тодорхой үүрэгтэй, шинжлэх ухаанч үнэлгээтэй, ил тод, нээлттэй, өндөр зохион байгуулалттай, стандартчлагдсан менежмент бүхий орчин цагийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын тогтолцоотой байж, Ерөнхийлөгч эсхүл бусад хүрээлэнгийн тэргүүн нь гол хариуцлагыг үүрэх ба шинжлэх ухаан, технологийн комисс зөвлөгөө өгч, ажилтан, албан хаагчдын хараа хяналтад судалгаа шинжилгээ хийгддэг, бусад байгууллагуудын мэргэжилтнүүдээс урьж удирдлага менежментэд оролцуулан олон нийтийн хяналтыг хэрэгжүүлдэг, ерөнхийлөгч тэргүүнийг томилохдоо өрсөлдөөнөөр сонгон шалгаруулдаг механизмыг бүрдүүлэх ёстой.</p>
<b>Тайлбар</b>	<p>Төрийн санхүүжилтээр байгуулагдсан шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь судалгаа шинжилгээ, технологийн нөөц баялгийг ашигтай, үр бүтээлтэйгээр хуваалцах, ашиглах механизмыг бүрдүүлнэ. Улсаас, төрийн мэдлийн бус байгууллагууд бие даан шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэн байгуулахыг дэмжиж ажиллах ба тэдний хууль ёсны эрхийг ашгийг баталгаажуулна. Төрийн бус байгууллагуудын</p>

	байгуулсан шинжлэх ухаан судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь хуулийн дагуу улсаас санхүүжиж буй аливаа судалгаа шинжилгээний төсөл, хөтөлбөрүүдэд тэгш эрхтэйгээр оролцох, өрсөлдөх эрхтэй. Ашгийн бус шинжлэх ухааны судалгаа, технологийн хөгжлийн хүрээлэнгүүд нь хуулийн дагуу холбогдох татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах боломжтой.
Эх сурвалж	<a href="http://data.stats.gov.cn/">http://data.stats.gov.cn/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/China.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/China.aspx</a> <a href="http://english.cas.cn/">http://english.cas.cn/</a>

## 8.БН СОЛОНГОС УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Ази/Зүүн Ази
Хүн амын тоо	50,801,405
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.68%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, ерөнхийлөгчийн засаглалтай БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>БН Солонгос Улсын Үндэсний ШУА (The National Academy of Sciences/KNAS)</i> нь 1954 оны 7 дугаар сард байгуулагджээ. 1988 онд батлагдаж 2013 онд нэмэлт, өөрчлөлт орсон “Үндэсний шинжлэх ухааны Академийн тухай” хуулиар одоогийн бүтэц, чиг үүргийн дагуу өөрчлөн байгуулагджээ. Үндэсний шинжлэх ухааны Академийн тухай ( <i>The National Academy of Sciences of the Republic of Korea Act</i> ) /1988 он/ хуулиар ШУА нь үндэсний ШУ-ны хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс судалгаа шинжилгээний хөтөлбөрийг дэмжих, хүмүүнлэгийн болон байгалийн шинжлэх ухааны салбарт онцгой амжилт гаргасан эрдэмтэд, судлаачдыг дэмжих зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага болохыг хуульчлан заасан. Үндэсний ШУА-ийн чиг үүрэг бол өөрийн орны эрдэмтэн судлаачдын эрдэм шинжилгээ судалгааны бүтээл, үр дүнг дэлхий нийтэд хүлээн зөвшөөрүүлэх, мөн судлаачдын мэдлэг чадвар, арга зүйг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухааны ололт амжилтыг улс орны хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулах судалгаа шинжилгээний ажилд дэмжлэг үзүүлэх явдал болно. Үндэсний академи нь эхэндээ Солонгосын соёл, соёлын өвийг хамгаалах тухай хууль (248 тоот) болон түүнийг дагаж мөрдөх хууль эрх зүйн баримт бичгээр баталгаажина. Шинжлэх ухааны үндэсний академийн ерөнхийлөгч болон дэд ерөнхийлөгчийг Ерөнхий Ассамблейгаас 2 жилийн хугацаатай томилох бөгөөд 1 удаа улируулан томилж болно. Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны хэлтэс, Байгалийн шинжлэх ухааны хэлтсийн захирал, хэсгийн дарга нарыг тухайн хэлтсийн болон хэсгийн нийт гишүүдээс сонгогдсон хүнийг 1 жилийн хугацаатай томилж мөн 1 удаа улируулан сонгож болно. Ерөнхий Ассамблей нь Шинжлэх ухааны үндэсний академийн дээд зөвлөлдөх байгууллага юм. Шинжлэх ухааны үндэсний академийн хуралдааныг Ерөнхий Ассамблейн хэлтсийн хуралдаан, хэсэг хуралдаан гэж ангилдаг. Академийн Ерөнхийлөгч шаардлагатай гэж үзвэл, эсхүл удирдах зөвлөлийн гурав ба түүнээс дээш гишүүд санал гаргасан тохиолдолд удирдах зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулна.

<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Тус улсын ШУА нь шинжлэх ухааны хөгжилд шаардлагатай дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шинжлэх ухааныг дэмжих үндэсний бодлогын зөвлөгөө, зөвлөмж гаргах;</li> <li>2. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэх үзүүлэх;</li> <li>3. Дотоод болон олон улсын эрдэм шинжилгээ, судалгааны хамтын ажиллагааг дэмжих, зохион байгуулах;</li> <li>4. Үндэсний шинжлэх ухааны салбарын шагнал</li> <li>5. Шинжлэх ухааны хөгжлийг дэмжих талаар бусад холбогдох асуудал.</li> </ol> <p>Үндэсний ШУА-иас 1986 онд Эрдэм шинжилгээ судалгааны санг байгуулж Үндэсний ШУА-ийн эрдэмтэд болон түүний харьяа хэлтсүүдийн судлаачдын дэвшүүлсэн эрдэм шинжилгээ судалгааны төслийн ажлыг санхүүжүүлэх, олон улсын ЭШ-ний бага хуралд оролцох, ЭШ-ний өгүүлэл бичиж нийтлэх зэрэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор үйл ажиллагаагаа явуулдаг байна. Академи Боловсролын яамны бүтцийн харьяа байгууллага Боловсролын яамны сайд эрхлэх асуудлын хүрээнд Шинжлэх ухааны үндэсний академийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.</p>
<p><b>ЭША-нуудын тоо</b></p>	<p>Үндэсний ШУА нь нийтдээ 150 орон тооны гишүүдтэй. Үүнээс Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны салбар 75, Байгалийн шинжлэх ухааны салбар 75 гишүүдтэй. Үндэсний ШУА-ийн удирдах албан тушаалтанд академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, Хүмүүнлэг, нийгмийн ухааны салбар болон Байгалийн шинжлэх ухааны салбар хариуцсан захирлуудтай байдаг. Энэ тоо нь нийт хүн амын 0.00029 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 29526.7 хүн ногддог байна.</p>
<p><b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b></p>	<p>Шинжлэх ухааны үндэсний академийн үйл ажиллагаанд шаардлагатай нарийвчилсан үйл ажиллагааны дүрмийг Ерөнхий Ассамблейгаас батлан хэрэгжүүлнэ. <i>Үндэсний шинжлэх ухааны Академийн тухай хуулийн 16 дугаар зүйлд</i>, Санхүүжилт хэсэгт: энэ хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүх зардлыг төрөөс санхүүжүүлэхээр заасан байна. БН Солонгос Улсын төсвийн зарцуулалтын 4.1%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Өмнөд солонгосын Үндэсний ШУА, түүний харьяа хэлтсүүд нь төрөөс шууд санхүүждэг бөгөөд жилийн төсөв нь 2008 оны байдлаар жилд 50 тэрбум вон буюу 4.5 тэрбум ам.долларын санхүүжилттэй.</p>
<p><b>Тайлбар</b></p>	<p>Шинжлэх ухааны үндэсний академийн үйл ажиллагаанд шаардлагатай нарийвчилсан үйл ажиллагааны дүрмийг Ерөнхий Ассамблейгаас батлан хэрэгжүүлнэ. Үндэсний шинжлэх ухааны Академи нь 1986 оноос судалгаа, шинжилгээний төсөлт ажилд тэтгэлэг олгох, гадаад болон дотоодын эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зорилгоор Судалгааны санг байгуулсан.</p>
<p><b>Эх сурвалж</b></p>	<p><a href="http://kosis.kr/nsportalStats/nsportalStats_0102Body.jsp?menuId=1&amp;NUM=1">http://kosis.kr/nsportalStats/nsportalStats_0102Body.jsp?menuId=1&amp;NUM=1</a>  <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/13444/13446.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/13444/13446.aspx</a>  <a href="http://www.nas.go.kr/eng/active/active/academic.jsp">http://www.nas.go.kr/eng/active/active/academic.jsp</a></p>

### 9.БЕЛЬГИ УЛС

<p><b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b></p>	<p>Европ/Баруун Европ</p>
--	---------------------------

<b>Хүн амын тоо</b>	11,348,855
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.15%
<b>Засаглалын хэлбэр</b>	холбооны бүгд найрамдах засаглалтай
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<p><b>Бельгийн эзэн хааны нэрэмжит ШУ, Урлагийн академийн</b> үндэс суурь анх 1769 онд “Брюсселийн утга зохиолын нийгэмлэг” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд хожим 1772 оны 12 дугаар сарын 16-нд Хатан хаан Мария Тересагийн ивээл санаачилгаар Эзэн хааны нэрэмжит шинжлэх ухаан, урлаг, утга зохиол судлалын академи болон өргөжижээ. Түүнчлэн 1845 оны 12 дугаар сарын 1-нд Бельгийн хаан I Леопольдын үүсгэл санаачилгаар орчин цагийн шинжлэх ухааны академи болон өөрчлөгдөж шинжлэх ухааны салбара тус бүрээр хөгжүүлэх шинэ зарлиг гаргасан нь өнөөгийн академийн эрх зүйн байдалтай нийцэх боломжийг бий болгосон байна.</p> <p>Бельгийн Эзэн хааны нэрэмжит Шинжлэх ухааны, Урлагийн академи (<i>The Royal Academies for Science and the Arts of Belgium/RASAB</i>) Бельгийн Эзэн хааны нэрэмжит Шинжлэх ухаан, урлагийн академи бол Бельгийн франц хэлээр яригч Шинжлэх ухаан, Урлагийн Хааны Академи болон Бельгийн голланд хэлээр яригч Шинжлэх ухаан, Урлагийн Хааны Фламандын академийн санаачилгаар байгуулагдсан байна. Эзэн хааны академийн үндсэн зорилго бол Бельгийн урлаг, шинжлэх ухааныг дэмжихэд оршино. Энэхүү шаардлагыг биелүүлэхийн тулд эрдэм шинжилгээ судалгааны болон соёлын үйл ажиллагаа өрнүүлэх, мөн Бельгийн их дээд сургуулиудын хоорондын харилцааг бэхжүүлэх олон улсын байгууллагууд дахь Бельгийн төлөөллийг батлах, засгийн газарт шинжлэх ухааны үндэслэлтэй, онолын чиг баримжаа бүхий судалгаа шинжилгээнд суурилсан зөвлөмж гаргаж өгөхөд түлхэц үзүүлэх, шинжлэх ухааны болон судалгааны үр дүнг их дээд сургуулиудын сургалтад ашиглах, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.</p>
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	<p>Бельгийн Эзэн хааны нэрэмжит Шинжлэх ухаан, Урлагийн академи нь шинжлэх ухаан, соёлын нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын эрдэм шинжилгээ судалгааны үйл ажиллагааг өрнүүлэх, мэдлэг суурилсан эдийн засаг, шинжлэх ухааны үндэслэлтэй хамтын ажиллагаа бодлого үйл ажиллагаа бүхий бодлого судлалыг бүрдүүлэх, эрдэмтэн судлаачдад олон улсын туршлага, шинжлэх ухааны практик ач тусыг засгийн газар, аж үйлдвэр, боловсролын болон бусад бүх салбарт санал зөвлөмж боловсруулж өгөх, цаашлаад засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт бодит хэрэгцээ шаардлагыг суулгаж, чингэхдээ судалгаанд суурилсан бодлого шийдвэрийг боловсруулахад ихээхэн анхаарч ирсэн байна. Чингэхлээр Бельгийн Эзэн хааны нэрэмжит Шинжлэх ухаан, Урлагийн академи нь</p> <ul style="list-style-type: none"> <li>• ШУА-ийн хүрээний Үндэсний хороодын дунд удирдлага зохион байгуулалтын зохицуулалт хийх, шаардлагатай тохиолдолд үндэсний зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулах;</li> <li>• олон улсын байгууллагууд болон хамтын ажиллагаатай гадаад орнуудын ШУА-иуд болон эрдэм шинжилгээний судалгааны томоохон нийгэмлэгүүдийн хооронды харилцааг зохицуулах, түүнд анхаарал хандуулах;</li> <li>• олон улсын эрдэм шинжилгээний бага хурал, симпозиумт Бельгийн төлөөлөгчдийг хамруулах, шинжлэх ухааны, урлаг, соёлын олон улсын хамтын ажиллагаа өрнүүлэх, чингэхдээ Бельгийн Төлөөлөгчдийн Ерөнхий Хурал, Олон</li> </ul>

	<p>улсын диплом байгууллагын хооронд соёл урлаг, боловсрол, шинжлэх ухааны олон чиглэлт үйл ажиллагааг өрнүүлэх түүнд дэмжлэг үзүүлэх, санаачлах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх;</p> <ul style="list-style-type: none"> <li>• ЭША-нууд болон Академийн гишүүдийн гадаад томилолтын зардлыг олон улсын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд тэгш солилцоогоор хүргүүлэх;</li> <li>• ШУА-ийн гишүүдийн ажлын үүрэг даалгаврын биелэлтийг шалгах, түүнд хяналт тавих.</li> <li>• судалгааны тогтвортой, баталгаатай байх зарчмыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үр дүнг тархаах;</li> <li>• судалгаа, эрдэм шинжилгээний чухал баримт бичгийг цуглуулах, түүнд шинжилгээ хийх;</li> <li>• судалгаа, шинжлэх ухааны арга зүй, шинжлэх ухааны философийн чиглэлээр олон улсын бага хурлууд, сургалт, семинарыг зохион байгуулах зэргийг гүйцэтгэнэ.</li> </ul>
<b>ЭША-нуудын тоо</b>	Бельгийн Эзэн хааны нэрэмжит Шинжлэх ухаан, урлагийн академи нь 4 үндсэн салбар буюу шинжлэх ухаан-бичиг соёлын, ёс суртахуун-улс төрийн шинжлэх ухааны болон урлаг, технологи, нийгмийн ухааны салбаруудад хуваагдана. Салбар тус бүрт орон тооны 50, сурвалжлагч 50 гишүүнээс бүрдэх бөгөөд нийтдээ 400 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид ажиллах бөгөөд нийт хүн амын 0.0035 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 3524.5 хүн ногддог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Бельгийн Вант Улсын төсвийн зарцуулалтын 5.6% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.ibz.rn.fgov.be/fileadmin/user_upload/fr/pop/statistiques/stat-1-1_f.pdf">http://www.ibz.rn.fgov.be/fileadmin/user_upload/fr/pop/statistiques/stat-1-1_f.pdf</a> <a href="http://statbel.fgov.be/nl/statistieken/cijfers/">http://statbel.fgov.be/nl/statistieken/cijfers/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Belgium.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Belgium.aspx</a> <a href="http://www.rasab.be/">http://www.rasab.be/</a> ; <a href="http://www.academieroyale.be/">http://www.academieroyale.be/</a> ;

## 10.БОЛИВИ

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Өмнөд Америк
<b>Хүн амын тоо</b>	10,985,059
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.15%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, ерөнхийлөгчийн засаглалтай Үндсэн хуульт БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Боливийн Үндэсний Шинжлэх Ухааны Академи (National Academy of Sciences in Bolivia - Academia Nacional de Ciencias de Bolivia)</i> нь тус улсын Засгийн газрын 1960 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн 5582 тоот тогтоолоор байгуулагджээ. Эл тогтоолын Үндэсний ШУА-д итгэл үзүүлэх тухай тусгай журмын 1 дүгээр зүйлд "Шинжлэх ухааны үндэсний академи бол үндэсний хэмжээний шинжлэх ухааны удирдах байгууллага мөн бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг үндэсний хэмжээнд дэмжин хөгжүүлэх, үндэсний эрдэмтдийг бэхжүүлэх улмаар суурь шинжлэх ухааны 10,

	байгалийн шинжлэх ухааны 12 хүрээлэн болон Академийн тэргүүлэгчдийн газар 32 орон тооны эрдэмтдээс бүрдэнэ.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Үндэсний ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд нь үндэсний хэмжээнд шинжлэх ухааны чадавхийг бэхжүүлэх, орон нутагт шинжлэх ухаан, техникийн дэвшлийг нэмэгдүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд идэвх санаачилгатай ажиллахыг өөрийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болгоно. Академийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэгт шинжлэх ухаан, технологийн ололт амжилтыг шинэчлэх, инновацижуулах, мөн Боливи Улсын нийгэм, эдийн засаг, экологийн болоод улс төрийн хөгжлийн зорилтыг дээшлүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх зэрэг багтана. Түүнчлэн үндэсний ШУА-ийн эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа нь тодорхой төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, цаг үеийн нөхцөл байдлыг тандан судлах, түүний үр дагаврыг судлах, нийгмийн ухааны төлөвшлийг хөгжүүлэх зэргээр хамтын гэрээ байгуулах замаар хараат бус судалгаа явуулж үр дүнг олон нийтэд болон ЗГ-ын байгууллагуудад хүргүүлж, тэдгээрийн үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
<b>ЭША-нуудын тоо</b>	250 орчим эрдмийн зэрэг цолтой эрдэм шинжилгээний ажилтан, судлаачидтай бөгөөд нийт хүн амын 0.0022 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 2275.8 хүн ногддог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Боливи Улсын төсвийн зарцуулалтын 4.9% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Боливи Улсын Үндэсний ШУ, түүний харьяа хүрээлэн, эрдэм шинжилгээний төвүүд нь хараат бус бие даасан статустайгаар Боливи Улсын Үндэсний Сангийн хорооноос санхүүжихийн зэрэгцээ залуу судлаачид болон эрдэм шинжилгээний ажилтнуудад жил бүр Үндэсний ШУА-иас грант төсөл хэрэгжүүлэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны дэмжлэг үзүүлж ажиллах үүрэгтэй байгууллага мөн.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.ine.gob.bo/indice/">http://www.ine.gob.bo/indice/</a> ; <a href="http://www.aciencias.org.bo/">http://www.aciencias.org.bo/</a> <a href="http://www.ianas.org/index.php/members/78-ianas/169-bolivia">http://www.ianas.org/index.php/members/78-ianas/169-bolivia</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/LatinAmericaCaribbean/Bolivia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/LatinAmericaCaribbean/Bolivia.aspx</a>

### 11. БОСНИ ГЕРЦЕГОВИНИ

<b>НУБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Өмнөд Европ
<b>Хүн амын тоо</b>	3,802,134
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.047%
<b>Засаглалын хэлбэр</b>	холбооны, парламентын засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<b>Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн ШУА</b> ( <i>Academy of Sciences and Arts of Bosnia and Herzegovina/ANUBiH</i> ) бол шинжлэх ухааны болон хүмүүнлэгийн эрдэм шинжилгээ судалгааг голлон эрхэлдэг нэр хүндтэй институци бүхий байгууллага бөгөөд 1966 онд Шинжлэх ухааны нийгэмлэг (1951)-ийн харьяанд тус улсын үндэсний бүртгэлийн газрын 40/75 тоот албан ёсны дугаартайгаар ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулийн 33/84 үндэслэгдэн байгуулагджээ. Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн академийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу хараат бус бие даасан академийн статустай болгон өргөтгөжээ. Жил бүрийн 6 дугаар сард Академийн их чуулган

	<p>хуралддаг. ШУА-ийн Тэргүүлэгчдийн гишүүдийг академийн нийт гишүүдийн хуралдаанаар нууц санал хурааж сонгодог.</p> <p>Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн академи нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан,</li> <li>• Анагаахын шинжлэх ухаан,</li> <li>• Байгалийн шинжлэх ухаан ба</li> <li>• Математикийн шинжлэх ухаан</li> <li>• Техникийн шинжлэх ухаан</li> <li>• Урлахуй ухааны үндсэн 6 төрөлжсөн шинжлэх ухааны салбараас бүрдэнэ. Тэдгээр салбар бүр нь дотроо судалгаа эрдэм шинжилгээний төвүүдтэй. Жнь: Балкан судлал, Толь бичиг судлал ба Үгсийн сан судлал, Философийн судалгааны төв, Анагаахын судалгааны зохицуулалтын төв, Систем судлалын төв зэрэгт хуваагдана.</li> </ul>
<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Хуулийн болон эрх зүйн баримт бичгийн дагуу Шинжлэх ухаан, Урлагийн академи бол шинжлэх ухаан, хүмүүнлэгийн үндсэн 6 салбараас бүрдэнэ. Салбар бүрийг салбарын нарийн бичгийн дарга нар удирдах бөгөөд тухайн салбарын гишүүд нь осни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн академийн Чуулганаас батлаж бүрэн эрхийг нь баталгаажуулна. Тухайн салбар шинжлэх ухааны өдөр тутмын ажлыг хянах, зохицуулах ахлыг Академийн ерөнхийлөгч хариуцана. ШУА-ийн болон түүний харьяа хүрээлэнгүүдийн үйл ажиллагааны хүрээнд иргэдийн дунд шинжлэх ухааны сэтгэлгээг хөгжүүлэх, хүмүүнлэг үзлийг дээшлүүлэх, урлаг судлалыг дэлгэрүүлэх, судалгаа эрдэм шинжилгээний үр өгөөжийг нэмэгдүүлэх, судалгааны үр дүнг шинжлэх ухааны болон нийгмийн бүхий л салбарт түгээн тархаах, мөн урлагийн салбарт бүтээлч хандлагыг бий болгоход дэмжих, шинжлэх ухаан, урлагийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд онцгой үүрэгтэй оролцоно.</p>
<p><b>ЭША-нуудын тоо</b></p>	<p>Шинжлэх ухааны ололт, дэвшлийг төрийн байгууллагуудад хүргэх, тэдэнд санал зөвлөмж гаргах, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, түүний ач холбогдлыг дээшлүүлэх, урлагийн мэдрэмжийг бий болгох үр дүнг тархаахад шинжлэх ухааны санаачилга гарган ажиллаж байна. Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн ШУА нь 600 орчим эрдэм шинжилгээний ажилтантай бөгөөд нийт хүн амын 0.094 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 946.8 хүн ногддог байна.</p>
<p><b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b></p>	<p>Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн ШУА-ийн эрх зүйн байдал нь хөдлөшгүйгээр батлагдсан тогтолцоотой. Учир нь академийн санхүүгийн болон хүний нөөцийг шууд улсын төсвөөс бус харин тухайн орон нутгийн төсөвт байршуулан олгодог байна. Тиймээс академийн санхүүгийн гол үндэслэл нь дан ганц орон нутгийн төсвөөс гадна санхүүгийн бусад үр дүнтэй эх үүсвэрээс санхүүжих шаардлагатай байдаг байна. Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн ШУА нь Сараева мужийн (Canton Sarajevo) нэгдсэн төсвөөс 60%-ийг, төсвийн үлдсэн 40%-ийг үндэсний болон олон улсын төлөөлөгчдийн байгууллага, бусад нийгэмлэгтэй эрдэм шинжилгээ, судалгааны захиалгат ажил, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүрдүүлдэг байна.</p>

Тайлбар	Судалгааны төвүүд нь бие даасан Ажлын хэсэг бүхий салбарын комисс хороотой байх бөгөөд тэдгээр хороод нь судалгаа эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлж дүгнэх ажлыг хариуцана. Босни Герцеговиний Шинжлэх ухаан, Урлагийн ШУА нь ЕХ-ны улс орнуудын Үндэсний ШУА-ууд (ALLEA)-ын гишүүн, Дэлхийн ШУА-иудын сүлжээ (IAP) болон Олон улсын Академиудын нэгдсэн холбооны гишүүн байгууллага юм.
Эх сурвалж	<a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/BosniaHerzegovina.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/BosniaHerzegovina.aspx</a> <a href="http://www.anubih.ba/">http://www.anubih.ba/</a>

## 12. ГЕРМАН УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Баруун Европ
Хүн амын тоо	82,175,700
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	1.10%
Засаглалын хэлбэр	холбооны, бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<p><i>Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Германы ШУА-ийн Холбоо (Union of German Academies of Sciences and Humanities)</i> нь Германы хүмүүнлэгийн шинжлэх ухааны академиудын нийгэмлэг юм. 1700-2004 оны хооронд 5 академи байгуулагдснаас 18 дугаар зуунд 3, 19 дүгээр зуунд 2, 20 дугаар зуунд 1 байгуулагдсан байна. Академийн гишүүд нь хоёр төрлийн гишүүнчлэлтэй ажээ: Гишүүн академиуд нь тус бүрдээ жинхэнэ гишүүд (1208)-тэй, сурвалжлагч гишүүд (732)-тэй. Гишүүд нь нэр хүндтэй эрдэмтэд байхаас гадна зарим байгууллагуудаас гаднаас сонгондох боломжтой ажээ. ШУ, Хүмүүнлэгийн ухааны ШУА-ийн холбоо нь дараахь эрдэм шинжилгээний хүрээлэн, судалгааны байгууллагууд болон төрөлжсөн академиудаас бүрдэнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Берлин-Бранденбургийн Хүмүүнлэгийн академи (156 жинхэнэ гишүүн/ 56 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Готтингийн Хүмүүнлэгийн болон ШУ-ны академи (146 жинхэнэ гишүүн /211 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Баварийн Хүмүүнлэгийн болон ШУ-ны академи (160 жинхэнэ гишүүн/ 159 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Лейпциг хот дахь Саксоны Хүмүүнлэгийн болон ШУ-ны академи (134 жинхэнэ гишүүн /76 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Хайделбургийн Хүмүүнлэг, ШУ-ны академи (171 жинхэнэ гишүүн/70 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Майнзын Утга зохиолын ШУА (132 жинхэнэ гишүүн/120 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Умард Ринх-Вествалийн Хүмүүнлэг, ШУ-ны академи (200 жинхэнэ гишүүн/110 сурвалжлагч гишүүн).</li> <li>• Хамбургийн Хүмүүнлэг, ШУ-ны академи (31 гишүүнтэй)</li> </ul>
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Германы ШУА-иудын Холбоонд дараахь найман академи албан ёсоор багтдаг. -Берлин-Бранденбургийн Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1992/1700). - Готтингений Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1751). - Баварийн Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1759).</p>

	<ul style="list-style-type: none"> <li>- Лейпцигийн Саксоны Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1846).</li> <li>- Хайделбергийн Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1909).</li> <li>- Майнзын Шинжлэх ухаан, Утга зохиолын Академи, (байгуулагдсан он: 1949).</li> <li>- Хойд Рейн-Вестфайланы Хүмүүнлэгийн ухааны Академи (байгуулагдсан он: 1970).</li> <li>- Гамбургийн Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны академи (байгуулагдсан он: 2004).</li> </ul>
<b>ЭША-нуудын тоо</b>	Германы ШУА-ийн холбооны хамгийн идэвхтэй гишүүд болох эмэгтэйчүүдийн эзлэх хувь харьцангуй бага буюу 6-10 хүртэлх хувь байна. Харин эрдэм шинжилгээ судалгааны ажилтнуудын 50 гаруй хувь нь эмэгтэйчүүд байна. Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Германы Академиудын холбоо нь 8 ШУА-ийг эгнээндээ нэгтгэсэн германы хамгийн том академи бөгөөд нийтдээ 2000 эрдэмтэн судлаачид, эрдэм шинжилгээний ажилтантай бөгөөд нийт хүн амын 0.0024 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 2433.8 хүн ногддог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	ХБНГУ-ын төсвийн зарцуулалтын 4.6%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Шинжлэх ухаан, Хүмүүнлэгийн ухааны Германы Академиудын холбооны санхүүжилт нь төсвийн хоёр эх үүсвэрээс бүрдэнэ. 2008 оны байдлаар жилийн үндсэн төсөв болох 354.700€ Германы Холбооны Төрийн сангаас санхүүжүүлсэн байна. Академи болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийн судалгааны хөтөлбөр, зохион байгуулалтын зардал болох 596.700€ (2008) Германы Холбооны Төрийн сангаас мөн санхүүжүүлжээ. Түүнчлэн ХБНГУ-ын засгийн газар болон Холбооны төрийн сангаас ШУ, хүмүүнлэгийн ухааны Германы ШУА-ийн холбоонд хамтарсан хөтөлбөр боловсруулах, түүнийг санхүүжүүлэх зардалд зориулж жилд дунджаар 45.303.300 € (2008 оны байдлаар) санхүүжилт хийсэн байна. Чингэхдээ, Холбооны гишүүн академийн өөрсдийн төсвийн орлого ойролцоогоор 3 сая орчим байгаагаас харвал Холбооны төр засгийн зүгээс шинжлэх ухааны салбарт жилд дунджаар 30 хүртэлх сая евроны санхүүжилт олгодог байна.
<b>Тайлбар</b>	Академийн эрдэм шинжилгээ, судалгаа шинжилгээний болон бусад зохион байгуулалтын зардлыг ХБНГУ-ын Холбооны Төрийн сангаас санхүүжүүлдэг.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://www.destatis.de/EN/FactsFigures/SocietyState/Population/CurrentPopulation/Tables/Census_SexAndCitizenship.html">https://www.destatis.de/EN/FactsFigures/SocietyState/Population/CurrentPopulation/Tables/Census_SexAndCitizenship.html</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/12866.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/12866.aspx</a> ; <a href="http://www.akademienunion.de/">http://www.akademienunion.de/</a>

## 13. ГРЕК УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Өмнөд европ
<b>Хүн амын тоо</b>	10,858,018
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.15%

Засаглалын хэлбэр	нэгдмэл, парламентын Үндсэн хуульт БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<p><i>Грекийн үндэсний Шинжлэх Ухааны Академи (Academy of Athens)</i> МЭӨ IV зууны үед Грек-Ромын агуу сэтгэгч Платон тус академийг анх байгуулсан бөгөөд тухайн үедээ тус академи нь Афины философийн сургуулийг үүсгэн санаачилсан төдийгүй тухайн үедээ эрэлхэг зоригтнуудын ариун газар буюу Академи хэмээн нэрлэдэг байв. Тус сургууль нь МЭ 529 оныг хүртэл үйл ажиллагааг явуулахыг эзэн хааны зарлигаар түр зогсоожээ. Энэ тухайн үедээ мэдлэгийг түгээж, мэдлэгт суурилсан бодлого, үйл ажиллагааг явуулах болсон нь орчин цагийн ШУА-ийн үндсийг тавьснаараа түүхэнд нэн чухал алхам болжээ. 1926 оны 3 дугаар сарын 18-нд соёрхон батлагдсан Үндсэн хуулийн дагуу Афины академийг үүсгэн байгуулсан эрх зүйн баримт бичгийн 4398/1929 заалтаар түүний үйл ажиллагааг тусгайлан заажээ. Афины академийн үндсэн зорилго бол эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх, түүнчлэн шинжлэх ухааны болон хүмүүнлэг урлаг судлалыг хөгжүүлэх, түүнчлэн шинжлэх ухааны судалгаа шинжилгээг боловсруулах, төрийн бүх салбарт мэргэшсэн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэхэд оршино.</p>
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>Грекийн үндэсний ШУА нь Боловсрол, шашин судлалын яаманд шууд харьяалагддаг байна. Академи нь нийтдээ 13 судалгааны төв, 10 судалгаа эрдэм шинжилгээний хэлтэстэй үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2002 оноос тус академи Үндэсний Анагаах ухаан биологийн судалгааны санг байгуулан ажиллаж байна. ШУА-ийн эрх зүйн баримт бичгийн дагуу академи нь <i>шинжлэх ухаан, хүмүүнлэгийн болон урлаг судлал, ёс зүйн ба улс төр судлалын</i> гэсэн үндсэн 3 хэсэгт хуваагдана. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Байгалийн шинжлэх ухааны салбарт математик, физик, анагаахын болон бусад хавсарга шинжлэх ухаанууд багтана;</li> <li>• Хүмүүнлэгийн болон урлаг судлалын салбарт хэл бичиг судлал, уран зохиол, хэл шинжлэл, түүх, урлаг, археологи багтана;</li> <li>• Ёс зүйн ба улс төр судлал, нийгмийн ухааны салбарт улс төрийн шинжлэх ухаан, теологи, философи, хууль эрх зүй, эдийн засаг болон нийгмийн шинжлэх ухаан багтана.</li> </ul> <p>Салбар шинжлэх ухааны нээлттэй хэлэлцүүлэг, эрдэм шинжилгээ судалгааны уулзалтыг сар бүр нэг удаа зохион байгуулж явуулдаг байна.</p>
ЭША-нуудын тоо	<p>Үндэсний ШУА-ийн жинхэнэ гишүүдийг Их чуулганы хурлын нууц санал хураалтаар үнэмлэхүй олны санал авч сонгогдоно. Одоогийн байдлаар үндэсний ШУА-ийн жинхэнэ гишүүдийн тоо 47, гадаад гишүүд 26, сурвалжлагч гишүүд 152 байна. Академийн жинхэнэ гишүүдийн нас 40-ээс дээш бөгөөд академийн салбар хүрээлэнгүүд болон их дээд сургуулийн дэргэдэх судалгааны төвүүдийн төлөөллөөс бүрдсэн байна. Гишүүдийг хүйсийн харьцаагаар авч үзвэл, 5% нь эмэгтэйчүүд байна. Мөн академийн салбар хүрээлэн, судалгааны төвүүдийн нийт ЭША-нуудын 55% нь эмэгтэйчүүд байгаагийн дээр шинжлэх ухааны салбарт ажиллаж буй профессорын зэрэгтэй эмэгтэйчүүд 50% -ийг эзэлдэг байна. ШУ-ны салбарт 1000 орчим эрдэм шинжилгээний ажилтнууд ажиллаж байгаа бөгөөд нийт хүн амын 0.0092 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 9209.7 хүн ногддог байна.</p>
Санхүүжилтийн байдал	<p>Грек Улсын төсвийн зарцуулалтын 3.1%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Академи нь шууд Засгийн газрын харьяа бөгөөд түүний санхүүжилтийг ЗГ бүрэн хариуцах бөгөөд академийн салбар хүрээлэн,</p>

<b>(Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Судалгааны төвүүдийн зардлыг академи өөрийн санхүүгийн зардалд багтаан улсын төсвөөс санхүүжүүлнэ. ШУА-ийн нийт санхүүжилтийн 15%-ийг гэрээслэл, хувьцааны ногол ашиг, болон бусад хараат бус эх үүсвэрээс санхүүжүүлдэг байна. Түүнчлэн академи нь гэрээслэл болон бусад төрлийн хандив зэргээс цуглуулсан хөрөнгийн эх үүсвэрээс оюутнуудад эрдэм шинжилгээний тэтгэлэг өгөх, мөн эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудыг санхүүжүүлэх зэрэг ажлыг гүйцэтгэдэг байна.
<b>Тайлбар</b>	Грекийн үндэсний ШУА Европын болон олон улсын шинжлэх ухааны нэгдсэн холбооны гишүүн бөгөөд Олон улсын Үндэсний ШУА-ууд (ALLEA)-ын гишүүн, Дэлхийн ШУА-иудын сүлжээ (IAP)-ний гишүүн байгууллага юм.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.statistics.gr/en/statistics/-/publication/SPO18/">http://www.statistics.gr/en/statistics/-/publication/SPO18/;</a> <a href="http://www.academyofathens.gr/">http://www.academyofathens.gr/;</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Greece.aspx;">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Greece.aspx;</a> <a href="http://www.academyofathens.gr/">http://www.academyofathens.gr/</a>

## 14.ИЗРАЙЛЬ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази/Баруун Ази
<b>Хүн амын тоо</b>	8,637,420
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.18%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Израйлийн Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн Академи (Israel Academy of Sciences and Humanities)</i> нь 1961 онд Кнессетийн хуулийн дагуу байгуулагдсан бөгөөд нэр хүндтэй 96 эрдэмтдээс бүрддэг. Тус академи нь Байгалийн ба нийгмийн шинжлэх ухааны үндсэн хоёр салбарт хуваагдах ба удирдлага зохион байгуулалтын хувьд Академийн Ерөнхийлөгч, дэд Ерөнхийлөгч болон хүмүүнлэгийн болон байгалийн шинжлэх ухааны салбар хариуцсан дарга нараас бүрдсэн зөвлөлтэй. Академийн салбарын бага чуулган нь тодорхой асуудлаар жилд 1-3 удаа хуралдаж нэгдсэн саналаа Их чуулганаар хэлэлцүүлдэг. Академи нь нийслэл Иерусалимд байрлах бөгөөд Израйлийн Ерөнхийлөгчийн мэдэлд шууд харьяалагдана.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Израйлийн Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн академийн Хүмүүнлэгийн ухааны салбар дэлхийн бусад судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, их дээд сургуулиудтай харьцуулахад зарим нэгэн дэд салбарын чиглэл, үйл ажиллагааны хувьд харилцан адилгүй төвшинд байдаг. Тухайлбал, хүмүүнлэгийн ухааны салбар нь Европ, Америкийн түүх, еврейн түүх, Зүүн Азийн болон Латин-Америкийн түүх, Орос судлал, урлагийн түүх, түүх, нийгмийн ухааны чиглэлээр өргөн хэмжээний судалгааг хийхээс гадна шинжлэх ухааны түүх, эдийн засаг, түүх, газар зүйн чиглэлээр нарийвчилсан суурь судалгааг хийдэг байна. Израйлийн Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн академийн гол үүрэг нь зарим талаар шинжлэх ухааны хамтын ажиллагааны хоёр талын гэрээний үндсэн дээр, дэмжих, Израйлийн болон олон улсын хамтын нийгэмлэгийн хооронд байгуулсан шинжлэх ухааны солилцоо, хамтын ажиллагааг зохицуулах, удирдан зохион байгуулахад голлон анхаардаг. Тус академи нь Израйль болон гадаадын эрдэмтэн судлаачидтай

	хамтран шинжлэх ухааны хамтарсан семинар зохион байгуулах, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны тэгш солилцоог өргөжүүлэх зорилгоор олон арван гэрээ хэлэлцээрийг байгуулдаг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны төв байгууллага юм.
<b>ЭША-нуудын тоо</b>	Академийн ШУ-ны салбар одоогийн байдлаар биологи, инженер, хими, математик, мэдээлэл-технологийн шинжлэх ухаан. Физик, амьдрахуйн ухаан, геологи, анагаахын шинжлэх ухааны чиглэлийн 60 гаруй нэр хүндтэй, авъяаслаг эрдэмтдээс бүрдэнэ. Академийн өнөөгийн эрх зүйн байдалтай шууд холбогдох бодлогын суурь 2 баримт бичиг байгаа нь 1961 онд батлагдсан Израйлийн ШУ, Хүмүүнлэгийн Академийн эрх зүйн байдлын тухай хууль (5721), мөн хуулийн 1962 онд хийгдсэн нэмэлт өөрчлөлт 5722/1962 (нэм.өөрчлөлт хийгдсэн 5736/1975; 5746/1986) хууль юм. 2011 оны 1 дүгээр сарын байдлаар тус Академи нь Израйлийн нэр хүндтэй 96 эрдэмтэдээс бүрдэнэ. Энэ нь дараах хоёр салбарт буюу Байгалийн шинжлэх ухааны салбар (54 гишүүнтэй), Хүмүүнлэгийн ухааны салбар (Нийгмийн шинжлэх ухааныг багтаана) (42 гишүүнтэй). 2008 оны байдлаар нийт гишүүдийн 75 хүртэлх насныхны тоо салбар тус бүрт 40-т хүрчээ. Тухайлбал, Хүмүүнлэгийн салбар дахь 42 гишүүдийн 5 (12.9%) нь эмэгтэйчүүд байгаа бол, Байгалийн шинжлэх ухааны салбарын 54 гишүүдийн 3 (5.5%) эмэгтэйчүүд байна. Үүнээс үзэхэд, Израйлийн хүмүүнлэг, шинжлэх ухааны академи нь 115 нэр хүндтэй эрдэмтэдтэй бөгөөд нийт хүн амын 0.0013 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 13314 хүн ногдог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Израиль Улсын төсвийн зарцуулалтын 7.7% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Израйлийн Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн академийн санхүүжилт нь Израйлийн Шинжлэх ухааны сангаас шууд санхүүжинэ. Санхүүжилтийг захиргааны болон судалгаа шинжилгээний зардал гэж ангилна.
<b>Тайлбар</b>	Шинжлэх ухааны сан нь 2003 онд Үндэсний Судалгаа, шинжилгээний зөвлөлийн дэргэд байгуулагдсан бөгөөд Зөвлөлийг тус улсын Дэд бүтцийн хөгжил, судалгаа шинжилгээний Үндэсний хорооны шууд санхүүжилтээр 5 жил хүртэлх урт хугацааны төслөөр 300 сая хүртэлх ам.долларын санхүүжилттэйгээр баталдаг байна. Нийт санхүүжилтийн дийлэнх хувь нь "их энергийн физик", синхротрон цацраг, мега тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, судалгаанд зарцуулна.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Israel.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Israel.aspx</a> ; <a href="http://www.academy.ac.il/RichText/GeneralPage.aspx?nodeId=903">http://www.academy.ac.il/RichText/GeneralPage.aspx?nodeId=903</a> ; <a href="http://www.academy.ac.il/">http://www.academy.ac.il/</a> ; <a href="http://www.cbs.gov.il/reader/cw_usr_view_folder?ID=141">http://www.cbs.gov.il/reader/cw_usr_view_folder?ID=141</a>

## 15.ИТАЛИ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Өмнөд Европ
<b>Хүн амын тоо</b>	60,589,766
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.81%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс

<p><b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b></p>	<p><b>Италийн ШУА</b> (<i>Accademia Nazionale dei Lincei</i>)-ийн суурь нь 1603 оын 8 дугаар сарын 17-ны өдөр хунтайж Федерико Цеси болон тухайн үеийн Италийн шинжлэх ухааны тэргүүдэх эрдэмтэд болон Иоханис Эк, Франческо Стеллити, Конт Анастасио Де Филлис нарын шууд оролцоотойгоор байгуулагджээ. Үүнээс хойш олон арван жилийн дараагаар, Үндэсний ШУА өнөөдрийн Италийн үндэсний академи болтлоо өргөжин хөгжжээ. Италийн Үндэсний ШУА бол төрийн бус, бие даасан статустай Италийн Соёлын өвийг хамгаалах яамны шууд харьяанд багтах бөгөөд эрх зүйн байдлын тухайн хуулиар зохицуулагдана. Хуулийн дагуу Үндэсний ШУА-ийн зорилго нь «соёл-ийн нэгдмэл бөгөөд түгээмэл байдлыг хадгалах, хамгаалах, шинжлэх ухааны мэдлэгийг түгээх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжиж, түүнийг шинжлэх ухаанч байдлаар зохицуулах»-ад оршино. Үндэсний ШУА нь нийгмийн өмнө шударга ёс, шинжлэх ухааны санаачилгатай байж нийгмийн бүхий л салбарт судалгаанд суурилсан үнэн зөв, баталгаатай хэрэглээг төлөвшүүлэхүйц суурь болон хавсарга судалгааг хийж үр дүнт бүх салбар, иргэдэд түгээн дэлгэрүүлж, сурталчилан таниулах үүрэгтэй.</p>
<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Италийн ШУА-ийн хууль ёсны байдал нь 2001 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн эрх зүйн байдлын тухай хууль, мөн 1987 оны 2 дугаар сарын 14-ны өдрийн хууль, хамгийн сүүлд 2000 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр тус академийн гишүүд хуулиар баталгаажина. Академи Физик, математик, байгалийн шинжлэх ухааны болон Ёс суртахуун, түүх, философийн шинжлэх ухаан (хүмүүнлэгийн)-ы хоёр үндсэн салбар ангид хуваагддаг. Эдгээр хоёр үндсэн салбар тус бүрт 90 орчим жинхэнэ гишүүд (үндэсний), 90 сурвалжлагч гишүүд, 90 гадаад гишүүдтэй. Эрх зүйн байдлын тухай хуульд зааснаар тодорхой нөхцөл байдлын улмаас үндэсний гишүүд буюу Академийн жинхэнэ гишүүдийн тоон хязгаарыг хоёр үндсэн салбар бүрт 105-аар хязгаарладаг байна.</p> <p><b>Физикийн шинжлэх ухааны салбар нь</b> (салбар бүр дотроо бага чуулган/дэд салбарт хуваагдана): I. Математик, механикийн дэд салбар (21 үндэсний, 21 сурвалжлагч, 21 гадаад); II. Одон орон, геодези, гео-физикийн дэд салбар (10 үндэсний, 10 сурвалжлагч, 10 гадаад); III. Физик, химийн дэд салбар (21 үндэсний, 21 сурвалжлагч, 21 гадаад гишүүдтэй); IV. Геологи, Палентологи, Эрдэс судлалын дэд салбар (11 үндэсний, 11 сурвалжлагч, 11 гадаад гишүүдтэй); V. Биологийн шинжлэх ухааны салбар (27 үндэсний, 27 сурвалжлагч, 27 гадаад) гишүүдтэй.</p> <p><b>Ёс суртахуун судлалын салбар</b> нь 7 сэдэвт хуваагдана: I. Хэл шинжлэл, авиа зүйн дэд салбар (18 үндэсний, 18 сурвалжлагч, 18 гадаад); II. Археологийн дэд салбар (11 үндэсний, 11 сурвалжлагч, 11 гадаад); III. Яруу найраг, урлаг судлал, шүүмжлэлийн дэд салбар (12 үндэсний, 12 сурвалжлагч, 12 гадаад); IV. Түүх, түүхийн болон түүх бичлэг антропологийн газарзүй (12 үндэсний, 12 сурвалжлагч, 12 гадаад); V. Философийн шинжлэх ухаан (8 үндэсний, 8 сурвалжлагч, 8 гадаад) гишүүдтэй; VI. Эрх зүйн шинжлэх ухаан (14 үндэсний, 14 сурвалжлагч, 14 гадаад); VII. Улс төрийн болон нийгмийн шинжлэх ухааны салбар (15 үндэсний, 15 сурвалжлагч, 15 гадаад) гишүүдтэй.</p>
<p><b>ЭША-нуудын тоо</b></p>	<p>Нийтдээ 810 гаруй эрдэм шинжилгээний ажилтан байгаа нь нийт хүн 0.00013 хувь буюу 1 эрдэм шинжилгээний ажилтанд 13368 хүн ногдож байна. Академийн гишүүнлэлд эмэгтэй гишүүдийн болон залуу эрдэм шинжилгээний ажилтнуудыг хориглосон зүйл байхгүй бөгөөд одоогоор 523 гишүүдийн ердөө 15 буюу 2.86% хувийг эмэгтэйчүүд эзэлдэг байна.</p>

<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Итали Улсын төсвийн зарцуулалтын 4.7% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Италийн Үндэсний ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн жилийн нийт төсөв 5.500.000 Евро байна. Санхүүжилтийн хагас нь төрийн шууд татаасаас бүрдэхийн зэрэгцээ Академи өөрийн олсон орлогоосоо санд төвлөрүүлэн түүнд мониторинг хийнэ. Академи олсон орлогоосоо өөрийн санаачилан хэрэгжүүлж буй төсөл, грантыг санхүүжүүлэх, соёлын өвийг хамгаалахад шаардагдах хөрөнгийн санхүүжилт, шагнал урамшуулал олгох, харьяа судалгааны байгууллагуудын судлаачдад грант олгох зэргээр тодорхой арга хэмжээнд зарцуулна. Академи болон түүний харьяа хүрээлэнгүүд нь жил бүр төсвийн санхүүжилтээс гадна бусад санхүүгийн эх үүсвэрийг олох, түүнчлэн хувийн хөрөнгө оруулалтыг татах боломжийг судалж нийгмийн сонирхогч бүх талуудтай хамтран ажилладаг.
<b>Тайлбар</b>	Италийн үндэсний ШУА нь олон улсын байгууллагуудтай холбоо тогтоох, цаашид түншлэн ажиллах зорилгоор Дэлхийн ШУА-ийн нэгдсэн сүлжээ, Анагаахын ШУ-ны олон улсын академид гишүүн, ЕХ-ны ШУА-иудын холбооны гишүүн, Европын ШУА-ийн ШУ-ны зөвлөхүүдийн Дээд зөвлөл, ШУА-иудын хүний эрхийг хамгаалах олон улсын хорооны Гүйцэтгэх хорооны гишүүнээр ажиллаж байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://demo.istat.it/bilmens2016gen/index.html">http://demo.istat.it/bilmens2016gen/index.html</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Italy.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Italy.aspx</a> ; <a href="http://www.lincci.it/modules.php?name=Content&amp;pa=showpage&amp;pid=92">http://www.lincci.it/modules.php?name=Content&amp;pa=showpage&amp;pid=92</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Italy/12929.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Italy/12929.aspx</a>

### 16. ИХ БРИТАНИЙ НЭГДСЭН ВАНТ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Умард Европ
<b>Хүн амын тоо</b>	65,110,000
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.87%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, хаант засаглалтай улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	Их Британий ШУ-ныг дэмжих Эзэн хааны нийгэмлэг ( <i>Royal Society Overview</i> )-ийн үүсэл нь 1640-өөд оны дунд үед байгалийн гүн ухаантнуудын уулзаж, ярилцдаг байсан "үл үзэгдэгч коллеж"-д анхлан байгалийн олон янзын хувьсал өөрчлөлт, судалгааны ажиглалт, туршилтын талаараа шинжлэх ухааны байр сууринаас хандаж мэдлэгээ солилцох, харилцан шүүмжилж, үзэл бодлоо хуваалцах болсон нь эцэстээ шинжлэх ухаан хэмээн нэрлэгдэх мэдлэгийн цогц нийлбэрийн үндсийг тавьжээ. Тэрхүү мэдлэгийн цогц нийлбэрийг эрэлхийлэгчдийн ээлжит цугларалт тогтмолжиж 1660 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр болсон 12 дахь удаагийн бүлгийн уулзалтын үеэр Кристофер Уорены тавьсан одон орны талаарх шинжлэх ухааны лекцийн дараагаар Грешамын коллежийг түшиглэн "Физик-математикийн судлагаа, туршилтыг дэмжих" нэртэйгээр байгуулагдсанаар албан ёсоор Эзэн хааны ШУ-ны нийгэмлэг үүсэх үндэс суурь тавигдсан байна.

<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Тус нийгэмлэг нь шинжлэх ухааныг олон уулзварт өнцгөөс судлах сургалт-эрдэм шинжилгээний шинэ аргыг боловсруулан нэвтрүүлснээр шинжлэх ухааны мөн чанарыг хамгаалах чингэхдээ нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан хувь хүний мөн чанар хэрхэн өөрчлөгдөж байгааг болон угсаатны цөөнхийн асуудал, жендэр, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд шинжлэх ухааны ололт, амжилтыг хэрхэн хослуулах, түүнийг нутагшуулахад онцгойлон анхаарахад чиглэсэн байна. 2010 оны Нийгмийн тэгш эрхийн тухай хуулиар шинжлэх ухааны үндэслэлтэй "хамгаалагдсан мөн чанар"-ыг бий болгох үүднээс шинжлэх ухааны олон янз байдлыг нэмэгдүүлэх зорилгоор нас, хөгжлийн бэрхшээл, хүйсийн тэгш байдал, жирэмсний болон амаржсаны, гэрлэлт, иргэний түншлэл, арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, мөн бэлгийн чиг баримжааг авч үзэхдээ шинжлэх ухаанч байдлаар хандаж байхыг тус нийгэмлэгийн зүгээс илэрхийлсэн байна. Энэ аливааг дан ганц талаас бус түүнийг философийн үүднээс мөн чанарыг тодорхойлсон, утга учрыг эрэлхийлсэн байдлаар хандах шинэ хандлага нийгэмд бий болгохыг уриалсан санаачилга болсон.
<b>ЭША-нуудын тоо</b>	Эзэн хааны ШУ-ны нийгэмлэгт Нобелийн шагналт, дэлхийд нэр хүндтэй 65 эрдэмтэн байдгийн дээр одоогийн байдлаар тус нийгэмлэг 1300 эрдэмтэн судлаачидтай үйл ажиллагааг явуулж байна. Энэ нь нийт хүн амын 0.0019 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 1996.6 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Их британи Улсын төсвийн зарцуулалтын 4.7% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Эзэн хааны ШУ-ны Нийгэмлэг нь байгуулагдсан цагаасаа хойш Эзэн хааны Тунхаг бичигт заасны дагуу Засгийн газраас хараат бус байхаар баталсан байна. 1663 онд "Байгалийн мэдлэгийг дээшлүүлэх Лондонгийн эзэн хааны нийгэмлэг"-ийн шинжлэх ухааны уриа бол " <i>verba non Nullius</i> " байгаль ертөнцийн талаарх мэдлэгийг суурь болон эмпирик судалгааны баримтаар нотлох нь тус нийгэмлэгийн чухал байр суурь юм.
<b>Тайлбар</b>	Эзэн хааны ШУ-ны нийгэмлэг, түүний харьяа салбар судалгааны хүрээлэн төвүүдийг тус нийгэмлэгээс томилогдсон 21 судлаач эрдэмтдээс бүрдсэн Зөвлөл удирдана. Тус Зөвлөл нь нийгэмлэгийн бизнесийн үйл ажиллагаа болон Нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүдээс хандивласан хөрөнгө мөнгийг хуулийн дүрмийн дагуу захиран зарцуулах эрхтэй. Нийгэмлэгийн дотоод журам болон нийгэмлэгийн талаар баримтлах баримт бичигт заасанчлан дүрэмдээ өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/populationandmigration/populationestimates">https://www.ons.gov.uk/peoplepopulationandcommunity/populationandmigration/populationestimates</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/UnitedKingdom/12466.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/UnitedKingdom/12466.aspx</a> <a href="http://royalsociety.org/">http://royalsociety.org/</a>

## 17. КАЗАКСТАН УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Ази/Төв Ази
Хүн амын тоо	17,753,200
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.24%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>БН Казакстан Улсын Үндэсний ШУА (National Academy of Sciences of the Republic of Kazakhstan)</i> нь 1946 онд тус улсын тэргүүлэх эрдэмтэд, эрдмийн зэрэг цолтой судлаачид хамтран төрийн статустайгаар байгуулжээ. Үндэсний ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд 1999 оны 2 дугаар сард тус хүрээлэн нь Казакстан улсын Боловсрол, ШУ-ны яамны харьяанд шилжжээ. Казакстаны Үндэсний ШУА-ийн үндсэн үйл ажиллагаа нь ШУ-ны судалгаа, шинжилгээ, шинжлэх ухааны хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон зорихын зэрэгцээ ШУ-ны салбарын ажилтнуудыг сургах, сургалтын үйл явцыг чанаржуулах, ШУ-ны үндэсний хөтөлбөрийг боловсронгуй болгох, өнөөгийн цаг үетэй нийцүүлэн зохицуулах, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, шинжлэх ухааны салбарт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, түүний үйл ажиллагаа хөгжлийг дэмжих. Дэлхий шинжлэх ухаан, математик, мэдээлэл зүй, физик, газар зүйн болон геофизикийн зайнаас тандан судлах арга зүйг дээшлүүлэх, сансрын технологи, хими, шинэ материал, биологийн идэвхт бодис, биохими, ургамал, ургамал судлал, хөрсний шинжлэх ухаан, нийгэм, хүмүүнлэгийн судалгааны чиглэлийг нарийвчлан судлах боломж, бүрдлийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч ажиллаж байна.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Казакстаны Үндэсний ШУА-ийн гишүүд нь харьяа хүрээлэн, төвүүд, лабораторийн эдэм шижнилгээ, судалгааны үйл ажиллагаанд хяналт тавих, цаашлаад математик, физик, геологи, металлург, хими, petrochemistry, биологи, анагаах ухаан, хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, түүх, соёл судлал, хэл, утга зохиол, казахын нийгэм, гүн ухааны сэтгэлгээний чиглэлээрх суурь болон хавсарга судалгаанд өндөр мэргэшсэн эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачдыг татан оролцуулах, улмаар тэдний шинжлэх ухааны болон сурган хүмүүжүүлэх үйл ажиллагаанд дадал, шинж арга зүйг эзэмшүүлэхэд анхаарч ажилладаг. Казахстаны Үндэсний ШУА-ийн нэг гол хэсэг нь БНУ дахь шинжлэх ухааны хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, шинжлэх ухааны болон тандан судалгааны чиглэлээр эрдэм шинжилгээний үр дүнг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор эрдэм шинжилгээний сэтгүүлийг бий болгож, түүнд эрдэмтдийн хамрагдах бололцоог нэмэгдүүлэхэд анхаарна. Түүнчлэн шинжлэх ухаан, судалгааны ажлын үр дүнг нэгтгэсэн Үндэсний тайланг төрийн тэргүүнд тайлагнах, олон төрлийн сургалт, эрдэм шинжилгээний нээлттэй хэлэлцүүлэг зэрэгт олон улсын шинжлэх ухааны хамтын ажиллагаа, инновацийн хөгжлийг нэмэгдүүлэх, түүнд дэмжлэг үзүүлж, суурь шинжлэх ухааны мэдлэгийг түгээхэд онцгойлон анхаарч ажилладаг байна.

ЭША-нуудын тоо	БН Казакстан улсын Үндэсний ШУА нь жинхэнэ болон сурвалжч гишүүдтэй бөгөөд одоогийн байдлаар 238 гишүүнтэйгээс (136 академич, 102 сурвалжлагч), 12 гадаад гишүүн, 88 хүндэт гишүүдтэй байна. Тус академийн хэмжээнд 500 гаруй эрдэм шинжилгэний ажилтан, эрдэмтэн судлаачид ажиллаж байгаа нийт хүн амын 0.0028 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгэний ажилтанд 2816.3 хүн ногдож байна.
Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)	БН Казакстан Улсын төсвийн зарцуулалтын 4.4%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Казакстаны Үндэсний ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд нь төрөөс шууд санхүүжих бөгөөд суурь судалгааны сэдвийг Академиас сонгон шалгаруулж ШУА-ийн салбарын ээлжит чуулганд танилцуулна. Академи сонгогдсон судалгааны сэдвийг санхүүжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцаж ажиллана.
Эх сурвалж	<a href="http://www.stat.gov.kz/faces/homePage?c404=1&amp;_afzLoop=14432126856073841">http://www.stat.gov.kz/faces/homePage?c404=1&amp;_afzLoop=14432126856073841</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Kazakhstan.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Kazakhstan.aspx</a> ; <a href="http://nauka-nanrk.kz/">http://nauka-nanrk.kz/</a>

## 18. КУБА УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Америк тив/ Каррибиан
Хүн амын тоо	11,239,004
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.15%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, нэг намын тогтолцоотой, БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	БНА Куба Улсын ШУА ( <i>Cuban Academy of Sciences/Academia de Ciencias de Cuba</i> ) бол Кубын төрийн байгууллага бөгөөд бие даасан зөвлөх үйлчилгээ үзүүлдэг шинжлэх ухааны асуудал хариуцсан төв байгууллага юм. Кубын ШУА нь анх 1861 оны 5 дугаар сарын 19-нд Испанийн Эзэн хааны ивээл дор анагаах ухаан, физик, байгалийн шинжлэх ухааны Гавайн академи нэртэйгээр байгуулагдсанаас хойш 35 жилийн дараа үүсгэн байгуулагдсан ажээ. Тус академи Европт байгуулагдсан эртний ШУА-дын нэгэн адил эртний мэргэшсэн шинжлэх ухааны байгууллага юм. 1902 онд байгуулагдсан БНУ тунхагласны дараагаар тус академийн бүтэц, зохион байгуулалтыг дахин шинэчлэн байгуулснаар "Эзэн хааны" гэх тодотголоос татгалзсан байна. 1962 онд өрнөсөн Кубын хувьсгалын үйл явцын дараанаас ШУА-ийг эрхлэх Үндэсний комиссийг байгуулснаар анх удаа Кубын үндэсний хэмжээний үр өгөөжтэй ШУ-ны байгууллагыг бий болгожээ.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	1982 онд үндэсний хэмжээний шинжлэх ухааны судалгааг гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн үйл ажиллагааг иргэдийн амьдралд нэвтрүүлэх, соён гэгээрүүлэх ажлын шат дараатайгаар хөгжүүлэх зорилгоор Шинжлэх ухаан, технологийн Үндэсний Хороо бүхий яамны статустай бие даасан институци болгон төлөвшүүлсэн байна. Улмаар 1984 оноос эхлэн Кубын ШУА, түүний харьяа хүрээлэн төвүүдийг Кубын Төрийн төв захиргааны харьяанд буюу Кубын Шинжлэх ухаан, технологи, байгаль орчны яамны харьяанд ажиллуулж улсын төсвөөс санхүүжүүлдэг байна. Тус академи нь ХАА, загас агнуурын шинжлэх ухааны салбар, Био-анагаах ухааны шинжлэх

	ухаан, Байгалийн шинжлэх ухааны салбар, Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны салбар, Техникийн шинжлэх ухааны салбаруудад хуваагддаг ШУА-ийн жинхэнэ гишүүнд их дээд сургуулиуд, шинжлэх ухааны салбарын хүрээлэн болон шинжлэх ухааны нийгэмлэгүүдийн зүгээс нэр дэвшүүлж өрсөлдүүлэх боломжтой.
<b>ЭША-нуудын тоо</b>	Одоогоор тус үндэсний ШУА-д 250 гаруй мэргэшсэн, эрдмийн зэрэг цолтой ЭША-нууд ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.0022 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 22243.9 ногддог байна. ШУА-ийн гишүүдэд эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор нэр дэвшигчдийг ижил квотоор дэвшүүлэхийг эрмэлздэг. Одоогийн байдлаар тус академийн гишүүдийн 28% нь эмэгтэйчүүд байгаа бол нийт эрдэм шинжилгээний ажилтнуудын дунд эзлэх эмэгтэйчүүдийн хувь 48 байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	БНА Куба Улсын төсвийн зарцуулалтын 6.7% -ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг. 1996 оноос Кубын ШУА өөрийн байгууллагын алсын зорилгоо "Кубын шинжлэх ухааныг хөгжүүлэх, үндэсний болон дэлхий дахины шинжлэх ухааны хөгжил дэвшилтэй хөл нийлүүлэх замаар үндэсний шинжлэх ухааны салбарын судалгаа шинжилгээг олон нийтийн амьдралтай уялдуулан мэргэжлийн шинжлэх ухааны зарчмыг төгөлдөржүүлэх улс орны хөгжилд стандарт боловсруулж нийгмийн бүхий л хүрээнд шинжлэх ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлан таниулахад чиглэн ажиллана" хэмээн шинээр томъёолжээ.
<b>Тайлбар</b>	Кубын ШУА нь олон улсын хэд хэдэн хөтөлбөрт хамрагдах бөгөөд ОУ-ын ШУА-ийн дэлхийн сүлжээний Усны хөтөлбөр, ШУ, Боловсролын хөтөлбөр, Дижитал Мэдлэгийг түгээх хүний нөөц, дэд бүтцийн хөтөлбөр, ОУ-ын ШУА-ийн дэлхийн сүлжээний Био-аюулгүй байдлын санаачилга, мөн ШУА-иудын Эрсдэл, гамшгийн эсрэг үйл ажиллагаа явуулах байгууллагуудын гишүүн байгууллага юм.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.one.cu/aec2015/03%20Poblacion.pdf">http://www.one.cu/aec2015/03%20Poblacion.pdf</a> ; <a href="http://www.interacademies.net/academies/byregion/latinamericacaribbean/cuba/13905.aspx">http://www.interacademies.net/academies/byregion/latinamericacaribbean/cuba/13905.aspx</a>

## 19.ЛАТВИ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Умард Европ
<b>Хүн амын тоо</b>	1,953,000
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.026%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, парламентын засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Латви Улсын ШУА (Latvian Academy of Sciences /LAS)</i> бол Латвийн үндэсний ШУА бөгөөд Латвийн ард түмний хэл соёл, түүхийн хөгжлийн судалгааг чанарын өндөр түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дэмжин хөгжүүлэх, улмаар төр улсын үйл ажиллагаанд шинжлэх ухааны үндэслэлтэй санал зөвлөмж гаргах, байгалийн баялаг, хүрээлэн буй орчны зохистой хөгжлийг хангахад хяналт тавих, төр-олон нийтийн харилцаанд шинжлэх ухааны холбогдох асуудлаар нийгмийн холбогдох асуудалд шинжлэх ухаанч үндэслэлээр ханган ажиллахыг үндсэн

	<p>чиглэлээ болгодог. Өнөөгийн Латвийн ШУА бол XIX зуунд Латвид бий болсон эрдэм шинжилгээ, судалгааны хэд хэдэн холбоодоос уламжлалтай төдийгүй 1946-1991 оныг хүртэл тус академи эрдэм шинжилгээ, судалгаагаа үргэлжлүүлэн гүйцэтгэсээр ирсэн. Улмаар 1992 оны 2 дугаар сарын 14-ны өдөр тус улсын Парламент (Seima)-аас батлагдсан Латвийн ШУА-ийн эрх зүйн байдлын хуулийн дагуу Академийн Их чуулганаар тус улсын шинжлэх ухаан, судалгааны ажлыг гүйцэтгэх чиг үүрэгтэй.</p>
<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Латвийн үндэсний ШУА нь Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагуудад шинжлэх ухааны үндэслэлтэй, үнэн бодит баримтад суурилсан санал зөвлөмжийг холбогдох асуудлаар гаргаж өгөхийн зэрэгцээ судалгаа шинжилгээний үр дүн, ололт амжилтыг ард иргэдэд түгээн дэлгэрүүлэх, үндэсний оюун-сэтгэлгээний өв соёлыг дэлгэрүүлэх үндсэн үүрэгтэй. Энэхүү чиг үүргийн хүрээнд Латвийн ШУА-ийн гишүүд болон салбарын хүрээлэнгүүдийн ЭША-нууд олон шинжлэх ухааны уулзварыг холбогдох шинжлэх ухааны төлөөллийг хамруулан судлахыг чухалчилдаг. Үндэсний ШУА нь шинжлэх ухааны дараахь 4 салбар буюу Физик, техникийн шинжлэх ухаан, Хими, биологи, анагаахын шинжлэх ухаан, Нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар, ХАА, ойн аж ахуйн шинжлэх ухааны салбарт хуваагддаг байна. Салбар бүр тухайн салбарын бага чуулгантай бөгөөд үндсэн үйл ажиллагаагаа Латвийн ШУА-ийн нэгдсэн чуулганд тайлагнадаг.</p>
<p><b>ЭША-нуудын тоо</b></p>	<p>2013 оноос эхлэн Латвийн ШУА нь шинжлэх ухааны болон эрдэм шинжилгээний тодорхой асуудлаар ижил төстэй үйл ажиллагаа явулдаг гадны улс орнуудтай харилцаа холбоо тогтооход онцгой анхаарч ирсэн байна. Одоогийн байдлаар тус улсын ШУА-д 1000 орчим эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн судлаачид ажиллаж байна. Латвийн ШУА-ийн жинхэнэ гишүүн буюу академичид 119, сурвалжлагч гишүүд 125, гадаад гишүүд 92, 4 улсаас нийт 57 хүндэт гишүүд байна. ШУА-ийн хэмжээнд жендэрийн харьцаа байгалийн болон нийгэм-хүмүүнлэгийн шинжлэх ухааны хавсарга болон суурь судалгааны салбарт эрэгтэйчүүд илүү жин дардаг байна. Латвийн ШУА-ийн салбарт ажиллагсад нийт хүн амын 0.051 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 512 хүн ногддог байна.</p>
<p><b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b></p>	<p>Латви улсын төсвийн зарцуулалтын 6.8% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг байна. 2012 оны 12 дугаар сард БНЛатви Улсын Парламентаас 2014-2020 он хүртэлх Үндэсний хөгжлийн төлөвлөгөөг батлахдаа тус улсын шинжлэх ухааны салбар, түүний судалгаа хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулах улсын төсвийн санхүүжилтийн хэмжээг ДНБ-ний 1.5%-иас доошгүй хэмжээнд санхүүжүүлнэ хэмээн хуульчлан баталсан байна. Латвийн ШУА нь хагас төсвийн санхүүжилттэй байгууллага бөгөөд санхүүжилтийн зарим эх үүсвэрийг олон улсын төсөл хөтөлбөрүүдэд оролцох замаар гадны улс орнуудын шинэ технологи, ололтуудыг нутагшуулах, мөн өндөр өртөг бүхий инновацийн төслүүдийг хэрэгжүүлэх замаар санхүүжүүлдэг байна.</p>
<p><b>Тайлбар</b></p>	<p>Латвийн үндэсний ШУА бол латвийн хөгжлийн судалгаа, философи-нийгмийн хөгжлийн түүх, соёл, уламжлал, үндэсний түүх судлал, улс төр судлал, хэл соёлын өв уламжлал, улс төрийн сэтгэлгээний түүх, байгалийн эрдэс баялаг, байгаль орчны судалгааг мэргэжлийн өндөр төвшинд хийж гүйцэтгэхийг зорьдог. Латвийн ШУА нь төсвийн тусгай гэрээний дагуу санхүүгийн дэмжлэгийг хандив тусламж, байгалийн баялагаас хуваарилсан ногдол ашиг зэрэг</p>

	бусад эх үүсвэрээс олдог байна. ШУА-ийг жинхэнэ болон сурвалжлагч, гадаад гишүүнтэй байж болохоос гадна өөрийн эгнээндээ нэр хүндтэй, авъяаслаг эрдэмтэн судлаачдыг багтаан ажиллахыг үүрэг болгосон байна.
Эх сурвалж	<a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Latvia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Latvia.aspx</a> ; <a href="http://www.lza.lv/">http://www.lza.lv/</a> ; <a href="http://www.lza.lv/images/stories/YearBook_2014.pdf">http://www.lza.lv/images/stories/YearBook_2014.pdf</a>

## 20. ЛИТВА УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Умард Европ
Хүн амын тоо	2,849,317
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.038%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, хагас-ерөнхийлөгчийн засаглалтай БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>Литва Улсын ШУА (Lithuanian Academy of Sciences)</i> нь 1941 оны 1 дүгээр сарын 16-нд байгуулагдсан. Литвийн ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгийн үйл ажиллагаа нь тус улсын соёл, нийгмийн хөгжлийн харилцаа, уламжлалт соёл, ёс суртахуун, ёс зүйн төлөвшил, ухамсрын төвшин, нийгэм, улс төр-эдийн засгийн хөгжлийн үйл явцтай шууд холбоотой төдийгүй Литвийн ард түмний түүхэн уламжлалт ёс заншил, түүх, философийн уламжлалт сэтгэлгээний өөрчлөлт зэрэг нь өнөөгийн хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн ялгарал, интеграцитай хэрхэн холбогдож буйг олон шинжлэх ухааны уулзвараас судлах нь тус академийн нэн тэргүүний зорилго оршиж байна. 1991 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн ШУ, судалгааны хөгжлийн Литвийн БНУ-ын тухай хуулиар Литвийн ШУА-ийн эрх зүйн байдлыг тодорхойлохдоо тус улсын шинжлэх ухаан, судалгаа эрдэм шинжилгээний төв төрийн харилцаанд зохицуулагдсан институци байна хэмээн тодорхойлсон байна.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Тус хуулийн дагуу ШУА-ийн эрх зүйн байдлыг шинээр томьёолж, улмаар 2003 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн Литвийн БНУ-ын Парламентаар албан ёсоор баталгаажуулсан байна. Хуулийн нэмэлт өөрчлөлтөөр Литвийн ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулиар тус лусад мөрдөгдөж байсан шинжлэх ухааны салбарын хуучин хууль тогтоомжууд эцэслэгдэн цуцлагдаж, шинжлэх ухааны салбарын шинэ үүд хаалгыг нээх боломж, нөхцөл бүрдсэн гэж үзэж болно. Чингэснээр ШУА-ийн нэр хүнд, нөлөө улс орны шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний хөгжлийн үндсэн түлхүүр болох нэн тэргүүний чухал салбар болно. Литвийн шинжлэх ухаан, боловсролын байгууллагуудад ажиллах тоо үлэмж нэмэгдэхийн хэрээр тус салбарт ажиллагчдын тоо мэдэгдэхүйц өсөх хандлагатай болжээ. Одоогоор нийт 29 төрийн мэдлийн судалгаа, эрдэм шинжилгээний төвүүд ажиллаж байгаагаас 24 хүрээлэн тогтвортой ажиллаж байна.
ЭША-нуудын тоо	1990 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн Литвийн ШУА нь ямар нэгэн улс төрийн болон төрийн институциудаас бүрэн хараат бусаар эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа явуулах шийдвэрийг гаргасан байна. Тухайн үед тус академи нь 17 эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэнгүүд болон хавсарга судалгааны туршилтын жижиг дунд

	<p>үйлдвэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байв. Тухайн үедээ дурдсан салбаруудад нийтдээ 5600 гаруй ажилтан албан хаагчидтай байсан бол өнөөдрийн 2000 орчим эрдэмтэн, судлаачидтайгаар ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.070 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 701 хүн ногддог байна.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>Литва улсын төсвийн зарцуулалтын 6.4%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Литвийн ШУА, түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь төсвийн байгууллага бөгөөд улсын төсвөөс санхүүждэг. Шинжлэх ухааны академи нь ашгийн төлөө бус байгууллага тул өөрийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх гол эх үүсвэр нь: төрийн татаас; буяны болон тусламжийн хөрөнгө; олон улсын хөтөлбөр, үйлчлүүлэгч хуулийн этгээдийн захиалгат судалгааны орлого; эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаанаас олсон орлого зэргээс санхүүжинэ.</p>
<b>Тайлбар</b>	<p>Литвийн ШУА нь ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг 26 эрдэм шинжилгээний хүрээлэн төвүүдтэй хамтын ажиллагааны гэрээтэй ажилладаг. Тус академи Вровлевскийн эрдэм шинжилгээний номын санг үүсгэн байгуулсан бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүл, мэдээллийн болон танин мэдэхүйн онол арга зүйн олон арван хэвлэмэл бүтээлүүдийг хэвлэн нийтэлдэг байна.</p>
<b>Эх сурвалж</b>	<p><a href="http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx">http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx</a>  <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Lithuania.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Lithuania.aspx</a>  <a href="http://lma.lt/lt/">http://lma.lt/lt/</a></p>

## 21. МАКЕДОНИ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Зүүн Европ
<b>Хүн амын тоо</b>	2,071,278
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.028%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<p><i>Македоны Шинжлэх ухаан, Урлагийн академи (Macedonian Academy of Sciences and Arts)</i> нь 1967 онд байгуулагдсан бөгөөд тус байгууллага нь БН Македон Улсын шинжлэх ухаан, Урлагийн хамгийн дээд нэр хүндтэй төв байгууллага юм. Шинжлэх ухаан, Урлагийн академийн харьяа нийгмийн шинжлэх ухааны салбар нь хөгжлийн судалгаа, шинжлэх ухааны судалгааны арга зүй, судалгааны үзэл баримтлалд суурилсан төсөл хөтөлбөрүүдийг зохион байгуулах, эрдэм шинжилгээний бага хурал, семинарыг зохион байгуулахын зэрэгцээ бие даасан судалгаа, Урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах бие даасан статустай.</p>
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	<p>Тус академи нь шинжлэх ухаан, урлагийн болоод бусад шинжлэх ухааны хавсарга судалгааг шинжлэх ухааны судалгааны орчин үеийн арга зүй, аргачлалыг баримтлан шинжлэх ухааны ололт амжилтыг олон нийтэд түгээхэд онцгойлон анхаардаг. Академи эрдэм шинжилгээний болон урлагийн төрөл бүрийн идэвхтэй үйл ажиллагааг дэмжин зохион байгуулахад идэвхийлэн оролцдог. Тус академи физик, хими, математик, механик, хүний эм,</p>

	молекул биологи, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухаан, урлаг судлалын чиглэлээр томоохон судалгаа шинжилгээний ажлыг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд санаачилан зохион байгуулж явуулдаг.
<b>ЭША-нуудын тоо</b>	Македоны Шинжлэх ухаан, Урлагийн академид одоогийн байдлаар тэргүүлэх зэргийн 365 эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.017 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 176.2 хүн ногддог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Македон Улсын төсвийн зарцуулалтын 5.1% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Македоны Шинжлэх ухаан, Урлагийн академи, түүний харьяа хүрээлэнгүүдийн санхүүжилтийн эх үүсвэр улсын төсвийн санхүүжилт бөгөөд нийт төсвийн 52.4% улсын төсөв, 23,84% өөрийн үйл ажиллагаанаас олсон орлого, 23,76% хандив тусламжаас бүрдэнэ.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.stat.gov.mk/OblastOpsto_en.aspx?id=2;">http://www.stat.gov.mk/OblastOpsto_en.aspx?id=2;</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Macedonia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Macedonia.aspx;</a> <a href="http://www.manu.edu.mk/about/membershttp://www.manu.edu.mk/">http://www.manu.edu.mk/about/membershttp://www.manu.edu.mk/</a>

## 22.МОНГОЛ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази/Төв Ази
<b>Хүн амын тоо</b>	3,127,925
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.134%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, парламентын засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<p><i>Монгол Улсын ШУА (Mongolian Academy of Sciences/MAS)</i> XIII зуунд Их хаан Хубилай “Бичгийн мэргэдийн хүрээлэн”-г байгуулсан нь Монголчууд эрт дээр үеэс эрдэм номыг эрхэмлэн дээдэлж ирсний илэрхийлэл юм. Ардын засгийн газрын 1921 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн тогтоолоор “Судар бичгийн хүрээлэн” байгуулагдсанаар Монгол улсад шинэ үеийн шинжлэх ухааны төв байгууллага бий болсон түүхтэй бөгөөд хожим нь Шинжлэх ухааны хүрээлэн, Шинжлэх ухаан, дээд боловсролын хүрээлэн болон өргөжин тэлсээр 1961 онд Шинжлэх ухааны Академи болон зохион байгуулагджээ.</p> <p>Монгол Улсын Их Хурлаас 1996 онд баталсан “Монгол улсын ШУА-ийн эрх зүйн байдлын” тухай хуулиар ШУА нь тус улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага болохыг хуульчлан заасан юм.</p> <p><b>ШУА-ийн эрхэм зорилго:</b> Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зорилтыг шийдвэрлэхэд гол хүчин зүйл болохуйц чадавх бүхий олон улсын түвшинд ойртсон онолын суурь судалгааны хүрээлэнгүүдийн сүлжээ бүхий Монгол улсын шинжлэх ухааны төв байгууллага болох.</p>

<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Өнөөдрийн байдлаар ШУА-ийн шууд харьяалалд 10 эрдэм шинжилгээний хүрээлэн төв, 2 салбарын төрөлжсөн академи үйл ажиллагаагаа явуулж байна. <b>Монгол Улсын ШУА нь бүтэц зохион байгуулалтын хувьд:</b> Академийн удирдах дээд байгууллага нь академийн бүх гишүүдийн чуулган бөгөөд жилд хоёроос доошгүй удаа хуралдана.</p> <p>Түүний чиг үүрэг нь: (i) Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, эрдэм шинжилгээ судалгааны ажлын үр дүнг хэлэлцэж судалгааны тодорхой чиглэлийг хөгжүүлэхэд Засгийн газарт дэмжлэг үзүүлэх; (ii) Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж гаргаж Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газарт өргөн барих, ШУА-ийн эрдэм шинжилгээ үйл ажиллагааны тайланг хэлэлцэх; (iii) Академийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, тэргүүлэгчид болон эрдэмтэн нарийн бичгийн даргыг 4 жилийн хугацаагаар сонгох болон (iv) хуулиар заагдсан бусад асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.</p> <p>Их чуулганы чөлөөт цагт ШУА-ийн өдөр тутмын үйл ажиллагааг Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид, эрдэмтэн нарийн бичгийн дарга, <b>Тэргүүлэгчид</b> гишүүдээс бүрдсэн Академийн Тэргүүлэгчид удирддаг бөгөөд Академийн Тэргүүлэгчид ажлын албаараа дамжуулан (Тэргүүлэгчдийн газар) үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.</p> <p>Шинжлэх ухаан, технологийн бодлогыг хэрэгжүүлэх, тэргүүлэх чиглэл, цөм технологийн судалгааны ажилд эрдэм шинжилгээний байгууллагуудын нэгдмэл хамтын ажиллагааг хангах, эрдэмтдийг өргөнөөр оролцуулах, Шинжлэх ухаан, бизнесийн байгууллага хоорондын түншлэл, хамтын ажиллагааг идэвхижүүлэх, эрдэм шинжилгээний бүтээл, дэвшилтэт технологийг хувийн хэвшлийнхэнд сурталчлан таниулах, судалгааны үр дүнг үйлдвэрлэл, хэрэглээнд нэвтрүүлэн хэрэгжүүлэх, үр өгөөжийг нь дээшлүүлэх зорилгоор ШУА-д Салбарын 5 бага чуулган, 2 салбарын төрөлжсөн академи үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр нь:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нийгмийн ухаан</li> <li>• Физик-математик-хими</li> <li>• Геологи-газарзүй</li> <li>• Техник-технологи</li> <li>• Биологийн салбарын бага чуулган</li> <li>• Анагаах ухааны академи</li> <li>• Хөдөө аж ахуйн академи юм.</li> </ul> <p>Бага чуулганууд болон салбар академи нь салбарын судалгаа шинжилгээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавих, салбарын шинжлэх ухааны зохион байгуулалтыг боловсронгуй болгох, тэргүүлэх чиглэлийн судалгааны ажил гүйцэтгэх, үр дүнг дээшлүүлэх, шинжлэх ухаан-бизнесийн байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх, улс орны хөгжлийн байдалд ШУ-ны үүднээс дүгнэлт гаргаж, үндэслэл боловсруулах чиглэлээр үндсэн үйл ажиллагаагаа явуулдаг.</p>
---	--

<b>ЭША-нуудын тоо</b>	Монгол Улсын ШУА болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд нийт 1250 эрдэм шинжилгээний ажилтан, эрдэмтэн удлаачид ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.039 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 399 хүн ногддог байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Монгол Улсын төсвийн зарцуулалтын 5.7% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. ШУА болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийг Монгол Улсын Засгийн газар буюу улсын төсвөөс санхүүжүүлдэг. Түүнчлэн ДНБ-ний 0.16 хувийг шинждэх ухааны салбарт зарцуулж байна.
<b>Тайлбар</b>	ШУА-ийн гадаад хамтын ажиллагаа бүс нутгийн түвшинд төдийгүй олон улсын хэмжээнд өргөжин тэлсээр ирсэн. ШУА нь уламжлалт харилцаа бүхий орнуудтай байгуулсан гэрээ хэлэлцээр, хамтын ажиллагааны протокол, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, шинээр зарим орны ШУА, эрдэм шинжилгээний байгууллагатай харилцаа холбоо тогтоох, олон улсын чанартай арга хэмжээнд оролцох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, хамтарсан экспедиц ажиллуулах, эрдэмтэд солилцох зэрэг чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. ШУА нь Олон улсын шинжлэх ухааны зөвлөлийн жинхэн гишүүн бөгөөд дэлхийн 25 орны эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллаж, тэдгээртэй байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу эрдэмтэн солилцооны хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлдэг.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.en.nso.mn/home">http://www.en.nso.mn/home</a> <a href="http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=21&amp;Itemid=118&amp;lang=mn">http://www.mas.ac.mn/index.php?option=com_content&amp;view=article&amp;id=21&amp;Itemid=118&amp;lang=mn</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Mongolia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Mongolia.aspx</a>

### 23.ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Зүүн Европ
<b>Хүн амын тоо</b>	146,727,405
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	1.96%
<b>Засаглалын хэлбэр</b>	холбооны, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>ОХУ-ын Шинжлэх Ухааны Академи (Russian Academy of Sciences)</i> нь 1774 оны 1 дүгээр сарын 28 (өрнийн тооллын) Аугаа Петр хааны санаачилга, Сенатын зарлигаар Санкт-Петербург хотноо байгуулагджээ. Академи байгуулагдсан даруйдаа шинжлэх ухааны судалгаа, шинжлэх ухааны бүтээлүүдээр дамжуулан Европын бусад эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран ажиллах замаар шинжлэх ухааны ололт амжилтуудыг идэвхийлэн судалж, цуглуулсан нь богино хугацаанд үр дүнгээ өгчээ. Тухайн үеийн шинжлэх ухааны болон уламжлалт сургууль, сургалтын тогтолцоо нь академийг байгуулахад ихээхэн түлхэц үзүүлсэний дээр академийн цаашдын хөгжил, шинжлэх ухааны өөрийн гэсэн өвөрмөц сургууль, сургалтын арга барилыг боловсруулахад хувь нэмэр оруулсан

	<p>байна. Оросын шинжлэх ухааны академи<sup>50</sup> нь ОХУ-ын шинжлэх ухааны дээд байгууллага, байгалийн болон нийгмийн шинжлэх ухааны салбарт суурь судалгаа хийх улсын тэргүүлэх төв юм. ОХУ-д шинжлэх ухааны байгууллагын эрх зүйн байдлыг дараахь үндсэн эрх зүйн баримт бичгүүдээр зохицуулж байна. Үүнд:</p> <p>1) <i>Шинжлэх ухаан, төрийн эрдэм шинжилгээ-техникийн талаарх бодлогын тухай хууль</i><sup>51</sup> нь 1996 онд батлагдсан бөгөөд эрдэмтэн судлаачид, шинжлэх ухаан, техникийн үйл ажиллагаа, төрийн байгууллагууд, шинжлэх ухаан, техникийн бүтээлийг хэрэглэгч, төрийн зүгээс инновацийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.</p> <p>2) <i>Оросын ШУА, төрийн шинжлэх ухааны академийг шинэчлэн зохион байгуулах болон ОХУ-ын зарим хуульд өөрчлөлт оруулах тухай хууль</i><sup>52</sup> нь 2013 онд батлагдсан бөгөөд ШУА-ийн эрх зүйн байдал, бүрэн эрх, чиг үүрэг болон түүний удирдлага, санхүүжилтийн эрх зүйн үндсийг зохицуулна.</p> <p>3) <i>Холбооны төрийн төсөвт байгууллага Оросын шинжлэх ухааны академийн дүрэм</i><sup>53</sup> нь ОХУ-ын Засгийн газрын 2014 оны 589 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд ШУА-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилго, түүний гишүүнчлэл, удирдлага, бүтэц, санхүүжилтийн асуудал болон бусад төрийн байгууллагатай харилцан хамтран ажиллахтай холбоотой харилцааг тус тус зохицуулна.</p>
<p><b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b></p>	<p>Хуучин ЗХУ-ын үед 1925 онд ЗХУ-ын ШУА-ийг байгуулж 1991 оныг хүртэл тус академи оросын шинжлэх ухааны ололт амжилтуудыг үлэмж баяжуулж, судалгаа шинжилгээний өөрийн гэсэн арга барил, арга зүйг төлөвшүүлж чадсан байна. 1991 онд ОХУ-ын Ерөнхийлөгчийн 11 дүгээр сарын 21-ний өдрийн зарлигаар академийг ОХУ-ын ШУА болгон шинэчлэн байгуулж улмаар тус байгууллагыг ОХУ-ын шинжлэх ухааны гол институци болгосон байна. ОХУ-ын ШУА нь анхнаасаа эрдэм шинжилгээний болон боловсролын үйл ажиллагааг цогцоор явуулж, өөрийн харьяандаа их сургууль, дунд сургуулиуд байгуулсан байна.</p> <p>ОХУ-ын ШУА боловсролын салбарын бүх үеийн шинэчлэлүүдэд томоохон үүрэг гүйцэтгэсэн. Тухайлбал, шинэчлэлийн бодлогыг боловсруулах, мэргэжлийн багш нарыг бэлтгэх, эрдэм шинжилгээ, боловсролын салбарын боловсон хүчний аттестачилал явуулах, нарийн мэргэжлийн боловсон хүчний тасралтгүй боловсрол явуулах зэрэгт чухал үүрэгтэй оролцож иржээ.</p>

<sup>50</sup> РАН - Российская академия наук.

<sup>51</sup> Федеральный закон от 23.08.1996 N 127-ФЗ(ред. от 23.05.2016)"О науке и государственной научно-технической политике"(с изм. и доп., вступ. в силу с 01.01.2017). Эх сурвалж: [www.consultant.ru](http://www.consultant.ru). 2017.01.18.

<sup>52</sup> Федеральный закон от 27.09.2013 N 253-ФЗ "О Российской академии наук, реорганизации государственных академий наук и внесении изменений в отдельные законодательные акты Российской Федерации". Эх сурвалж: [www.consultant.ru](http://www.consultant.ru). 2017.01.18.

<sup>53</sup> Постановление Правительства Российской Федерации от 27 июня 2014 г. № 589 "Об утверждении устава федерального государственного бюджетного учреждения "Российская академия наук". Эх сурвалж: [www.gas.ru](http://www.gas.ru). 2017.01.18.

	<p>2013 онд ОХУ-ын ШУА -ийн тухай хуулиар ШУА-ийг шинэчлэн зохион байгуулж, тус академид Оросын Анагаах ухааны академи, Оросын Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академийг нэгтгэжээ.<sup>54</sup></p> <p>ОХУ-ын ШУА зорилго, чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлнэ. Төрийн бүх байгууллагууд болон түүний удирдлагын зүгээс ШУА-ийн эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаанд нөлөөлөх, тус байгууллага өөрийн зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь саад болох шийдвэр гаргахыг хуулиар хориглоно.<sup>55</sup></p>
<b>ЭША-нуудын тоо</b>	<p>Холбооны төрийн төсөвт байгууллагад ОХУ-ын ШУА-иас гадна Оросын боловсролын академи, Оросын архитектур, барилгын шинжлэх ухааны академи, Оросын дүрслэх урлагийн академи хамаардаг. Одоогийн байдлаар ШУА-ийн бүтцэд шинжлэх ухааны 13 салбар, бүс нутгийн 3 салбар, 15 төв ажиллаж байна. Мөн төрөлжсөн 3 академи үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>ОХУ-ын ШУА-ийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдэд нийтдээ 99.500 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид ажиллаж байгаагийн зэрэгцээ тус ШУА-д 800 академич, 10.000 гаруй шинжлэх ухааны доктор, 24.400 гаруй боловсролын доктор, 14.500 эрдмийн зэрэггүй эрдэм шинжилгээний ажилтан ажилладаг байна. Энэ нь нийт хүн амын 0.067 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 678 хүн ногдож байна.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>ОХУ-ын төсвийн зарцуулалтын 3.5% Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулагддаг. ШУА бол төрийн санхүүжилтээр бүрэн санхүүжих бөгөөд суурь судалгааны сэдвийг Академийн зүгээс сонгон шалгаруулж, улмаар ШУА-ийн салбарын ээлжит чуулганаар танилцуулсан судалгааг санхүүжүүлэх, түүнд дэмжлэг үзүүлэх ажлыг хариуцана. ОХУ-ын ШУА нь холбооны төсвөөс санхүүжинэ гэж Шинжлэх ухааны бодлогын тухай хуулийн 6.3, ОШУА-ийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд тус тус тусгасан. ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гаргасан статистик мэдээнээс үзэхэд 2015 онд холбооны төсвөөс иргэний шинжлэх ухаанд 439,4 млрд руб. төсөвлөсөн нь ДНБ-д эзлэх хувиар 0.54 хувийг эзэлж байна. Зардлын хувьд холбооны төсвийг ерөнхийд нь шинжлэх ухааны суурь болон хавсарга судалгаанд хуваарилснаас үзэхэд иргэний шинжлэх ухааны зардал 2011-2015 онд ДНБ-д эзлэх хувиар 0.53-0.60 хувь, үүнээс суурь шинжлэх ухааны зардал 0.13-0.16, хавсарга шинжлэх ухааны зардал 0.37-0.44 хувийг тус тус эзэлж байна. Эрдэм шинжилгээний болон дээд боловсролын байгууллага төсвийн хөрөнгөөр Засгийн газрын тогтоосон журмын дагуу суурь судалгаа, эрэл хайгуулын судалгаа хийсэн тохиолдолд тухайн судалгаа, түүний шинжлэх ухаан, техникийн үр дүнг ШУА-д тайлагнах үүрэгтэй.</p>
<b>Тайлбар</b>	<p>Харин 2015 онд суурь судалгаанд 120,2 млрд. руб. Буюу шинжлэх ухааны нийт зардлын 27,4 хувь, хавсарга судалгаанд 319,2 млрд. руб буюу шинжлэх ухааны нийт зардлын 72,6 хувь тус тус болж байна. Эндээс үзэхэд, суурь судалгааны зардал 2015 онд 15 жилийн өмнөхөөс 1.7 дахин хасагдсан бол хавсарга судалгааны зардал 1.4 дахин нэмэгдсэн байна. Холбооны төрийн төсөвт байгууллага болох ОШУА-ийн 2015 оны төсөв хэд хэдэн эх үүсвэрээс санхүүжигдсэн бөгөөд төсвийн эх үүсвэр нь нийт санхүүжилтийн 86.5 хувийг эзэлж байна.</p>
<b>Эх сурвалж</b>	<p><a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/13383.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/13383.aspx</a></p>

<sup>54</sup> ОШУА-ийн тухай хуулийн 18-р зүйл.

<sup>55</sup> ОШУА-ийн тухай хуулийн 18-р зүйл.

<http://www.ras.ru/>

#### 24.ПОЛЬШ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Зүүн европ
Хүн амын тоо	38,426,809
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.51%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, парламентын засаглалтай БНУ
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<p>Польшийн Шинжлэх ухааны академи<sup>56</sup> (<i>Polska Akademia Nauk</i>) бол эрдэм шинжилгээ, судалгааны улсын байгууллага бөгөөд түүний эрх зүйн байдал, санхүүжилтгүй холбоотой харилцааг дараахь (i) <i>Польшийн Шинжлэх ухааны академийн тухай хууль /ПШУА-ийн тухай хууль</i><sup>57</sup>, (ii) <i>Шинжлэх ухааны үйл ажиллагааг санхүүжүүлэх зарчмын тухай хууль /Шинжлэх ухааны санхүүжилтийн тухай хууль</i><sup>58</sup> хуулиар зохицуулна. Польшийн ШУА бол үндэсний эрдэм шинжилгээ, шинжлэх ухааны төв байгууллага бөгөөд 1952 онд Парламентын санаачилгаар байгуулагдсан бөгөөд 1951 онд тус байгууллагын Эрх зүйн байдлын тухай хуулиар тус улсын шинжлэх ухааны төв байгууллага хэмээн хуульчилсан байна. Польшийн ШУА-ийн хууль ёсны зорилго бол шинжлэх ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, шинжлэх ухааны онолын болон эмпирик судалгааг удирдан зохион байгуулах, судалгаа шинжилгээнд суурилсан үр дүнг практикт нэвтрүүлэхэд оршино. ШУА нь бүтцийн хувьд бие даасан хараат бус өөрийн удирдлагатай, Академи нийтдээ 350 үндэсний болон олон улсын сурвалжлагч гишүүдтэй, суурь судалгаа, эрдэм шинжилгээний 6 салбартай. Тухайлбал, Нийгмийн ШУ-ны, Биологийн ШУ-ны, Математик, физик, химийн ШУ-ны, Техникийн ШУ-ны, Хөдөө АА, Ойн АА, Ургамал судлалын, Анагаахын ШУ-ны, Дэлхийн судлал ба уул уурхайн шинжлэх ухааны хүрээлэнгүүдтэй. ШУА-ийн төв нь нийслэл Варшав хотын ШУ, Соёлын төв ордонд байрлах бөгөөд түүний салбарууд Краков, Вроклав, Поцнан, Катовч, Гданск, Лотц зэрэг хотуудад байрладаг.</p>
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>Польшийн Шинжлэх ухааны академи болон түүний харьяа хүрээлэнгүүд нь судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх, судалгааны нийгмийн хөгжлийн үр дүнг дээшлүүлэх, мөн судалгааны танин мэдэхүйн үр өгөөжийг нэмэгдүүлэх, нийгмийн харилцаанд шинжлэх ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэхэд оршино. ШУА-ийн хүрээлэнгүүд бүтцийн хувьд богино хугацаатай судалгааны нэгжүүд, урт хугацаатай суурь судалгааны салбаруудаас бүрдэнэ. Хүрээлэнгийн нэгж, салбарууд нь мэргэшсэн судалгааны чиглэл, үйл ажиллагааны нөхцөлөөс шалтгаалж бие даасан гэрээт судлаачдыг өөрийн судалгаандаа татан оролцуулаад зогсохгүй шинжлэх ухааны ирээдүйн зүй хандлагыг дээшлүүлэхэд анхаарч онол, үзэл баримтлалын эрс шинэчлэлийг хийж чадсан байна.</p>

<sup>56</sup> Polish Academy of Sciences (PAN)

<sup>57</sup> The Act of 30 April 2010 on the Polish Academy of Sciences.

<sup>58</sup> The Act of 30 April 2010 on the Principles of Financing Science.

	<p>Польшийн ШУА ба төрийн байгууллагын харилцаа: Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч, Сейм болон Сенатын маршал буюу дарга, төв засгийн газрын сайдууд, эсхүл яамны хүсэлтээр /эсхүл өөрийн санаачлагаар/ төрийн бодлого тодорхойлох, хэрэгжүүлэхэд гэж байгаа асуудлын талаар санал, дүн, шинжээчдийн санал болон урьдчилсан таамаглалыг ШУА гаргаж өгнө.<sup>59</sup></p>
<b>ЭША-нуудын тоо</b>	<p>Польшийн ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдийн эрдэм шинжилгээний ажилтнууд их дээд сургуулиудад судалгаа, шинжилгээний үр дүн, туршилт, онолын сургалтыг явуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээ, сургалтын хамтарсан үйл явцыг хослуулан явуулахад чиглэгдэнэ. Одоогийн байдлаар үндэсний ШУА-ийн гишүүд тоо 325 байгаагийн 178 нь жинхэнэ гишүүд, 178 нь сурвалжлагч гишүүд, 197 нь гадаад гишүүд байна. БН Польш улсын ШУА нь ПШУА нь 5 салбарт нэгтгэсэн 5500 гаруй эрдэм шинжилгээний ажилтантай 79 шинжлэх ухааны хүрээлэнгийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.014 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 1431 хүн ногддог байна.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>БНПУ-ын төсвийн зарцуулалтын 5.4% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг байна. Польшийн ШУА, түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь улсын төсвөөс шууд санхүүжихийн зэрэгцээ, ЕХ-ны болон бусад хандивлагч, донор улсуудын эрдэм шинжилгээ, сургалтын тусгай сангуудаас санхүүждэг. Польшийн ШУА-ийн нийт санхүүжилтийн 76,3% нь Польшийн Засгийн газар болон орон нутгийн захиргааны байгууллагаас, 5,3% нь гадаадын хөрөнгө оруулалт, хандиваас, 17,5% бусад эх сурвалжаас бүрддэг байна. 2014 онд ПШУА-ийн нийт актив 690,7 сая злот байсан ба үүний дийлэнх нь газар, барилга эзэлж байна. Энэ үзүүлэлт 2011 оноос хойш тогтмол бүрч ирсэн байна. Тодруулбал, 2011 онд 1 тэрбум гаруй злот, 2013 онд 780,3 сая злот байжээ.<sup>60</sup> ПШУА, түүний хүрээлэнгүүд нь шинжлэх ухааны үр дүнг эргэлтэд оруулах зорилгоор шинжлэх ухааны асуудал хариуцсан сайдын зөвшөөрлөөр хуульд заасны дагуу ашгийн төлөө байгууллагын хувьцааг авах, эзэмшиж болно. Хувьцааны ашиг, хувьцаа худалдсан ашиг нь ПШУА, түүний хүрээлэнгүүдийн ашиг байна.<sup>61</sup></p> <p>Шинжлэх ухааны санхүүжилтийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд заасны дагуу Ерөнхий сайдын дэргэдэх Мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөх байгууллага байх ба түүний үндсэн зорилтын нэг нь аудит хийх, эрдэм шинжилгээний ажлыг үнэлэх үүрэгтэй. Мэргэжлийн дүгнэлт гаргах, зөвлөх байгууллагын үндсэн ажлын нэг нь 4 жил тутам нэгээс цөөнгүй удаа шинжлэх ухааны байгууллагуудын эрдэм шинжилгээ, судалгаа, боловсруулалтын ажлуудын чанарт иж бүрэн үнэлгээ хийнэ.</p>
<b>Тайлбар</b>	<p>Польшийн ШУА-ийн жинхэнэ гишүүдийн тоо 13 байгаа нь нийт гишүүдийн 4 хувийг эзэлдэг байна. Өөрөөр хэлбэл, Польшийн их дээд сургууль төгсөгчдийн 65 хувь нь эмэгтэйчүүд байдаг бөгөө судалгаа хөгжлийн чиглэлээр эрдэм</p>

<sup>59</sup> ПШУА-ийн тухай хуулийн 2 дугаар зүйл.

<sup>60</sup> Comparing National Academies of Sciences in Central and Eastern Europe: Research Careers in the Polish Academy of Sciences – National Topography. MTA Law Working Papers, 2015/30. Dorota Wiszejko-Wierzbicka - Agnieszka Kwiatkowska. Magyar Tudományos Akadémia / Hungarian Academy of Sciences. Budapest. ISSN 2064-4515. Эх сурвалж: <http://jog.tk.mta.hu/mtalwp>

<sup>61</sup> ПШУА-ийн тухай хуулийн 82 дугаар зүйл.

	шинжилгээний ажил хийдэг эрдэмтэдийн 43 хувь нь эмэгтэйчүүд байна. Үүнээс шинжлэх ухааны зөвлөл, судалгааны болон бодлогын төвшинд эмэгтэйчүүдийн 6 хүртэлх хувь, их дээд сургуулиудын ректор, захиралуудын 8.6 хувь нь эмэгтэйчүүд байдаг байна. Энэ бол эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх, жендэрийн тэгш байдлыг хангах, удирдах болон шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүдийн оролцоог хангахад төдийлэн бодит тооны харьцаа биш гэж үздэг байна.
Эх сурвалж	population_size_and_structure_by_territorial_division_as_of_june_30_2016.pdf <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Poland/13047.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Poland/13047.aspx</a>

## 25. СЛОВАК УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Баруун Европ
Хүн амын тоо	5,426,252
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.073%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<b>БН Словак Улсын ШУА (Slovak Academy of Sciences)</b> нь 1953 онд байгуулагдсан цагаасаа хойш суурь болон хавсарга судалгааг гүйцэтгэнэ. Академийн бүрэлдэхүүнд нийтдээ 69 эрдэм шинжилгээний хүрээлэнтэй бөгөөд түүний 48 нь шууд улсын төсвөөс, бусад 21 байгууллага нь хагас төрийн бус байгууллагын статустай үйл ажиллагаагаа явуулна. Словакийн ШУА нь тус улсын Иргэний хөдөлгөөн, холбоодын тухай хуулийн дагуу бусад судалгаа шинжилгээний байгууллагуудыг шинжлэх ухааны үндэсний нийгэмлэгийг өөрийн судалгааны хүрээнд багтаан хамтран ажиллана. Академийн Их чуулган болон Шинжлэх ухааны зөвлөл болон Академийн тэргүүлэгчдийн газар бие даасан үйл ажиллагааг явуулна. Академийн их чуулган бол Словакийн ШУА нь өөрийгээ удирдах, хараат бус удирдах дээд байгууллага мөн бөгөөд академийн салбар бүрээс томилогдсон гишүүдээс бүрдэнэ. Академийн Шинжлэх ухааны зөвлөл бол тус байгууллагын судалгаа эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтаар хангах, шинжлэх ухааны болон үзэл баримтлалын үндсэн зөвлөлгөө өгч ажиллана.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Словакийн ШУА нь шинжлэх ухааны суурь 3 салбарт хуваагдана (математик, физик, техник, дэлхий судлал ба мэдээлэл технологийн судалгаа, анагаах, хими, биологи, хөдөө аж ахуй, мал эмнэлэгийн шинжлэх ухаан, түүх, хүн судлал, соёл урлаг судлал багтана). 1. Математик физик (4), Сансар дэлхий судлал (4), Инженерийн шинжлэх ухаан (7); 2. Амьдрахуй ухаан, биологи, химийн шинжлэх ухаан (5), Анагаахын шинжлэх ухаан (7), Байгалийн шинжлэх ухаан (7); 3. Нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэг, урлаг болон түүх, соёл судлал багтана (3), Нийгмийн ухаан ба хүмүүнлэг (7), Соёл, урлаг (7); 4. Тусгай үйл ажиллагаа эрхэлдэг 6 нэгж хэлтсүүд, Төрийн үйлчилгээ хүргэх 4 хэлтсүүдтэй.

<b>ЭША-нуудын тоо</b>	Словакийн ШУА-ийн салбар хүрээлэнгүүдэд нийтдээ 3250 ажилтан албан хаагчид ажиллаж байгааг 1460 нь эрдмийн зэрэг цолтой эрдэмтэд байгаа нь нийт хүн амын 0.059 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 589.9 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	БН Словак Улсын төсвийн зарцуулалтын 4.3% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Словакийн Шинжлэх ухаан, урлагийн академи, түүний харьяа хүрээлэнгүүд нь Словакийн болон Европын олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах замаар олон улсын болон үндэсний хэмжээний хамтарсан төсөл, шинжлэх ухааны судалгааны төрийн хөтөлбөр болон Европын шинжлэх ухааны сангийн үйлчилгээнд хамрагдаж санхүүжигдэнэ.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://slovak.statistics.sk/wps/portal/ext/products/informationmessages">https://slovak.statistics.sk/wps/portal/ext/products/informationmessages</a> <a href="http://www.sav.sk/?lang=en&amp;doc=sas-history">http://www.sav.sk/?lang=en&amp;doc=sas-history;</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Slovakia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Slovakia.aspx;</a>

## 26. СЛОВЕНИ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Өмнөд Европ
<b>Хүн амын тоо</b>	2,064,241
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.028%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, хаант засаглалтай улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	БН Словени Улсын Шинжлэх ухаан, урлагийн академи ( <i>Slovenian Academy of Sciences and Arts/SASA</i> ) нь тус улс дахь эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудын хамгийн эртний байгууллага бөгөөд 1693 онд Operosorum Academia нэртэйгээр байгуулагджээ. Словений ШУА бол өмнөх нийгмийн үед нийгмийн хамгийн нэр хүндтэй хүмүүс болох сүмийн санваартан, язгууртан, сэхээтнүүдийн төлөөллөөс бүрдэж байв. Энэ байдал 1725 оныг хүртэл буюу хагас зууны туршид үргэлжилсэн. 1779 онд байдал өөрчлөгдөж улмаар 18 дугаар зууны үе гэхэд Словенид ямар нэгэн академи үлдээгүй байна. 1938 онд одоогийн ШУА-ийн үндсийг тухайн үеийн нийгмийн болон шинжлэх ухааны томоохон зүтгэлтнүүд нийлж байгуулсан бөгөөд дэлхийн II дайны үед тус улсын ШУА нь өөрийн үйл ажиллагаагаа идэвхтэй явуулж ирсэн төдийгүй дайны дараагаар Словений Шинжлэх ухаан, урлагийн академи нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулах болсон байна.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Словенийн Шинжлэх ухаан, Урлагийн академи нь хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны үндсэн хоёр салбарт хуваагдах бөгөөд нийтдээ 17 эрдэм шинжилгээний хүрээлэнтэй. Хүрээлэнгүүд нь Академийн шууд удирдлаг дор харьяалагдах бөгөөд хүрээлэн нь дотроо судалгаа мэргэшсэн төвүүдтэй байдаг. Тухайлбал, 1. Антропологи, орон зайн судалгааны хүрээлэн 1994 онд байгуулагдсан 123 ЭША-тай, 2. Археологийн хүрээлэн 1972 онд байгуулагдсан 150 ЭША-тай,

	<ol style="list-style-type: none"> <li>3. Биологийн хүрээлэн 1950 онд байгуулагдсан 20 ЭША-тай,</li> <li>4. Газар зүйн хүрээлэн 1946 онд байгуулагдсан 110 ЭША-тай,</li> <li>5. Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн 1981 онд байгуулагдсан 15 ЭША-тай,</li> <li>6. Соёл судлал, дурсамж судлалын хүрээлэн 2008 онд байгуулагдсан 30 ЭША-тай,</li> <li>7. Урлагийн түүх судлалын хүрээлэн 2005 онд байгуулагдсан 12 ЭША-тай,</li> <li>8. Словений Карстологийн хүрээлэн 1976 онд байгуулагдсан 30 ЭША-тай,</li> <li>9. Словений Цагаачлалын судалгааны хүрээлэн 1990 онд байгуулагдсан 15 ЭША-тай,</li> <li>10. Словений Утга зохиол, хэл бичиг судлалын хүрээлэн 1935 онд байгуулагдсан 25 ЭША-тай,</li> <li>11. Словений хөгжим судлалын хүрээлэн 1980 онд байгуулагдсан 25 ЭША-тай,</li> <li>12. Словений угсаатны зүйн хүрээлэн 1947 онд байгуулагдсан 25 ЭША-тай,</li> <li>13. Словений хэл судлалын хүрээлэн 1945 онд байгуулагдсан 75 ЭША-тай,</li> <li>14. Түүхийн хүрээлэн 1947 онд байгуулагдсан 30 ЭША-тай</li> <li>15. Палентологийн хүрээлэн 1970 онд байгуулагдсан 150 гаруй ЭША-тай,</li> <li>16. Философийн хүрээлэн 1979 онд байгуулагдсан 35 ЭША-тай,</li> <li>17. Этнохөгжим судлалын хүрээлэн 1934 онд байгуулагдсан 75 ЭША-тай,</li> </ol> <p>Словений ШУ, Урлагийн академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь академийн зүгээс өгсөн захиалгат судалгааг онолын болоод прагматик төвшинд шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа нотолгоонд суурилсан үнэн бодит, баталгаатай гүйцэтгэхэд түлхүү анхаарна. Бусад ижил төстэй төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран харьцуулсан улс төр судлал, соёлын харилцаа, ёс зүйн асуудлыг олон шинжлэх ухааны уулзварт чиглүүлэн судална. Их дээд сургуулиудын боловсролын хөтөлбөрт судалгаанд суурилсан сургалт, практикийн дадал зуршилыг эзэмшүүлэхэд хамтран ажиллана.</p>
<b>ЭША-нуудын тоо</b>	<p>Словений Шинжлэх ухаан, урлагийн академи нь Их чуулганаар сонгогдсон жинхэнэ, сурвалжлагч, гадаад гишүүнтэй. Академийн жинхэнэ гишүүдийг “академич” цолтой байх бөгөөд эрх зүйн байдлын хуулиар академи 60 академич, 30 сурвалжлагч гишүүнтэй байхаар заасан байдаг. Жинхэнэ гишүүдийг сонгох насны дээд хязгаар 75 байна. Одоогийн байдлаар академи 1 хүндэт гишүүнтэй, 76 жинхэнэ, 27 сурвалжлагч гишүүнтэйгээр үйл ажиллагааг явуулж байна. Словений ШУА-ийн харьяа хүрээлэнд нийтдээ 1000 орчим эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчид ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.048 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 484 хүн ногдож байна.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>БН Словени Улсын төсвийн зарцуулалтын 5.8%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Словений ШУА-ийн харьяа Философи, шинжлэх ухааны судалгааны хүрээлэн нь улсын төсвөөс шууд санхүүжихээс гадна олон улсын төсөл хөтөлбөрүүд болон тусгай сангуудаас нэмэлт санхүүжилт авдаг байна.</p>
<b>Эх сурвалж</b>	<p><a href="http://www.stat.si/StatWeb/en/field-overview?idp=17&amp;headerbar=13">http://www.stat.si/StatWeb/en/field-overview?idp=17&amp;headerbar=13</a>  <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Slovenia/12494.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Slovenia/12494.aspx</a></p>

<http://www.sazu.si/en/about-sasa>

## 27.ТАЖИКСТАН УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази/Төв Ази
<b>Хүн амын тоо</b>	8,551,000
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.114%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Тажикстан Улсын ШУА (Academy of Sciences of the Republic of Tajikistan)</i> болох Тажикстан байнгын ажиллагаатай шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэх мэргэшсэн байгууллагыг 1920-1930 оны үед байгуулж эхэлсэн байна. Тухайлбал, хуучин ЗХУ-ын ШУА-ийн эрдэмтдийн явуулсан өргөн хэмжээний судалгааны экспедици нь тус улсад шинжлэх ухааны судалгааны ажлыг орчин үеийн нөхцөл байдалд тохируулан нутагшуулах, үйл ажиллагааг эхлүүлэхэд онцгой нөлөө үзүүлжээ. Тус экспедициэр Тажикийн ард түмний түүх, соёлыг судлах, улс орны байгалийн нөөц баялгийн эрэл хайгуул хийх, эрдэм шинжилгээний төвийг байгуулах, эрдэм шинжилгээний ажилтнуудыг сургахад тусгайлан анхаарч ажиллаж байв. Тажикстаны ШУА бол эрдэм шинжилгээний хангалттай нөөц бололцоотой, өргөн хүрээг хамарсан суурь болон хавсарга судалгааг хийх чадавх, туршлагатай, шинжлэх ухаан, соёл, боловсрол, эдийн засгийн цаашдын хөгжилд их нөлөө үзүүлж чадахуйц хэмжээний үндэсний чадавхжсан байгууллага юм. Тажикстаны орчин цагийн ШУА 1951 онд үүсэн байгуулагджээ.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Одоогоор Тажикстаны ШУА нь 21 салбар хүрээлэн, ШУА-ийн харьяа Памир дахь судалгааны төв болон Умард Тажикстан дахь Хужантын эрдэм шинжилгээн, судалгааны хүрээлэн, өмнөд Тажикстаны Хатлин дахь Эрдэм шинжилгээний төвүүдийг тус тус бүтэцдээ багтаасан байна. Салбарын хүрээлэнгүүд нь байгалийн, техникийн анагаахын болон нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний ажлаа гүйцэтгэж байна. ШУА-ийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын үндсэн чиглэл нь дараахь үндсэн 3 салбарт буюу Физик-математик, хими болон геологийн шинжлэх ухааны салбар; биологи анагаахын салбар; нийгмийн шинжлэх ухааны салбарт хуваагдаж байна. Тухайн салбарууд нь онолын мэдлэгийг практикт шилжүүлэх замаар үндэсний эдийн засгийн хөгжлийн чадавхийг дээшлүүлэх, хөдөө аж ахуй, газар тариалан, барилга байгууламж, металлург, химийн үйлдвэрлэл болон компьютерийн програм хангамж, геологи, нийтийн эрүүд мэндийн үйлчилгээг бэхжүүлэх шинжлэх ухааны ололт дэвшлийг нийгмийн хөгжлийн хандлагад нийцүүлэн солонгоруулахад үндсэн чиглэлээ тодорхойлон ажиллаж байна. Нийгэм-улс төрийн хуучин тогтолцооноос гарсан он жилүүдэд ШУА-ийн хүрээлэнгүүдийн үйл ажиллагааг дахин шинээр томъёолон ажиллаж эхэлснээс хойш өнөөдрийн байдлаар Тажикстан болон ОХУ-ын нэр дээр 150 гаруй эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зохиогчийн эрхийн сертификат бүртгэгдсэн байна.

<b>ЭША-нуудын тоо</b>	Тажикстаны ШУА нь нийтдээ 2149 хүн ажиллаж байгаагийн 866 нь судлаач, эрдэм шинжилгээний ажилтнууд (үүнээс 140 нь шинжлэх ухааны докторууд, 339 нь боловсролын докторын зэрэгтэй) байгаагийн 387 нь эрдмийн зэрэг цолгүй ажилтнууд байдаг. Тус академийн тэргүүлэгчид нь 28 жинхэнэ гишүүн, академич, 51 сурвалжлагч гишүүн, 13 нь Тажикистаны ШУА-ийн гадаад гишүүнтэйгээр эрдэм шинжилгээ судалгааны ажлаа гүйцэтгэдэг байна. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.025 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 2513 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Тажикстан улсын төсвийн зарцуулалтын 2.2% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Тажикистаны ШУА, түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн гадаад харилцааг өргөжүүлэх зорилгоор гадаад орнуудын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудтай хамтын ажиллагаа тогтоох, харилцан санхүүжилт гаргаж судалгаа явуулахыг зөвшөөрдөг. ШУА, түүний харьяа хүрээлэн, төвүүд нь шууд улсын төсвөөс санхүүждэг. Засгийн газраас бусад улс орнуудын хооронд хийх аливаа гэрээ хэлэлцээрт өөрийн орны ШУА-ийн үйл ажиллагааг дэмжих, хамтран төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор албан ёсны батлан даалт гаргаж өгөх, тодорхой санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэдэг байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.stat.tj/en/">http://www.stat.tj/en/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx">http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Tajikistan.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Tajikistan.aspx</a> ; <a href="http://www.anrt.tj/index.php/en/">http://www.anrt.tj/index.php/en/</a>

## 28. ТАЙВАНЬ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази тив /Зүүн Ази
<b>Хүн амын тоо</b>	23,532,065
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.31%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, хагас ерөнхийлөгчийн засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<b>Тайвань (БНХАУ)-ий Шинжлэх Ухааны Академи (<i>Academia Sinica</i>)</b> нь эх газрын Хятадад 1928 онд эрдэм шинжилгээ, судалгааны нэр хүндтэй хүрээлэнгүүд болох Шинжлэх ухаан судлал, Нийгмийн ухааны судалгаа шинжилгээний ажлуудын хүрээнд төлөвшин хөгжжээ. 1949 онд Гоминданы засгийн газар Тайвань руу шилжсэний дараа нийслэл Тайпай хотноо Тайваний ШУА дахин байгуулагдсан бөгөөд шилжилтийн он жилүүдэд тус Академи нь хөрөнгө санхүүгийн гачигдалтай, улс төрийн тогтворгүй байдалтай учирч байсан ч шинжлэх ухааныг хөгжүүлэх үндэсний зорилтын хүрээнд ШУА-иас математик, физикийн шинжлэх ухаан, амьдрах ухаан, хүмүүнлэг-нийгмийн шинжлэх ухааны чиглэлээр төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байжээ.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Тайваний ШУА нь нийт 24 эрдэм шинжилгээний салбар хүрээлэнтэй. 1954 онд тус ШУА-ийг дахин шинэчлэх, бүтэц бүрэлдэхүүнийг сайжруулах үүднээс өмнө нь байсан 23 хүрээлэн дээр нэмж Социологийн хүрээлэнг бие даасан хүрээлэн болгон байгуулжээ. Үндэсний ШУА-ийн эрдэм шинжилгээний ажлын үндсэн зорилго бол судалгаа

	шинжилгээний үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх, судалгаанд суурилсан төлөвлөлтийг бий болгох, судалгааны үйл ажиллагаанд олон нийтийг татан оролцуулах, залуу судлаачид, эрдэмтдийг судалгаа эрдэм шинжилгээний арга зүй, дадал сургах, эрдэм шинжилгээний дадал эзэмших ур чадварыг дээшлүүлэх, судлаачдын ёс зүйд төлөвшүүлэхэд онцгойлон анхаардаг. Түүнчлэн эрдэм шинжилгээ, судалгааны үр өгөөжийг нийгмийн хөгжлийн хурдацтай хөл нийлүүлэхэд бодлогоор дэмжихэд чиглэгдэнэ.
<b>ЭША-нуудын тоо</b>	1994 орчим эрдэм шинжилгээний ажилтан, судлаачид байгаа нь нийт хүн амын 0.008 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 847.3 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Тайвань улсын төсвийн зарцуулалтын 3.6% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг бөгөөд Тайваний ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд нь бие даасан статустайгаар тус улсын ЗГ-ын шууд удирдлага дор судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаагаа явуулдаг байна. Мөн олон улсын болон үндэсний хэмжээний томоохон сангуудаас төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, онолын болон суурь судалгааны сэдвийн зөвлөх үйлчилгээнд өрсөлдөх замаар давхар санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэн ажилладаг байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://www.sinica.edu.tw/main_e.shtml">https://www.sinica.edu.tw/main_e.shtml</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/11850.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/11850.aspx</a> ; <a href="https://www.sinica.edu.tw/en/articles/12">https://www.sinica.edu.tw/en/articles/12</a> ;

## 29.УНГАР УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Зүүн Европ
<b>Хүн амын тоо</b>	9,830,485
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.13%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>БН Унгар Улсын ШУА (Hungarian Academy of Sciences)</i> буюу Нийгэм судлалын академи нь 1825 онд байгуулагдсан бөгөөд 1845 оноос Унгарын ШУА гэж нэрлэгдэх болсон. Тус академи нь 1848 оныг хүртэл Унгарын хэл, уран зохиол, үндэсний театрыг хөгжүүлэхэд ихээхэн амжилттай ажиллаж байв. Унгарын ардын яруу найргийн дээжсийн цуглуулгыг үндэсний ашиг сонирхлоос үүдэлтэй аливаа асуудлыг шийдвэрлэхэд өрсөлдөөнт байдлаар шүүн хэлэлцэх болсноор жүжгийн зохиол бичих, орчуулгын бүтээл туурвихад ихээхэн хувь нэмэр оруулжээ. Энэ нь Унгарт шинжлэх ухааны ном бүтээлийг хэвлэн нийтлэх үндсийг тавьсан юм. 1869 онд баглагдсан хуулинд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулан 1945 оныг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байжээ. Тус хуулинд заасны дагуу Академийн үндсэн зорилго бол шинжлэх ухааны аливаа судалгааг уламжлал, шинэчлэлийн ямар цаг үед хослуулан үргэлжлүүлэх, улмаар Унгарын утга, уран зохиолын нарийвчилсан судалгааг үргэлжлүүлж, түүнийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэгдсэн байна. ШУА-ийн эрх зүйн байдлын тухайн хуулинд зааснаар академи нь дараахь үндсэн 3

	салбараар эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гүйцэтгэнэ: I. Хэл шинжлэл, гоо зүй, II. Философи, нийгэм, түүхийн шинжлэх ухаан, III. Математик, байгалийн шинжлэх ухаан гм.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Салбарын судлаачдын судалгааны үндсэн чиглэл нь нэн орчин үеийн шинжлэх ухаан, анагаах ухааны болон физик, сэтгэл судлал, нийгмийн шинжлэх ухааны түүхийн гол гол асуудалд илүү анхаарал хандуулж ажилладаг. Мөн түүхийн танин мэдэхүйн болон социологийн мэдлэгээр дамжуулан тулгамдаж буй асуудлыг тодруулан гаргах, түүнд нарийвчилсан задлан шинжилгээ хийхийг зорьдог. Өөрөөр хэлбэл, аливаа бэрхшээлтэй асуудлыг судлахад олон шинжлэх ухааны уулзвараас судалж, түүнд илүү дэлгэрэнгүй онолын болон нөхцөл байдлыг урьдчилан таамагласан задлан шинжилгээ хийхийг оролдох болсон байна. Судалгааны баг хоёр долоо хоногт судалгаа шинжилгээний завсрын үр дүнг тодруулсан семинар, нээлттэй хэлэлцүүлэг, дугуй ширээний ярилцлага хийж онолын дискурсыг тогтмол өрнүүлдэг байна.
<b>ЭША-нуудын тоо</b>	Өнөөдрийн байдлаар ШУА-д 1392 эрдэм шинжилгээний байгууллагуудын эрдэм шинжилгээний ажилтнуудын 55 хувь нь 35 хүртэлх настай бөгөөд энэ салбарт ажиллах хүний нөөц хүйсийн харьцаагаар тогтвортой өссөөр байгаа ажээ. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.014 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 1416 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	БН Унгар Улсын төсвийн зарцуулалтын 4.6% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Унгарын ШУА болон түүний салбарууд тус улсын төсвөөс санхүүжинэ. Академи өөрийн олсон нийт орлогын 25 хүртэлх хувийг эмч, багш нарын сарын цалин дээр судалгааны ажлын нэмэгдэл тооцон олгох бөгөөд олсон орлогын татвараас хуримтлагдсан жилийн дундаж нэмэлт орлого нь ойролцоогоор 120 сая евроны төсөвтэй.
<b>Тайлбар</b>	Түүнчлэн тус салбарын нэг гол судлагдахуун нь Төв Европын оюуны сэтгэлгээний хандлагыг судлахад онцгойлон анхаарч, энэ чиглэлээр суурь болон хавсарга судалгааг хийж гүйцэтгэдэг байна. Философи, түүхийн шинжлэх ухааны салбараас Унгарын гүн ухаан, оюун сэтгэлгээний түүх, мөн олон улсын хэмжээний асуудалд Унгарын шинжлэх ухаан, хүмүүнлэгийн түүхэн гүйцэтгэх үүргийг судлахад гол анхаарлаа хандуулдаг.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Hungary.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Hungary.aspx</a> ; <a href="http://www.ksh.hu/pls/ksh/docs/eng/xstadat/xstadat_annual/i_wdsd003b.html">http://www.ksh.hu/pls/ksh/docs/eng/xstadat/xstadat_annual/i_wdsd003b.html</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Hungary.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Hungary.aspx</a>

## 30.УКРАЙН УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Зүүн Европ
Хүн амын тоо	42,620,007
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.57%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, хаант засаглалтай
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>Украины Үндэсний ШУА (National Academy of Sciences of Ukraine)</i> нь 1918 онд байгуулагдсан бөгөөд хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан тусгаар улсуудын хамтын нийгэмлэгийн орнуудын ууган академиудын нэг юм. Академи байгуулагдсан эхний он жилүүдэд үндсэндээ шинжлэх ухааны гурван хэлтэст буюу түүх-хэл бичиг судал, физик-математик, нийгэм-эдийн засгийн судалгаанд хуваагдаж байв. ШУА-ийн эрх зүйн байдлын хуулиар тус улсын академи нь бие даасан статустай эрдэм шинжилгээ судалгаа, шинжлэх ухааны төв байгууллага мөн бөгөөд төрийн шууд ивээлд байна. Хуулийн дагуу ШУА нь жинхэнэ болон сурвалжлагч, гадаад гишүүдтэй байх бөгөөд эрдэм шинжилгээний ажилтан, судлаачидтай байх бөгөөд харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй байна. ШУА нь байгалийн, техникийн, нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарын зохион байгуулалттайгаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа эрхлэн гүйцэтгэнэ.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	Украины Үндэсний ШУА нь байгалийн, техникийн, нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарын зохион байгуулалттайгаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлаа дараах 14 хүрээлэнгүүдээр дамжуулан эрхлэн гүйцэтгэнэ. Үүнд: Математик, Информатик, Механикийн, Физик-Одон орон судлалын, Дэлхий судлал, Физик-техникийн, Материал судлалын, Эрчим хүчний болон инженерийн, Цөмийн физикийн, эдийн засгийн, түүхийн философийн болон эрх зүйн, утга зохиол, хэл урлаг судлалын чиглэлээр төрөлжсөн хүрээлэнгүүдтэй байна. Академи нь мөн дараах 5 бүс нутгийн судалгааны төвүүдтэй байх бөгөөд тэдгээр нь Украины Боловсрол, Шинжлэх ухааны яамны давхар статустай байна: Донецк мужийн, Баруун бүсийн (Львиль), Өмнөд бүсийн (Одесс), Зүүн хойд бүсийн (Харькив), Дниеперийн (Дниепропетск) болон Киевийн Шинжлэх ухаан, инновацийн төвүүдтэй. 2014 оноос Кремийн ШУ-ны төвийн санхүүжилтийг Украины Үндэсний ШУА-иас шууд санхүүжүүлэх болсон. Академийн бүтцэд судалгаа, аж үйлдвэрийн туршилтын бааз (судалгааны аж ахуйн нэгж, зураг төсөл, технологийн байгууллагууд, мэдээллийн төв)-ууд шууд харьяалагдах бөгөөд судалгааны эрдэм шинжилгээний туршилтын бааз 168, аж үйлдвэрийн туршилт-практикийн бааз 46 байна.
ЭША-нуудын тоо	Өнөөдөр Украины Үндэсний ШУА 3 үндсэн суурь судалгааны хүрээлэн, 15 чиг үүргийн комисс, 140 орчим эрдэм шинжилгээний ажилтантай 13 салбар, 170 эрдэм шинжилгээ, судалгааны хүрээлэн төвтэй, 13.000 эрдэм шинжилгээний ажилтан судлаачтай, 545 байгууллагыг өөрийн гишүүнчлэлд багтаадаг. 2016 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар тус улсын ШУА-ийн салбар хүрээлэнгүүдэд нийтдээ 37.447 ажилтан албан хаагчид ажиллаж байгаагийн 18.346 нь эрдмийн зэрэг цолтой эрдэмтэн судлаачид ажиллаж байгаагийн 2530 нь боловсролын, 7603 нь шинжлэх ухааны докторууд байна. Мөн улсын хэмжээнд 197 академич, 379 сурвалжлагч гишүүн, 104 гадаад гишүүд

	байна. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.087 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 878 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	БН Украин Улсын төсвийн зарцуулалтын 4.4% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Украины Үндэсний ШУА болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь шууд улсын төсвөөс санхүүжих бөгөөд судалгаа, шинжилгээний нээлттэй сонгон шалгаруулалтад оролцож олсон санхүүгийн бусад эх үүсвэрээс санхүүждэг.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://database.ukrcensus.gov.ua/PXWEB2007/eng/news/op_popul_e.asp">http://database.ukrcensus.gov.ua/PXWEB2007/eng/news/op_popul_e.asp</a> <a href="http://www.nas.gov.ua/EN/About/Pages/default.aspx">http://www.nas.gov.ua/EN/About/Pages/default.aspx</a>

## 31.ФИНЛЯНД УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Умард Европ
<b>Хүн амын тоо</b>	5,503,347
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.074%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, бүгд найрамдах улс
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<i>Финляндын ШУА-ийн Үндэсний Зөвлөл (Council of Finnish Academies)</i> нь Финляндын шинжлэх ухааны нийгэмлэгийн хүрээнд үндэсний болон олон улсын төвшинг нэмэгдүүлэх зорилгоор 1975 онд байгуулагдсан. 2003 онд Финляндын Техникийн ШУА болон Финланд дахь Шведийн Инженерийн академийн нэгдэж Финляндын ШУА-ийн нэгдсэн холбоог байгуулжээ.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Финляндын Үндэсний ШУА-ийн зөвлөлийн найман төлөөлөгчөөс бүрдэх бөгөөд тэдний хоёр нь Финляндын Шинжлэх ухаан, хэл бичиг судлалын академиас, 2 нь Финляндын хэл бичиг судлал, шинжлэх ухааны нийгэмлэгээс, 1 нь Финляндын Техникийн ШУ-ны Академиас, 1 нь Финланд дахь Шведийн Инженерийн шинжлэх ухааны академиас, 2 нь Финляндын Шинжлэх ухааны судалгааны нийгэмлэгүүдийн нэгдсэн холбооноос тус тус томилогддог. Финляндын ШУА-ийн Зөвлөл нь үндэсний облон олон улсын төвшинд хүмүүнлэгийн болон шинжлэх ухааны бүх салбарын чанарыг дээшлүүлэх, судалгаа, хөгжлийн болон судалгаа туршилтын ажлыг дэмжих үйл ажиллагааг явуулдаг. Нөгөө талаар аливаа тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхдээ судалгаанд суурилсан экспертийн санал дүгнэлт бүхий тайлан, үйлдвэрлэлийн үнэлгээ, мөн түүнчлэн шинжлэх ухааны олон уулзварт заагт харилцан уялдаатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн чухалчилдаг. Зөвлөл нь олон улсын тавцанд Финляндын хэл соёл, шинжлэх ухаан, эрдэм шинжилгээний байгууллагуудыг шууд төлөөлөх бөгөөд Финляндын үндэсний хэмжээний шинжлэх ухааны 30 гаруй мэргэжлийн хороодын үйл ажиллагааг Шинжлэх ухааны олон улсын зөвлөл (ICSU)-д төлөөлөх үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах үүрэгтэй. Зөвлөл нь эдгээр үйл ажиллагааны болон бусад нэгдсэн арга хэмжээний төсөв, зардлыг Финляндын Боловсролын яамнаас шууд татаас авч түүнийг хуваарилаж тараах эрхийг эдэлнэ.

<b>ЭША-нуудын тоо</b>	2008 оны эхээр тус нийгэмлэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх үүднээс Финляндын Мэргэшсэн судалгааны нийгэмлэгүүдийн холбоонд шилжүүлсэн. 1899 онд байгуулагдсан тус улсын үндэсний холбоо нь Финлянд дахь мэргэшсэн нийгэмлэгүүдийн үндэсний сүлжээ /шүхэр/-ийн байгууллагын статустай байгуулагдсан байна. 2008 оны эхээр тус нийгэмлэг 250.000 гишүүнчлэлтэй, шинжлэх ухааны судалгааны нэгэн сонирхолтой жирийн эрдэмтэд, жирийн итгэгчдээс бүрдсэн 251 шинжлэх ухааны нийгэмлэгүүдээс бүрдэнэ. Шинжлэх ухааны салбарт ажиллагсдыг нийт хүн амд эзлэх хувь 4.5 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 4 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Финлянд Улсын төсвийн зарцуулалтын 7.5% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Финляндын ШУА-ийн санхүүжилт нь улсын төсөв болон олон нийтийн хандив тусламж, хувийн болон олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрүүдээс санхүүжинэ.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://tilastokeskus.fi/til/vamuu/2016/index_en.html">http://tilastokeskus.fi/til/vamuu/2016/index_en.html</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Finland.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Finland.aspx</a> ; <a href="http://www.academies.fi/en/">http://www.academies.fi/en/</a>

## 32. ФРАНЦ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Баруун Европ
<b>Хүн амын тоо</b>	66,991,000
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.90%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, хагас-ерөнхийлөгчийн засаглалтай БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<b>Франц Улсын Шинжлэх Ухааны академи</b> ( <i>Académie des Sciences, Institut de France</i> ) нь 1666 оны 12 дугаар сарын 23-ны өдөр тухайн үеийн Францийн шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн Жан-Бафтист Колбертийн санаачилга, хүсэлтээр XIV Луис хааны зарлигаар байгуулагдсан судалгаа эрдэм шинжилгээний нийгэмлэг юм. Тус академи байгуулагдсанаар 17-18 дугаар зууны үеийн Европын шинжлэх ухааны хөгжилд гарсан томоохон ололт төдийгүй эрт үед байгуулагдсан ШУА-иудын нэг болсон. Тус Академи байгуулагдсан эхний 30 орчим жилд институцийн хэлбэрт харайхан орж хэлбэржилгүйгээр харьцангуй албан бус байдлаар оршиж байв. Өнөөдөр Францын ШУА нь үндсэн Хүрээлэн буй орчны судалгааны хүрээлэн, Сансар судлал, Эрчим хүч, Био-анагаахын шинжлэх ухаан, Нийгэм, ёс суртахуун, Олон улсын харилцаа, Сурган хүмүүжүүлэх, Амьдралын ухааны чиглэлийн хүрээлэнгүүдийг багтаадаг.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	1793 оны конвенцийн дагуу түүнийг Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн ухааны хүрээлэн болгон өөрчилж, тус хүрээлэнгийн үндсэн чиг үүргийг харилцан уялдаатай үйл ажиллагааг явуулах зарчмаар математик, физикийн шинжлэх ухааны салбар; ёс зүй ба улс төрийн шинжлэх ухааны салбар; утга зохиол, урлаг судлалын чиглэлээр тус бүр 3 үндсэн хэсэгт хуваагдан үндсэн чиг үүргээ биелүүлдэг байна. Түүнчлэн академийн харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүд нь Төрийн үйлчилгээний сайдын шууд удирдага дор ажил үүргээ гүйцэтгэнэ.

	Хүрээлэнгүүдэд ажиллаж байгаа ШУА-ийн жинхэнэ болон сурвалжлагч гишүүд, академийн гадаад болон хүндэт гишүүд нь санал хураалтаар сонгогдох бөгөөд сонгууль нь төрийн үйлчилгээний байгууллагуудыг төлөөлж ажиллана.
<b>ЭША-нуудын тоо</b>	ШУА-ийн жинхэнэ гишүүд нь насан туршдаа сонгогдох бөгөөд нийтдээ 150 жинхэнэ гишүүн, 300 орчим сурвалжлагч гишүүд, 120 гаруй гадаад гишүүнчлэлтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Тэдгээр нь шинжлэх ухааны дараах бүлгүүдэд хуваагдана: Математик-физикийн шинжлэх ухааны салбар буюу түүний харьяа салбарууд, Хими, биологи, геологи ба анагаах ухааны салбарын суурь судалгааны салбаруудтай. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.0008 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 0.8 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Франц улсын төсвийн зарцуулалтын 5.9% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Францын ШУА-ийн харьяа хүрээлэнгүүд нь тус улсын ЗГ-ын тусгай сан, нарийн бичгийн дарга нарын газар болон бусад агентлагуудаас санхүүждэг.
<b>Тайлбар</b>	ШУА-ийн харьяа хүрээлэнгүүдэд ажиллаж байгаа гишүүд нь жилд 1500 франкийн цалинтай байхаас гадна нарийн бичгийн дарга нарын газраас жилд нэг удаа 6000 франкийн тэтгэлэг олгоно.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://www.bdm.insee.fr/bdm2/affichageSeries?idbank=001641607&amp;page=tableau&amp;request_locale=en">https://www.bdm.insee.fr/bdm2/affichageSeries?idbank=001641607&amp;page=tableau&amp;request_locale=en;</a> <a href="http://www.academie-sciences.fr/">http://www.academie-sciences.fr/;</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/France.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/France.aspx;</a>

## 33. ЧЕХ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Европ/Зүүн европ
<b>Хүн амын тоо</b>	10,572,427
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	0.14%
<b>Засаглалын хэлбэр</b>	нэгдмэл, парламентын засаглалтай Үндсэн хуульт БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	<b>БН Чех Улсын ШУА (Academy of Sciences of the Czech Republic)</b> Чехийн ШУА-ийн судалгаа, эрдэм шинжилгээний үндсэн чиглэл нь хуучин Чехословакийн ШУА-ийн судалгааны ажлын чиглэл, үзэл баримтлалыг өөрийн зорилгоо болгохоос татгалзаж, улмаар шинжлэх ухааны шинэ мэдлэг, онолын үзэл баримтлалыг хувьсан өөрчлөгдөж буй нөхцөл байдалд тохируулан үргэлжүүлэхийг зорьсон явдал мөн. Чехийн ШУА-ийн үндэс нь 1784 онд байгуулагдахдаа Хааны нэрэмжит ШУ-ны нийгэмлэгийн хүмүүнлэг, байгалийн шинжлэх ухааны салбаруудыг эгнээндээ багтаасан байна. 1861-1863 оны үед Ян Эвангелиста Пуркина анх Академи бол шинжлэх ухааны судлагдахууны хувьд их сургуульд суурилсан бус бие даасан эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдтэй байж түүгээр дамжуулан шинжлэх ухааны суурь болон онолын судалгаануудыг гүйцэтгэж улмаар нийгмийн бүх хүрээнд шинжлэх ухааны ололт амжилтууд, түүний үр дүнг тархаан түгээх, түүнийг мэдлэгт шилжүүлэхэд онцгойлон анхаарах хэрэгтэйг санаачилсан байна. Үндэсний ШУА-ийн шинжлэх ухааны санаачилга нь эрдэм шинжилгээний

	хүрээлэнгүүд нь олон шинжлэх ухааны уулзвартай шууд холбогдож судалгааны үзэл баримтлалыг өргөжүүлэх, арга зүйг баяжуулахад чухал үүрэг гүйцэтгэхийг гол чиглэл болгодог.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	БН Чех улсын ШУА бол гагцхүү шинэ инновацийг институцилан түгээх, олон нийт, төр засгийн үйл ажиллагаанд шинжлэх ухаанд суурилсан бодлогын зөвлөмж боловсруулж өгөхөд үндсэн үүрэг нь чиглэгдэнэ. Чехийн ШУА, түүний харьяа хүрээлэнгүүдийн тэргүүн зорилго нь байгаль, техник, нийгмийн болон хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгааны хамрах хүрээг тэлж суурь судалгааг түлхүү хөгжүүлэхэд онцгойлон анхаарах явдал мөн. Чингэхдээ суурь судалгааны чиг хандлагыг олон шинжлэх ухааны уулзварт бодит орчинд нэвтрүүлэх замаар нарийвчлан судлах, улмаар олон улсын төвшинд хурдацтай хөгжиж буй шинжлэх ухааны ололт амжилт, хөгжлийн чиг хандлагыг Чехийн үндэсний соёл, нийгмийн хөгжлийн хандлагад нийцүүлэх бэхжүүлэхэд чиглэгддэг. Академийн хүрээлэнгүүдийн эрдэмтэн судлаачдыг давтан сургах, тэдний их дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаанд оролцуулах, залуу судлаачдыг чадваржуулахад үйл ажиллагааныхаа нэг гол чиглэл болгон ажиллаж байна. Нөгөө талаар, академийн эрдэмтдийн хийсэн хавсарга судалгааг үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх, тэдний хамтын ажиллагааг өрнүүлэх, хамтарсан судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхэд анхааран ажиллаж байна.
<b>ЭША-нуудын тоо</b>	БН Чех улсын үндэсний ШУА нь нийтдээ 7000 гаруй эрдмийн зэрэг цолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажилтантай. Энэ бол 1510 хүнд 1 эрдэм шинжилгээний ажилтан ногдож байна. 2015 оноос эхлэн тус академийн албан ёсны нэрийг "Czech Academy of Sciences (CAS) буюу Чехийн ШУА гэж нэрлэх болжээ. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.066 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 663 хүн ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Чех улсын төсвийн зарцуулалтын 4.2%-ийг Боловсрол, шинжлэх ухааны салбарт зарцуулдаг байна. Чехийн үндэсний ШУА, түүний харьяа хүрээлэнгүүд нь улсын төсвөөс шууд санхүүжинэ. Судалгааны санхүүжилтийн загвар нь Академи дээр төвлөрөх бөгөөд олон улсын тогтсон стандартын дагуу баталгаажина. Суурь судалгааны эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн санхүүжилтийг Академийн нэгдсэн судалгааны зорилготой нийцэж буй тохиолдолд зорилгод чиглэсэн санхүүжилтээр санхүүжүүлэхийн зэрэгцээ зарим судалгаа (хувь судлаачид болон ЭШ-ний хүрээлэнгүүд)-г нээлттэй сонгон шалгаруулалтын хэлбэрээр грант-төслийн хэлбэрээр санхүүжүүлнэ.
<b>Тайлбар</b>	2007 оны байдлаар Чехийн ШУА болон түүний салбар хүрээлэнгүүдийн нийт зардал 866.2 сая Чех кронаар тооцогдож байсан бөгөөд түүний 55.1 хувийг шинжлэх ухааны хүрээлэнгүүд дээр хэрэгжсэн төсөл, судалгааны ажлуудын үр дүнг практикт шилжүүлэх замаар олсон орлогыг татан төвлөрүүлэх замаар шинжлэх ухааныг дэмжих сангийн зохион байгуулалтаар олсон орлогоор дараагийн шатны эрдэм шинжилгээний ажлын зардлыг гүйцэтгэдэг байна. Түүнчлэн хилийн чанад дахь ижил төстэй судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Чехийн шинжлэх ухааны төлөв байдлыг олон улсын төвшинд интеграцичлах бодлогыг баримтлан ажиллаж байна.
<b>Эх сурвалж</b>	<a href="https://www.czso.cz/csu/czso/population">https://www.czso.cz/csu/czso/population</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx">http://www.interacademies.net/Academies/ByCountry.aspx</a> ; <a href="http://www.avcr.cz/">http://www.avcr.cz/</a> ;

## 34.ШВЕДИЙН ВАНТ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Умард Европ
Хүн амын тоо	10,001,900
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.042%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, хаант засаглалтай
Үндэсний ШУА-ийн нэр, статус	Шведийн Эзэн хааны нэрэмжит ШУА ( <i>Royal Swedish Academy of Sciences /RSAS</i> ) нь 1739 онд байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд статусын хувьд хараат бус, төрийн бус байгууллагын зарчмаар ажилладаг шинжлэх ухааны нийгэмлэг юм. ШУА-ийн үндсэн зорилго нь шинжлэх ухааныг дэмжих, нийгэмд шинжлэх ухааны ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, шинжлэх ухааны нөлөөг бэхжүүлэхэд оршино.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>Академи нь байгуулагдсан цагаасаа эхлэн хөдөө аж ахуй, ойн аж ахуй, уул уурхай зэрэг нийгмийн практик ач холбогдолтой салбаруудад голлон анхаарч ирсэн байна. Өнөөгийн Шинжлэх ухааны академийн зорилго бол "шинжлэх ухааныг дэмжих, түүнчлэн шинжлэх ухааны үр өгөөж, нөлөөг нийгэмд батжуулан бэхжүүлэх"-д чиглэгдэх бөгөөд эрх зүйн баталтгаажсан статустай байгууллагын хувьд нийгмийн гол чухал асуудлуудад шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, түүнийг бодитоор үнэлэх, эрдэм шинжилгээ, судалгааны үр дүнг мэдээлэх шинжлэх ухааны нийгмийн үүргийг бэхжүүлэхэд өндөр чанартай бүтээл гаргахад дэмжлэг үзүүлнэ. Академийн гишүүд дараах ангиллаар хуваагддаг бөгөөд гадаад гишүүдийн хувьд насны дээд хязгаар 65 хүртэл байна.</p> <p>Түүнчлэн Шведийн судалгаа хөгжил, шинэтгэлийн үйл явцад дэмжлэг үзүүлэх дэлхий нийтийн асуудалд хамтран ажиллаж, тогтвортой хөгжлийн олон улсын шинжлэх ухааны бодит уялдаа холбоог өрнүүлэхэд олон шинжлэх ухааны бодит оролцоог ханган ажиллахыг чухалчилж байна.</p> <p>ШУА нь дотроо математик (13), одон орон-сансар судлалын шинжлэх ухаан (11), физик (18), хими (18), геофизик (12), био шинжлэх ухаан (28), анагаахын шинжлэх ухаан (25), инженерийн шинжлэх ухаан (13), нийгмийн шинжлэх ухаан (21), хүмүүнлэгийн болон тодорхой шинжлэх ухааны салбар (16)-ын гишүүдээс бүрдэнэ.</p>
ЭША-нуудын тоо	Академийн байнгын Тэргүүлэгчдийн газар буюу нарийн бичгийн дарга нарын газарт 30 орчим ажилтан, албан хаагчид ажиллана. Академийн гишүүдийн хувьд гадны 175, үндэсний 175 гишүүдээс бүрдэх бөгөөд гишүүдийн насны хязгаар 65 нас байх ба сонгуулийн зарчмаар сонгогдоно. Харин ШУА-ийн эрдэм шинжилгээний ажилтнуудын хувьд насны хязгаар байхгүй. Өнөөгийн байдлаар Эзэн хааны нэрэмжит ШУА нь 400 гаруй эрдэм шинжилгээний ажилтан, гадны 175 гишүүдтэй бөгөөд нийтдээ 600 ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна. Эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.005 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 5998 хүн ногдож байна.

<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Шведийн Хаант Улсын төсвийн зарцуулалтын 8%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Хүрээлэнгийн төсөв, үйл ажиллагааны зардал нь санхүүгийн жилийн гүйцэтгэлээр шийдэгдэнэ. Санхүүгийн жилийн гүйцэтгэлийг Академийн Удирдах зөвлөлд танилцуулж, дараагийн жилийн төсвийн төслийг танилцуулна. ШУА-ийн харьяа хүрээлэн, төвүүдийн санхүүжилт нь Засгийн газрын нийт төсвийн 12%-тай тэнцэх хэмжээний төсвийг төрөөс шууд санхүүжүүлэх бөгөөд төсвийн бусад орлогыг төрийн бус байгууллагууд, олон улсын болон үндэсний хэмжээний тусгай сангуудаас академийн салбар хүрээлэнгүүдийн боловсруулсан төслүүдийг сонгон шалгаруулалтын зарчмаар санхүүжүүлнэ. Мөн хувийн салбар, хандивлагчдаас санхүүжинэ.
<b>Тайлбар</b>	Академийн нарийн бичгийн дарга нарын газар болон түүний харилцаа холбоо, захиргааны болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.
<b>Эх сурвалж</b>	<a href="http://www.scb.se/">http://www.scb.se/</a> ; <a href="http://www.kva.se/en/">http://www.kva.se/en/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Sweden.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Sweden.aspx</a>

## 35.ЭНЭТХЭГ УЛС

<b>НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл</b>	Ази тив /Өмнөд Ази
<b>Хүн амын тоо</b>	1,311,070,000
<b>Дэлхийн хүн амд эзлэх хувиар</b>	17.5%
<b>Засаглалын хэлбэр</b>	холбооны, парламентын засаглалтай, Үндсэн хуульт БНУ
<b>Үндэсний ШУА-ийн нэр, статус</b>	Энэтхэгийн үндэсний ШУА-ийн үндэс суурь нь 1935 оны 1 дүгээр сарын 7-нд Калкута хотын Үндэсний шинжлэх ухааны хүрээлэн (National Institute of Science of India)-ээс үүсэлтэй бөгөөд 1945 оны 10 дугаар сард Энэтхэгийн Засгийн газраас тухайн үеийн энэтхэгийн шинжлэх ухааны үндэсний нийгэмлэгийн үйл ажиллагаа, цар хүрээг тэлж шинжлэх ухааны бүхий л салбарыг хөгжүүлэх зорилтыг тавих замаар <b>Энэтхэгийн Үндэсний шинжлэх ухааны академи (Indian National Science Academy/INSA)</b> –ийг Делигийн их сургуульд төвлөрүүлэн байгуулжээ. Хожим 1948 оны 4 дүгээр сард Жавхарлал Неругийн шууд удирдлага дор Шинэ Дели хотод Бахадур Шахи Зафар Марг хэмээх шилтгээнд шилжиж улмаар 1951 -1968 оныг хүртэл Энэтхэгийн Засгийн газрын шууд харьяалал дор тус байгууллагыг Шинжлэх ухааны олон улсын зөвлөлд албан ёсоор элсэж, 1970 оны 2 дугаар сараас эхлэн тус хүрээлэнг Энэтхэгийн Үндэсний ШУА хэмээн нэрлэх болсон байна. Үндэсний ШУА бол шинжлэх ухааны бүх салбаруудыг өөртөө багтаасан шинжлэх ухааны төв байгууллага мөн бөгөөд Энэтхэгийн эрдэмтдийн эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны гол төв тэргүүлэх байгууллага юм. Үндэсний ШУА-ийн тэргүүн зорилго нь Энэтхэгийн эрдэмтдийн эрх ашгийг хамгаалах, олон улсын байгууллагуудтай хууль ёсны хүрээний уялдаа холбоог бий болгох, олон улсын хамтын ажиллагааг дэмжих, эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухааны мэргэжлийн мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэх

	зорилгоор санал бодлоо чөлөөтэй солилцох, Энэтхэгийн шинжлэх ухааныг хүн төрөлхтний болоод улс орны сайн сайхны төлөө учир шалтгааныг олж танин шинжлэх ухааны мэдлэгийг түгээн тархаахад дэмжлэг үзүүлэхэд оршино.
<b>Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг</b>	Үүнээс гадна, Энэтхэгийн Үндэсний ШУА нь хамтран ажилладаг олон улсын байгууллагууд, бусад улсын ШУА-иуд болон ЗГ байгууллагуудын зүгээс эрдэм шинжилгээний ажилтнууд, эрдэмтэд төрөл бүрийн тэтгэлэг олгох замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг практиктай хослуулан ажиллахад анхаарч ажилладаг. Тухайлбал, ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын ШУА-иуд бусад улсын Засгийн газраас зарласан тэтгэлэгт хөтөлбөр, хамтын ажиллагааны сангуудтай нягт хамтран ажилладаг байна. Энэтхэгийн ШУА-иас дурдсан байгууллагуудтай хамтран Шинжлэх ухааны боловсрол олгох академийн хөтөлбөрийг зохион байгуулах хүрээнд улс орны хэмжээнд шинжлэх ухаан, технологийн үр өгөөжийг амьдралд нэвтрүүлэх, зарим тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд гол анхаарал хандуулан ажилладаг. Одоогийн байдлаар тус академийн зүгээс “Энэтхэгийн Шинжлэх ухааны тайлан”, “Энэтхэгийн шинжлэх ухааны салбар дахь эмэгтэйчүүдийн үүрэг хариуцлага”-ыг нэмэгдүүлэх, “Шинжлэх ухааны боловсрол”-ыг дээшлүүлэх 11 дэх Таван жилийн үндэсний төлөвлөгөөг батлан гаргаж, түүнийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.
<b>ЭША-нуудын тоо</b>	Үндэсний академи нь Судлаачдыг дэмжих тусгай сантай бөгөөд тус сан нь үндэсний болон гадаадын судлаачдын судалгаа, эрдэм шинжилгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус тэтгэлэгт хамрагдсан судлаачид Энэтхэгийн Үндэсний ШУА-ийн Судлаачдыг дэмжих сангаас дэмжлэг авч дэвшүүлсэн төсөл, судалгааны ажил нь батлагдсан тохиолдолд сангийн (125 гишүүнтэй) өмнө “тусгай тангараг” өргөнө. Академи нь Энэтхэгийн нэр хүндтэй, шилдэг эрдэмтдээс сонгон шалгаруулан тус зөвлөлийг бүрдүүлнэ. Одоогийн байдлаар үндэсний 754 судлаач, гадны 90 судлаачид багтаж байна. Үндэсний ШУА-ийн удирдлага зохион байгуулалт, чиг үүрэг болоод бусад асуудлыг хариуцан ажиллах Зөвлөлийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэй Тэргүүлэгчдийн зөвлөл хариуцах бөгөөд эрдэм шинжилгээ, судалгааны бусад асуудлыг Энэтхэгийн ЗГ болон Хамтын ажиллагаатай байгууллага, академиудаас томилогдсон 4 хүртэлх төлөөлөл, бусад 20 гишүүний хамт удирдана. ТУЗ-д Академийн ерөнхийлөгч болон 6 дэд ерөнхийлөгч нар мөн багтсан байна. Үндэсний ШУА нь нийтдээ 5205 эрдэм шинжилгээний ажилтан, албан хаагчидтай бөгөөд энэ нь нийт хүн амын 0.0003 хувийг эзэлж, 3 сая хүнд 1 эрдэм шинжилгээний ажилтан ногдож байна.
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	Энэтхэг улсын төсвийн зарцуулалтын (ДНБ-д эзлэх хувиар) 2.2%-ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг.
<b>Тайлбар</b>	1974 оноос тус академи, “Kothari” шинжлэх ухааны судалгааны хүрээлэнтэй хамтран Шинжлэх ухаан, технологийн хөгжил, эрдэм шинжилгээ, судалгааны дорвитой бүтээл гаргасна Залуу судлаач, эрдэмтэд зориулсан шагналыг бий болгосноор шинэ залуу эрдэмтэн судлаачдыг төлөвшүүлэх, шинэ бүтээлч санаачилга, шинжлэх ухааны нээлт бүхий томоохон бүтээл туурвих урам зориг, сэдлийг бүрдүүлж өгсөн. 1981 оноос тус шагналыг зөвхөн Энэтхэгийн үндэсний ШУА удирдаж зохион байгуулж, санхүүжүүлж байна.

Эх сурвалж	<a href="http://censusindia.gov.in/">http://censusindia.gov.in/</a> ; <a href="http://www.insaindia.org/">http://www.insaindia.org/</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthAsia/India.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthAsia/India.aspx</a> <a href="http://www.interacademies.net/File.aspx?id=20816">http://www.interacademies.net/File.aspx?id=20816</a>
------------	---

## 36.ЭСТОНИ УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Европ/Умард Европ
Хүн амын тоо	1,317,797
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	0.018%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, бүгд найрамдах улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<i>Эстоний ШУА (Estonian Academy of Sciences)</i> нь 1938 онд Эстонийн эрдэмтэд, шинжлэх ухааны нийгэмлэгийнхний санаачилгаар байгуулагджээ. 1946-1995 оныг хүртэл тус академи нь эгнээндээ 19 эрдэм шинжилгээний хүрээлэн, технологийн төвүүдийг өөрийн эгнээндээ багтаасан судалгаа, эрдэм шинжилгээний төв байгууллага болон өргөжжээ. 1997 онд батлагдсан Эстонийн ШУА-ийн эрх зүйн байдлын тухай хуулиар академийн эрхэм зорилго нь байгаль, техникийн болон хүмүүнлэгийн ухааны судалгааг дэмжин хөгжүүлэх, улмаар Эстонийн нийгэм, соёл, эдийн засгийн хөгжилд дэмжлэг туслалцаа үзүүлэхээр заажээ.
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	2014 оны 12 дугаар сарын 1-ний байдлаар тус академийн жинхэнэ гишүүдийн тоо 97-г хүрсэн байна. Эстоний ШУА нь бүтэц зохион байгуулалтын хувьд 4 үндсэн салбарт хуваагдана: <ul style="list-style-type: none"> <li>• Астрономи, физикийн салбар</li> <li>• Информатик, инженерийн салбар</li> <li>• Геологи, химийн салбар</li> <li>• Хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны салбар</li> </ul>
ЭША-нуудын тоо	2016 оны 12 дугаар сарын байдлаар тус академийн хэмжээнд 1200 орчим эрдмийн зэрэг цолтой эрдэм шинжилгээний ажилтнууд ажиллаж байгаа нь нийт хүн амын 0.091 хувийг эзэлж, 1 эрдэм шинжилгээний ажилтанд 910 хүн ногдож байна.
Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)	Эстони Улсын төсвийн зарцуулалтын 5.1% -ийг Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулдаг. Академийн бүх салбар байгууллагууд хамтран ажиллах гэрээ байгуулж улсын төсвөөс шууд санхүүжинэ. Академийн ашиг сонирхол, зорилгод нийцсэн тохиолдолд төрийн болон төрийн бус байгууллагууд, хувийн салбарынхантай хамтран ажиллах боломж нээлттэй.
Эх сурвалж	<a href="http://www.akadeemia.ee/en/">http://www.akadeemia.ee/en/</a> ; <a href="http://www.stat.ee/main-indicators">http://www.stat.ee/main-indicators</a> ; <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Estonia.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/CentralEasternEurope/Estonia.aspx</a> ; <a href="http://www.akadeemia.ee/en/membership/divisions/4/">http://www.akadeemia.ee/en/membership/divisions/4/</a> <a href="https://www.riigiteataja.ee/en/eli/ee/522042014001/consolide">https://www.riigiteataja.ee/en/eli/ee/522042014001/consolide</a>

## 37.ЯПОН УЛС

НҮБ-ын статистикийн тив, газар зүйн байршлын бүсчлэл	Ази/Зүүн Ази
Хүн амын тоо	126,860,000
Дэлхийн хүн амд эзлэх хувиар	1.70%
Засаглалын хэлбэр	нэгдмэл, парламентын ардчилалтай, Үндсэн хууль хаант засаглалтай улс
Үндэсний ШУА-ийн нэр, статус	<p>Японы шинжлэх ухааны академи нь анх 1879 онд байгуулагджээ. Тус Академи нь Ерөнхийлөгч, ерөнхий салбар хариуцсан хоёр Дэд Ерөнхийлөгч, 150 гишүүнтэй үйл ажиллагаа явуулахын дээр гишүүдийг шинжлэх ухааны салбарт амжилт гаргасан эрдэмтдээс насан туршид нь сонгон ажиллуулдаг байна. Дэлхийн II дайны дараа шинжлэх ухаан, технологийн салбарт төрөөс анхаарч шат дараатай арга хэмжээ авснаар өнөөдөр Япон улсын шинжлэх ухааны салбар төрийн нэгдсэн бодлогод зангидагдан хурдацтай хөгжиж байна. Японы Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэдэх “<i>оңцгой статус</i>”-тай байгууллага юм. Тус академийн эрх зүйн байдлыг Японы академийн тухай бие даасан хуулиар зохицуулна.</p> <p>1949 онд Засгийн газраас шинжлэх ухааны салбарыг хөгжүүлэх зорилгоор “Японы шинжлэх ухааны зөвлөл”-ийг байгуулсан бөгөөд зөвлөл нь төрийн болон олон улсын шинжлэх ухааны байгууллагуудтай хамтран ажиллаж, шинжлэх ухааны салбарын эрдэмтдийг гадаад, дотоодын эрдэмтэдтэй холбох, эрх ашгийг нь хамгаалах, цөмийн аюулгүй байдалтай холбоотой санал, зөвлөмжийг Засгийн газар, олон нийтэд зориулан гаргаж ирсэн байна. 1959 онд Засгийн газрын дэргэдэх “Шинжлэх ухаан, технологи, инновацийн зөвлөл”-ийг байгуулснаар шинжлэх ухаан, технологийн салбарын суурь бодлогыг гаргадаг эрх бүхий субъект болсон ба зөвлөлөөс гаргасан бодлого, урт хугацааны төлөвлөгөөний дагуу холбогдох яам, агентлаг, эрх бүхий байгууллагууд үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөөгөө боловсруулан ажилладаг болсон байна.</p> <p>1995 онд “Шинжлэх ухаан, технологийн суурь хууль” батлагдаж, тус хуулийн дагуу 1996 онд “Шинжлэх ухаан, технологийн үндсэн төлөвлөгөө”-г баталжээ. Эл төлөвлөгөө нь шинжлэх ухаан, технологийн системийг өөрчлөх, эрдэмтэн судлаачдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, зардлыг үр ашигтай зарцуулах, Японы шинжлэх ухаан, технологийн салбарын олон улс дахь өрсөлдөх чадварыг дээшлүүлэхийг үндсэн зорилго болгон тодорхойлсон байна.</p>
Үндэсний ШУА-ийн үйл ажиллагаа, чиг үүрэг	<p>Японы ШУА нь ерөнхий - 2, дэд - 7 шинжлэх ухааны салбарт хуваагдаж, ерөнхий болон салбар хуралдаан зохион байгуулдаг. Академийн ерөнхий хуралдаанаар академитай холбоотой чухал асуудлаар шийдвэр гаргадаг бол салбар хуралдаанаар тухайн салбарын цаг үеийн болон шаардлагатай асуудлаар хуралдаж, шийдвэр гаргадаг. Академи нь дараахь үндсэн үйл ажиллагааг эрхэлнэ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны ном, бүтээл, ололт амжилтыг шагнах;</li> <li>• Академийн гишүүдийн гаргасан материал, бүтээлийг засварлаж, хэвлэх;</li> <li>• Японы эрдэм шинжилгээний судалгаа, бүтээлийг хөгжүүлэх зорилгоор шаардлагатай бусад үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэх.</li> </ul>

	<p>Академи нь ажлын албатай бөгөөд нарийн бичгийн дарга болон хэд хэдэн туслах ажилтантай. Эдгээр ажилчид нь Академийн ерөнхийлөгч болон албаны бусад ажилчдын удирдлага дор Японы ШУА-ийн өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг байна.</p> <p>Японы шинжлэх ухааны салбарын төрийн байгууллагууд нь Ерөнхий сайдын шууд удирдлага болон Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яаманд харьяалагддаг. Ерөнхий сайдын харьяанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухаан, технологийн бодлогын хороо,</li> <li>• Японы шинжлэх ухааны зөвлөл ажилладаг бол</li> </ul> <p>Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны харьяанд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Үндэсний шинжлэх ухаан, технологийн бодлогын институт,</li> <li>• Японы шинжлэх ухааны академи</li> <li>• Бие даасан шинжлэх ухааны 9 институт ажиллаж байна.</li> <li>• <b>Японы шинжлэх ухааны зөвлөл</b><sup>62</sup> (Science council of Japan):</li> </ul> <p>Японы шинжлэх ухааны зөвлөл нь 1949 онд Ерөнхий сайдын эрх мэдлийн дор “<b>онцгой эрхт байгууллага</b>” гэсэн статустай байгуулагдсан. Зөвлөлийн гол зорилго нь улсынхаа шинжлэх ухааны салбарыг хөгжүүлж, идэвхжүүлэх, цаашилбал ард иргэдийн амьдрал, үйлдвэрлэл, засаг захиргааны байгууллагууд дахь шинжлэх ухааны ач холбогдол, нөлөөллийг нэмэгдүүлэх зорилготой.</p>
<b>ЭША-нуудын тоо</b>	<p>Зөвлөл нь тус улсын 840.000 эрдэмтдээс сонгогдсон 2000 гишүүн, 210 зөвлөлийн гишүүнтэй томоохон байгууллага болсон байна. Зөвлөл нь Ерөнхийлөгч, 3 дэд ерөнхийлөгчтэй ба эдгээр удирдлагуудыг зөвлөлийн гишүүдээс сонгодог. Харин зөвлөлийн 210 гишүүнийг Ерөнхий сайд томилдог бол зөвлөлийн 2000 гишүүнийг тус улсын нийт эрдэмтдээс судалгааны бүтээл, ололт амжилтыг үндэслэн зөвлөлийн Ерөнхийлөгч сонгодог байна. Тус улсын эрдэм шинжилгээний ажилтнуудын нийт хүн амд эзлэх хувь 0.06 байгаа нь 1 эрдэм шинжилгээний ажилтанд 662 хүн ногдож байна.</p>
<b>Санхүүжилтийн байдал (Төсвийн зарцуулалт - ДНБ-ний хувиар)</b>	<p>Япон улсын төсвийн зарцуулалтын (ДНБ-д эзлэх хувиар) 3.5% Боловсрол (шинжлэх ухаан)-ын салбарт зарцуулагддаг байна. Японы шинжлэх ухаан, технологийн салбар өрсөлдөх чадвараараа дэлхийд тэргүүлэх болж, “Эдийн засгийн хамтын ажиллагааны нийгэмлэгээс жил бүр гаргадаг “<i>R&amp;D санхүүгийн үзүүлэлт</i>”-ээр Япон улс нь 2016 оны байдлаар ДНБ-ийн 3,39% буюу 4.913.4 тэрбум ам.долларыг шинжлэх ухаан, технологийн салбарт зарцуулсан нь дэлхийд АНУ, БНХАУ-ын дараа гуравдугаар байрт орж байна. Мөн 2000 оноос хойш шинжлэх ухааны салбар дахь Нобелийн шагналыг 14 удаа хүртсэн нь тус улсын шинжлэх ухааны салбарын хөгжлийн нэг үзүүлэлт болох юм.</p>
<b>Тайлбар</b>	<p>Япон улс 2015 оны улсын нэгдсэн төсвөөс нийт 3,626.9 тэрбум иен-ийг Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хуваарилсан байх бөгөөд үүнийг дараах байдлаар төсөвлөсөн хуваарилалтаас үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яаманд - 66%</li> </ul>

<sup>62</sup> Японы шинжлэх ухааны зөвлөлийн албан ёсны сайт <http://www.scj.go.jp/en/index.html>

	<ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засаг, худалдаа, аж үйлдвэрийн яаманд - 14%</li> <li>• Бусад яам, агентлагийн шинжлэх ухаан, технологи, инновацийн зардалд - 20%-ийг тус тус хуваарилсан байна.</li> </ul>
Эх сурвалж	<a href="http://www.stat.go.jp/english/data/jinsui/tsuki/index.htm">http://www.stat.go.jp/english/data/jinsui/tsuki/index.htm</a> <a href="http://www.scj.go.jp/en/">http://www.scj.go.jp/en/</a> <a href="http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Japan.aspx">http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEastAsiaPacific/Japan.aspx</a>

### Цахим эх сурвалж:

1. <http://www.lu.lv/eng/general/administrative/institutes/agencies/institute-of-philosophy-and-sociology/>
2. <http://nasb.gov.by/eng/organizations/departments/>
3. <http://www.science.gov.az/en/cat.php?fid=contact>
4. <http://nasb.gov.by/rus/organizations/institutes/inogum.php#off2472>
5. <http://www.sci.am/resorgs.php?oid=30&langid=1>
6. <http://www.nas.aknet.kg/eng/index.php?menu=56>
7. [http://www.cas.cz/nejcastejsi\\_otazky/](http://www.cas.cz/nejcastejsi_otazky/)
8. <http://e-history.kz/en/organization/show/187>
9. <http://www.klemens.sav.sk/fiusav/?q=en/staff>
10. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/MiddleEastCentralAsia/Kazakhstan.aspx>
11. <http://www.sav.sk/?lang=en&charset=&doc=home-info>
12. <http://fi.zrc-sazu.si/index.php?q=en/node/2>
13. <http://www.klemens.sav.sk/fiusav/?q=en/staff>
14. <http://www.interacademies.net/default.aspx?id=10877>
15. [http://en.wikipedia.org/wiki/Turkish\\_Academy\\_of\\_Sciences](http://en.wikipedia.org/wiki/Turkish_Academy_of_Sciences)
16. <http://www.nas.go.kr/eng/intro/intro/officers.jsp>
17. <http://economy.news.mn/content/190297.shtml>
18. [http://www.nas.go.kr/eng/membership/members/list\\_h.jsp?NP\\_Code=10000060&NP\\_DataCode=20000024](http://www.nas.go.kr/eng/membership/members/list_h.jsp?NP_Code=10000060&NP_DataCode=20000024)
19. <http://www.icsu.org/publicdb/frmDisplayMember?docid=1da0655677d4989bae00c6a5bb1c0fd5>
20. <http://www.dlmpst.org/pages/history.php>
21. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/LatinAmericaCaribbean/Cuba.aspx>
22. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Belgium/13746.aspx>
23. <https://www.science.org.au/committee/history-and-philosophy-science>
24. <https://royalsociety.org/about-us/diversity/>
25. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Austria/12271.aspx>
26. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/UnitedKingdom/12466.aspx>
27. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/WesternNorthernEurope/Finland.aspx>
28. [http://www.afghanbios.info/index.php?option=com\\_afghanbios&id=2950&task=view&total=3021&start=20&Itemid=2](http://www.afghanbios.info/index.php?option=com_afghanbios&id=2950&task=view&total=3021&start=20&Itemid=2)
29. <http://mta.hu/articles/research-institute-of-philosophy-of-the-hungarian-academy-of-sciences-126407>
30. <http://www.interacademies.net/Academies/ByRegion/SouthEasternEurope/Macedonia.aspx>
31. [http://www.lza.lv/index.php?option=com\\_content&task=view&id=256&Itemid=139](http://www.lza.lv/index.php?option=com_content&task=view&id=256&Itemid=139)
32. [http://en.wikipedia.org/wiki/Macedonian\\_Academy\\_of\\_Sciences\\_and\\_Arts](http://en.wikipedia.org/wiki/Macedonian_Academy_of_Sciences_and_Arts)

33. <http://www.fsi.lu.lv/?setl=2>
34. [http://en.wikipedia.org/wiki/Institute\\_of\\_Philosophy\\_%28National\\_Academy\\_of\\_Sciences\\_of\\_Belarus%29](http://en.wikipedia.org/wiki/Institute_of_Philosophy_%28National_Academy_of_Sciences_of_Belarus%29)
35. [http://www.acad.ro/academia2002/acadeng/pag\\_cont03\\_4.htm](http://www.acad.ro/academia2002/acadeng/pag_cont03_4.htm)
36. <http://www.sci.am/resorgs.php?oid=30&langid=1>

### 3.4. Шинжлэх ухааны доктор

Шинжлэх ухааны доктор (Латинаар *Scientiae Doctor*), ихэвчлэн *Sc.D., D.Sc., S.D., D.S.*, эсвэл *Dr.Sc.* хэмээн товчилдог бөгөөд дэлхийн хэд хэдэн улс орнуудад олгодог эрдэм шинжилгээ, судалгааны зэрэг юм. Зарим улс оронд, "Doctor of Science" /шинжлэх ухааны доктор/ зэрэг нь шинжлэх ухааны энгийн стандартын докторын зэргийн /Ph.D./ хувьд хэрэглэгддэг нэр юм.

Бусад орнуудад *Sc.D.* зэрэг нь *Ph.D.* зэргээс илүү шинжлэх ухааны мэдлэгтэй, шинжлэх ухаанд оруулсан тогтвортой хувь нэмрийг үнэлэн "өндөр докторын" зэргийг олгодог юм. Тухайн цолыг бас хүндэт цолын хувьд олгодог.

#### ОХУ-ЫН ТУРШЛАГА

ЗХУ, ОХУ болон бусад социалист орнуудад шинжлэх ухааны дээд зэрэг юм. ОХУ-ын их сургуулиудад докторын зэрэг нь профессорын албан тушаалд орох конкурсын нэг болзол байдаг юм.

ОХУ-д докторын зэрэг нь докторын диссертацийг олон нийтийн өмнө ил тод хамгаалсны үр дүнд үндэслэн ОХУ-ын Боловсрол, шинжлэх ухааны яамны Аттестатчиллын Дээд комиссийн /ВАК/ тэргүүлэгчдийн газраар олгогддог. Горилогч нь дэд зэргийн цолтой байх ёстой. "Шинжлэх ухааны зэрэг олгох журам"-ын дагуу *"Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертаци нь зохиогчоос онолын заалтыг үндэслэн гүйцэтгэн боловсруулсан шинжлэх ухааны шинэлэг томоохон ололт гэж мэргэшүүлэх боломжтой нийлбэр бүхий улс орны эдийн засагт оруулах хувь нэмрийн хувьд нийгэм-соёлын ба аж ахуйн чухал ач холбогдолтой шинжлэх ухааны томоохон асуудал шийдвэрлэж болохуйц техник, эдийн засаг, технологийн шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаанд түшиглэн явагддаг ажил юм"*.

Шинжлэх ухааны доктор зэрэг горилсон диссертаци нь гурван төрөлтэй байдаг. Үүнд:

- Тусгайлан бэлтгэсэн гар бичмэл (энэ нь хамгийн их түгээмэл байна);
- Эрдэм шинжилгээний илтгэл эсвэл судалгааны тайлан (энэ нь диссертацийн эрдмийн зөвлөлийн хүсэлтээр ВАК-ын тогтоол гарган горилогч нь шинжлэх ухаан, практикийн асар их ач холбогдолтой мэргэжлийн холбогдох салбарт нийтэлсэн судалгаа, техникийн бүтээлүүдийн үндсэн дээр боловсруулсан судалгааны ерөнхий /гол/ үр дүнгийн товч хураангуй юм.
- Нийтэлсэн нэг сэдэвт зохиол /монографи/. "Шинжлэх ухааны зэрэг олгох журам"-аар тогтоогдсон шалгуурыг хангасан болон эрдэм шинжилгээний шүүмжтэй сэдвийн бүрэн цогц судалгаатай шинжлэх ухааны ном хэвлэл юм.

Докторын диссертацийн шинжлэх ухааны гол үр дүн нь ВАК-аар тодорхойлсон жагсалтанд орсон тэргүүлэх шинжлэх ухааны сэтгүүлд шүүмжийн хамт хэвлэгдсэн байх ёстой. Диссертацид горилогчийн гол санаа, дүгнэлт, шинэлэг тал, практик ач холбогдол зэрэг тусгасан хоёр хүртэл хэмжээтэй (хүмүүнлэгийн шинжлэх ухааны хувьд 2.5 х.х.) хэвлэлийн хуудастай хураангуй хавсаргагдсан байх ёстой.

Диссертацийн хураангуйг албан ёсны хамгаалалтаас гурван сарын өмнө хамгаалах зөвлөлийн гишүүд болон ВАК-аар тодорхойлсон байгууллагуудад тараагдсан байх ёстой. Диссертацийн хамгаалалт нь хамгаалах эрдмийн зөвлөлийн нээлттэй хуралдаанаар явагддаг бөгөөд хамгаалах эрдмийн бүрэлдэхүүнд тухайн салбарын шинжлэх ухааны доктор зэрэгтэй эрдэмтэд багтдаг. Хамгаалах зөвлөл нь албан ёсны гурван шүүмжлэгчийг урьдчилан томилдог. Албан ёсны шүүмжлэгч нар албан ёсны

саналыг бичгээр өгөх ёстой. Диссертацийн хэлэлцүүлэгт хамгаалах зөвлөлийн гишүүд болон албан шүүмжлэгчээс гадна бусад эрдэмтэн мэргэжилтэн оролцох эрхтэй байдаг.

Санал хураалт нууцаар явагддаг бөгөөд хамгаалалтын хуралдаанд оролцсон хамгаалах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь дэмжлэг үзүүлэх ёстой.

## БУСАД УЛС ОРНЫ ТУРШЛАГААС

Гадаадын бусад орнуудад ОХУ, Монгол улс шиг шинжлэх ухааны докторын (Sc.D.) зэрэгт тавих шалгуур, шаардлага харьцангуй өөр байдаг учраас харьцуулахад төвөгтэй байдаг.

Тиймээс барууны зарим оронд магистр, докторын боловсрол нь нэг үе шатны тогтолцоог хэрэглэдэг учраас докторын зэрэг хамгаалсан төгсөгч нарт философийн доктор (Ph.D.) зэргийг олгосон тохиолдолд Орост энэ зэрэг нь ихэвчлэн дэд эрдэмтний зэрэгтэй адилтгаж байна. Иймд ОХУ-д шинжлэх ухааны докторын зэрэг илүү дээгүүр үнэлгээтэй гэж тооцоолдог.

Гэхдээ зарим барууны орнуудад Оросын шинжлэх ухааны докторын зэрэгтэй дүйцэх Ph.D. зэрэгтэй эрдэмтэнд олгодог цол байдаг. Тухайлбал, англо-саксоны шинжлэх ухааны /академик/ тогтолцоонд Ph.D. зэргийн дараа байгалийн шинжлэх ухаанд шинжлэх ухааны доктор (Doctor of Science, D.Sc.) нэртэй, хэл судлалд утга зохиол, хэл шинжлэх ухааны доктор (Doctor of Letters, D.Litt.), хууль зүйн шинжлэх ухаанд хуулийн доктор (Doctor of Laws, LL.D) зэрэг цол хэрэглэдэг.

Гэхдээ гол зарчмын ялгаа нь энэ цолыг гол төлөв диссертацийг хамгаалах үр дүнгээр биш харин нийтэлсэн бүтээл, шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэр эсвэл олон нийтийн үйл ажиллагааны дүнгээр олгодог. Ийм учраас шинжлэх ухааны доктор, утга зохиол, хэл шинжлэх ухааны болон хуулийн доктор зэрэг цол нь олон жилийн гавьяа, зүтгэлийг үнэлсэн хүндэт цол юм.

Европын эх газрын шинжлэх ухааны тогтолцоонд (ХБНГУ, Австри г.м.) ОХУ-ын болон Монголын шинжлэх ухааны докторын зэрэг олгох журамтай ижилдүү “habilitation” буюу “мэдлэгээ сэргээх” журам байдаг. Тодорхой нэг утгаараа энэхүү журам манай шинжлэх ухааны докторын хамгаалалттай ижил төстэй байдаг бөгөөд “habilitation” шалгалтын дараа “doctor habilitatus, Dr. habil.” зэргийг олгосноор их дээд сургуульд профессорын тушаалд орох эрхтэй болдог. Гэхдээ doctor habilitatus, Dr. habil. нь тусгай Ph.D.-оос дээш эрдмийн зэрэг биш зөвхөн их дээд сургуульд багшлах эрх олгодог докторын зэрэгт нэмэгдэл мэргэшил/шалгуур/ болдог.

“Боловсролын олон улсын стандартчилсан ангилал” /МСКО-Баримт №36 С/19/-ын 262 дугаар зүйлд МСКО-8 түвшинд хамаарах сургалтын хөтөлбөрүүд нь улс орноос хамааран дэд эрдэмтэн (Ph.D), шинжлэх ухаан/философийн доктор (D.Phil), хэл утга зохиолын доктор (D.Lit), байгалийн шинжлэх ухааны доктор (D.Sc), хуулийн доктор (LL.D) гэх зэргээр нэрлэдэг. Гэхдээ онцлон хэлэхэд “доктор” гэдэг нэртэй ижил төстэй хөтөлбөрүүдийг 263 дугаар зүйлд тусгасан шалгууруудад тохирсон тохиолдолд МСКО-8

түвшинд хамруулах болно /ёстой/. МСКО-8 түвшинг тодорхойлоход олон улсын түвшинд харьцуулахын тулд “докторантур эсвэл ижил төстэй” нэр томъёо хэрэглэдэг”.<sup>63</sup>

## ЗАРИМ УЛС ОРНЫ ЖИШИГ

### Хятад, Япон, Өмнөд Солонгос

Эдгээр орнуудад ихэвчлэн Sc.D./D.Sc зэргийг Graduate School-д зохих сургалтыг дүүргэсэн тохиолдолд АНУ-ын Ph.D in science доктор зэрэгтэй тэнцдэг.юм шинжлэх ухааны мэдлэг, хангалттай үнэлгээ, судалгаа гүйцэтгэхэд болон батлан хамгаалах дараа -д авсан байна.

### Австри, Герман, Швейцар

Герман, Австри, Швейцари Германы ярьдаг бус нутагт байгалийн шинжлэх ухааны салбар бүрт хамгийн түгээмэл докторын зэрэг хэрэглэдэг. Үүнд:

- Dr. rer. nat.: Doctor rerum naturalium, literally "Doctor of the things of nature"
- Dr. rer. medic.: Doctor rerum medicarum, Doctor of medical sciences
- Dr. sc. nat.: Doktor der Naturwissenschaften, Doctor of Natural Sciences
- Dr. sc. ETH: Doktor der Naturwissenschaften ETH, Doctor of Natural Sciences, awarded by ETH Zurich, Switzerland.
- Dr. phil. nat.: Doctor philosophiae naturalis, used only by Goethe University Frankfurt instead of Dr. rer. nat.
- Dr.-Ing.: Doktor der Ingenieurwissenschaften (Doctor of Engineering), awarded by German technical universities.
- Dr. mont.: Doctor rerum montanarum, awarded by the Montanuniversität Leoben instead of Dr. techn.
- Dr. techn.: Doctor technicae, awarded by Austrian technical universities.
- Dr.sc.agr.: Doctor scientiarum agrariarum, Doctor of Agricultural science
- Dr.sc.hum.: Doctor scientiarum humanarum, Doctor of Humanistic Sciences
- Dr.sc.inf.: Doctor scientiarum informaticarum, Doctor of Science in Informatics
- Dr.sc.inf.med.: Doctor scientiarum informaticarum medicæ, Doctor of Science in Medical Informatics
- Dr.sc.inf.biomed.: Doctor scientiarum informaticarum biomedicæ, Doctor of Science in Biomedical Informatics
- Dr.sc.math.: Doctor scientiarum mathematicarum, Doctor of Mathematics
- Dr.scient.med.: Doctor scientiæ medicæ, Doctor of Medical Sciences
- Dr.sc.mus.: Doctor scientiæ musicae, Doctor of Musicology
- Dr.sc.oec.: Doctor scientiarum oeconomicarum, Doctor of Economics
- Dr.sc.pol.: Doctor scientiarum politicarum, Doctor of Political Sciences
- Dr.sc.soc.: Doctor scientiæ socialis, Doctor of Social Sciences

<sup>63</sup> [п.262 Международной стандартной классификации образования \(МСКО\) 2011](#) (документ № 36 С/19), [см. п.29 Доклада Исполнительного совета ЮНЕСКО от 12.02.2012](#), установлено, что «В разных странах программы, относящиеся к уровню МСКО 8, называются по-разному, например, кандидат наук (Ph.D), доктор наук/философии (DPhil), доктор литературы, (D.Lit), доктор (естественных) наук (D.Sc), доктор права (LL.D), докторская степень или аналогичные термины. Однако важно отметить, что программы с названиями, схожими с названием „доктор“, следует включать в уровень МСКО 8, только если они соответствуют критериям, описанным в пункте 263. В целях сопоставимости данных на международном уровне для обозначения уровня МСКО 8 используется термин „докторантура или её эквивалент“.»

Эдгээр бүх докторын зэрэг нь АНУ-ын системийн Ph.D эсвэл Sc.D. зэрэгтэй тэнцэх юм.

### Их Британи, Ирланд, Пакистан, Энэтхэг, Хамтын Нөхөрлөлийн орнууд /Commonwealth/

Ирланд, Нэгдсэн Вант Улс болон Commonwealth –ийн орнуудад /Энэтхэгийн, Бомбей дахь технологийн хүрээлэн/ шинжлэх ухааны доктор /Doctor of Science/-ын зэрэг нь Дээд /Өндөр/ доктор-ын зэргийн нэг юм. Шинжлэх ухааны докторын зэрэг нь олон улсын түвшинд судалгаа, цалин хүрсэн тухайн их сургуулийн багш ажилтанд олгодог. Горилогч нь бүтээлийнхээ түүврийг зохих факультетийн зөвлөлд гаргаж өгдөг бөгөөд зөвлөл үүний үндсэн дээр шийдвэр гаргадаг. Энэ зэргийг /Doctor of Science/ авахын тулд заавал Ph.D зэрэгтэй байх албагүй. Жишээ нь, Ph.D зэрэггүй харин олон бүтээлтэй эрдэмтэн ч шинжлэх ухааны докторын зэрэг хүртэж болно.

### Чех, Словак, Унгар улс

Чех ба Словак улсад “шинжлэх ухааны доктор”-ын зэрэг /DrSc. нэрийн ард/ нь Doctor of Science зэрэгтэй Хамтын нөхөрлөлийн орнуудад /Commonwealth/ Шинжлэх ухааны доктор /D.Sc./ зэрэгтэй ижил төстэй утгаар хэрэглэдэг.

Харин Чехэд 2001 оноос хойш DrSc зэргийг олгодоггүй, оронд нь 2006 оноос хойш “Шинжлэх ухааны доктор(DSC.)-ын зэрэг нь ихэвчлэн байгалийн болон формаль шинжлэх ухааны салбарт хийсэн судалгаанд их сургуулиас биш, харин БНЧУ-ын Шинжлэх ухааны академиас олгодог.

Словак ба Унгар улсад "Шинжлэх ухааны доктор" (Dr.Sc.)-ын зэргийг Шинжлэх ухааны Словак Академи өгдөг.

### Франц

Францад шинжлэх ухааны доктор зэрэг (doctorat ES эсвэл d'État doctorat)-ийг сорилын болон байгалийн шинжлэх ухааны салбарт өндөр докторын зэрэг гэж тооцож, 1984 онд хүчингүй болоод бэлтгэгдсэн профессор (Habilitation à diriger des recherches, HDR) зэргээр орлогдсон.

### Дани улс

Dr. Scient зэрэг нь өндөр докторын зэрэг /higher doctorate/ юм.

### АНУ

АНУ-д албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн уламжлалт шинжлэх ухааны доктор /Doctor of Science/-ын зэрэг эрдэм шинжилгээний их дээд сургуулиудаас олгодог академик судалгааны докторын зэрэг юм. Академик судалгааны Sc.D. (Эсвэл D.Sc.) зэрэг нь АНУ-ын Боловсролын яам ба Үндэсний шинжлэх ухааны сангийн үзэж байгаагаар илүү түгээмэл Ph.D зэрэгтэй ижил төстэй байна.

АНУ-д Carnegie Classification of Institutions of Higher Education /Дээд боловсролын байгууллагын Карнеги ангилал/ -ийн дагуу ИДС-иудыг докторын зэрэг, магистрын зэрэг, бакалаврын зэрэг гэх зэрэглэлд хуваадаг бөгөөд докторын зэрэг олгодог их сургуулиудыг эрдэм шинжилгээний их сургууль /research university/ гэж нэрлэдэг. Тэд 3 зэрэгтэй:

- *Doctoral Universities - Highest Research Activity (R1)* (115 их сургууль)
- *Doctoral Universities - Higher Research Activity (R2)* (107 их сургууль)
- *Doctoral Universities - Moderate Research Activity (R3)* (113 их сургууль)



ШУА, ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ГАЗАР



ШУА, ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН

Эл судалгааг ШУА-ийн Тэргүүлэгчдийн газрын захиалга, санхүүжилтээр ШУА-ийн Философийн хүрээлэнг түшиглэсэн судалгааны баг хийж гүйцэтгэв.

Судалгааны багийн удирдагч Академич Г.Чулуунбаатар  
Доктор (Ph.D) Д.Батмөнх

Судалгааны багийн зөвлөх академич С.Нарангэрэл

Судалгааны төслийн багийн судлаачид

Магистр Т.Алтансүвд /ШУА, Тэргүүлэгчдийн газар/

Доктор (Ph.D) Ц.Цэцэнбилэг

Доктор (Ph.D) О.Хатанболд

Б.Лхагвадорж /БСШУСЯ/

Докторант Ц.Болормаа /УИХ-ын судалгааны төв/

Докторант Ж.Батжаргал

Судалгааны төслийн эрх зүйн шинжилгээ хийсэн судлаачид

Докторант Ц.Болормаа

Магистр Төмөрбаатар

Магистр Ц.Жаргал

Б.Лхагвадорж /БСШУСЯ/

Магистр Т.Алтансүвд /ШУА Тэргүүлэгчдийн газар/

Судалгааны төслийн социологийн судалгаа, шинжилгээ хийсэн судлаачид

Доктор (Ph.D) Ц.Цэцэнбилэг

Докторант Ж.Батжаргал

Докторант О.Баасантогтох

Докторант Ё.Ундрал

Магистр Д.Номун-Эрдэнэ

Магистр Ж.Пүрэвханд

Магистр Ц.Бадам

Дэлхийн улс орнуудын жишиг, харьцуулсан судалгаа

Доктор (Ph.D) О.Хатанболд

Докторант Н.Баяр